



ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

Улаанбаатар
2020



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
ҮНДСЭНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ СҮРГҮҮЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН



Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр

Төслийн тайлан

Улаанбаатар хот

2020

14201 Улаанбаатар хот, ш/х-46А-430, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-4,

Утас/Факс: (976)7730-7730 (2133)

И-хаяг: ei@num.edu.mn

Энэхүү судалгааны ажил ҮХГ, ОТ ХХК, МУИС-ийн ЭЗХ-гийн байр суурийг бус, харин тухайн судлаачдын байр суурийг илэрхийлэх болно.

МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны баг

Багийн ахлагч:

Х.Цэвэлмаа, Эдийн засгийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор

Багийн зөвлөх:

Ч.Хашчулуун, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш, доктор, профессор

Б.Сувд, МУИС-ийн Эмерит профессор

Багийн гишүүд:

Ц.Готов	М.Дэлгэрнасан
	И.Базаррагчаа
Ц.Баярбаатар	Ц.Жаргалсайхан
Т.Энэбиш	
В.Батцэнгэл	Ч.Заяа
	Д.Энхжаргал
Ц.Базарханд	
Б.Чинбат	
Н.Тогтох	Ц.Батболд
С.Намжилмаа	М.Алтанбагана
	Х.Билгүүн
Б.Батболд	Д.Далайцэцэг
Б.Амарсанаа	Б.Уянга
Ц.Батсүх	
Ц.Цэцэгмаа	С.Цолмон
Ц.Цэцэгсайхан	А.Өнөржаргал
Ч.Нарантуяа	А.Заяадэлгэр
С.Мөнхнаран	
Г.Гантулга	Д.Дорлигжав
Б.Нямдаваа	Э.Алтанболд
Б.Энх-Амгалан	Г.Нямбаяр
Б.Индраа	Б.Эрдэнэчимэг
Д.Насанжаргал	С.Амартүвшин
	Б.Цогт-Эрдэнэ
Ж.Батсуурь	Д.Төмөрсүх
	Ж.Гэрэлчулуун
Ц.Сэлэнгэ	Ж.Баатархүү
Г.Баттөр	Б.Дэмчигсүрэн
	Т.Дөлтуяа
Д.Ганболд	

Агуулга

Талархал.....	6
Товчилсон үг	7
Хүснэгт.....	8
Зураг	9
ХУРААНГУЙ.....	11
СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА	13
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	13
БҮЛЭГ I. ГОВИЙН БҮСИЙН БАЙГАЛЬ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ	18
1.1 Байгаль	18
1.2 Эдийн засаг	40
1.3 Нийгэм	83
БҮЛЭГ II. ГОВИЙН БҮСИЙН ДӨРВӨН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	111
2.1 Аймгуудын хөгжлийн бодлогод хийсэн шинжилгээ	111
2.2 Бүсийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахад зайлшгүй анхаарал хандуулах асуудлын тухайд.....	119
БҮЛЭГ III. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР (төсөл)	130
3.1 Говийн дэд бүсийн хөгжлийн логик хүрээ	130
3.1.1 Алсын хараа 2050 ба говийн бүсийн хөгжлийн утга	132
3.1.2 Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн тулгуур зарчим.....	134
3.1.3 Тэргүүлэх болон дэд чиглэлийн үндэслэл.....	136
3.1.4 Говийн дэд бүсийн хөгжлийн институцийн шинэчлэл, тулгарч буй асуудал.....	137
3.2 Говийн дэд бүсийн зорилтот хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, гол зорилго ба зорилтууд.....	141
3.3 Говийн дэд бүсийн зорилтот хөтөлбөрийн зорилтууд ба арга хэмжээ, үр дүн.....	143
Эх сурвалж.....	161
Хавсралт.....	164
Хавсралт 1. Стратегийн ордууд	164
Хавсралт 2. Өмнийн говийн бүлэг суурингийн тогтолцоо	164
Хавсралт 3. Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд.....	167
Хавсралт 4. Бүсчилсэн хөгжлийн агуулгаар орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт	172
Хавсралт 5. Аймгуудын хөгжлийн бодлогын шинжилгээ	176
Хавсралт 6. Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах санал.....	179
Хавсралт 7. Говьсүмбэр аймгийн санал.....	180
Хавсралт 8. Дундговь аймгийн санал.....	181
Хавсралт 9. Дорноговь аймгийн санал.....	182
Хавсралт 10. Өмнөговь аймгийн санал.....	183
Хавсралт 11. Аймгуудын Бүсийн хөгжлийн бодлогод ирүүлсэн саналыг Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал төсөлд тусгасан байдлын товъёог.....	185
Хавсралт 12. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт 2018.....	188
Хавсралт 13. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт 2019.....	192
Хавсралт 14. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт	195
Хавсралт 15. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт	199
Хавсралт 16. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт	202

Хавсралт 17. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. ҮХГ	205
Хавсралт 18. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Орон нутагт	208
Хавсралт 19. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санал. Дорноговь аймаг	213
Хавсралт 20. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санал. Өмнөговь аймаг	214
Хавсралт 22. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санал. ҮХГ	217
Хавсралт 23. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санал. Эрдэнэс Оюу Толгой ХХК	219

Талархал

МУИС-ийн судалгааны багийн хамт олны нэрийн өмнөөс биднийг судалгаанд гүн дэмжлэг үзүүлсэн ҮХГ-ын Б.Баярсайхан, Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Мөнхжаргал, Д.Мөнхсайхан нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье!

Энэхүү судалгааг гүйцэтгэх явцад орон нутгийн судалгааг удаа дараа явуулсан. Ийм үйл ажиллагааг бүрэн дэмжин ажилласан Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, аймаг бүрт байгуулагдсан ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлж, хамтран ажилласандаа баяртай байна.

Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг боловсруулах явцад бүх талаар дэмжин тэвчээртэй, хүлээцтэй ажилласан ОТ ХХК-ийн Стратегийн төслүүдийн ерөнхий менежер Ш.Байгалмаа, стратегийн төслийн мэргэжилтэн М.Халиун нартаа маш их баярлалаа.

МУИС-ийн ЭЗХ-гийн урилгыг хүлээн авч, үнэтэй зөвлөмж өгч ажилласан ЭЗХ-гийн зөвлөх МУИС-ийн Эмерит профессор Б.Сувд, ЭЗХ-гийн зөвлөх профессор Ч.Хашчулуун, судалгааг гүйцэтгэсэн төслийн зөвлөхүүд болон судлаачдаа Хүрээлэнгийн нэрийн өмнөөс болон хувиасаа гүн хүндэтгэл илэрхийлж, та бүхний үнэтэй санал зөвлөмж, чиглэл, мөн 4 аймгийн ИТХ-д хүргэх санал, говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлалын төсөл, УИХ-аар Алсын хараа 2050-ийг хэлэлцэхээс өмнө гаргасан санал зөвлөмж нь аймаг, бүсийн түвшний хөгжлийн бодлого төдийгүй бидний хамтын ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсныг тэмдэглэж, та бүхнийхээ эрдэм судлалын ажилд өндөр амжилт хүсэн ерөөе!

МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны ажлыг дэмжин ажилласан бүх хүмүүст дахин дахин талархал илэрхийлье.

Товчилсон үг

АХБ	Азийн хөгжлийн банк
ДБ	Дэлхийн банк
ДҮТ	Дулааны үйлчилгээний төв
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮҮ	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЗ	Мянганы хөгжлийн зорилго
НААҮ	Нийтийн аж ахуй, үйлчилгээ
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
СЦС	Сэргээгдэх цахилгаан станц
ТБЭХС	Төвийн бүсийн эрчим хүчний систем
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЭХС	Эрчим хүчний станц

Хүснэгт

Хүснэгт 1. Гадаргын усны тооллогын дүн	24
Хүснэгт 2. Говийн дэд бүсийн аймгуудын газрын доорхи усны нөөц, баялгийн тооцоо	25
Хүснэгт 3. Говийн бүсийн аж үйлвэрийн хэрэгцээнд ашиглах усны нөөц ашиглалтын баланс	34
Хүснэгт 4. Эрчимжсэн МАА-н салбарын зарим үзүүлэлтүүд, улсын дүнгээр	44
Хүснэгт 5. Бэлтгэгдсэн арьс шир ба урамшууллын үзүүлэлтүүд	46
Хүснэгт 6. Говийн дэд бүсийн газар тариалангийн талбайн үзүүлэлтүүд	47
Хүснэгт 7. Жимс, жимсгэний хураасан ургац, мян.кг-аар, улс, аймаг, жилээр	48
Хүснэгт 8. Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	53
Хүснэгт 9. Нийтийн хоолны салбарын голлох үзүүлэлтүүд	53
Хүснэгт 10. Хөнгөн үйлдвэрийн салбарын голлох үзүүлэлтүүд, 2010 оны үнээр, тэрбум төгрөгөөр	54
Хүснэгт 11. Аймгийн үл хөдлөх соёлын дурсгалын нэгтгэл	60
Хүснэгт 12. Аймгийн үл хөдлөх дурсгалын нэгтгэл, төрлөөр	61
Хүснэгт 13. Аймгийн биет бус соёлын өвийн нэгтгэл, төрлөөр	62
Хүснэгт 14. Өмнөговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар	62
Хүснэгт 15. Дундговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар	62
Хүснэгт 16. Дорноговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар	63
Хүснэгт 17. Говьсүмбэр аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар	63
Хүснэгт 18. Олон улс, улсын чанартай авто замын урт	68
Хүснэгт 19. Орон нутгийн чанартай замын нийт урт	69
Хүснэгт 20. Нүүрсний экспортын төсөөлөл /мянган тонн/	70
Хүснэгт 21. Төмрийн хүдрийн экспортын төсөөлөл /мянган тонн/	70
Хүснэгт 22. Зэсийн баяжмалын экспортын төсөөлөл /мянган тонн/	71
Хүснэгт 23. Дорноговь аймгийн ачаа тээвэрлэлтийн төсөөлөл, сая тн/жилд/	72
Хүснэгт 24. Суурин интернет хэрэглэгчийн тоо	73
Хүснэгт 25. Аймгуудын хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ	83
Хүснэгт 26. 15-аас дээш насны ажиллагчдын тоонд тухайн салбарт ажиллагчдын эзлэх хувь	90
Хүснэгт 27. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн өөрчлөлт, 2007-2017	92
Хүснэгт 28. Зорилтот аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, 2016-2018	93
Хүснэгт 29. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, хүнээр	94
Хүснэгт 30. Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд	97
Хүснэгт 31. Соёлын эдийн засгийн үзүүлэлтүүд	98
Хүснэгт 32. Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний шалгуур	98
Хүснэгт 33. Музейн үйлчилгээний шалгуур	99
Хүснэгт 34. Аймгийн төвүүдийн театр, чуулгын үзүүлэлтүүд	99
Хүснэгт 35. Аймгийн төвүүдийн музейн үйлчилгээ	99
Хүснэгт 36. Аймгийн урлагийн мэргэжлийн байгууллагын үнэлгээ	99
Хүснэгт 37. Аймгийн музейн үнэлгээ	100
Хүснэгт 38. Сумдын соёлын үйлчилгээний шалгуур	100
Хүснэгт 39. Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо (аймаг, бүсээр)	101
Хүснэгт 40. Бодлогын шинжилгээ хийсэн баримт бичгүүд	111
Хүснэгт 41. Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд (салбараар)	112
Хүснэгт 42. Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн шалгуур	116
Хүснэгт 43. Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилт	116
Хүснэгт 44. Шинжлэх ухаан, технологитой холбоотой бодлогын баримт бичиг	117
Хүснэгт 45. Шинжлэх ухаан, технологийн баримт бичгийн уялдаа	117
Хүснэгт 46. Нийгмийн хамгааллын салбар дахь ач холбогдлоор оноо өгсөн байдал	124
Хүснэгт 47. Говийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын оноо	124
Хүснэгт 48. Говьсүмбэр аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо	124
Хүснэгт 49. Дундговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо	125

Хүснэгт 50 Дорноговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо.....	125
Хүснэгт 51 Өмнөговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо	125

Зураг

Зураг 1 Бүс нутгийн хөгжилд нөлөөлөх оронзайн суурь үзүүлэлтүүд	14
Зураг 2 Бүс, дэд бүсийн бичил бүс.....	15
Зураг 3 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх арга зүйн схем	16
Зураг 4 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтийн ангилал	16
Зураг 5. Говийн дэд бүсийн ландшафтын гадны нөлөөнд өртөх эрсдэлийн үнэлгээ	18
Зураг 6. Монгол орны төв бүсийн говийн дэд бүсийн ландшафт нутаг дэвсгэрийн зохистой бүсчлэл	21
Зураг 7 Ерөнхий зураглал	40
Зураг 8. Хонинд толгойд шилжүүлсэн 100 га бэлчээрт ногдох малын тоо, аймгуудаар	41
Зураг 9. Нийт мал сүрэгт ямаан сүргийн эзлэх хувь, улсын дундаж, сонгосон аймгаар	42
Зураг 10. Өвчнөөр хорогдсон малын нийт малд эзлэх хувь, аймгаар, 2009-2018.....	43
Зураг 11. Бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар гаргасан уст цэг худгийн тоо	43
Зураг 12. Зудтай жилүүд, 1940 – 2018 он, улаан өнгө – ган, зудтай жилүүд.....	44
Зураг 13. Махны үйлдвэрлэл, төрлөөр, улсын дүнгээр, мянган тонноор	45
Зураг 14. Бэлтгэгдсэн ноос ба олгогдсон урамшууллын хэмжээ, улсын дүнгээр, 2011-2017.....	46
Зураг 15. Хураан авсан төмс, хүнсний ногооны хэмжээ, тонноор	48
Зураг 16 Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог /Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол/	50
Зураг 17 Ашиглалтын тусгай зөвшөөрөл (ашигт малтмалын төрлөөр)	51
Зураг 18 Ашиглалтын тусгай зөвшөөрөл (аймгаар)	51
Зураг 21. Хүнсний бүтээгдэхүүн ундаа үйлдвэрлэлийн салбарын бүтцийн өөрчлөлт, нийт үйлдвэрлэл, 2010 оны үнээр, их наяд тогтоогоор	52
Зураг 22. Хүнсний бүтээгдэхүүний хангамж	54
Зураг 23 Дорноговь аймаг, Гадаад, дотоодын жуулчны тоо, 2010-2018 он	57
Зураг 24 Дундговь аймаг, Гадаад, дотоодын жуулчны тоо, 2012-2018 он	58
Зураг 25 Өмнөговь аймаг, жуулчны баазуудаар үйлчлүүлсэн жуулчны тоо, (2012-2018 он)	59
Зураг 26 Өмнөговь аймаг, Говь Гурвансайхан БЦГ-ын тасалбар авсан жуулчны тоо 2013-2018.....	59
Зураг 27 Өмнөговь аймаг, Жуулчны баазуудын зардал, 2018	60
Зураг 28 Говийн бүсийн аймгуудын цахилгаан хангамжийн бүдүүвч	64
Зураг 29 Говьсүмбэр аймаг	64
Зураг 30 Дорноговь аймгийн цахилгаан эрчим хүчний системд холбогдсон сумд	65
Зураг 31 Дорноговь аймгийн сумдын 2014 - 2018 оны цахилгаан эрчим хүчний хэрэглээ, мян.кВт.цаг	66
Зураг 32 Дундговь аймгийн цахилгаан эрчим хүчний хангамж	67
Зураг 33 Өмнөговь аймгийн цахилгаан хангамжийн байдал.....	68
Зураг 34 Нүүрсний уурхай болон тээвэрлэх чиглэлүүд	70
Зураг 35 Зэсийн баяжмал, БНХАУ руу экспортлох чиглэл	71
Зураг 36 Дамжин өнгөрөх тээвэрлэлт.....	71
Зураг 37 Говийн дэд бүсийн 100 хүнд ноогдох 3G хэрэглэгчийн харьцуулалт	73
Зураг 38 Говийн дэд бүс дэх 100 хүнд ноогдох суурин интернет хэрэглэгчийн харьцуулалт	74
Зураг 39 Хүн амын нутагшилт.....	83
Зураг 40 Хүн амын ердийн цэвэр өсөлт.....	84
Зураг 41 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүн амын нягтшил	84
Зураг 42 Монгол улсын хүн амын нутагшилтын тогтолцоо. 2017	85
Зураг 43 Хот суурины төвлөрөл. 2017	86
Зураг 44. Говийн бүсийн аймгуудын хүн амын өсөлтийн 2030 он хүртэлх төсөөлөл, хувиар	87
Зураг 45. Монгол улсын нийт хүн амд говийн дэд бүсийн аймгуудын хүн амын эзлэх хувь	87
Зураг 46. Аймгуудын хүн амын шилжилт хөдөлгөөнд гарч буй өөрчлөлт, сүүлийн 10 жилээр	88
Зураг 47. Говийн аймгуудын хүн амын нягтрал болон ачаалал, хувиар	88

Зураг 48. 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын улсын нийт дүнд аймгуудын эзлэх хувь	89
Зураг 49. Говийн дэд бүсийн аймгуудын 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт ..	89
Зураг 50. Өмнөговь аймгийн 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт	90
Зураг 51. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин, 2001, 2009, 2017 оноор, мян төгрөг	91
Зураг 52. Ажилгүйдлийн түвшин, хувиар, аймаг тус бүрийн 1992-оос 2017 оны үзүүлэлт	91
Зураг 53. Говийн дэд бүсийн аймгуудын бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр	92
Зураг 54 Говийн дэд бүсийн бичил бүсийн төв, бүлэг суурингууд	104
Зураг 55 Давхаргуудын давхцуулалт, Өмнийн Говийн дотоод бүсчлэлийн урьдчилсан төсөөлөл	104
Зураг 56 Говийн дэд бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ	105
Зураг 57 Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд (салбараар, хувиар)	113
Зураг 58 Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2003-2020) Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)	113
Зураг 59 Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого (2002-2020), Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021)	114
Зураг 60 Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого	114
Зураг 61 “Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр 2010-2020 ...	114

ХУРААНГУЙ

МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны баг “Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг Үндэсний хөгжлийн газрын захиалгаар ОТ ХХК-ийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн.

Монгол улсын УИХ-аар “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” (2001), “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль” (2003) тус тус батлагдаж байсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу энэхүү баримт бичгийн хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болж, түүнийг шинэчлэх үе шатанд ирээд байна. Энэ нь УИХ-аар 2015 онд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж буй цаг хугацаатай давхцаж байна. Үүний зэрэгцээ Монгол улсын Засгийн газраас “Алсын хараа 2050”-г хэлэлцүүлж эхлээд байна.

Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын хэрэгжилтийг хангах, НҮБ-ын ТХЗ-д хүрэх нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын мөн чанар, үүн дээр нэмээд гадаадын хөрөнгө оруулалт, худалдаа, баялгийн үзэл баримтлалыг нэгэн зэрэг батламжлах нь Монгол улсын хөгжлийн үйл явцад зайлшгүй авч үзэх асуудал болж байгаа юм.

Байгаль/хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв байдал их хурдацтай өөрчлөгдөж буй даяаршлын нөхцөлд дэлхийн улс орнууд, түүний дотор хоёр хөрш орон болох ОХУ, БНХАУ-ын геополитик, геоэдийн засгийн бодлогын чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж байна. Тухайлбал, ОХУ нь Зүүн хойд Ази, Номхон далайн орнуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ нь Ази, Европыг холбож байсан торгоны замын худалдаа, эдийн засгийн харилцааг үндэслэн “Бүс - зам” санаачилгыг хэрэгжүүлж, энэ санаачилгад олон орон татагдаж орсон. Хятад-Монгол-Орос гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг батламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

Монгол хүний байгаль эх дэлхийгээ хүндэтгэн хайрлах итгэл үнэмшил, хүн бүрт нийгмийн гарал үүсэлээс үл хамааран тэгш, хүртээмжтэй, ижил чанартай боловсрол, эрүүл мэнд, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл, аюулгүй орчинд өсөн хөгжих боломж, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын зорилтуудад хүрэх хийгээд МХЗ-ыг хэрэгжүүлэх явцад олж авсан сургамж гээд ХХI зууны эхэн үеийн Монголын эдийн засаг – нийгмийн өөрчлөлтийг танин мэдэж, өөрчлөлтөд дасан зохицоход бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал чухал үүрэгтэй юм.

Монгол улсын өргөн уудам газар нутаг, түүний газрын доорхи болон дээрх нөөц баялгийг дотоод, гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахаар бүрэн гүйцэд, зохистой ашиглаж, аймгуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн нийгмийн хөгжил цэцэглэлтэд хүрэх бүрэн боломжтой. Гэсэн хэдий ч хүн амын төвлөрлийг сааруулах талаар хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр, тухайлбал, чөлөөт бүсүүд, аж үйлдвэрийн парк, бүсийн тулгуур төвүүдийн төслүүд нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөв, мөнгөний бодлого ба арга хэмжээтэй харилцан уялдаж чадаагүйгээс үр дүн хангалтгүй, хэрэгжилтийн үр дүн бодитой харагдахгүй байх асуудал хэвээр оршсоор байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын өрсөлдөх давуу талд үндэслэн говийн дэд бүсийн түвшинд өрсөлдөх чадвартай дэд кластерийн стратеги, бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх нь нийгмийн хөгжлийн олон талт оролцогсдыг бүсийн хөгжлийн үйл явцад сонирхлынх нь дагуу холбон уялдуулахад зайлшгүй чухал билээ. Энэ удаагийн судалгаагаар говийн дэд бүсийн дөрвөн аймгийн байгаль/хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн өнөөгийн нөхцөл байдлыг шинжилж, салбарын түвшин дэх хөгжлийн бодлогын баримт бичгийг газарзүйн байршлаар үнэлэн дүгнэж, салбаруудын хөгжлийн харилцан хамаарал ба үр нөлөөг бодитой таньж мэдэх нь олон жилийн хоцрогдлыг даван

туулах, цаашилбал, бодитой хэрэгжүүлж чадаагүй бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэ өнцгөөр харах, хамтын ажиллагааны институцийг шинэ түвшинд хүргэхэд чухал ач холбогдолтой.

Судалгааны үр дүнд үндэслэн Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр нь нийгэм, эдийн засаг, байгаль/хүрээлэн буй орчин гэсэн тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлийг байгаль/хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгэм гэсэн эрэмбээр авч үзэн байгаль/хүрээлэн буй орчин ба эдийн засаг, эдийн засаг ба нийгэм, нийгэм ба байгаль/хүрээлэн буй орчин гэсэн харилцан хамааралд тулгуурласан Ногоон эдийн засгийн тайлбараар баяжуулж, улмаар ТХЗ болон Ногоон хөгжлийн зорилгод ойрын 10 жилд хүрэхийн тулд институцийн шинэчлэлд төвлөрч, нийгмийн хөгжил цэцэглэлтэд оролцогч бүх талуудын үүрэг, хариуцлагыг эрс дээшлүүлэхэд чиглэж байна. Энэ нь зарим төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэгч газар, хэлтэс, нэгжүүд аймгуудад байдаггүй зохион байгуулалтын дутагдлыг нөхөж, үйлдвэр, худалдаа, санхүүгийн урсгалд аймгууд нь байгаль, эдийн засаг, нийгмийн боломжит нөөцөө бүрэн гүйцэд ашиглан аймгийн мезо болон микро түвшин дэх өрсөлдөх давуу талыг бэхжүүлэхийн зэрэгцээ хүчин зүйлс, өрсөлдөөн ба стратеги, эрэлтийн нөхцөлийг ханган салбаруудын харилцан хамтын ажиллагааг дэмжин ажиллахад бодит хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Монгол улсын байгаль/хүрээлэн буй орчин болон нийгэмд тулгарч буй ээдрээтэй олон асуудлыг нөөцийн өрсөлдөх чадвар, микро ба макро эдийн засгийн өрсөлдөх чадвартай уялдуулан шийдвэрлэх арга замыг хамтын хүчээр олж, баялгийн үзэл баримтлал болон гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу дотоод ба гадаад худалдааны тэнцвэртэй, өрсөлдөөнтэй, харилцан ашигтай байдлыг хангах, дөрвөн аймгийн аж ахуйн нэгжүүдийг өртгийн сүлжээний санхүүжилтийн ялгавартай үйлчилгээ хийгээд өрсөлдөөний бодлого (ногоон худалдааны бодлого)-оор дэмжих нь Говийн дэд бүсийн хөгжлийн шинэчлэгдэж буй үзэл баримтлалд чухал байр суурь эзэлнэ.

Монгол улсын Алсын 2050 урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал батлагдаж гарлаа. Мөн Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлага төлөвлөлтийн тухай хуулийг баталсан. Эдгээр урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал болон хууль эрх зүйн зохицуулалтын баримт бичгийн дагуу Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн үзэл баримтлалын төсөл чухал ач холбогдолтой болохыг МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөхүүд болон судлаачдын судалгааны үр дүнгүүд баталж байна.

Цаашид “Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг хэмжихүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой болгохын тулд санхүүжилт, удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтийн механизмыг илүү тодорхой болгох шаардлага тулгарч байгаа билээ.

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Үндэсний хөгжлийн газар нь “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн хамтран боловсруулах чиг үүрэгтэй. Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 15 дугаар тогтоолын 5 дугаар заалтад тус газарт Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах талаар чиглэл өгсөн.

Говийн дэд бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлт, байршлын судалгаа нь “Бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулах ажлын хүрээнд хийгдэж байгаа бөгөөд судалгааны үр дүн, санал, зөвлөмжийг бүсчилсэн хөгжлийн болон тухайн бүсэд хамаарах Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлэх боломжтой.

Энэхүү судалгааг ҮХГ-ын захиалгаар ОТ ХХК-ийн дэмжлэгтэйгээр МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөхүүд судлаачдын хамт жил хагасын хугацаанд гүйцэтгэсэн. Байгаль/хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгэм гээд нийтдээ 17 салбарын нөхцөл байдлыг шинжлэх ухааны янз бүрийн аргад тулгуурлан шинжилж, салбаруудын хөгжлийн бодлогын баримт бичгийг газарзүйн байршлаар судалж, үр дүнг нэгтгэн үзүүлсэн.

Энэ хугацаанд МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөхүүд судлаачдын хамт дөрвөн аймагт хэд хэдэн удаагийн томилолтоор ажиллаж, аймгуудын ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс болон ажлын хэсэгтэй нягт хамтран ажилласан. Олон удаагийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, аймгийн ААНБ, мэргэжлийн салбарын холбоод, төрийн захиргааны байгууллагуудын санал зөвлөмж, тайлбарыг тусган ажилласан.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомжтой уялдуулсан. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”, 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг мөрдөж ажилласан.

Судалгааны зөвлөхүүд салбарын хөгжлийн нөхцөл байдал болон бодлогын шинжилгээг гүйцэтгэж, улмаар Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 2030 он хүртэлх чиглэлийг дөрвөн аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс болон ИТХ-аас санал авах, судалгааны үр дүнд үндэслэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгах санал зөвлөмжийг ҮХГ болон Засгийн газарт, Монгол улсын Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлалд тусгах саналыг УИХ-д тус тус хүргүүлж байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд Говийн дэд бүсийн хөгжлийн өнөөгийн байдал болон бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг газарзүйн байршлаар авч үзэж, шинжилсэн. Улмаар санал болгож буй Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрт гадаад хамтын ажиллагаа, цаашилбал, үндэсний, говийн дэд бүсийн, бусад дэд бүсийн, аймаг хоорондын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргахад анхаарал хандуулах нь нэн чухал гэж үзсэн. Энэхүү дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр нь ойрын 10 жилийн хугацаанд ТХЗ-ын суурь хэрэгжилтийг хангахын зэрэгцээ Ногоон хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлалд үндэслэнэ гэж таамагласан.


Судалгаанд “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”, журамд тусгасан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлого тодорхойлох нөхцөл байдлын дүн шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн заалтуудыг үндэс болгов. Бодлогын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, үзэл баримтлалын төсөл боловсруулахад салбар дундын, бүс хоорондын болон удирдлагын түвшин хоорондын уялдааг хангасан ба хангах арга зүйн хандлага, зарчмыг баримталсан. Үүнд:

- Говийн дэд бүсийн аймгуудын хөгжлийн түвшин, гарааны нөхцөл байдалд шинжилгээ хийх;
- Говийн дэд бүсийг цаашид бие даасан дэд бүсийн жишгээр хөгжүүлэх стратегийн чиглэлийг харуулах, энэ нөхцөлд Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангах, Говийн дэд бүсийн аймгуудын хөгжлийн тогтвортой байдал, тэнцлийг хангах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах шаардлагыг харгалзан үзэх;
- Говийн дэд бүсийн хөгжлийн бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа, дотоод ба гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан түншлэлийг дэмжиж өргөжүүлэх;
- Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх, түүнийг тодотгон сайжруулахад оролцогч талуудын зөвшилцөл, зохион байгуулалтыг тодорхойлох;
- Говийн дэд бүсэд уул уурхай, логистик, хонины ноолуур, торомны ноос, ингэ болон ямааны сүү сүүн бүтээгдэхүүний дэд кластер, онцолсон салбарын өртгийн сүлжээг хөгжүүлэхэд голлон төвлөрөх хандлагатай байх талаар илүү анхаарсан.

Олон улсын түвшний бодлого, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээр; салбар салбарт холбогдох хуулиуд; Монгол Улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд; салбаруудын хүчин төгөлдөр үйлчилж буй бодлого хөтөлбөрүүд; Бүс, аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө; Сумын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө гэх зэрэг баримт бичгүүдийг цуглуулан, ангилах; олон улсын гэрээ, хэлэлцээр ба салбаруудын чиглэлийн бодлого, зорилгыг тодорхойлох; салбаруудын бодлого ба хууль эрх зүйн зохицуулалтад тулгарч буй асуудлууд, улс, бүс, аймгийн бодлогын баримт бичгүүдийн баталгаажилт, хугацаа, зорилго, зорилтын нийцлийг үнэлэх, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлт, уялдаа, залгамж чанар, санхүүжилтийг тодорхойлох, үнэлэх, дүгнэх арга замыг шинжилж, хөгжлийн үзэл баримтлалыг харуулах логик – бүтцийн схемийг зураглах, түүний бүрдэл хэсгүүдийн дэс дараалал, хоорондын уялдаа, гарах үр дүнг системчлэх матрицыг хэрэглэсэн.

Судалгаа нь бүс нутгийн орон зайн төлөвлөлтийн арга зүйд үндэслэсэн.


Зураг 1 Бүс нутгийн хөгжилд нөлөөлөх оронзайн суурь үзүүлэлтүүд



Бүс нутгийн хөгжлийн эдийн засгийн газар зүйн шинэ хандлагад хамаарах бүс нутаг төлөвлөлтийн аналогийн загварт эдийн засгийн бүс нь дотоод буюу дэд бүстэй байх бөгөөд төв бүс, хязгаар бүсүүдэд

мезо түвшинд хуваагдана. Бүс бүр бүлэг суурингийн тогтолцоотой байх бөгөөд гол тэнхлэгийн дагуу орших суурин газар нь бүсийн аль нэг эрэмбийн төвүүд байна. Өөрөөр хэлбэл, дэд бүс бүр нь бүсийн төвтэй байх ба төв, дэд бүсийн төв болох суурин газар нь эдийн засгийн бүсийн төв болж бусад бүс, дэд бүс, суурин газруудыг холбосон тэнхлэгийн дагуу байрших юм. Энэ загварт тэнхлэг, төв, хязгаар гэх үндсэн 3 хүчин зүйлийг харгалзсаны зэрэгцээ макро, мезо түвшний бүсчлэлийг авч үзэн цаашид микро бүсүүдийг тогтоон хөгжүүлэх боломжийг олгоно гэж үзсэн.

Зураг 2 Бүс, дэд бүсийн бичил бүс



Эх сурвалж: Базарханд, Ц., 2015

Бүс нутгийн бүлэг суурингийн тогтолцоог тодорхойлсны үндсэн дээр байгалийн нөхцөл нөөц, газар ашиглалтын байдал, үйлдвэр, уурхайн байрлал, дэд бүтцийн тэнхлэгийг харгалзан төвийн бүсийн 3 дэд бүсийг тогтоосон. Төвийн бүсийн дотоод бүсүүдийг тогтоохдоо байгалийн нөхцөл, нөөц, орон зайн хамаарлыг чухалчлан авч үзээд бүсийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөрт дурдагдсан хөгжлийн чиг хандлагыг харгалзсан үзсэн.

Зураг 3 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх арга зүйн схем



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 4 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтийн ангилал



Эх сурвалж: Судалгааны баг

Судалгааны үр дүнд салбарын хуулиуд нь ТХЗ, ногоон хөгжил болон ногоон эдийн засгийн үзэл баримтлалыг үндэсний ба бүсийн түвшинд харилцан уялдаатай байх, Хөгжлийн бодлогын болон улс, бүс, аймаг, сумын түвшний бодлогын баримт бичгүүдийн усны чиглэлээрх зорилго,

зорилтуудын нийцлийн дүгнэлт; бодлогын баримт бичигт тусгасан салбарын хөгжлийн зорилго зорилтуудын хэрэгжилт, давхардал, дутагдлын үнэлгээ, дүгнэлт; бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилго, зорилт, хэмжүүр, шалгуур үзүүлэлт, хариуцагч эзэн, хүрэх түвшин, хүрэх үр дүнг дэвшүүлсэн байдлын үнэлгээ, зөвлөмжийг боловсруулсан. Гол хүлээгдэж буй үр дүн бол хөгжлийн бодлого төлөвлөлтийн институцийн тогтолцоог бүсийн түвшинд бэхжүүлэхэд чиглэж байгаа юм.

Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын орчинд бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх нөхцөл бүрдэж чадаагүйг хөгжлийн сүүлийн 20 жилийн туршлага харуулсан. Ажиглалтаар яамд болон аймгийн ЗДТГ-ууд харилцан уялдаатайгаар салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийг уялдуулаагүй нь институцийн ой санамж, төрийн байгууллага хоорондын чиг үүргийн шилжилт, тэдгээрийн оновчлол, нэгдмэл нэг үйл хэргийн төлөөх зөвшилцөл үүсэж чадаагүйтэй холбоотой болохыг зөвлөхүүд, судлаачдын судалгааны үр дүнгээр нэгтгэн харуулахад чиглэх болно. Тиймээс бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд салбаруудын харилцан уялдаатай, нэгдмэл, цогц, бие биенийгээ дэмжих үйл ажиллагаа хөгжил дэвшил, цэцэглэлтэд зайлшгүй бөгөөд үр дүн рүү чиглэхэд хүрэлцээтэй гэж үзнэ.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийн үндсэн санаа нь байгаль ба эдийн засаг, эдийн засаг ба нийгэм, нийгэм ба хүрээлэн буй орчин гэсэн эргэх орчлыг харилцан хамааралд нь авч үзэх юм. Эндээс ногоон хөгжил, ногоон эдийн засгийн ойлголт нь шинэ зүйл биш, харин тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлд хүрэхийн тулд нөөцийг зөв, үр дүнтэй ашиглаж, хаягдлын менежментийг хамтатган авч үзэхэд чиглэх болно. Энэ нь ТХЗ 2030-тай нийцэж байгаа бөгөөд ТХЗ-оос бусад зорилгыг илүү татаж чадах нэгээс хоёр зорилгод чиглэх нь бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд салбаруудын харилцан уялдаатай, нэгдмэл, цогц, бие биенийгээ дэмжих үйл ажиллагаа, бүсийн хөгжил цэцэглэлтийг хангана гэж томъёолж байна.

БҮЛЭГ I. ГОВИЙН БҮСИЙН БАЙГАЛЬ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ


1.1 Байгаль

Говийн дэд бүс нь Монгол улсын эдийн засгийн бүсчлэлийн хувьд онцлогтой бүс нутаг юм. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 22.8%-ийг эзлэх 355.1 мянган ам дөрвөлжин км бүхий нутаг дэвсгэрийг хамран оршино. Говийн дэд бүсэд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь гэсэн 4 аймаг багтан тус бүс нь баруун талаараа Баянхонгор, Өвөрхангай аймгууд, хойд талаараа Төв, Хэнтий аймгууд, зүүн талаараа Сүхбаатар аймаг, өмнөд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-той хил залган оршино. Энэхүү бүс нутаг нь газарзүйн байрлалын хувьд зам тээвэр, дэд бүтцийн харьцангуй хамгийн ашигтай байрлалд оршиж, эдийн засгийн гадаад, дотоод харилцааны үндсэн тэнхлэгүүд тухайн бүсийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрнө.

Говийн дэд бүсийн ландшафтын гадны нөлөөнд өртөх эрсдэл

Говийн дэд бүсийн хэмжээнд уулын хээрийн, намагт нугын, говийн, цөлийн, хужир мараат хам бүрдэл, элсэн хуримтлалын гэсэн ландшафтын хэв шинжүүд ялгардаг. Ландшафтын хэв шинжээр ялгаатай нутгууд нь хөрсний үржил шим, биомассаар харилцан адилгүй байх төдийгүй аж ахуйн ашиглалт, нөхөн сэргэх чадвар нь мөн харилцан адилгүй байна.

Зураг 5. Говийн дэд бүсийн ландшафтын гадны нөлөөнд өртөх эрсдэлийн үнэлгээ



Эх сурвалж: Б.Нямдаваа, Алтанболд, МУИС. ЭЗХ. 2020

Говийн дэд бүсийн хэмжээнд нийт нутгийн 3,41 хувийг эзлэх 1 630,8 мянган га талбай нь хөрсний элэгдэл эвдрэлд өртөөгүй нутаг байна. Харин 18,1 хувийг эзлэх буюу нийт 8 676,9 мянган га талбай хөрсний элэгдэл эвдрэлтэй нутаг хамран оршино. Говийн дэд бүсийн өмнөд хэсгээр боржин чулуун тогтоц бүхий 12-20° хэвгийтэй гадаргад Их, Бага газрын чулуу, Ерлөг уул, Их Нарт, Харангат, Модот шивэр, Мухар шивэр, Ногоон чулууны ам, Гурвансайхан, Зөөлөн, Эргэлийн зоо Гэгээтийн хөндий зэрэг өвөрмөц сонин тогтоц бүхий газрууд багтана. Говийн дэд бүсийн хэмжээнд 15,1 хувийг эзлэх

буюу нийт 6 764,5 мянган га талбай нь хөрсний элэгдэл эвдрэлийн ангиллаар “дунд” гэсэн зэрэглэлд хамрагдаж байна. Уулын хээрийн хүрэн хөрс, уулын карбонатгүй ба бага карбонаттай хүрэн шороон хөрс, уулын хүрэн хөрс гэх мэтийн хөрс давамгайлан тархсан. Уулын хээрийн ландшафт бүхий тавиу энгэр хажуу, ойтой шууд залгах хэсэгт чийгийн хэмжээ харьцангуй ихсэх тул ургамалд нугархаг шинж мэдэгдэхүйц ихсэнэ. Тухайлбал, Дундговь аймгийн Дэрэн сум багтана.

Гадны нөлөөнд хүчтэй өртөх эрсдэлтэй нутаг ангилалд хөрсний ялзмагт үе давхарга 50-75 хувь буюу хөрсний элэгдэл эвдрэлийн ангиллаар “их” гэсэн зэрэглэлд багтах уулын цөлөрхөг хээрийн бор хөрс, заримдаг говь, цөлийн бор саарал хөрс, мөн голын татам аллювийн хөрс буюу нуга намгийн хөрс тархан өнгөн хэсэгтээ хүлэржсэн янзтай байх бөгөөд хайргат, сайргат хэв шинжийн хучаастай. Ландшафтын хувьд элс нь дотроо хэд хэдэн бүлэг төрөлд хувагдах бөгөөд далан, довцог, бүрхэвч, манхан хэв шинжийн элс зонхилохоос гадна бутны довцог, хунгар элс, сайрын элс зэрэг жижиг хэлбэрийн элс тархсан байдаг. Ургамалжилтын хувьд хялгана, ерхөг, таана, хазаар өвс, шарилж, ортууз, харганаас бүтсэн дэгнүүлт үетэнт, заримдаг сөөгөнцөр-дэгнүүлт үетэнт бүлгэмдэл голлох ба энэ нь тачир ургамалтай төдийгүй харьцангуй сийрэг юм. Хэмжилт хийхэд 1 м² талбайд 3 зүйлийн ургамал бүртгэгдсэн, нийт ургац 30-40%, дунджаар ургамал нөмрөг тачир сийрэг, голлон ургах хармаг дунджаар 50 см өндөртэй байхаас гадна хүчтэй салхины нөлөөгөөр энэ тэнд хармагийн бутанд хурж тогтсон довцог элс үүссэн байх нь элбэг. Загт элсэн хучаас бүхий хотгорт торлог, сухай, хармаг, алтан харгана, бор шаваг, бударгана, нохойн шибээ буюу хялганат хээрийн ургамалтай хил залган алаглан ургах боловч хоолой болон шалын элстэй төв хэсгээс жинхэнэ тал хүртлэх нарийн зурвас газраар толболсон өвөрмөц хэв шинжийг үүсгэн оршино. Гадаргын хувьд ухаа гүвээт тал, уулс хоорондын томоохон хотгор, хөндий хоолой энд хамрагдана. Дундговь аймгийн нутагт хуурай хээр болон говийн ландшафт өргөн зурвасаар бүслэг байдлаар хамгийн тод ажиглагдах бөгөөд Говьсүмбэрийн хойд хэсэг, Хар айраг сумын баруун урд хэсэг, Улаанбадрах сумын нутагт орших Борхойн тал, Хөвсгөл сумын нутагт /х.ө. 43°32', з.у.109°58' / болон Хонгорын элс, Халтар загийн элс, Өлзийт сум, Хулд, Тэвшийн говь, Дэлгэрцогт сумын хойд хэсэгт тархах бөгөөд хөндийн ёроол хэсэгт жижиг тойром мэр сэр тохиолдоно. Энэ ангилалд багтах нутаг нь төв бүсийн говийн дэд бүсийн нутгийн 34,09 хувийг эзлэх буюу 16 773,1 мянган га талбайг хамран оршино.

Гадны нөлөөнд маш хүчтэй өртөх эрсдэлтэй нутаг ангилалд хөрсний ялзмагт үе давхарга 75< хувь буюу хөрсний элэгдэл эвдрэлийн ангиллаар “их” гэсэн зэрэглэлд багтах хэт хуурай цөлийн борзон хөрс, шалын бор, саарал хөрсөн бүрхэвчтэй ургамал нөмрөгийн бүрхэц 25-30%, 1 м² талбайд дунджаар 3 зүйл ургамалтай сийрэг тархалттай хэт гандуу цөлийн ландшафт хамаарна. Энэхүү ландшафт нь Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь аймгуудын нутгийн урд хэсгээр улсын хил хүртэл өргөн тархсан байна. Умардын цөлийн ландшафт нь Гурван тэс, Жарангийн элс, Хонгорын элс, Галбын говь, Өөшийн говиор тархсан. Гадаргын үнэмлэхүй өндөр 800-1400 м-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд түүнд хужир, марз цөөнгүй тохиолдоно. Ийм ухаа гүвээт талын дунд энд тэнд ганц нэг буюу хэсэг бүлэг толгод товойж харагдана. Ухаа гүвээт тал дундах жижиг хотсоос гадна том хотгорууд чухал суурийг эзлэх бөгөөд ихэвчлэн зүүн хойноос баруун урагшаа сунаж тогтсон байна. Элсэн хуримтлал үүссэн байх нь олонтаа тохиолдоно. Цөлийн бүсэд тархсан элсэн хуримтлал нь зарим ургамлын амьдралын хөгжлийн үе шатуудтай холбоотойгоор үүсэж хөгжсөн. Тухайлбал, молцог элс сухайн, довцог элс хармагийн, далан элс загийн өсөх хөгжих, буурах бүх хандлагатай холбоотой байх тул цөлжилтийн бүсэд голлох хэв шинжийн элсийг бүрдүүлдэг дээрх ургамлын тухайд элсний нүүлт хөдөлгөөнд идэвхтэй нөлөө үзүүлдэг. Юуны өмнө эдгээр ургамал нь бие даасан элсний хэлбэрийг үүсгэж, элсийг барьж тогтоох бөгөөд энэ нь хөгжлийн хэд хэдэн үе шатыг дамждаг ажээ. Хужир-мараат хам бүрдэл маш бага хэмжээгээр энд тэнд толбо байдлаар тааралдах бөгөөд баглуур, бор бударгана, хармаг, зэгс, дэрс, бор бударгана-шар бударгана бүлгэмдлүүд голлоно.

Говь, цөлийн бүсэд нэн түгээмэл хотгор гүдгэрийн хэлбэр бол хотгор хоолой газар юм. Тэдгээрийн хэлбэр дүрс, хэмжээ янз бүр ч гэсэн өргөн их хэмжээний хотгор ихээхэн нийтлэг бөгөөд тийм хотгорын гадарга тэгш буюу дотоод хэсэг рүүгээ үл ялиг хэвгий учраас ёроолд нь нуур, хужир, шал тойром тогтсон байдаг. Говийн дэд бүсийн хэмжээнд Давст нуур, Улаан нуур, Хонгорын элс, Галбын говь, Долоодойн говь, Холбоогийн тал зэрэг газруудыг дурдаж болно. Монгол орны хуурай гандуу бүс нутгийн цөлжсөн газрын талбай 3,4 хувиар нэмэгдсэн хэмээн үзсэн. /Д.Даш, 2000/. Өмнөговь аймгийн Баяндалай, Гурвантэс, Цогцэций, Баян-Овоо, Номгон зэрэг сумдын нутагт довцог, молцог, далан элсийг үүсгэгч хармаг, сухай, заг нь гадны нөлөөнд өртөн өсөлт хөгжилт нь удааширч ялангуяа хүн малын нөлөөгөөр эвдэрч устах хандлага илүүтэй байгаа нь ажиглагдаж байна. Жишээлбэл, Өмнөговь аймгийн Баян-овоо сумын урдуур орших Сүүжийн говийн Дайчин, Таван алд, Зээмэгийн заг, Ханбогд сумын зүүн урд орших Онгон, Саглар, Хар заг, Номгон суманд Гурван гүний хоолойгоос эхлэн Хүрмэн, Баяндалайн урдуурх Гурванбөхтийн заган ойн нөөц байхгүй болж, энд тэнд алаг цоог тархалттай үлдсэн. Төв бүсийн говийн дэд бүсийн хэмжээнд 29,3 хувийг эзлэх буюу нийт 14 018,5 мянган га талбайг хамран оршино.

Ландшафт-нутаг дэвсгэрийн төлөвлөлт, бүсчлэл

Говийн дэд бүсийн хэмжээнд ландшафт гадны үйл ажиллагаанд өртөж, улмаар тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж байгаа нь тогтоогдсон. Ландшафтын энэхүү өөрчлөлтөнд хүний үйл ажиллагаа зонхилох үүрэг гүйцэтгэж байна.


Ландшафтын төлөвлөлт нь амьдралыг дэмжих систем болох ландшафтуудын үндсэн үйл ажиллагаа болон байгаль ашиглалтын тэнцвэртэй байдлыг хангаж байгаа тодорхой ландшафт дахь нийгмийн үйл ажиллагааны орон зайн зохион байгуулалтыг хийхэд ашиглаж байгаа нэгдмэл арга зүйн хэрэгсэл, мөн байгаль хамгаалах асуудлын зөрчилдөөнийг шийдэх, зохистой төлөвлөлт бүхий үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх арга хэмжээг боловсруулах, байгаль ашиглагчдын сонирхолыг хангах, байгаль хамгаалах бүх субъектууд ба нутаг дэвсгэрийн төлөвлөлттэй аж ахуйн үйл ажиллагааг нэгтгэсэн нэгдмэл үйл явц юм.

Ландшафт-нутаг дэвсгэрийн ашиглалтын зохистой бүсчлэл нь байгалийн нөхцөл, нөөц, орон зайн бүтэц, геосистемд үзүүлж байгаа хүний ачаалал, аж ахуйн үйл ажиллагаа, түүнийг хязгаарлаж байгаа чадавхийн судалгаанд үндэслэн боловсруулагдсан. Энэ судалгааны гол ач холбогдол нь ургамал, амьтан, хөрс, ус, уур амьсгал, түүнчлэн хүн амын аж ахуйн үйл ажиллагаа, газар ашиглалтын орчин үеийн байдал болон байгалийн чадавхи, нутаг дэвсгэрийн эдийн засгийн хөгжлийн судалгаанд үндэслэн байгаль-нутаг дэвсгэрийн ялгааг гаргасанд оршино.

Говийн дэд бүсийн ландшафт ашиглалтын өнөөгийн төлөв байдал, түүний гадны нөлөөлөлд өртөх эрсдэлийг үнэлсэн үнэлгээ, хээрийн судалгаагаар бүрдүүлсэн анхдагч мэдээ, материалд тулгуурлан газар цаашид ашиглах газар ашиглалтын үндэс болж байгаа ландшафт-нутаг дэвсгэрийн ашиглалтын зохистой 7 бүсийг ялган тогтоосон болно. Үүнд:

- I. Гадны нөлөөнд сулавтар өртөж байгаа хамгаалагдсан бүс
- II. Гадны нөлөөнд сул өртөж байгаа бэлчээр ашиглалтын бүс
- III. Гадны нөлөөнд дунд зэрэг өртсөн нөхөн сэргээж зохистой ашиглах бүс
- IV. Гадны нөлөөнд хүчтэй өртөж байгаа ачаалал ихтэй бүс
- V. Гадны нөлөөнд хүчтэй өртөж байгаа уул уурхайн ашиглалтын бүс
- VI. Гадны нөлөөнд хүчтэй өртсөн нөхөн сэргээх шаардлагатай бүс
- VII. Гадны нөлөөлөлд хүчтэй өртсөн элсжиж байгаа бүс нутаг

Зураг 6. Монгол орны төв бүсийн говийн дэд бүсийн ландшафт нутаг дэвсгэрийн зохистой бүсчлэл



Эх сурвалж: Б.Нямдаваа, Алтанболд, МУИС. ЭЗХ. 2020

Гадны нөлөөнд сулавтар өртөж байгаа хамгаалагдсан бүсэд нийтдээ 6 460 810 га нутаг дэвсгэр хамрагдахаас Говийн бага дархан цаазат газрын “А”, “Б” бүс 1 830 429,36 га, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын 20 229,3 га, Нагалхан уулын байгалийн нөөц газрын 1 860,7 га, Их нарт 66 591,7 га, Загийн ус 273 571,2 га, Арваннайман Богд 25 670,2 га, Бүрдэнэ булаг 36 159,4 га, Эргэлийн зоо 59 839,5 га зэрэг байгалийн нөөц газрын, Сүйхэнт уулын байгалийн дурсгалт газрын 4 827,3 га талбай тус тус орно. Дархан цаазат газрын бүсэд байгалийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалах, байгалийн үзэгдэл үйл явцыг өөрийн нь хөгжил хөдөлгөөд судлах, байгаль хамгаалах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зорилготой байгуулагддаг удаан хугацаагаар хамгаалж судлахаар аж ахуйн үйл ажиллагаанаас чөлөөлөгдсөн нутаг дэвсгэр ордог. Байгалийн цогцолборт газар нь экологи, түүх, гоо зүйн хувьд онцгой ач холбогдолтой хүн амын амралт, аялал жуулчлалд зориулагдсан газар юм. Зөвшөөрөгдсөн хязгаарлалтын бүсэд зохион байгуулалттай аялал жуулчлал хөгжүүлж, зүй зохистой ашиглахаас өөр зорилгоор аж ахуйн үйл ажиллагааг бүрэн хориглосон бүс байх шаардлагатай. Байгалийн нөөц газар нь тодорхой хугацаанд байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авагдсан газар юм. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой нөөц баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэнд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр уламжлалт аж ахуй эрхэлнэ.

Гадны нөлөөнд сул өртсөн бэлчээр ашиглалтын бүсэд говийн дэд бүсийн 26 236 694.6 га талбай буюу бэлчээр, хадлангийн талбайн ихэнх нь хамрагдана. Хамрагдах бэлчээр, хадлангийн талбайн хэмжээг аймгуудаар авч үзвэл Говьсүмбэр аймаг 458 154,4 га, Дундговь аймаг 7 163 480,8 га, Дорноговь аймаг 7 163 480,8 га, Өмнөговь аймаг 11 451 578,6 га талбайтай. Энд бэлчээрийн мал аж ахуйн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байгаа бүс нутаг орох ба хүний үйл ажиллагааны нөлөөнд бага өртдөг уул, тал, хээр, говь, цөлийн ландшафт давамгайлна. Аж ахуйн ашиглалтын гол чиглэл нь мал аж ахуй, тээвэр юм. Монгол орны төв бүсийн говийн дэд бүсийн хэмжээнд бэлчээрийн ургац,

даацаас хамаараад мал сүрэг жигд биш тархалттай байдаг тул бэлчээрийн даац нь ерөнхийдөө хэтэрсэн. Малын тоо толгойг хэт өсгөхгүй тохиолдолд цаашид энэ хэмжээнд нь сэлгэн ашиглах боломжтой. Үүний тулд одоо байгаа сүргийн бүтцийг хэвээр нь хадгалах, цаашид адуу, ямааны тоо толгойг хязгаарлах шаардлагатай. Говийн бүсэд ачаа болон зорчигч тээврийн гол гол замууд байдаг. Хэдийгээр аймгуудын төвийг нийслэл Улаанбаатар хоттой холбосон хатуу хучилттай зам барьж байгуулж байгаа боловч аймаг хооронд, сум хооронд орон нутгийн чанартай олон салаа замуудтай, үүнийг арилгах, сум суурин газруудыг засмал замаар холбож хөрсний эвдрэлийг багасгах шаардлагатай. Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын малын бэлчээр бүхий газар нутгийн дийлэнх нь бэлчээрийн усан хангамж муутай тул бэлчээрт бага ашиглагддаг. Харин гол, горхи, нуур цөөрөм, булаг шанд, худаг зэрэг уст цэгийн ойр орчимд бэлчээрийн даац хэтэрсэн байгаа тул ашиглагдахгүй байгаа бэлчээрийг усжуулах, уст цэгийн ойр орчмын бэлчээрийг өнжөөх, сэргээн сайжруулах шаардлагатай.

Гадны нөлөөнд дунд зэрэг өртсөн нөхөн сэргээж зохистой ашиглах бүсэд 1 426 581 мян/га нутаг буюу хүний үйл ажиллагаанд маш ихээр өртсөн, нөхөн сэргээж сайжруулах зайлшгүй шаардлагатай заган ой бүхий нутаг хамрагдана. Монгол орны говийн бүсэд манай орны заган ойн 30,7 % (1 426 581 мян/га) оршино. Энэ бүсэд Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн заган ой тархсан нутаг тус тус хамрагдаж байна. Заган ойн ашиглалтын энэ бүсэд модыг төлөвлөлтгүй хэт их огтолсноос нөөц багасаж, түүний хил хязгаар хумигдаж, дагалдах ургамал бүрхэвч сийрэгжин улмаар идэш тэжээлийн хомсдолоос ан амьтан ховордон устах, зарим нь дайжин тархалтын хилээ өөрчлөх болсон. Иймд юуны өмнө заган ойг зохистой ашиглах, нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай. Энэ бүсэд ойн ландшафтыг давуу хамгаалах хэрэгтэй.

Гадны нөлөөнд хүчтэй өртөж байгаа ачаалал ихтэй бүсэд Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт орших аймаг, сумын төв, суурин газрын эдэлбэр нутаг хамрагдана. Эдэлбэр газрын хэмжээг аймгуудаар авч үзвэл, Говьсүмбэр аймгийн хот суурин газрын эдэлбэр талбай 19 845,1 га, Дундговь аймгийн хот суурин газрын эдэлбэр талбай 41 450,2 га, Дорноговь аймгийн хот суурин газрын эдэлбэр талбай 41 450,2 га, Өмнөговь аймгийн хот суурин газрын эдэлбэр талбай 44 310,7 га байна. Энэ бүс нутагт байгалийн хам бүрдлүүд бүрэн эвдэгдсэн, хүний байгальд үзүүлэх нөлөөлөл нь эргээд гамшигийн хэмжээнд хүртэл буюу бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэд дахин их болсон Хар-Айраг, Чойр, Бор-Өндөр, Мандалговь, Даланзадгад, Сайншанд зэрэг агаар, хөрс, усны бохирдолтой суурин газрууд, ургамал бүрхэвчээ хамгаалах чадавхи бага, хүчтэй эвдэрсэн, маш их эзмэг элсэрхэг хөрс бүхий говь цөлийн ландшафт бүхий нутгууд орно. Ихэнх суурин газарт ногоон талбайн тоог хэмжээг зайлшгүй нэмэгдүүлэх, түүний эргэн тойронд чөлөөт ногоон байгууламж байгуулах, суурин газрын нутаг дэвсгэрийг ногоон ургамлаар хэсэгчлэн хувааж байгалийн ландшафтад ойртуулах, утаа болон хортой бодис, чимээ шуугианы эх үүсвэрээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Эрчимтэй ашиглалтын хил дотор багтаж буй орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжихгүй, түүнд саад тотгор болж буй аж ахуйн нэгж байгууллагад хүрээлэн буй байгаль орчинд үзүүлж буй хортой нөлөөлөл, учруулж хохирлын хэмжээгээр торгууль ноогдуулах, тэдгээрийн, байгаль болон хүнд ихээхэн аюул учруулж байгаа хортой ачааллыг устгах хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг дэмжих зорилготой юм.

Гадны нөлөөнд хүчтэй өртөж байгаа уул уурхайн ашиглалтын бүсэд говийн дэд бүсийн нутгийн 24 438,65 га талбай хамрагдаж байна. Энд олборлолт явуулж буй уул уурхайн ашиглалтын бүс болох уурхайн тосгон, уурхайн зам, карьер, ухсан нүх, овоолго шороо, ухсан нүх, хотгор, тунгаагуурын нуур, цөөрөм, хайрга бүхий хөрс, ургамал бүрхэвч нь бүрэн устаж, гадаргын хэлбэр төрх нь бүхэлдээ хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдөж байгалийн унаган төрх нь алдагдаж

байгаа нутаг орно. Уул уурхайд ашиглагдаж байгаа талбайг аймаг тус бүрээр авч Говьсүмбэр аймагт 745,0 га талбай, Дорноговь аймагт 1 999,2 га талбай, Өмнөговь аймагт 14 586,0 га талбай, Дундговь аймагт 7108,45 га талбайд тус тус олборлолт явуулж байна. Энэ бүсэд хамрагдаж байгаа нутгуудаас хамгийн их анхаарал татаж байгаа нэг асуудал бол хуучин ашиглаж дууссан алт, жоншны уурхайн хагас дутуу нөхөн сэргээлт хийсэн, огт хийлгүй орхисон талбайнуудад олон зуун мянган гар аргаар алт олборлогчид алт олборлон жилийн турш суурьшмал байдалтай болж ихээхэн талбайг эвдэн сүйтгэж байна.

Гадны нөлөөлөлд маш хүчтэй өртсөн ашиглалтаас бүрэн чөлөөлж сэргээн сайжруулах бүсэд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээс гадна алтны үндсэн ба шороон ордын ашиглалтын улмаас химийн хорт бодис маш ихээр хуримтлагдаж тэр нь хүн, байгальд онцгой хор нөлөө үзүүлж байгаа, цаашид үзүүлэх хор нөлөө нь улам ихсэх хандлагатай байгаа ордуудыг ашиглалтаас бүрэн чөлөөлж хоргүйжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай. Энэ бүсэд 37773 га нутаг дэвсгэр буюу уул уурхайн ашиглалт явуулж дууссан ямар нэгэн нөхөн сэргээлт хийлгүй орхисон том том ухмал карьер, овоолго шороо, хайрга бүхий хөрс, ургамал, газрын гадарга нь бүхэлдээ хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдөж байгалийн унаган төрх нь алдагдсан бүс нутаг орно. Энэ талаар явуулсан судалгааны материалаас үзэхэд хөрсөн дэх мөнгөн усны дундаж агуулга Европын холбооны стандартад заагдсан хэмжээнээс Манлай, Цогтцэций, Цогт-Овоо, Ханбогд, Даланзадгад, Номгон, Хүрмэн, Гурвантэс, Ноён суманд 2.24-22.9 дахин их байна. Хөрсөн дэх цианитын агуулга зөвхөн Гурвантэс суманд дээрх стандартад заасан хэмжээнээс их байна. Мышьякийн хөрсөн дэх агуулга Цогтцэций, Ханбогд, Даланзадгад, Сэврэй суманд дээрх стандартад заасан хэмжээнээс их байна. Ноён сумаас авсан усны дээжин дэх цианитын дундаж агуулга нь 0,07 мг/л байгаа нь үндэсний стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 7 дахин их байна. Өмнөговь аймгийн 12 сумын нийт 111 цэгт хуримтлагдсан 36 373 метр куб /54559 тн/ шлам, хаягдлыг Ханбогд сумын Дөрвөлжин тээг, Баяндалай сумын Чулуут нуруу гэдэг газруудад байгуулсан хаягдлын санд төвлөрүүлж, химийн хорт бодисоор бохирдсон 57 573 метр квадрат талбайд хөрс хуулалт хийсэн.

Гадны нөлөөлөлд хүчтэй өртсөн элсжиж байгаа бүс нутагт Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын нутагт орших томоохон элсэн хуримтлал болон элсний нүүлтэд өртсөн, цөлжсөн газар нутаг орно. Монгол орны төв бүсийн говийн дэд бүсийн хэмжээнд Дорноговь аймгийн нутагт орших Далайн элс, Хулгарын элс, Нарийн элс, Бүргэдийн элс, Сүүдэртийн элс, Цагаан Овооны элс, Өмнөговь аймгийн нутагт орших Төхөмийн элс, Хонгорын элс зэрэг арав гаруй томоохон элсэн тарамцагууд хамрагдана. Энэ бүсийн хэмжээнд сүүлийн 30 орчим жилийн хугацаанд нийтдээ 1800 га талбайд шинээр элс үүссэн байна. Аймгуудаар авч үзвэл, 2012 оны байдлаар Говьсүмбэр аймагт 1705 га, Өмнөговь аймагт 96,4 га талбай элсэжсэн. Шинээр элсжиж байгаа нутагт ямар нэг ашиглалтын үйл ажиллагаа явуулахгүй, элсний нүүлтийг ургамал бүрхэвчээр тогтворжуулах, сайжруулах замаар элсний ландшафтыг хамгаалах шаардлагатай. Ургамлаар нөхөн сэргээлт хийх нь салхины хүчийг зохих хугацаанд бууруулж хөдөлгөөнт элсийг үндсээрээ бэхлэн салхинд хийсэж нүүхээс нь найдвартай хамгаалахын зэрэгцээ ус, чийгийн горимыг зохицуулж байгалийн тэнцвэрийг бий болгож байдгаараа үлэмж ач холбогдолтой. Хөдөлгөөнт элсийг ургамалжуулан бэхжүүлэхдээ олон наст өвслөг ургамал, сөөгийг үр болон мөчрөөр тарих, суулгацыг шилжүүлэн суулгах аргыг хэрэглэн нөхөн сэргээлт хийх шаардлагатай. Мөн элсжиж байгаа газар нутагт мал бэлчээрлүүлэх, аж ахуйн үйл ажилагааг бүр мөсөн зогсоох хэрэгтэй.

Гадаргын ус

Говийн дэд бүсэд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудыг хамруулсан. Эдгээр аймагт гадаргын ус багатай түр зуурын уруйн ус урсах хуурай сайрууд түгээмэл байдаг. Хүн амын

унд ахуйн болон мал аж ахуй, үйлдвэрлэлийн ус хангамжийн багахан хэсгийг тус бүс нутагт орших булаг, шанд, баянбүрдийн усаар хангадаг.

Монгол Улсад зохион байгуулагдсан усны тооллогын дүнгээс үзэхэд гол горхи, булаг шанд, рашаан, нуур, тойром 1022 тоологдсон нь улсын дүнгийн 10.7% бөгөөд гадаргын усны дийлэнх буюу 85%-ийг урсац багатай булаг, шанд эзэлж байгаагийн дээр ус элбэгтэй 2017 онд 2007 онтой харьцуулахад тоо хэмжээ нь буурсан нь тус бүс нутгийн гадаргын усны хомсдол, эмзэг байдлыг харуулж байна. Говийн дэд бүсийн гадаргын усны нөөц нь Монгол орны гадаргын усны нийт нөөцийн 0.03 хувийг эзэлдэг.

Хүснэгт 1. Гадаргын усны тооллогын дүн

Аймаг	Гол горхи		Булаг шанд		Рашаан		Нуур, тойром	
	2007	2017	2007	2017	2007	2017	2007	2017
Говьсүмбэр	1	5	6	13	3	2	13	1
Дорноговь		1	363	289	4	6	6	111
Дундговь	1	1	152	124	3	4	2	10
Өмнөговь	3	4	581	442	1	10	2	21
Бүгд дүн	5	11	1,102	868	11	22	23	143
Улсын дүн	5,128	5,228	9,306	10,742	429	450	3,747	3,598

Эх сурвалж: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2400_011V1

Тус бүс нутгийн булгуудын ус геоморфологи, геологи, гидрогеологийн нөхцөлөөс шалтгаалан анион, катионы концентраци өндөртэй, эрдэсжилт ихэвчлэн 300-1500 мг/л-ийн хооронд хэлбэлздэг. Гадаргын ус бүхий газруудад мал сүргийн бөөгнөрөл өндөр байдгаас аммоний агууламж 0.5 мг/л-ээс давж бохирдох тохиолдол элбэг гардаг байна.¹ Түүнчлэн тус бүс нутагт уул уурхай эрчимтэй хөгжиж, түүнийг дагалдан хот, суурин газар өргөжин, ус хэрэглээ нь нэмэгдэж, энэ нь ховор, хомс гадаргын усны ундарга, урсацыг бууруулах, бохирдуулах зэргээр тухайн орчны экосистемд сөрөг нөлөөлөх үзүүлэх явдал нэмэгдсээр байна.

Газрын доорхи ус

Уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор тус бүс нутагт газрын доорхи усны судалгаа сүүлийн жилүүдэд нилээд идэвхтэй хийгдэж, хяналт мониторингийн асуудал ч анхаарлын төвд байх болжээ. ДБ-наас 2010 онд Өмнөд говийн бүс нутгийн газрын доорхи усны үнэлгээ хийгдсэн байдаг. Энэхүү судалгаанд тус бүс нутгийн газрын доорхи усны ихэнх нь маш бага тэжээлтэй эсвэл тэжээлгүй дарагдмал ус байдаг гэж тодорхойлсон.

¹ Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, “Дунар-орд” ХХК, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан суурь судалгааны эмхэтгэл, Улаанбаатар, 2018 он

Хүснэгт 2. Говийн дэд бүсийн аймгуудын газрын доорхи усны нөөц, баялгийн тооцоо

№	Уст давхаргын ангилал	Авч болох усны хэмжээ, $10^3 \text{ м}^3/\text{жил}/\text{км}^2$	Тогтоосон газрын доорхи усны ашиглаж болох нөөц, сая $\text{м}^3/\text{жил}$		
			Дундговь	Өмнөговь	Дорноговь
1	Их нөөцтэй	>1	25	31	19
2	Дундаас их нөөцтэй	0.1-1.0	77	138	71
3	Багаас дунд нөөцтэй	0.03-0.1	2	89	19
4	Бага нөөцтэй	0.003-0.03	3	3	4
5	Хязгаарлагдмал	<0.003	0	0	0
6	Нийт		107	261	113

Эх сурвалж: Н.Жадамбаа, Н.Буянхишиг нар, 2007 он, Өмнөд говийн бүс нутгийн газрын доорхи усны үнэлгээ

Монгол орны нутаг дэвсгэрийн өмнөд хэсэгт буюу говийн бүсэд олж илрүүлэн, усны ашиглалтын нөөцийг нь тогтоосон газрын доорхи усны ордуудын дийлэнх нь цэрдийн галавын сэвсгэр хурдсанд орших уст үе, давхаргад байдаг. Усны нөөц нь 1.0- ээс 1100 л/с байх ба ус нь дийлэнх тохиолдолд цэнгэг буюу усны эрдэсжилт дийлэнх тохиолдолд 1.0-1.5 г/л-ээс бага байна.² Говийн дэд бүс нутгийн ундарга (өндөр болон дундаж ундаргатай) сайтай уст давхаргууд хуурай сайр, уулын бэлд аллювийн элс, хайрган хурдсанд агуулагдана. Энэ уст давхаргууд нь бага гүнтэй ($< 50\text{м}$) тохиолдох ба мал аж ахуй, унд ахуйн ус хангамжийн гол эх үүсвэр болдог. Ихэнх ундрага сайтай уст давхаргууд их гүнд элсэн чулуунд тохиолдоно. Говийн дэд бүсийн уст давхаргууд нь өргөн талбайд ижил геологийн структурт оршин ундарга сайтай ч өргөн тархалттай биш. Ус нэвтрүүлэх чадвар сайтай формациуд (уст давхарга) хязгаарлагдмал тархалттай ус нэвчүүлэх чадвар муутай, уст давхрага болж чадахгүй чулуугаар хүрээлэгдсэн байдаг.³

МХЕГ-аас 2012, 2013 онд нэгдсэн төлөвлөгөөний дагуу улсын хэмжээнд “Хот, суурин газрын хүн амын унд, ахуйн ус хангамжийн усны чанар, аюулгүй байдалд” хийсэн хяналт шалгалтын дүнгээр усны чанарын хувьд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгууд хатуувтар, Өмнөговь аймаг хатуу устайд хамаардаг гэсэн дүгнэлт гарсан.

Говьсүмбэр аймагт томоохон гол байхгүй, 2017 оны усны тооллогоор 5 горхи, 13 булаг, 2 рашаан, 1 нуур тойром бүртгэгдсэн байна (Хүснэгт 1). Чойр орчмын бус нутаг геологийн тогтоцын хувьд ихэнх талбайд Дээд Цэрдийн элс, хайргархаг сул барьцалдсан хурдас ба Доод Цэрдийн шаварлаг хурдас тугээмэл тархсан. Дээд Цэрдийн галавын хурдаст усны нөөц илуу тархалттай бөгөөд судалгаанд хамрагдсан нийт уст цэгийн тал хувь нь стандартаас давсан эрдэсжилттэй, 60 орчим хувь нь магнийн ион зонхилсон хатуу устай байна. Энэ бүгдээс үзэхэд тус бус нутгийн усны чанар

² БОАЖЯ, Хөгжлийн тлхүүр ус, 2018 он

³ Туинхоф.А, Н.Буянхишиг нар, Өмнөд говийн бүс нутгийн газрын доорхи усны үнэлгээ, ДБ, 2010 он

төдийлэн сайнгуу байгаа учир чанарыг сайжруулж унданд хэрэглэх явдал зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна.⁴

Говьсүмбэр аймагт Шивээ-овоо, Тэвшийн говь гэсэн газрын доорхи усны 2 орд байна.⁵ Сүмбэр сумын (Чойр хот) унд ахуйн усны эх үүсвэр нь Тэрэгтийн худаг юм.

2008 онд Н.Мөнхбаатар, М.Жаргалсайхан нар Чойрын хотгорын өмнөд хэсэгт хийсэн гидрогеологийн судалгаагаар доод цэрдийн зүүнбаянгийн дээд дэд свитийн нүүрслэг зузаалгын уст давхаргад нөөцийн үнэлгээ өгсөн. Энэхүү газрын доорхи усны ордын усны ашиглалтын нөөц баялгийн үнэлгээ хийгдсэн Жаргалант нуурын орд нь Хараатын ураны ордын хойт хэсэгтэй залган байрлана. Орд нь доод цэрдийн зүүнбаянгийн дээд дэд свитийн нүүрслэг зузаалагт агуулагдах ба ус агуулагч чулуулаг нь элс, сул барьцалдсан элсэн чулуу, алевроит, хайрга, гравелит, хүрэн нүүрснээс тогтдог, нийт талбай нь 246.2 км², уст үеийн дундаж зузаан нь 48.5 м. Ордын гидрохимийн нөхцөл нийлмэл бөгөөд ордын өмнөд хагаст давсархаг, давстай (3-11,8г/л), хойд хагаст сул давсархаг (1-3г/л), баруун, зүүн захаар цэнгэг (1г/л хүртэл) ус тархсан байна. Жаргалант нуурын ордыг үйлдвэрлэлийн зэргээр 25 жилийн туршид үнэлсэн газрын доорхи усны ашиглалтын 11,232 м³/хоногийн нөөцийг С₁ зэргээр үнэлэн баталгаажуулсан.⁶

Дундговь аймаг мөн гадаргын ус багатай, 2017 оны усны тооллогоор гол горхи 1, булаг шанд 124, рашаан 2, нуур тойром 10 бүртгэгджээ. Энэ мужид олон жилийн гадаргуун усны урсац хэмжээ 0.5-0.7 мм/жил байна. Гадаргын усны эх үүсвэрийг хэдийгээр малын ус хангамж, унд ахуйд бага зэрэг хэрэглэж байгаа боловч, гадаргын усны ашиглах боломжит нөөц байхгүй гэж тооцдог.

Дундговь аймагт газрын доорхи усны нийт 17 орд газар байгаагаас танилцуулбал, Мандалговь хотын төвийн Олгойн говь-2 усан хангамжийн газрын доорхи усны ордод 1989 онд Н.Лхагва, Б.Нямдарь, Л.Батжаргал нар ашиглалтын нөөц баялгийн үнэлгээ өгсөн байдаг. Тус ордын ус агуулагч чулуулаг нь доод цэрдийн Түвшинговь давхраадсын нүх сүвтэй терриген хурдас болно. Ус агуулагч хурдас ордын хүрээнд даралтгүй ус тархсан. Газрын доорхи ус 8.2-24.0 м-ээс илэрнэ. Уст давхаргын зузаан нь 14.0-50.0м байна. Цооногууд дахь усны түвшинг 20.0-27.85м бууруулахад ундарга нь 0.8-9.0л/с байжээ. Газрын доорхи усны ордын ашиглалтын нөөцийг гидродинамикийн аргаар нийт 432.0 м³/хон –оор буюу 5.0 л/с –ээр, В зэргээр баталгаажуулсан байна. Ордын газрын доорхи ус нь химийн найрлагаараа ба чанараараа ундааны усны улсын стандартын шаардлагыг бүрэн хангаж байна. Сульфат-гидрокарбонат, кальци-натрийн найрлагатай, эрдэсжилт 0.5-0.7 г/л, ерөнхий хатуулаг 3.6-5.5 мг-экв/л байна.¹⁸ Дундговь аймгийн Олгойговийн усны ордод 1995 онд Р.Баттөмөр, Н.Лхагва, С.Ганхуяг нар газрын доорхи усны ашиглалтын нөөц баялгийн үнэлгээ хийсэн бөгөөд үүгээр тус ордын ус агуулагч чулуулаг нь доод цэрдийн Тэвшинговийн свитийн сэвсгэр хайрга, сайрга, элсэрхэг хурдас болно. Ус агуулагч хурдас ордын хүрээнд бага даралттай ус тархсан. Газрын доорхи ус 20-34 м-ээс илэрнэ. Даралт 5.7-24.3 м. Уст давхаргын зузаан нь 15.8-45 м байна.

⁴ Говьсүмбэр аймгийн усны чанарын асуудалд, Монгол орны геоэкологийн асуудал №11(13), ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, УБ-2015

⁵ <http://www.eic.mn/groundwater/>

⁶ Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл, Улаанбаатар хот 2018 он

Цооногууд дахь усны түвшинг 28.0-7.2 м бууруулахад ундарга нь 1.8-10.0 л/с байжээ. Газрын доорхи усны ордын ашиглалтын нөөцийг гидродинамикийн аргаар нийт 2678 м³/хон-оор буюу 31.0 л/с-ээр, үүнээс А зэргээр 1382 м³/хон-оор буюу 16.0 л/с-ээр, В зэргээр 864 м³/хон-оор буюу 10.0 л/с-ээр С₁ зэргээр 432 м³/хон-оор буюу 5.0 л/с-ээр тус тус баталгаажуулсан байна.

Дорноговь аймагт газрын доорхи усны нийт 14 орд газар судлагдаад байна. Дорноговь аймаг нь гидрогеологийн мужлалаар говь хээрийн бүсэд хамаарах ба ус агуулагч чулуулгийн бүтэц, геологийн тогтоцоос хамаарч дараах уст үе, цогцолборуудад хуваагдана. Үүнд:

1. Дөрөвдөгчийн уст үе: Ус агуулагч чулуулаг нь янз бүрийн ширхэгтэй элс, хайрга, хайрганцар, бул чулуу зэргээс бүрэлдэн заримдаа шавар, шаваранцартай үелэн байрласнаас түрлэгтэй ус агуулна.
2. Палеоген-неогены хурдас, чулуулгийн уст үе: Нутгийн нилээд хэсэгт тархсан ба элсэн чулуу, хөрзөн, зануужин, шавар үетэй хайрга, бул чулуу, хайрганцар дайрга, ац цавтай занар зэрэг чулуулгаас тогтоно.

Сайншанд хотын ус хангамжийн эх үүсвэр нийлбэрээр 300 м³/хон ундаргатай 517 ба 518-р цооногийг ОХУ-ын Буровод байгууллагаас өрөмдөж гаргасан бөгөөд 1983-1985 онд Сайншанд хотын төвлөрсөн ус хангамжид зориулан Ч.Борчулуун, С.Ганхуяг нар гидрогеологийн эрэл хайгуул хийж Хөтөл нуур, Хар цавын орчимд Зээгийн хөтлийн ордыг Сайншандаас урагш 20 орчим километр зайд илрүүлж усны нөөцийг А зэргээр 4968 м³/хон гэж тогтоожээ.⁷

Зээгийн Хөтөлийн газар доорхи усны ордын газар доорхи ус нь Дээд цэрдийн Сайншандын хурдас дотор бүрэлдэн тогтож хуримтлагддаг. Газар доорхи усны гүн гадаргуугийн рельефээс хамааран 3,5-28,1м хооронд хэлбэлздэг. Уст үеийн доор орших ус үл нэвтрүүлэх давхарга нь доод цэрдийн Зүүнбаянгийн свитийн долгиолог атираажсан аргиллит байдаг байна. Уст үеийн зузаан тогтмол биш бөгөөд 20-48 м хүртэл өөрчлөгддөг. Шавхалтыг 1 түвшний бууралттайгаар 7-15 хоног хийхэд усны түвшний бууралт төв цооногуудад 9.9-16.94 м болж тэдгээрийн ундарга 5-0.27 л/сек хүрч байжээ.¹⁹

Өмнөговь аймаг гадаргын ус төдийлөн элбэг бус, 2018 оны усны тооллогоор гол, горхи 4, булаг 442, рашаан 10, нуур тойром 21 бүртгэгдсэн байдаг. Өмнөговь аймагт бэлчээрийн зориулалтаар гаргасан 405 өрөмдмөл худгийн өгөмжийг үндэслэн ундарга, хувийн ундаргаар нь ус агуулсан чулуулаг тус бүрээр нь ангилж үзэхэд ундарга нь 0.1 л/с –ээс бага, хувийн ундарга нь 0.01 л/с –ээс бага цооногийг ашиглалтад оруулж байгаагүй байна. Энэ нь Өмнөговь аймгийн нутагт гаргасан өрөмдмөл худаг харьцангуй сайн ундаргатай болохыг харуулж байна. Нийт худгийн 76.5% (310) нь 1-5л/с ундаргатай, 54.6% нь 0.1 –1 л/с.м хувийн ундаргатай байна. Судалгааны дүнгээс үзэхэд дээд цэрд болон түүнээс залуу настай сэвсгэр болон сэвсгэрдүү тунамал хурдас дотор устай давхарга, үеийн усжилт илүү байгаа зүй тогтол ажиглагдаж байна (Г.Цэрэнжав. Н.Жадамбаа).

Даланзадгад хотын төвлөрсөн эх үүсвэрийн газар доорхи усны хайгуул хийж тогтоогдсон ашиглалтын нөөц 4061 м³/хоног, уг эх үүсвэрээс 2000 м³/хоног ус олборлож байгаа одоо үед усны түвшин тооцоолсон хэмжээнээсээ илүү доошилж байгаа мэдээ байдаг. Өмнөговь аймгийн

⁷ Борчулуун.У, “Монгол орны Дорноговийн бүсийн гидрогеологийн структуруудад газар доорх ус бүрэлдэн бий болох ба тархан байрлах нөхцөл” УБ, 1994

Ханхонгор сумын Мандах-Бумбатын газрын доорхи усны ордод хийсэн судалгаагаар газрын доорхи усны нөөцийг үйлдвэрлэлийн А+В зэргээр 2600.6 м³/хон (30.1 л/сек) хэмжээтэй гэж тогтоожээ.⁸

Говийн дэд бүсийн томоохон төслүүдийн ус хангамжийн боломж⁹

“Тавантолгой”-н усан хангамж: Тавантолгойн нүүрсний уурхайн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох гидрогеологийн эрэл хайгуулын ажил 1979-2013 онуудад үргэлжилсэн. Энэ хүрээнд Балгасын-Улаан нуур, Мандах, Баянзаг, Онгийн – Их улаан нуур, Зээг сухайтын хонхор, Зайрмагтай, Нарийнзаг, Таван-Алд, Борзонгийн говь, Загийн усны хоолой гэсэн газрын доорхи усны нийт 10 орд газрыг илрүүлэн, усны ашиглалтын нөөцийг нь тогтоосон байдаг. Тэдгээрээс Тавантолгойн уурхайд хамгийн ойрхон байршилтай (65 км), усны батлагдсан нөөц өндөртэй (25 жил ашиглахад 404.19 л/с, үүнээс В зэргээр 200.57 л/с; С зэргээр 203 л/с) буюу Тавантолгойн уурхайн 20 жилийн дараах усны хэрэгцээг (371.0 л/с) бүрэн хангах боломжтой нь “Балгасын-Улаан нуур”-ын газрын доорхи усны орд юм.

“Ухаа худаг”-ийн усан хангамж: “Энержи ресурс” ХХК нь 2009-2012 оныг дуустал уурхайн усан хангамжийн эх үүсвэрийг олж тогтоох зорилгоор гидрогеологийн эрэл, хайгуулын ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж, уурхайгаас баруун хойш 25 км-т орших “Наймант”, хойт зүгт 60 км-т орших “Наймдай”-н газрын доорхи усны ордуудыг илрүүлэн, усны ашиглалтын нөөцийг нь тооцсон. Одоо Наймантын ордын усны нөөцийг Ухаахудагийн уурхай болон Цогтцэций сумын төвийн усны хэрэглээг хангахад ашиглаж байна. Харин Наймдайн газрын доорхи усны ордын хайгуулын ажлыг 2009-2012 онуудад “Aquaterra” ХХК гүйцэтгэж, усны ашиглалтын нөөцийг 20 жил ашиглах хугацаанд С зэргээр 112.0 л/с байна гэж тооцоолжээ. Одоо уг ордын усны нөөцийг Ухаахудагийн уурхайн хэрэгцээнд ашиглах зорилгоор “Энержи ресурс” ХХК ус дамжуулах шугам хоолойн барилгын ажлыг хийж дуусаад байна. Дээр дурдсан 2 ордын газрын доорхи усны ашиглалтын батлагдсан нийт нөөц 229.0 л/с байгаа ба тэр нь Ухаахудагийн уурхай болон Цогтцэций сумын төвийн 2035 оны усны хэрэгцээг (153.75 л/с=138.75 + 15.0 л/с-ээр) хангах боломжтой гэж харагдаж байна.

“Тавантолгойн цахилгаан станц” төслийн усан хангамж: Тавантолгой, Ухаахудагийн нүүрсний уурхайг түшиглэн барихаар төлөвлөсөн 450 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станцын усны хэрэгцээ 38.0 л/с байх тооцоотой байна. Тэрхүү усны хэрэгцээг Наймдайн ордоос авах бол Ухаахудагийн уурхайтай, Балгасын-Улаан нуурын ордоос авах бол Тавантолгойн уурхайтай нэгдсэн ус хангамжийн сүлжээгээр хангах боломж харагдаж байна. Тавантолгойн цахилгаан станц нь Балгасын-Улаан нуурын газрын доорхи усны ордын усны нөөцөөс Тавантолгойн уурхайтай хамтран ашиглах тохиолдолд усны нийт хэрэгцээ 371+38=409.0 л/с, Балгасын -Улаан нуурын ордын баталгаажсан нөөц нь хүрэхээргүй байна. Иймд Тавантолгойн цахилгаан станцын усны хэрэгцээг хангах зорилгоор 2016 онд Наймдайн ордын залгаа талбайд газрын доорхи усны хайгуулын ажил гүйцэтгэж Загийн усны хоолойн гүний усны ордыг ирүүлэн 63,65 л/с-ийн ашиглалтын нөөцийг 25 жилийн хугацаанд ашиглах боломжтой гэж батлуулсан байна.

“Оюу толгой” төслийн усан хангамж: Оюу толгойн уурхайн усны хэрэгцээг хангах зорилгоор “Оюу толгой” ХХК 2003-2008 оныг дуустал гидрогеологийн эрэл, хайгуулын ажлыг өөрийн

⁸ Монгол орны өмнөд бүсийн газрын доорх цэнгэг усны ордууд, Экоговь компани, 2011 он

⁹ У.Борчулуун, З.Цэрэндорж нар, Хөгжлийн түлхүүр “Ус”, 4 дүгээр бүлэг, 2018 он

хөрөнгөөр гүйцэтгэж, уурхайгаас зүүн хойш 60-80 км-т орших “Гүний хоолой”, зүүн урд зүгт 60 км-т орших “Галбын говь”-ийн газрын доорхи усны ордуудыг олж тогтоон, усны ашиглалтын боломжит болон таамаг нөөцийг тооцсон байдаг юм. Гүний хоолойн газрын доорхи усны ашиглалтын нөөцийг 40 жилийн хугацаагаар 870.0 л/с гэж тооцсон байна.

Одоо Гүний хоолойн газрын доорхи усны орд дээр хоногт 900.0 л/с ус олборлох хүчин чадалтай 28 худаг гаргаж, 5 ус өргөх станц, 1 тасалдалттай ус өргөх станц, нэг бүр нь 200,000 шоо м багтаамжтай 2 ш ус хуримтлуулах цөөрөм, 88 км DICL, 65 км HDPE ус дамжуулах яндан хоолойг барьж, үйлдвэрийн болон ахуйн зориулалттай усныхаа нийт хэрэгцээг хангаж байна. Харин “Галбын говь”-ийн газрын доорхи усны ордыг нөөцөндөө байлгаж байгаа. Таамаг нөөц нь 25 жилийн ашиглах хугацаанд 427.6 л/с байх төлөвтэй гэсэн тооцоотой байдаг. Гүний хоолой болон Галбын говийн ордуудын газрын доорхи усны баталгаат болон таамаг нөөц нь Оюу толгойн уурхайн усны ирээдүйн хэрэгцээг тодорхой хугацаанд хангах боломжтой юм.

“Цагаансуврага” төслийн усан хангамж: Цагаан суврагын зэс молибденийн уулын үйлдвэр усныхаа хэрэглээг хангахуйц хэмжээний нөөцтэй “Нарангийн хоолой” гэдэг усны ордыг олж илрүүлээд, хамгийн багадаа 25 жилийн туршид шаардагдах усныхаа хэрэгцээг тэндээс хангахаар ашиглалтанд бэлтгэж байна. Түүнээс гадна уурхайгаас зүүн урагшаа 70 км – т оршдог, 800 л/с усны нөөцтэй Цагаанцавын газрын доорхи цэнгэг усны орд байгаа юм.

“Сайншандын аж үйлдвэрийн парк” төслийн усан хангамж: Сайншандын Аж үйлдвэрийн паркийн усны хэрэгцээг (1 жилд хэрэглэх усны хэмжээ 7 сая м³ буюу 222.0 л/с) Сайншандаас зүүн хойш 35-45 км-т орших “Бор хөөвөрийн говь”-ийн газар доорхи усны ордоос хангахаар төлөвлөж, 1987 онд илрүүлэн нөөцийг нь үнэлсэн уг ордод 2014 онд нэмэлт гидрогеологийн нарийвчилсан хайгуулын ажил хийж, усны нөөц нь үйлдвэрийн паркийн усны хэрэгцээг хамгийн багадаа 30 жилийн туршид бүрэн хангах боломжтой гэсэн дүгнэлтийг БОАЖЯ-ны Усны нөөцийн зөвлөл гаргаад байна. Сайншанд хотын өнөөгийн усны хэрэгцээг (60.0 л/с) хотын төвөөс урагшаа 10-11 км-т орших “Зээгтийн Хөтөл”-ийн цэнгэг усны ордоос авч байна. Уг ордын усны ашиглалтын нөөц нь 57.4 л/с байдаг ба 1985 оноос эхлэн одоог хүртэл 30 гаруй жил Сайншанд хотын хэрэгцээнд ашиглаж байна. Түүнчлэн шинээр баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн ус хангамжийн хэрэгцээнд “Бор хөөвөрийн говь”-ийн гүний усны ордыг ашиглах боломж бий.

Говийн бүсийн ус хэрэглээ

Говийн 4 аймагт 2017 оны байдлаар 197.6 мянган хүн суурьшин амьдарч байгаагийн 39.4 хувь нь аймгийн төвд, 19 хувь нь аж үйлдвэр, уул уурхай эрчимтэй хөгжиж буй Замын-Үүд, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдад амьдарч байна. Ялангуяа Цогтцэций, Ханбогд сумдын хүн амын өсөлт сүүлийн жилүүдэд харьцангуй өндөр байна. Тус бүс нутагт ийнхүү хүн ам өсөж, үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаа нь бүс нутгийн ус хэрэглээг эрс нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан суурь судалгааны эмхэтгэл, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл болон Алтайн өвөр говийн сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл, Онги голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах суурь судалгаанд хийгдсэн усны нөөц ашиглалтын балансаас үзэхэд Говьсүмбэр аймагт 2040 он гэхэд, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд,

Дорноговь аймгийн Замын-Үүд сумдад 2030 он гэхэд ашиглалтын баримжаат нөөц дутагдах тооцоо гарсан байна. Тус бүс нутагт уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжилтэй холбоотойгоор усны нөөц дутагдаж болзошгүй гэсэн тооцоо олон судалгаагаар гарсан байдаг.

2017 оны байдлаар Хот суурин газрын ус хэрэглээ 4,217.1 м³/хоног, Оюу толгой, Ухаа худаг-ийн ус хэрэглээ 45,225.5 м³ хоног байсан байна.¹⁰ Үүн дээр хөдөөгийн хүн амын ус хэрэглээ “Престиж инженеринг” ХХК-иас тодорхойлсноор ХАА-н ус хэрэглээ 21,045.0 м³/хоног, судлаачийн тооцоолсноор хөдөөгийн хүн амын ус хэрэглээ 1099.6 м³/хоног гэснийг тус тус нэмснээр бүсийн нийт ус хэрэглээ ойролцоогоор 71,587.2 м³/хоног байна. Энэ нь 2011 оны хэрэглээ (32,338.0 м³/хон)-тэй харьцуулахад 2.2 дахин өссөн үзүүлэлт юм.

Хот суурины ус хангамж, ариутгах татуурга

Говийн дэд бүсэд уул уурхай эрчимтэй хөгжиж байгаа нь энд ус хангамж, ариун цэврийн байгууламж эрчимтэй хөгжих үндэс болж байна.

Говьсүмбэр аймгийн ус хангамж, ариутгах татуурга: Говьсүмбэр аймаг харьцангуй төвлөрсөн, аймгийн 3 сум болох Сүмбэр, Баянтал, Шивээговь сумд нь ус хангамж, ариутгах татуургын системтэй. Сүмбэр сум буюу Чойрын ус хангамжийг “Ус-Ду” ОНӨААТҮГ хариуцдаг. Усны эх үүсвэр нь 7 км зайд орших Тэрэгтийн хөндийн гүний Зхудагнаас өргөлтийн насосны станцаар дамжуулан цэвэр усаар хангагддаг. Цэвэр усны шугам сүлжээ нь гол төлөв 1969 оны тоног төхөөрөмжүүдтэй, 1972-1986 онуудад ашиглалтанд орсон, Ф200-150мм-ийн голчтой 4.5 км урт ус хангамжийн шугам сүлжээ, усыг төмөргүйжүүлэх байгууламж, 500м³-ийн багтаамж бүхий 2 усан сантай. Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ нь 1970 онд ашиглалтанд орсон. Цэвэрлэх байгууламж, бохир усны насосны станцтай. Ф200мм-ийн голчтой 3 км, Ф300 мм-ийн 7.8 км шугам хоолойтой. Уг цэвэрлэх байгууламжийг Польшийн Засгийн газрын хөнгөлттэй зээлээр 2019-2022 онд шинэчлэхээр ажиллаж байна. Баянтал сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг “Талын илч” ОНӨААТҮГ, Шивээговь сумын төвийнхийг “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ тус тус хариуцан ажилладаг.

Дорноговь аймгийн ус хангамж, ариутгах татуурга: Сайншанд сумын ус хангамжийн эх үүсвэр нь хотоос урагш 17-24 орчим км-т орших Зээгийн Хөтөлд оршдог. 1992 оноос эхлэн ашиглагдаж байгаа гүний 4 худаг бүхий байгууламжаас завсрын 3 насосны станц, халдваргүйжүүлэх төхөөрөмжөөр дамжин 2х1000м³-ийн багтаамжтай усан санд 2хФ200мм-ийн голчтой хоолойгоор шахна. Эндээс өөрийн урсгалаар Ф100-Ф150мм-ийн голчтой цагираг хоолойгоор дамжуулан ундны цэвэр усыг хэрэглэгчдэд түгээж байна. Цэвэр усны гол шугам хоолойн урт 54.2 км. Ус хангамжийн эх үүсвэрийн тогтоогдсон хүчин чадал 2100 м³/хоног боловч одоогоор бүрэн ашиглаагүй 1200-1300 м³/хоног ус ашигладаг. Цэвэрлэх байгууламж нь 1987 онд ашиглалтанд орсон 2700м³/хоног хүчин чадалтай, биологийн цэвэрлэгээтэй боловч одоогоор ажиллаагүй байна. Цэвэрлэх байгууламжийн насосны станцын болон бохир усны шинжилгээний лабораторын барилга, хлораторын барилга, уурын зуухны барилга, гүний худгийн барилгууд нь бүгд ажиллагаагүй болж тоногдсон тул хотоос цуглуулсан бохир усыг аваарын хоолойгоор дамжуулан шууд хөрсөнд хаяж байна. 2019 оны 1-р сард Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр АХБ-ны санхүүжилтээр Дорноговь аймгийн

¹⁰ ХСУХАТАУЗЗ-ийн тайлан нэгтгэлийн мэдээ, 2018 он

Сайншанд суманд шинээр бохир ус цэвэрлэх байгууламжийг барихаар болж бүтээн байгуулалтын ажил нь 2019 оны гуравдугаар сард эхлэх юм.

Замын-Үүд сумын ус хангамжийг “Чандмань Бадрал” ХХК хариуцан явуулж байна. Тус ХХК-ий хариуцсан усны эх үүсвэрийн 2-3.8л/с ундарга бүхий 9 цооног байгаа бөгөөд эдгээрээс 720-1512м³/хоног хүчин чадалтай 3 худгийн нь ашиглан хоногт нийт 1750 орчим м³/хоног хүртэл ус олборлодог. Ус хангамжийн систем нь 500м³-ийн багтаамжтай 2 усан сан, 14.5 км цуглуулах, түгээх шугам, Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хүрээнд байгуулсан 3250 м³/хоног хүчин чадалтай ус цэвэршүүлэх үйлдвэр, Усны лабораторитой. Гэр хорооллын иргэдэд шугамд холбогдсон 5 УТБ-аар үйлчилж байна. Ариутгах татуургын систем нь механик, биологи цэвэрлэгээ бүхий бохир ус зайлуулах Цэвэрлэх байгууламж, 3040 м³/хоног хүчин чадалтай саарал ус цэвэрлэх үйлдвэр, 5.6 км татан зайлуулах шугамтай.

Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутгаар дамжин өнгөрөх төмөр замын дагуу Монгол оросын Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн ЭХУХ-ийн 2, БОСАҮ-ний 3-р ангиуд ус, хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. Ус хангамжид төмөр замын өртөө, зөрлөг бүрд усны эх үүсвэрийн худгууд, нийтдээ 90 шахам км цэвэр усны усны цаглуулах, дамжуулах, түгээх шугам сүлжээ, бохир ус татан зайлуулахад 20 орчим мянган км шугам ашиглаж байна.

Дундговь аймгийн ус хангамж, ариутгах татуурга: Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын (Мандалговь) ус хангамжийн эх үүсвэр нь хотоос 35 км-ийн зайд байрлах Олгойн говьд байрлах гүний 5 худаг бүхий барилга байгууламжаас бүрдэнэ. Завсрын өргөлтийн 2 насосны станцын тусламжтайгаар Ф200мм-ийн голчтой ган хоолойгоор дамжуулан 2х1500м³-ын усан санд шахаад усан сангаас өөрийн урсгалаар Ф150-100мм-ийн голчтой цагираг шугамаар хотын төвийн хэрэглэгчдийг ундны усаар хангаж байна. Ус хангамжийн эх үүсвэрийн хүчин чадал 2640м³/хоног, ашиглалтын хүчин чадал 1140м³/хоног. Цэвэр усны шугам хоолойн урт 15 км. Хоногт 1400м³ бохир усыг цэвэрлэх хүчин чадалтай, механик цэвэрлэгээ бүхий цэвэрлэх байгууламж 2000 онд ашиглалтанд орсон. Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн II үе шатны төслөөр Мандалговь хотод шинээр бохир усны насосны станц, сараалжийн барилга барих, гадна ариутгах татуургын 0.93 км шугам хоолойг угсрах ажлууд хийгдэж, цэвэрлэх байгууламж нь энгийн биологи цэвэрлэгээтэй болсон. Аймгийн бусад сумдад ус хангамж, ариутгах татуургын систем хөгжүүлэх шаардлагатай байна. Тус аймгийн цэвэрлэх байгууламжийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн нэмэлт санхүүжилтээр 2019-2021 онд шинэчлэхээр төлөвлөсөн.

Өмнөговь аймгийн ус хангамж, ариутгах татуурга: Өмнөговь аймгийн сумын төв суурин газруудад ус хангамж ариутгах татуургын систем харьцагуй сайн хөгжсөн байна.

Даланзадгад хотын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг “Гүний ус” ХХК хариуцан ажилладаг бөгөөд Монгол Улсын аймаг, орон нутгийн НААҮ-ний байгууллагууд дотроос хувийн хөрөнгийн оролцоотой ганц компани юм. Тус компани нь хоногт 1000 м³ усыг олборлон аймгийн төвийн орон сууцны 1000 гаруй өрх, 300 гаруй аж ахуйн нэгжид түгээдэг ба тэдгээрийн хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэрлэдэг. Усны эх үүсвэрийн 5 гүний худаг, 1000м³ эзэлхүүн бүхий 3ш усан сан, ус түгээх 30 байр, 25 км шугамаар дамжуулан ундны усыг түгээж байна. Ариутгах татуургын 23.2 км шугам сүлжээний ашиглалтыг хариуцна. Ихэвчлэн ф150-300мм вааран болон ширэм хоолой ашиглагддаг. Цэвэрлэх байгууламж нь анх 1974 онд 1800м³/хон

хүчин чадалтайгаар ашиглалтад орсон. Одоогийн байдлаар $1100\text{м}^3/\text{хон}$ бохир ус хүлээн авч цэвэрлэж байгаа бөгөөд АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн нэмэлт санхүүжилтээр 2018-2020 онд шинэчлэл хийхээр ажил эхлээд байна.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт ажиллаж буй “Ухаа худаг ус хангамж” ХХК, “Энержи интернэшнл” ХХК, “Паблик сервис” ХХК нь нийт 40 орчим гүний худгаар ус олборлон, 10 гаруй км шугам сүлжээгээр Цогтцэций сум, “Ухаа худаг” ЦС, “Оюу олгой” ХХК-ийн усны хэрэгцээг хангаж байна. Ариутгах татуургын тухайд “Ухаа худаг ус хангамж” ХХК, “Хаанзаа” ХХК нь ЦБ хариуцан ажилладаг бөгөөд бохир ус татан зайлуулах үйлчилгээг эдгээрээс гадна “Паблик сервис” ХХК хариуцан ажиллаж байна. Мөн 2017 оноос эхлэн Цогтцэций суманд “Цог өрнөх” ОНӨААТҮГ, Ханбогд суманд “Хан дизель” ОНӨААТҮГ, Гурвантэс суманд “Шугшаа уул” ОНӨААТҮГ-ууд ус хангамж, ариутгах татуургыг хариуцан ажиллаж байна.

“Оюу толгой” ХХК нь $2\text{км} \times 2\text{км}$ хэмжээтэй хаягдлын сантай, $600\text{м}^3/\text{хоног}$ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий 3, $250\text{м}^3/\text{хоног}$ хүчин чадал бүхий 1 цэвэрлэх байгууламжтай, 300м^3 эзэлхүүнтэй цэвэрлэсэн ус хуримтлуулах 1 усан сантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Жилд 2748.3 мянган м^3 бохир усыг цэвэрлэн технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигладаг. “Энержи ресурс” ХХК нь хаягдал усныхаа 55-60 хувь буюу $4500\text{--}6500\text{ м}^3/\text{хоног}$ усыг технологийн хэрэгцээнд дахин ашиглаж байна. $100\text{м}^3/\text{хоног}$ хүчин чадал бүхий уурхайн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж, Цэцийн хорооллын $1200\text{м}^3/\text{хоног}$ хүчин чадал бүхий бохир ус цэвэрлэх байгууламжтай.

Хөдөө аж ахуйн ус хангамж

Говийн дэд бүсийн аймгуудад нүүдлийн мал аж ахуй түүний дотор бог мал, тэмээ үржүүлэхэд тохиромжтой байдаг байна. Байгаль цаг уурын нөхцөлөөс шалтгаалан газар тариалангийн хөгжил сул юм. Хөдөөгийн хүн амын усан хангамж, ариун цэврийн байгууламжийн асуудал Монгол улсын хувьд эмзэг асуудал бөгөөд ХХААХҮЯ, БХБЯ, ЭМЯ-дын дунд тодорхой эзэнгүй орхигдож ирсэн гэж хэлж болно. Нэг талаас сум суурин газрын ус хангамжийн асуудалд эдгээр байгууллагууд бүгд тодорхой үүрэг рольтой оролцож байгаа боловч ус хангамж, хүртээмж, ялангуяа ариун цэврийн байгууламжийн асуудал шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Ганц нэгээрээ нүүдэллэн амьдардаг малчдын асуудлыг ХХААХҮЯ хариуцан, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Хүнсний аюулгүй байдал” зэрэг бодлого хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байгаа боловч авч хэрэгжүүлсэн ажлууд нь худаг гаргах, усны эх үүсвэр хамгаалах, эсвэл малын ус хангамжтай хамтруулан шийдвэрлэхэд чиглэгдсэн байдаг нь айл өрхийн усны хангамж, хүртээмжийг дээшлүүлж чадахгүй байна. Дэлхийн ТХЗ-д 2030 он гэхэд ил задгай бие засах явдлыг эцэс болгоно гэсэн зорилт тавьсан бөгөөд үүнийг биелүүлж монгол хүний эрхийг хангахын тулд малчдын ариун цэврийн байгууламжийг оновтой шийдвэрлэх гарц шийдэл эрэлхийлэх, асуудлыг хариуцах байгууллагыг тодорхой болгох шаардлагатай юм.

Говийн дэд бүс нутаг дахь уул уурхай, үйлдвэрүүдийн ус хэрэглээ, цаашидын төлөв

Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор: Нарийвчилсан хайгуул нэмж хийсний үр дүнд газрын доорхи уснаас энэ аж үйлдвэрийн цогцолборын хэрэглээнд ашиглахад хэрэглээний 30 орчим хувийг л хангах боломжтой гэж тооцоолж байна. Бүс нутаг дахь газрын доорхи уснаас аж үйлдвэрийн цогцолборын барилгын ажлын үед ашиглах боломжтой боловч цогцолбор бүрэн хүчин чадлаараа

ажиллаж эхлэхэд усны нөөц хүрэлцэхээргүй байгаа гэсэн тооцоо хэд хэдэн судалгааны үр дүнд гарсан байна. Сайншанд-замын–Үүдийн бүс нутгийн ус хэрэглээ ойрын 20 орчим жилд 554 мянган м³/хоног гэж үзэхэд газрын доорхи усны тогтоогдсон нөөц 409 мянган м³/хоног байгаа нь 145 мянган м³/хоногийн хомсдол байна гэсэн үг. Иймд усны өөр эх үүсвэр хайх шаардлагатай болно.

Усны хэрэгцээг тодорхойлох тооцоонд тусгасан Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт барихаар төлөвлөсөн үйлдвэрүүд:

1. Цементийн үйлдвэр
2. Коксын үйлдвэр
3. Хар төмөрлөгийн үйлдвэр
4. Нүүрс хийжүүлэх үйлдвэр
5. Газрын тос боловсруулах үйлдвэр
6. Зэс хайлуулах үйлдвэр
7. Цахилгаан станц болно.

Оюу Толгой: Оюу толгойн ордыг ашиглахад үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллавал 1250 л/сек ус хэрэгтэй болно. Хамгийн ойрхон ашиглахаар төлөвлөсөн газрын доорхи усны орд болох “Гүний хоолойн” газрын доорхи усны ордын нөөц Усны нөөцийн зөвлөлөөр баталгаажуулсан нь 870 л/сек буюу 75 168 м³/хоногоор нөөцийг баталсан. Цаашид өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах асуудал хэд хэдэн хувилбараар судалгаа, төсөөлөл хийгдсэн боловч эцэслэн үийдээгүй байна. Дээр дурдсан баталгаажсан нөөцийн асуудлаар газрын доорхи усны эрдэмтдийн санал зөрөлдөөнтэй байдаг бөгөөд энэ асуудлыг одоо хийгдэж байгаа ажиглалт, газрын доорхи усны мониторингийн дүнд үндэслэн, нэмэлт нарийвчилсан судалгаа хийж, нэгдсэн нэг дүгнэлтэд хүрэх шаардлагатай байна.

Оюу Толгойн үйлдвэр болон дэд бүтцийн хэрэгцээнд 3800 л/сек ус хэрэглэх бөгөөд 3194 л/сек усыг үйлдвэрийн усан сангаас 607 л/сек усыг газрын доорхи уснаас ашиглахаар төлөвлөж байгаа бөгөөд үлдсэн хэсгийг ашигласан усаа дахин ашиглах замаар, мөн тодорхой хэсгийг гадаргын усаар хангах хувилбарууд байдаг.

Оюу Толгойн Ус хангамжийн нийт хөрөнгө оруулалт нь 144.7 сая америк доллар, 1л/сек-д ногдох хөрөнгө оруулалт нь 165.3 мянган америк доллар, Баруун Нарангийн ус хэрэглээ 123.1 л/сек ба ус хангамжийн нийт хөрөнгө оруулалт нь 20.9 сая америк доллар, 1л/сек-д ногдох хөрөнгө оруулалт нь 170 мянган америк доллар байна.

“Оюу Толгойн цахилгаан станц” төсөл: Тавантолгойн нүүрсийг ашиглан эрчим хүч гаргаж Оюутолгойн зэс баяжуулах үйлдвэрийн хэрэгцээг хангах зорилготой. Төлөвлөж буй хүчин чадал 450.0 МВт бөгөөд ус бага хэрэглэдэг, агаарын хөргөлттэй, үнсээ хуурайгаар зайлуулдаг орчин үеийн технологитой байхаар төлөвлөсөж байна.

Оюу Толгойн бохир ус Цэвэрлэх байгууламж: БУЦБ-ийн байгууламж нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Оюу толгой зэс-алтны ордыг ашиглах төслийн лицензийн талбай дахь барилгын түр суурингийн хэсэгт байрлах хуучин БУЦБ-ийн өргөтгөл бөгөөд 278.6 м² талбай эзэлж оршино. Мөн хуучин БУЦБ-аас өмнөзүгт 24 м зайтай 144 м² талбай бүхий газарт шинээр баригдсан цэвэрлэсэн усыг хадгалах бетонон байгууламж байрладаг. Одоогийн байдлаар Оюу толгой төслийн хэмжээнд өдөрт гарч буй цэвэрлээгүй 200 м³ усыг болон цэвэрлэсэн 200 м³ нийт 400 м³ усыг хаягдал ус хаях санд нийлүүлдэг. Оюу толгой төслийн нутаг дэвсгэр дэх цэвэрлэсэн болон цэвэрлээгүй нийт

бохир ус нь ойролцоогоор хоногт 400 м³, сард 12000 м³, жилд 146000 м³ болж байна. Иймээс хуучин ашиглаж байсан 800 хүн/эквивалент буюу хоногт 120 м³ бохир усыг цэвэрлэх хүчин чадал бүхий БУЦБ-ийг 4000 хүн/эквивалент хүчин чадалтай болгож хүчин чадлыг нэмэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа ажээ. Шинээр барих БУЦБ-ийн тооцоолсон хүчин чадал нь 4000 хүн/эквивалент буюу хоногт хүлээн авч цэвэрлэх бохир усны хэмжээ 600-840 м³/хоног, байх юм.

Таван Толгой: Таван толгойн нүүрсний ордыг ашиглахад 920 л/сек буюу 82166 м³/хоног ус шаардагдах бол энэ хавьд 200 км радиуст байгаа газрын доорхи усны нийт ордын хэмжээ 760 л/с буюу 68000 м³/хоног нөөцтэй байна. Хэрвээ Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.4-ын дагуу газрын доорхи цэнгэг усны ордуудыг зөвхөн ундааны зориулалтаар ашиглана гэвэл Таван толгой орчмын хамгийн гол нөөц “Балгасын улаан нуур” болон хэд хэдэн ордын нөөц яваандаа үйлдвэрлэлийн ашиглалтаас хасагдах магадлал өндөр байгаа ажээ. Таван толгойд “Балгасын улаан нуур” ордыг эхний ээлжинд ашиглах тухай яригдаж байна. Газрын доорхи усны тогтоогдсон нөөцийн хэмжээгээр нь ашиглах аваас 25 жилийн дараа дуусна гэж тооцсон байдаг.

Говийн бүсийн газрын доорхи усны томоохон ордуудын нэг “Балгасын улаан нуур”-ын газрын доорхи ордыг 1986 оны үед судлаад 450 л/сек гэж тогтоосон байсан боловч 2007-2008 онд Баттөмөр доктор тэргүүтэй судалгааны баг нарийвчилсан хайгуул хийн 150 л/сек гэж батлуулсан байна. Ийнхүү зөрүүтэй үр дүн зарим тохиолдолд гарч байна.

Тавантолгойн ордын хувьд Наймантын хөндий, Балгасын улаан нуур, Зайрмагтай, Гурамсангийн хоолой, Борзонгийн говь, Таван алдын говь, Мандал-Овоо, Мандах-бусбат, Оорцог-хадан ус зэрэг газруудаас ямар хэмжээний ус авах боломжийн нарийвчилсан хайгуул судалгаа хийж үлдсэн тодорхой хэсгийг нь гадаргын усаар хангах шаардлагатай болж байна.

Таван толгойн цахилгаан станц: Өмнөд говийн уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх эрчим хүчний хэрэгцээтэй холбогдуулан Тавантолгойн нүүрсний төслүүдийг хэрэгжүүлэх эрчим хүчний хэрэгцээтэй холбогдуулан Тавантолгойн нүүрсний ордод түшиглэн 600.0МВт-н хүчин чадал бүхий эрчим хүч үйлдвэрлэх цахилгаан станц барихаар төлөвлөсөн. Тавантолгойн орд нь 4.6 тэрбум тн эрчим хүчний нүүрсний ба цаашдаа нүүрс угаах үйлдвэрийн дагалдах бүтээгдэхүүнийг уг станцад хэрэглэвэл үйлдвэрлэх цахилгааны үнэ хямдрах боломжтой юм байна. Станц нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн эрчим хүчний системд нийлүүлэх ба ус бага хэрэглэдэг агаарын хөргөлттэй, үнсээ хуурайгаар зайлуулдаг зэрэг орчин үеийн технологитой байхаар зорьсон байна.

Дээрх төслүүдийн тооцоо судалгааг үндэслэн Говийн дэд бүс нутагт уул уурхай, хүнд үйлдвэрлэл хөгжүүлэхэд тулгарч болзошгүй усны нөөцийн дутагдах хэмжээг тоймлон тооцоолоход, төслүүд бүрэн хүчин чадлаараа ажиллах үед 130.7 мянган м³/хоног ус дутагдахаар байна.

Хүснэгт 3. Говийн бүсийн аж үйлвэрийн хэрэгцээнд ашиглах усны нөөц ашиглалтын баланс

№	Ордын нэр	Нийт батлагдсан усны нөөц, м ³ /хоног	Одоогийн эрэлт, м ³ /хоног	Хэтийн эрэлт, м ³ /хоног	Дутагдах эх үүсвэр, м ³ /хоног
1	Оюу-Толгой	85,968.0	86,400.0	91,584.0	(5,616.0)
2	Таван толгой	17,611.3	36,000.0	82,166.4	(64,555.1)
3	Цагаан суварга	25,920.0	25,000.0	52,185.6	(26,265.6)

№	Ордын нэр	Нийт батлагдсан усны нөөц, м ³ /хоног	Одоогийн эрэлт, м ³ /хоног	Хэтийн эрэлт, м ³ /хоног	Дутагдах эх үүсвэр, м ³ /хоног
4	Сайншандын Аж үйлдвэрийн парк	36,072.0	27,000.0	40,000.0	(3,928.0)
5	Шивээ овоо	17,280.0	40,000.0	53,222.4	(35,942.4)
	Нийт	182,851.3	214,400.0	319,158.4	(130,691.1)

Эх сурвалж: Д.Балжинням, “Ус ашиглалтын хэтийн хандлага” илтгэл, “2011 он-усны жил”, Улаанбаатар, 2010 он

Өнөөг хүртэл хийгдсэн судалгаа тооцоонуудаас үзэхэд Говийн дэд бүс нутгийн усны нөөцийн хязгаарлагдмал байдал нь Монгол улсын уул уурхай, хүнд үйлдвэрийн эрчимтэй хөгжлийг хязгаарлах нэг гол хүчин зүйл болох нь харагдаж байна. Говийн дэд бүс нутагт төлөвлөсөн томоохон төслүүд хэрэгжсэн тохиолдолд усны хэрэгцээ 2030-2040 онд 18.8-34.25 сая м³/жил гэсэн хэмжээгээр усны нөөцөөс давж, усны хэрэгцээг хангахад усны нөөц дутагдахад хүрнэ гэсэн тооцоог Дэлхийн банкны судалгааны үр дүн харуулсан. Тус бүс нутгийн усны хэрэгцээг 10,000.0–35,000.0 жилд нөхөн сэргээгддэг газрын доорхи усаар хангаж байгаагаас энэ нөөц тодорхой хэмжээгээр шавхагдан цөлжилт хүрээгээ тэлж, яваандаа амьдрах нөхцөл хумигдах сөрөг үр дагавартай. Иймд^{11 12}:

- Усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх, нүүрсний уурхай, цахилгаан станцуудад хуурай технологи хэрэглэх, төслүүдийн ойролцоох газрын доорхи усны нарийвчилсан судалгаа хийж ашиглах;
- Одоогийн болон ирээдүйд өсөн нэмэгдэх үйлдвэрлэлийг хязгаарлаж зөвхөн Өмнөд говийн бүс дэх газрын доорхи усаар хангах;
- Газрын доорхи усны нөөцийн ашиглалтыг бүрэн зогсоож, одоогийн болон ирээдүйд өсөн нэмэгдэх хэрэгцээг Хангайн бүсийн томоохон голуудын урсацад тохируулга хийж усан сан, боомт байгуулж, ус дамжуулах шугам хоолойгоор Өмнөд говийн бүсэд шилжүүлэн зөвхөн гадаргын усаар хангах;
- Гадаргын болон газрын доорхи усны эх үүсвэрийг хослуулан хэрэглэх;
- Орхон, Сэлэнгэ, Туул, Хэрлэн голын сав газрын голын хөндийн газрын доорхи усны нөөцийг Өмнөд Говийн бүс рүү шугам хоолойгоор тээвэрлэн ирээдүйн хэрэгцээг хангах зэрэг хэд хэдэн хувилбарыг санал болгосон байдаг.

Газрын доорхи уснаас тодорхой хэмжээний ус аваад хэрэглэхэд нөхөн сэргээлт байхгүй, шууд усны нөөцөөсөө хасагддаг бол гадаргын уснаас ашиглахад байгалийн жамаараа тодорхой хугацаанд нөхөн сэргээгдэх магадлалтай байдгаараа давуу талтай.

Өнөөг хүртэл Говийн дэд бүсийг усаар хангах чиглэлээр олон судалгаа хийгдэж, усны өсөн нэмэгдэх эрэлтийг хангах хувилбаруудыг дэвшүүлж байгаа боловч эдгээр нь хоорондоо зөрчилдөөнтэй, тодорхой нэгдсэн шийдэлд одоогоор хүрээгүй байна. Гэхдээ хамгийн тодорхой зүйл бол Говийн дэд бүсийн газрын доорхи ус нь хэдэн мянган жилийн туршид хуримтлагдсан нөөц бөгөөд үүнийг уул уурхайд цөөн хэдэн жил ашиглаад шавхагдвал ирээдүйд Монгол Улсын говийн экосистемд нөхөж баршгүй хохирол учирч, энэ бүсийн иргэдийн амьдрах нөхцөл доройтно гэдэгтэй хэн бүхэн санал

¹¹Хөгжлийн түлхүүр “Ус”, 2018 он

¹² Ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах эрэмбэлсэн шийдлүүд, Усны нөөцийн бүлэг-2030

нэг байдаг. Гэхдээ энэ “нөхөж баршгүй хохирол” чухам ямар хэмжээгээр үнэлэгдэх вэ гэдгийг хараахан тооцоолж гаргаагүй юм.

Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдаж буй говийн дэд бүсийн Говь-Сүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгууд нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 22,5% буюу 35 516 500 га нутаг дэвсгэрийг эзлэх бөгөөд 2018 оны байдлаар говийн бүсийн нийт нутаг дэвсгэрийн 0,1%-ийн өндөр уулын хад асга буюу ян сарьдаг, 4,7%-ийг ой, тайга, 1,8%-ийг, 0,9%-ийг нугат хээр, 0,2%-ийг намгархаг нуга, 12,6%-ийг хээр, 7,3%-ийг хуурайвтар хээр, 7,2%-ийг хуурай хээр, 1,3%-ийг мараалаг хээр, 27,5%-ийг цөлөрхөг хээр, 16,7%-ийг цөлжүү хээр, 5,5%-ийг гандуу хээр, 0,7%-ийг заган ой, 5,5%-ийг элсэрхэг цөл, 3,9%-ийг хэт гандуу цөл, 0,1%-ийг нуур тойром, 2,2%-ийг элс-элсэрхэг газар, хот суурингийн эдэлбэр газар 0,3%-ийг, 1,4% тариалангийн талбай, 0,3%-ийг уул уурхайн эвдрэлд өртсөн газар эзэлж байна. Өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд эдгээр аймгийн ландшафт-газрын бүрхэвчийн үндсэн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт гарсан. Үүнд:

1. Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өнгөрсөн 28 жилийн хугацаанд мараалаг нуга 4,1%-иар, хээр 5,2%-иар, хуурай хээр 19,1%-иар, нуур тойром 18,4%-иар, тариалангийн талбай 4,9%-иар тус тус багассан. Харин цөлөрхөг хээрийн талбай 56,4%-иар, цөлжүү хээр 2,5%-иар, элс 78,3%-иар, хот суурингийн эдэлбэр газар 36,5%-иар, уурхайлалтад өртөж эвдэрч доройтсон газар 36,1%-иар тус тус нэмэгдсэн.
2. Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өнгөрсөн 28 жилийн хугацаанд гандуу хээр 1,6 дахин, цөлжүү хээр 0,1%-иар, цөлөрхөг хээр 9,9%-иар, элс-элсэрхэг газар 24,5%-иар, хот суурингийн эдэлбэр газар 24,8%-иар тус тус нэмэгдсэн байхад хээр 55,4%-иар, хуурай хээр 8,4%-иар, нуур тойром 50,9%-иар, тариалангийн газар 23,8%-иар тус тус багассан. Тус аймагт өнгөрсөн 28 жилийн хугацаанд нийт 560 га газар уурхайлалтад өртөж, эвдэрч доройтсон.
3. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өнгөрсөн 28 жилийн хугацаанд цөлжүү хээр 30,8%-иар, элсэрхэг цөл 1,02 дахин, хот суурингийн эдэлбэр газар 1,1 дахин, уурхайлалтанд өртөж эвдэрсэн газар 5,2 дахин нэмэгдсэн байхад хээр 12,1%-иар, хуурай хээр 1,2%-иар, цөлөрхөг хээр 19,4%-иар, нуур тойром 55,3%-иар нэмэгдсэн.
4. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өнгөрсөн 28 жилийн хугацаанд цөлөрхөг хээр 26,7%-иар, цөлжүү хээр 38,4%-иар, элсэрхэг цөл 10,6%-иар, элс 1,3 дахин, хот суурингийн эдэлбэр газар 1,3 дахин, уурхайлалтанд өртөж эвдэрсэн газар 33704 га-аар тус тус нэмэгдсэн байхад заган ойн талбай 5,9%-иар, хуурай хээр 93,8%-иар, нуур тойром 90,4%-иар, тариалангийн газар 1,1%-иар тус тус багассан.

Эндээс дүгнэхэд Говийн дэд бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өнгөрсөн 28 жилийн хугацаанд хуурай хээрийн талбай хамгийн их буюу 45,9%-иар, нуур тойрмын талбай 29,4%-иар, ойн талбай 18,7%-иар, хээрийн ландшафт 14,8%-иар, намгархаг хээрийн талбай 12,4%-иар, хуурайвтар хээрийн талбай 6,2%-иар, нугат хээрийн талбай 3,3%-иар, хэт гандуу хээрийн талбай 2,5%-иар тус тус багасчээ. Харин цөлөрхөг хээрийн талбай 6,4%-иар, цөлжүү хээрийн талбай 20,9%-иар, элсэрхэг цөл бүхий газар 52%-иар, хот суурингийн эдэлбэр газар 31,5%-иар, тариалангийн талбай 11,1%-иар, элс-элсэрхэг газар 5,2%-иар, уул уурхайн үйл ажиллагаанд өртөж эвдэрч доройтсон газар 2.7 дахин нэмэгдсэн.

Өнөөгийн байдлаар урт нэртэй хууль буюу “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг батлан голын эх орчмыг хамгаалсан нь гол усны нөөцийг хадгалах, цаашид тэдгээрийн ашиглалтанд хяналт тавих нь экосистемийн тогтвортой хөгжилд нөлөөлөх нь дамжиггүй. Гэвч хуурай хээр, говь, цөлийн бүсийг зохистой ашиглах, төлөвлөх шинжлэх ухааны үндэслэл одоо хэр боловсруулагдаагүй байгаа нь гандуу нутагт хүний олон талын үйл ажиллагаанд үлэмж нэрвэгдэж, антропогены цөлжилт эрчимжих талбар болон хувирсаар байна. Элсний нүүлт, ургамал нөмрөгийн алдралт, хөрсний давсжилт, ул хөрсний бохирдолт, биологийн олон төрөл байдлын хорогдолт, газрын хэвлийг сэндийлж буй явдал зэргээр хоорондоо нарийн уялдаа шүтэлцээ бүхий байгалийн тэнцвэр алдагдахад хүрч говь нутгийн био чадавхи хомсдож байгаа бас нэг шалтгаан болж байна.

Говийн дэд бүсийн 4 аймгийн усны салбарын өнөөгийн байдлын судалгаанаас харахад:

- ✓ Говийн дэд бүсийн аймгуудад гадаргын усны нөөц бага, Монгол орны гадаргын усны нөөцийн 0.03% ногдож байгаа бөгөөд хэдийгээр мал аж ахуй, хүн амын унд ахуйд хэрэглэж байгаа боловч ашиглах боломжит нөөцөд оруулж тооцдоггүй байна;
- ✓ Говийн дэд бүс нутгийн зарим аймагт усны чанар ундны усны шаардлагад нийцэхгүй байна. Иймд аймгийн төв, сумын төвүүдэд ундны усны чанар сайжруулах төхөөрөмжүүд хэрэглэж байгаа боловч, үарим нь шаардлага хангахгүй байна.
- ✓ Хөдөөгийн хүн ам, хот суурин газрын гэр хорооллын ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл доогуур, худаг гаргах төдийхнөөр хязгаарлагддаг тул хөдөөгийн хүн амын усны аюулгүй байдал алдагдсан.
- ✓ Тус бүс нутгийн ус хэрэглээний дийлэнхийг газрын доорхи усаар хангаж байна. Говийн 4 аймгийн ус хэрэглээ 2011 онд Престиж инженеринг ХХК-ийн тооцоноор 32,338.0 м³/хон байсан бол 2017 онд 71,587.2 м³/хоног болж 2.2 дахин өссөн;
- ✓ Тус бүс нутагт хийгдсэн усны эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, усны нөөц ашиглалтын балансаас үзэхэд уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх томоохон төслүүдийг хэрэгжүүлээгүй тохиолдолд газрын доорхи усны нөөц баялаг нь ирээдүйн хэрэгцээг хангах боломжтой бөгөөд харин төлөвлөж байгаа төслүүдийг хэрэгжүүлсэн тохиолдолд алсдаа 130.7 мянган м³/хон ус дутагдах тооцоо гарсан;
- ✓ Монгол орны хойд хэсгээс гадагшаа ургалтай голуудад урсацын тохируулга хийсэн тохиолдолд хилийн усны хэлэлцээртэй холбоотой асуудлууд зайлшгүй хөндөгдөх бөгөөд үүнд Орхон, Туул голуудтай холбогдох асуудал Оросын Холбооны Улстай хийсэн, Хэрлэн голоос ус татх асуудал БНХАУ-тай хийсэн хилийн усны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарна;
- ✓ Орхон төслийн хувьд Байгаль нуурт нөлөөлж болзошгүй гэсэн асуудал үүсэж, улмаар Орос-Монголын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хоёр талын эрдэмтдийн дэд ажлын хэсэг хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ төслийн хүрээнд эхний ээлжинд Орхон, Шүрэнгийн УЦС-ын төслийг хамруулан Бүс нутгийн байгаль орчны үнэлгээг (БНБОУ) хийлгүүлэх нь зүйтэй гэж үзээд байна¹³;
- ✓ Хэрлэн голын хувилбарыг хэрэгжүүлэх боломж бүрдэх эхлэл тавигдан энэ төслийн ТЭЗҮ, БОННУ-г хийх талаар 2017 оны 8-р сард Засгийн газрын тогтоол батлагдаад байна. Өнөөдрийн байдлаар Хэрлэн голын төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын санхүүжилтийг шийдвэрлэж, эхлүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар ажиллаж байна.

¹³ Хөгжлийн түлхүүр “УС”, 2018 он

- ✓ Хэдийгээр Говийн дэд бүсийг усаар хангах хувилбарууд яригдаж байгаа боловч хөрөнгө мөнгөний хүрэлцээ муугаас голлон шалтгаалж цогц үнэлгээ хийгдээгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх ТЭЗҮ боловруулагдаагүй байна.

Санал, зөвлөмж

Ландшафтын гадны нөлөөнд өртөх эрсдэлийн үнэлгээг *боловсруулсны дараа* байгаль хамгааллын бодлогын асуудлыг цогц байдлаар авч үзэх нь зүйтэй. Манай орны хэмжээнд экосистемийн цогц байдал ихээхэн өөрчлөгдөж, ялангуяа цөлжилтөнд хүчтэй нэрвэгдэж, говь, хээрийн бүсийн экосистемийн бэлчээр нутаг алдралд орж, биологийн элдэв төрөл зүйл хомсдож, тэдгээрийн цогц байдал алдагдан экологийн тэнцвэрт харьцаа улам доройтох хандлагатай болж байна. Одоогоор доройтсон газар орчинг зориудаар нөхөн сэргээх үйл ажиллагааг өргөн хэмжээнд явуулах, нөхөн сэргээх арга технологи боловсруулах нь чухал байна. Зориудаар нөхөн сэргээх үйл ажиллагааг өнөөгийн байдлаар маш бага хэмжээний талбайд хийж байгаа бөгөөд тухайлбал, цөлийн хээрийн бүсэд хамрагдах төв суурин газруудаас Өмнөговь аймгийн төв, Дорноговь аймгийн Замын-Үүд зэрэг сумдын төвийг элсний нүүлт хөдөлгөөнөөс хамгаалах ойн зурвас, ногоон бүс байгуулах зориудаар нөхөн сэргээх үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байна.

Говийн дэд бүсийн хэмжээнд бэлчээр сайжруулалтын ажил орхигдсон нь ажиглагдсан бөгөөд бэлчээр сайжруулалтыг дэлхийн хэмжээнд явуулсан туршилт судалгааны ажлын дүнг харгалзахын зэрэгцээ экологийн тодорхой нөхцөлд дасан зохицсон унаган ургамлын гарал үүслийн онцлог, тэдгээрийн тэсвэрт чанарыг тооцох нь зүйтэй.

Говь, цөлийн бүсийн байгалийн нөхөн сэргээлт удаан явагдах, хөрс хамгааллын богино хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулагдаагүй байгаа нь хөл газрын ургамлын тархалт нэмэгдэх үндсэн нөхцөл болж байна. Иймд говь, хээрийн бүсийн тэгш тал газруудад бэлчээрийг сэлгээтэй ашиглах эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж газар тариаланд ашиглахыг бүрэн хориглох нь зүйтэй. Үүнээс гадна говь, цөлийн бүсийн хэмжээнд машин техникийн нөлөөний улмаас олон хөрсний доройтол нэмэгдэх хандлагатай байна, үүний нэг жишээ бол олон салаа зам үүсэх явдал юм. Иймд бүс нутгийг ногооруулах, ургамалжуулах, олон салаа замаар зорчихгүй байх зэрэг хамгаалалтын арга хэмжээг авах нь доройтлоос сэргийлэх арга хэмжээний бас нэг хэлбэр юм.

Говийн дэд бүсэд уул уурхайн үйл ажиллагаа нь экосистемийг хэт хүчтэй доройтуулагч хүчин зүйл болоод байна. Эдгээр үйл ажиллагаа нь хүний нөлөөгөөр явагдаж байгаль орчинд хор хөнөөлт голомт үүсгэгч эх үүсвэр болдгоороо онцлогтой. Иймээс нэн даруй экологийн чадавхийг дээшлүүлэх нөхөн сэргээх үйл ажиллагааг явуулах шаардлагатай. Энэхүү үйл ажиллагаанд асар их хөрөнгө шаардагдах ба эхлээд техник, дараа нь ойжуулалт, усжуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэх нь зайлшгүй. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг тухайн газар нутгийн геологи-геоморфологийн онцлог, байгалийн бүс, бүслүүр дэх түүний байршил, зэргэлдээ орших экосистемүүдийн онцлог болон элэгдэл эвдрэлийн зэрэглэл, ландшафтын гадны нөлөөнд өртөх эрсдэлийг харгалзан төлөвлөх шаардлагатай бөгөөд давхар ашиглалтын технологид хяналт тавих, агаар болон усан мандал бохирдуулагчийг багасгах технологийг нэвтрүүлэхийн зэрэгцээ хаагдсан уурхайн орхигдсон газруудыг нөхөн сэргээх нь газрын баялгийг ашиглах үйл ажиллагааны салшгүй хэсэг нь болох ёстой. Уул уурхайн аж ахуйн хэлбэрүүдэд байгальд ээлтэй ашиглалтын технологийг нэвтрүүлэхийг үйл ажиллагааны анхан шатанд анхааран үзэх шаардлагатай. Ялангуяа тээвэрлэлтийн асуудлыг анхааран үзэж, хөдөөгийн шороон замыг хатуу хучилттай болгох нь олон салаа замын байгаль орчинд учруулах хор хөнөөлийг багасгах нь дамжиггүй. Байгалийг зохистой ашиглах ба экосистемийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд бүсүүдийн статусыг тодорхой болгох нь ихээхэн ач холбогдолтой.

Цөлжилтийн явцад хүний үйл ажиллагааны үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор уул уурхайн үйл ажиллагааг хянаж, нөхөн сэргээлт хийлгэхийн зэрэгцээ бэлчээрийн даацыг барьж, нэг уст цэгийн ойролцоо малын тоог хязгаарлах бодлого хэрэгжүүлэх зэрэг болно.

Дэлхийн ТХЗ-д 2030 он гэхэд ил задгай бие засах явдлыг эцэс болгоно гэсэн зорилт тавьсан бөгөөд үүнийг биелүүлж монгол хүний эрхийг хангахын тулд малчдын ариун цэврийн байгууламжийг оновтой шийдвэрлэх гарц шийдэл эрэлхийлэх, асуудлыг хариуцах байгууллагыг тодорхой болгох шаардлагатай байна.

Говийн 4 аймгийн хүн амын усны аюулгүй байдлыг сайжруулах, үүнд баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, эрүүл ахуйн нөхцөлийг дээшлүүлэх, хөдөөгийн хүн амыг зорилтот бүлэг болгон авч олон жил яригдаж, тодорхой эзэнгүй орхигдож байгаа малчдын ус хангамж, ариун цэврийн асуудлыг цогцоор шийдэх нь зүйтэй. Говийн эдийн засгийн өсөлтийг хангах усны нөөцийн шийдлүүдийг цогц байдлаар судалж, одоо байгаа судалгаануудад үнэлгээ өгөн, ус шилжүүлэх төслүүдэд олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц ТЭЗҮ хийлгэх хэрэгтэй.


Говийн дэд бүсийг усаар хангах хувилбаруудад цогцоор Стратегийн үнэлгээ хийх, нэгдсэн бодлого барих үндэслэлийг боловсруулж, хэрэгжүүлэх нь зайлшгүй.

Хилийн усны хэлэлцээрт нэмэлт оруулах асуудлыг эрчимжүүлэх, хэлэлцээрт Сэлэнгэ, Хэрлэн голуудаас Монгол улсад ашиглах урсацын хувь хэмжээг тусган оруулах нь зүйн хэрэг.

1.2 Эдийн засаг

Эдийн засгийн бүс нутаг гэдэг нь газарзүйн байршлаараа ойр дөт, нэгдмэл нэг дэд бүтэцтэй, түүндээ тулгуурлан харьцангуй бие даан хөгжих бололцоотой аж үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ болон эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэх боломжтой засаг захиргаа, нийгэм эдийн засаг, нутаг дэвсгэрийн цогцолбор болно. Монгол орны эдийн засгийн төв бүс нь уул уурхайн голлох ордууд, Дарханы үйлдвэр технологийн бүс, Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор, Говьсүмбэрийн логиستيкийн төв зэрэг үйлдвэрлэлийн гол бүс, Ази Европыг холбосон авто зам, төмөр зам, хилийн голлох Замын-Үүд, Ханги мандал, Гашуунсухайт, Цагаан дэл, Шивээ хүрэн боомтуудыг өөртөө багтаасан онцлог бүс нутаг юм.

Зураг 7 Ерөнхий зураглал



Эх сурвалж: МУИС. Геологи, газарзүйн тэнхимийн судалгааны баг, 2020

Говийн дэд бүсийг бусад бүстэй харьцуулбал түлш-эрчим хүч, уул уурхайн олборлох болон баяжуулах үйлдвэр, барилга, барилгын материалын үйлдвэр, хөнгөн-хүнс зэрэг аж үйлдвэрийн олон салбар харьцангуй сайн хөгжсөн. Тус бүс нь ашигт малтмалын нөөцөөр баялаг, улсын хэмжээнд дээгүүрт орох стратегийн ач холбогдол бүхий олон ордууд энэ бүсэд байрладаг.

Говийн дэд бүс нь 2017 оны байдлаар ДНБ-ий бараг 26%-ийг хөдөө аж ахуй, 39%-ийг аж үйлдвэр, 35%-ийг үйлчилгээний салбар эзэлж байгаагаас харахад бүсийн голлох салбар нь аж үйлдвэрийн салбар байна. Энэхүү дэд бүс нь эдийн засгийн төвийн бүсийн ДНБ-ий 47%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд салбаруудаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбарын 48%, аж үйлдвэрийн салбарын 44%,


үйлчилгээний салбарын 49%-ийг тус тус нийлүүлж байгаа эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдол бүхий дэд бүс болно.

Хөдөө аж ахуйн салбар

Монгол улс хангай, хээр, цөлөрхөг хээр, говийн бэлчээр хосолсон 110.4 сая га бэлчээр, 1.7 сая га хадлангийн талбай бөгөөд нийт 112,1 сая га бэлчээр, хадлангийн талбайтай. Бэлчээр, хадлангийн талбай нь хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 97 хувийг эзэлдэг бөгөөд нийт бэлчээрийн 52,9 сая га-г өвөл, хаврын улиралд 60,3 сая га-г зун намрын улиралд ашиглаж байна. Монгол улсын хэмжээнд урьдчилсан дүнгээр 2018 оны жилийн эцэст малын тоо 66.4 сая толгойд хүрч, өмнөх оныхоос 250 мянган толгой буюу 0.36 хувиар өсчээ.

Говийн дэд бүс нь Монгол улсын нийт газар нутгийн 22.7 хувийг хамрах боловч нийт мал сүргийн 13.4 хувь нь буюу 9 сая мал ногдож байна. Өөрөөр хэлбэл, нэгж талбайд ногдох малын тоо бусад бүстэй харьцуулахад бараг хоёр дахин бага гэсэн үг. ***Мал аж ахуйн салбарын тухайд*** сүргийн бүтцийг авч үзвэл говийн дэд бүсэд тэмээ ба ямаан сүргийн нягтшил бусад бүстэй харьцуулахад илүү өндөр буюу харгалзан 51.2 ба 16.8 хувийг эзлэж байгаа бол үхэр сүргийн 4.5 хувь нь тус бүсэд ногдож байгаа нь үхэр адгуулахад тохиромж багатай болохыг харуулж байна. Хэрэв богт шилжүүлбэл 2018 оны байдлаар Монгол улсын нийт мал сүргийн тоо 111 сая толгой хонин толгойгоор илэрхийлэгдэх бөгөөд нийт мал сүргийн 11.7 хувь нь говийн дэд бүсэд ногдож байна. Өөрөөр хэлбэл, малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацын хувьд бусад бүстэй харьцуулахад хоёр дахин бага ачаалал үүрч байна. С.Цэрэндаш¹⁴ нарын (2018) тогтоосон 86 сая хонин толгойн бэлчээрийн боломжит хэмжээнээс 24.8 сая толгойгоор хэтэрчээ. Одоогийн байдлаар зөвхөн улсын хэмжээнд Дорнод, Өмнөговь, Дорноговь аймагт мал сүргээ нэмж өсгөх бэлчээрийн боломжтой байгаа гэж тооцоолсон.

Зураг 8. Хонинд толгойд шилжүүлсэн 100 га бэлчээрт ногдох малын тоо, аймгуудаар



Эх сурвалж: ҮСХ

Бэлчээрийн газраас хот суурингийн дэд бүтэц, ашигт малтмал, газар тариалан зэрэг өөр ангилалд шилжиж байгаа нь бэлчээрийн талбайн хэмжээ багасах шалтгаан болоод байна (Ш.Сэржхүү 2018). Үүнээс үүдэлтэйгээр 2017 оны байдлаар бэлчээрийн талбайн хэмжээг 1964 оны бэлчээрийн талбайтай харьцуулахад 9.0 сая га-гаар багасчихаад байна. Ш.Сэржхүү нарын (2018) тооцооноор Монгол улсын өнөөгийн нийт бэлчээрийн нөөц, боломжид үндэслэн тохируулан тооцоолсон мал нь


¹⁴ Ш.Сэржхүү, “Мал сүргийн тоог бэлчээрийн даац, нөхцөлтэй уялдуулж тогтоох”, 2018, ҮСХ

толгойн дүнгээр 51.6 сая толгой гарсан нь 2017 онд тоологдсон малаас 22.0 хувь буюу 14.6 сая толгойгоор бага байж зохист түвшиндээ очихоор байна.

Бэлчээрийн хэмжээ, даац буурч байгаа шалтгаан нь бэлчээрийн хортон шавж, мэрэгчдийн тархалт юм. ХХААХҮЯ-ны мэдээгээр 2008-2017 онуудад бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой 5,541.2 мянга га, царцаатай 998.1 мянган га талбайд тэмцэх арга хэмжээг зохион байгуулжээ. Үүний үр дүнд бэлчээрийн ургамал хамгааллын ажлын үр дүнд нийт 6.5 сая га талбайгаар бэлчээрийн даац багтаамжийг нэмэгдүүлэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэвийн явуулаад эерэг нөлөө үзүүлжээ. Энэ нь нэг га талбайгаар бэлчээрийг нэмэгдүүлэхэд ойролцоогоор 2200 төгрөгийн зардал гаргасан гэсэн үг.

Сүргийн бүтцийг авч үзэхэд 1970 онд нийт сүрэгт эзлэх ямааны хувийн жин 18.6 хувь байсан бөгөөд жилийн 48 жилийн хугацаанд уг үзүүлэлт жилд дунджаар 1.6 хувь өсөж 2018 он гэхэд 40.8 хувьд хүрчээ. Говийн дэд бүсийг авч үзвэл нийт сүрэгт эзлэх ямааны жин 1970 онд улсын хэмжээний үзүүлэлттэй харьцуулахад 8.6 пунктээр илүү буюу 27.2 хувь байсан бол 2018 он гэхэд уг үзүүлэлт улсын хэмжээний үзүүлэлттэй харьцуулахад 10 пунктээр илүү буюу 50.1 хувьд хүрч нийт мал сүргийн талаас илүү хувь нь ямаа болоод байна.

Зураг 9. Нийт мал сүрэгт ямаан сүргийн эзлэх хувь, улсын дундаж, сонгосон аймгаар




Эх сурвалж: ҮСХ

Дөрвөн аймгийн ямаан сүргийн эзлэх хувь улсын дүнгээс илүү бөгөөд Өмнөговь аймгийн хувьд хамгийн өндөр буюу нийт сүргийн 2/3 –ийг ямаа бүрдүүлснийг харж болно. Ямаан сүргийн тоо толгой өсөхөд нөлөөлж буй нэг чухал хүчин зүйл нь ноолуурын үнийн өөрчлөлт болохыг Өмнөговь, Говь-Алтай аймгуудын малчдын өгөгдөлд үндэслэн хийсэн судалгааны үр дүн харуулж байна¹⁵. Судалгааны гол үр дүнгүүдийн нэг нь инфляцийн улмаас өрхийн амьдралын өртөг нэмэгдэж байгаатай ижил чиглэлд гэхдээ гурав дахин илүү хурдтайгаар ноолуурын урамшууллыг өсгөх болсон нь бэлчээрийн доройтлын үндсэн шалтгаануудын нэг болсон гэж харуулсан бөгөөд том хөхтөн амьтадын амьдрах орчинг хумиж байгаа хүчин зүйлүүдийн нэг болсон гэж үзжээ. Гэтэл 1970 оноос хойш ямаан сүргийн эзлэх хувийн жин тасралтгүй өссөөр 2008 онд оргилдоо (улсын хэмжээнд 46.1 хувь, Говийн дэд бүст 56.4 хувь, Өмнөговь аймагт 70.5 хувь) хүрч улмаар алгуур буурсан дүр зураг ажиглагдаж байна (Энэ хугацаанд ямааны тоо толгой нэмэгдсээр байгаа).

¹⁵ Berger *et al.* 2013. Globalization of the Cashmere Market and the Decline of Large Mammals in Central Asia, Conservation Biology, 27 (3)


Зураг 10. Өвчнөөр хорогдсон малын нийт малд эзлэх хувь, аймгаар, 2009-2018



Эх сурвалж: ҮСХ

МАН-н салбарын хувьд малын тоо, бэлчээрийн даацаас гадна малын зүй бус хорогдолын хувь Говийн дэд бүсийн хувьд авч үзэх нь малын эрүүл мэндийн тогтолцоо бусад бүсээс хэр зэрэг зөрүүтэй байгааг харах боломж олгоно. Өвчнөөр хорогдсон малын нийт сүрэгт эзлэх хувийг харвал Дундговь аймаг улсын дунджаас өндөр байгаа бол бусад аймгуудын хувьд улсын дунджаас бага байдаг ерөнхий төлөвтэй байна. Зураг 3-аас харахад сүүлийн 10 жилийн хугацаанд өвчнөөр хорогдсон малын нийт сүрэгт эзлэх хувь улсын дунджаар буурах төлөвтэй байгаа бол Дундговь аймгийн хувьд өсөх хандлагатай, Дорноговь аймгийн хувьд 0.06 хувь орчимд хэлбэлзэх хандлагатай байна. Харин Говьсүмбэр, Өмнөговь аймгуудын хувьд улсын дунджаас бага бөгөөд буурах хандлагатай байна.

Зураг 11. Бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар гаргасан уст цэг худгийн тоо




Эх сурвалж: ҮСХ

Улсын хэмжээнд 2006 оны байдлаар бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар гаргасан уст цэг, худгийн тоо 28.3 мянга байсан бол 2018 он гэхэд 48.3 мянга болж 1.7 дахин өсчээ. Мөн хугацаанд Говийн дэд бүсэд эсрэгээрээ 1.8 хувиар буурсан дүнтэй байна. Өөрөөр хэлбэл, 2006 онд нийт гаргасан уст цэг, худгийн 42 хувь нь Говийн дэд бүсэд хамаарагдаж байсан бөгөөд энэ үзүүлэлт тасралтгүй буурсаар 2018 гэхэд 23 хувьд хүрчээ. Өмнө хэсэгт дурдсанчлан бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж болох гурван аймгийн хоёр нь энэ бүсэд харъяалагдаж байгааг тооцвол шинээр уст цэг, худаг гаргах ажлыг эрчимжүүлэх нь үр өгөөжтэй ажил болох боломжтой.

МАН-н салбар бараг бүхэлдээ байгаль цаг уурын нөхцөлөөс бүрэн хамаарах бэлчээрийн аж ахуйн шинжтэй тул байгалийн гамшигт үзэгдлээс сэргийлэх нь чухал ач холбогдолтой. ХХААХҮЯ-ны мэдээллээс харахад 1940-2018 он хүртэл нийт 79 жилийн судалгаагаар өнтэй буюу хэвийн жил 42 (55 хувь) тохиолдсон бол ган, зудтай жил 36 буюу 45 хувь байжээ¹⁶.

Зураг 12. Зудтай жилүүд, 1940 – 2018 он, улаан өнгө – ган, зудтай жилүүд



Эх сурвалж: ХХААХҮЯ

Ган, зудтай жилийн давтамж нь ямар нэг тодорхой зүй тогтолгүй бөгөөд урьдчилан тааварлахад бэрх байгаа ч ган, зудтай жилүүдийн тасралтгүй үргэлжлэх хугацаа уртсах хандлагатай болж байгаа нь ажиглагдаж байна. 2009–2018 оны хооронд байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотойгоор улсын төсвөөс 81.2 тэрбум төгрөг, бусад олон улсын болон дотоодын хандивлагчдын тусламж 58.6 тэрбум төгрөг, нийт 139.8 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Гамшигт үзэгдэл тохиолдох эрсдэл улам бүр нэмэгдэж байгаа тохиолдолд МАН-н салбарыг байгалаас хараат бус болгох шаардлага урган гарч байна. Иймээс Монгол улсын Засгийн газраас шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр улсын хэмжээнд 1727 аж ахуйн нэгжид 74.0 мянган толгой сүүний чиглэлийн үхэр, 236 аж ахуйн нэгжид 28.7 мянган толгой махны чиглэлийн үхэр, 1511 аж ахуйн нэгжид 353.1 мянган толгой мах, ноосны хонь, 34 фермд 13.1 мянган толгой гахай, 40 фермд 766.9 мянган толгой тахиа, 31 ферм, 397 өрхийн 11492 бүл зөгий тоологдлоо. ХХААХҮЯ-ны мэдээгээр сүүлийн 11 жилийн хугацаанд сүү ба махны чиглэлийн 2329 үхэр импортлосноос Говийн дэд бүсэд дөнгөж 5 үхэр (Замын-Үүд) ногдож байгаа нь туйлаас хангалтгүй юм.


Хүснэгт 4.Эрчимжсэн МАН-н салбарын зарим үзүүлэлтүүд, улсын дүнгээр

Эрчимжсэн аж ахуй	2010	2014	2017
Сүүний үхрийн аж ахуй	649	1554	1727
	21412	59799	74077
Махны үхрийн аж ахуй	101	351	236
	11307	12705	28788
Мах, ноосны хонины аж ахуй	128	236	1511
	101681	43388	353165
Гахайн аж ахуй	190	476	Ферм - 34, Өрх - 915
	15064	32094	28440
Тахианы аж ахуй	148	405	Ферм - 40, Өрх - 1157
	397468	761973	798439
Зөгийн аж ахуйн	68	299	Ферм - 31, Өрх - 397

¹⁶ <http://mofa.gov.mn/exp/blog/7/8>

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байна. 2010 оны дүнтэй харьцуулахад сүүний үхрийн аж ахуй 2.7 дахин өсөж, 1727 болсон бөгөөд үхрийн тоо 3.5 дахин өсөж, 74 мянгад хүрчээ. Махны үхрийн аж ахуйн хувьд мөн хугацаанд 2.4 дахин олон болж үхэр сүргийн тоо толгой 2.6 дахин өсөж бараг 29 мянгад хүрээд байна. Туслах аж ахуйн хувьд зөгий ба тахианы аж ахуй хүчин чадал нэмэгдэж, гахайных бага зэрэг буурчээ. Говийн дэд бүсийн хувьд 2008 оноос хойш гадаадаас импортлон оруулж ирсэн өндөр ашиг шимт малын мэдээлэл бүртгүүлсэн ганц тохиолдол байгаа нь Дорноговь аймгийн Замын-Үүдэд бүртгэгджээ. Эндээс үзэхэд ХХААХҮЯ-наас баримтлаж буй эрчимжсэн МАА-н бодлого говийн дэд бүсэд үр дүн багатай үйлчилж байгааг харуулж байна. Түүнчлэн эрчимжсэн МАА-н салбарыг хөгжүүлэхтэй холбоотойгоор мэдээллийн нэгдсэн санг үүсгэж хөгжлийн бодлого хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг хянах хэрэгцээ шаардлага гарч байна.

Зураг 13. Махны үйлдвэрлэл, төрлөөр, улсын дүнгээр, мянган тонноор




Эх сурвалж: ҮСХ

Сүүлийн жилүүдэд бэлтгэсэн махны хэмжээ ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Бүтцийн хувьд авч үзвэл үхрийн ба адууны махны эзлэх хувийн жин нэмэгдсэн дүнтэй, хонь ба ямааны махны хэмжээ өссөн боловч эзлэх хувийн жин нь бага зэрэг буурсан дүнтэй байна. Харин сүүний үйлдвэрлэлийн хэмжээг авч үзвэл улсын дүнгээр сүүлийн зургаан жилийн хугацаанд хувиар өсч, хүрсэн бөгөөд үнээний сүүний өсөлт хамгийн том нөлөөг үзүүлжээ. Сүүний хоёрдогч том эх үүсвэр нь ямаан сүрэг бөгөөд 2018 оны байдлаар 173.6 мянган литр сүүг саасан дүнтэй байна.

2011-2017 онд нийт 160 мянган тонн ноос бэлтгэгдсэн бөгөөд мөн хугацаанд үндэсний үйлдвэрт хонь, тэмээний ноосоо тушаасан 593.7 мянган /давхардсан тоогоор/ малчин, мал бүхий хуулийн этгээдэд 158.5 тэрбум төгрөгийн урамшууллыг олгоод байна. Ноосны урамшуулал олгосноор ноосон түүхий эдийн ач холбогдлыг малчид сайтар ойлгосон, тэдний хандлага өөрчлөгдөж хяргасан ноосоо ашиглахгүй хаях, норгох шатаах зэрэг үзэгдэл алга болсон, ноос бэлтгэлийн чанарт анхаардаг болсоноор ноосон түүхий эдийн ашиглалт нэмэгдсэн ба тэмээний тоо толгой 24.8 хувиар

өссөн үзүүлэлт гарсан гэж ХХААХҮЯ дүгнэжээ. Тэмээн сүргийн өсөлт дан ганц урамшууллаар шийдэгдсэн гэж үзэх нь учир дутагдалтайг анхаарах шаардлагатай. Цаашид төрөөс олгох урамшууллыг ноосны чанар, үүлдэрлэг байдлаас хамааран ялгавартайгаар олгодог болох нь хамгийн зохистой хувилбар гэж үзэж, судалгааг эхлүүлэх санал холбогдох байгууллагуудаас гарч байна. Малчдын ноосны чиглэлийн үүлдрийн малыг өсгөж үржүүлэх санал санаачилга нэмэгдэж, улмаар ноосны чиглэлийн үүлдрийн малын тоо толгой, нийт мал сүрэгт эзлэх хувь өсөх ба салбарын баримталж буй бодлоготой уялдаж байгаа юм.

Зураг 14. Бэлтгэгдсэн ноос ба олгогдсон урамшууллын хэмжээ, улсын дүнгээр, 2011-2017



Эх сурвалж: МУИС-ийн ЭЗХ. Д.Насанжаргал, С.Амартүвшин, Б.Цогт-Эрдэнэ. ХХААХҮЯ ба ҮСХ-ны мэдээлэлд үндэслэн тооцов.

Нийт бэлтгэгдсэн ноосны тооцооллыг хийхдээ ҮСХ нь хонин сүргийн хувьд 7 сар хүртэлх хорогдлыг, ямаан сүргийн хувьд оны эхний 2 сарын хорогдлыг, бусад малын хувьд оны эхний 3 сард хорогдсон малын тоог хасаж, үлдэх дүнгээр тооцоолдог бол урамшуулал олгогдсон ноос нь ноос угаах үйлдвэрүүдэд тушаагдсанаар бүртгэгдэх тул илүү бодит тоо болно. Урамшуулал олгож эхэлснээр тушаагдсан ноосны хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа ч сүүлийн жилүүдийн малын огцом өсөлттэй харьцуулахад бага байгаа нь урамшууллын хөтөлбөр сайн ажиллаж байгаа эсэхийг нягтлан шалгах үндэслэл болж байна. Тухайлбал, урамшуулалд зарцуулсан мөнгөн дүн 2013 онд 36,6 тэрбум төгрөг, бүртгэгдсэн ноосны хэмжээ 18.2 мянга байсан бол 2014 онд олгосон урамшууллын хэмжээ хоёр дахин багассан байхад бүртгэгдсэн ноолуурын хэмжээ харьцангуй багаар буюу 8 хувиар буурчээ. Арьс, ширний нийлүүлэлтийн хувьд мөн адил төрөөс урамшуулал олгох хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд нийт бэлтгэгдэх боломжтой арьс ширний ¼ орчим нь дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэгдэж байна. Нийт бэлтгэгдсэн арьс, ширний хэмжээг тооцохдоо хүнсэнд хэрэглэсэн мал дээр зүй бусаар хорогдсон том мал, хорогдсон төлөөс ашигласан арьс, ширний хэмжээг тодорхой үржүүлэгч ашиглан нэмж тооцох ҮСХ-ны аргачлал нь тойм хэлбэрээр хийгддэг ч тухайн хугацаанд бодитоор нийлүүлэгдэх боломжтой арьс, ширний хамгийн их хэмжээг харуулах давуу талтай.

Хүснэгт 5. Бэлтгэгдсэн арьс шир ба урамшууллын үзүүлэлтүүд

Он	Нийт бэлтгэгдсэн арьс ширний хэмжээ /мян.ш/	Урамшуулал ногдуулалт			
		Нийт дүнд эзлэх хувь	Бодын тоо /мян.ш/	Богийн тоо /мян.ш/	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/

2013	9934.1	7%	40.6	700.8	2.7
2014	9196.1	23%	163.5	1909.1	8.1
2015	13673.6	18%	168.5	2324.4	9.5
2016	12601.0	25%	278.2	2846.7	12.7

Эх сурвалж: МУИС-ийн ЭЗХ. Д.Насанжаргал, С.Амартүвшин, Б.Цогт-Эрдэнэ. ХХААХҮЯ ба ҮСХ-ны мэдээлэлд үндэслэн тооцов.

2013 онд нийт арьс ширний дөнгөж 7 хувь нь дотоодын үйлдвэрүүдэд журмын дагуу нийлүүлэгдэж урамшуулал авч байсан бол дараагийн жилүүдэд нь огцом нэмэгдэж 25 хувьд хүрчээ. Энэ төрлийн урамшууллын хувьд мөнгөн дүнгийн өсөлтийн хувь нь ойролцоо хамааралтай байна. Урамшууллын дүн бод ба бог малд өөр өөр байгаа тул нөлөөлөл нь адилгүй байна. Энэ хугацаанд бод малын арьс, ширний урамшуулал илүү үр дүнтэй ажиллаж мөн хугацаанд 7 дахин өссөн дүнтэй байгаа бол богийн арьс, ширний хувьд 4 дахин нэмэгджээ.

Газар тариалангийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг газар тариалангийн салбарт төрөөс баримтлаж байгаа бодлогыг газарзүйн байршилтай холбон авч үзлээ. Төрөөс газар тариалангийн талаар баримтлах бодлогын хүрээнд нийт нутаг дэвсгэрийг 5 бүсэд хувааж, өөр хооронд нь харилцан адилгүй байдлаар бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. 2018 оны ургац хураалтын урьдчилсан дүнгээр нийтдээ 453.8 мянган тонн үр тариа, 168.8 мянган тонн төмс, 100.7 мянган тонн хүнсний ногоо, 123.8 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан аваад байна.

Хүснэгт 6. Говийн дэд бүсийн газар тариалангийн талбайн үзүүлэлтүүд

Говийн бүс	Тариалангийн нийт талбай, га	Ашиглагдаж буй талбай, га	Атаршсан талбай, га	Ашиглалтгүй талбайн эзлэх хувь
Говьсүмбэр	51	51	0	0
Дорноговь	60	60	0	0
Дундговь	101	101	0	0
Өмнөговь	164	164	0	0
Нийт дүн	376	376	0	0
Улсын дүн	1269498	740732	548766	51.9

Эх сурвалж: ХХААХҮЯ

Говийн дэд бүсэд тариалангийн талбайг 376 га гэж тооцсон бөгөөд энэ бүсэд байгаль, цаг уур, газарзүйн нөхцөл байдлаас шалтгаалан үр тарианы ургамал тариалахад тохиромжгүй гэж үздэг. Ашиглалтгүй атарсан газар бүртгэгдээгүй бөгөөд бүртгэгдсэн бүх талбайд төмс, хүнсний ногоо тариалсан гэж бүртгэгджээ.

Зураг 15. Хураан авсан төмс, хүнсний ногооны хэмжээ, тонноор



Эх сурвалж: УСХ

Газарзүйн онцлогоос шалтгаалан ил талбайн тариалалт эрхлэх нь тохиромжтой биш тул тус бүс нутагт усалгаатай, хамгаалалттай тариаланг хөгжүүлэхээр төрөөс баримтлах бодлогод тусгасан. ХХААХҮЯ-ны мэдээгээр 2004-2015 онуудад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон орон нутгийн өмчлөлийн 327 услалтын системийг сэргээн засварлаж, шинэчилж, шинээр байгуулахад улсын төсвөөс 37,7 тэрбум төгрөгийн, хувийн хэвшилээс 42,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээр 54,0 мянган га талбайг усжуулах боломжтой болсон. Мөн гадаадын төсөл хөтөлбөрөөс 343.7 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, жижиг услалтын системийг засварлаж, усалгааны тоног төхөөрөмж олгосон. Үүний үр дүнд хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилтэй 327 услалтын системийг ашиглалтад оруулж, усалгаатай тариалангийн хэмжээг 54.0 мянган га-д хүргээд байна. Тэдгээрийн 213 услалтын системийн 16,5 мянган га талбайг бороожуулагч машин, бичил усалгааны төхөөрөмж ашиглан услаж байна. Усалгааны ажлын механикжуулалтын түвшин 32.2 хувьд хүрээд байна.

2017 оны байдлаар 1990 онтой харьцуулахад хамгаалалттай газар тариалангаас авах ургацын хэмжээ 4.3 дахин нэмэгдэж, 5.1 мянган тонн болж, хүлэмжийн талбайн хэмжээ 8.4 дахин өсөж, 75.9 га-д хүрсэн боловч дотоодын лооль, хэмх, чинжүүний хэрэгцээний дөнгөж 1/3 хангах хэмжээнд байна. Агуулах зоорийн хувьд 2017 оны байдлаар 1990 онтой харьцуулахад 3.4 дахин нэмэгдэж, тухайн хугацаанд тасралтгүй нэмэгдсээр 270 мянган тоннд хүрчээ. Аймгуудын түвшинд нарийвчилсэн мэдээлэл ил тод биш байна.

Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд газар тариалангийн салбарт чухлаар авч үзэгдэх нэг зүйл нь тэжээлийн ургамал тариалах явдал юм. Тэжээлийн ургамал тариалсан талбай өмнөх нийгмийн үетэй харьцуулахад 5 дахин багассанаар ургац хураалт 10 дахин буурсан үзүүлэлттэй байна. 2017 оны байдлаарх тэжээлийн үйлдвэр, цехийн судалгааны дүнгээс үзвэл Өмнөговь аймагт 3 бүртгэгдсэнээс бүгд үйл ажиллагаагаа зогсоосон, Дундговь аймагт 2 бүртгэгдсэнээс нэг нь үйл ажиллагаагаа зогсоосон, Дорноговь аймагт 4 бүртгэгдсэнээс 1 нь үйл ажиллагаагаа зогсоосон дүнтэй байгаа бол Говьсүмбэр аймагт нэг ч бүртгэгдээгүй байна. Нийт тэжээлийн ихэнх хэсгийг ойт хээр, өндөр уул, ялангуяа газар тариалангийн бүсэд бэлтгэж байсан. Тэжээл үйлдвэрлэл, тариалалтын хувьд оргил үе нь 1987 онд нийт 160,0 гаруй мянган га-д тэжээлийн ургамал тариалж 600,0 гаруй мянган тн тэжээлийн ургамал хураан авч байжээ.

Хүснэгт 7. Жимс, жимсгэний хураасан ургац, мян.кг-аар, улс, аймаг, жилээр

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
--	------	------	------	------	------	------	------	------


Улсын дүнд эзлэх хувь	0.3%	1.3%	0.7%	0.9%	0.6%	0.8%	1.0%	1.0%
Говийн дэд бүс	4,643	7,635	11,647	10,935	8,392	12,271	14,941	17,269
Говьсүмбэр	883	1,785	4,957	0	0	0	870	1,240
Дорноговь	0	500	0	0	800	0	0	13
Дундговь	320	1,250	1,900	2,245	22	6,224	3,626	1,317
Өмнөговь	3,440	4,100	4,790	8,690	7,570	6,047	10,445	14,699

Эх сурвалж: ҮСХ

Говийн дэд бүс нутгийн сумдад хавар эрт дулаарч намар орой хүйтэрдэг дулааны улирлын үргэлжлэх хугацаа харьцангуй урт учир хүнсний төрөл бүрийн ногоо тариалах, зарим ногооны үр үржүүлэх, хүлэмжийн аж ахуй эрхлэх, жимс жимсгэнэ тариалах, суулгац үржүүлэхэд боломжийн тохиромжтой гэж үздэг. Гэвч сүүлийн жилүүдийн ургацын хэмжээ хангалтгүй түвшинд байна. Жимс, жимсгэнэ хамгийн бага тариалдаг аймаг нь Дорноговь бол бүс нутагтаа хамгийн их жимс, жимсгэнэ тариалдаг аймаг нь Өмнөговь байна. Ерөнхийдөө говийн дэд бүсэд тариалагдаж байгаа жимс, жимсгэний хураасан ургацын хэмжээ алгуур боловч тогтвортой өсөх хандлагатай байна.

Энэ бүс нутагт дулаан илүү шаарддаг тарвас, амтат гуа, хулуу, чигсэнцэр, хэмх, лооль болон амтат ба халуун чинжүү зэрэг ногооны үр үржүүлэхэд илүү зохимжтой. Харин манжин, лууван, бөөрөнхий байцаа зэрэг ногооны үр үржүүлэхэд тийм ч зохимжтой биш байдаг гэсэн туршилт судалгааны дүгнэлт байна. Төлөвлөгөөт эдийн засгийн үед Өмнөговь аймгийн Булган, Дорноговь аймгийн Мандах сумын Цагаан цав зэрэг газарт тариалалт хийж үр үржүүлэх талаар ажиллаж байсан туршлага уламжлал бий. Мөн Өмнөговь аймгийн Даланзадгад зэрэгт яст болон үрт жимсний тариалалт хийгдэж байсан одоо ч тэр үеийн жимст цэцэрлэгийг өнөө хүртэл арчилж жимс авч бас зохих хэмжээгээр суулгац үржүүлж байна. Иймд энэ бүс нутагт импорт орлох яст болон үрт талбайн жимс жимсгэнийг (алим, чавга, лийр, тоор, интоор, бөөрөлзгөнө, хармаг, гоёо гэх мэт) түлхүү тариалах боломжтой. Энэ бүсэд зуны болон 3 улирлын халаалтгүй, мөн 4 улирлын халаалттай хүлэмжийн аж ахуй эрхлэх боломжтой. Өмнөговь аймаг энэ чиглэлээр нилээд үр бүтээлтэй ажиллаж байна. Цаашид хүлэмжийн аж ахуйг хүнсний ногооны чиглэлээр төдийгүй импорт орлох дулаан илүү шаарддаг мод буданд ургадаг болон өвслөг ишт жимсгэнийг өмнөд хөршийн туршлагаар тариалах боломжтой. Тухайлбал, усан үзэм, жүржийн төрлийн жимс, интоор, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, луун жимс, анар, тоор, лийр гэх зэрэг олон нэр төрлийн жимс жимсгэнэ тариалах боломжийн талаар тус салбарын мэргэжилтнүүд судалж байна.

Зураг 16 Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог /Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол/



Эх сурвалж: МУИС-ийн ЭЗХ. Судлаач Х.Билгүүн

Уул уурхайн олборлох, баяжуулах салбар


Монгол улсын уул уурхайн салбар нь эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг, 2009 оноос хойш улсын хөгжилд үзүүлж буй үр нөлөө хүчтэй байна. Ялангуяа говийн дэд бүсэд идэвхтэй ажиллаж байгаа уул уурхайн олборлох болон баяжуулах үйлдвэрийн аймгийн эдийн засагт үзүүлэх үр нөлөө ойрын ирээдүйд хүчтэй хадгалагдах хандлагатай. Хөгжил байршлаас харахад энэ бүсэд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын уурхай, үйлдвэрийн үйл ажиллагаа өргөн хүрээтэй, олон чиглэлээр өрнөж, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн 52.4%, хайгуулын тусгай зөвшөөрлийн 41.9% нь говийн аймгуудыг оролцуулан эдийн засгийн төвийн бүсэд ногдож байна. Зэс хайлуулах болон газрын тос боловсруулах үйлдвэр ч говийн дэд бүсэд баригдахаар болж, эхний ажлууд хийгдэж эхлээд байна.

Энэ бүс нутгийн хамгийн өргөн тархалттай эрдсийн нөөцийн нэг бол жонш юм. Монросцветмет нэгдлийн уулын үйлдвэр Дорноговь аймгийн Өргөн, Айраг, Даланжаргалан суманд ажиллаж Монгол улсын жоншны 30 хувийг үйлдвэрлэж байна. Мөн Даланжаргалан суманд "Кэйвин инвест" ХХК нь 98% хүртэл агуулгатай жонш баяжуулан Америк, Япон улсад экспортолдог. Эрдэнэ суманд "Коммод" ХХК жоншны хайгуул, олзворлолт, Айраг суманд БНХАУ-ын хөрөнгө оруулалттай "Янтай уул" ХХК жонш баяжуулан экспортолж байна.


"Доншен Монгол" ХХК нь Зүүнбаян суманд 2003 оноос газрын тосны хайгуул явуулж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заагдсан хайгуулын 5314 кв талбайд жилд 600 мянга орчим баррель түүхий нефть олборлож, экспортолж байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлд 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 1560 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын төрөл, байршлаар нь ангилан үзүүлэв.

Зураг 17 Ашиглалтын тусгай зөвшөөрөл (ашигт малтмалын төрлөөр)



Зураг 18 Ашиглалтын тусгай зөвшөөрөл (аймгаар)



Эх сурвалж: АМГТГ-ын цахим хуудасны мэдээлэл www.mrpam.gov.mn

Газрын тосны бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр

Урьдчилсан ТЭЗҮ-ээр боловсруулах үйлдвэрийг Чойр, Сайншанд, Бор-Өндөр, Чойбалсан зэрэг байршил дээр газрын тосны ордын байршил, дэд бүтэц, түүхий тос болон бэлэн бүтээгдэхүүний логистик, зах зээлд ойр байх зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалж, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт байгуулахаар Засгийн газрын тогтоол гарсан. Үйлдвэрийн үндсэн технологи, хүчин чадлыг олон улсад газрын тос боловсруулах үйлдвэрт өргөн ашиглагдаж байгаа 5 төрлийн

технологиос түүхий тосны шинж чанарт тохирсон байдал, тунгалаг бүтээгдэхүүний гарц, бүтээгдэхүүний стандарт зэргийг тооцоолж сонгохоор төлөвлөсөн. Үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1 тэрбум ам.доллар байх бөгөөд боловсруулах үйлдвэр 0.7 тэрбум ам.доллар, газрын тос дамжуулах хоолой 264.5 сая ам.доллар, жилд 1.2 тэрбум ам.долларын борлуулалт хийх, жилийн цэвэр ашиг 160 сая ам.доллар, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 8-10 жил байхаар тооцоолж байна. Тус үйлдвэр нь жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулж, евро-4, 5 стандартын шаардлага хангасан 560 мянган тонн автобензин, 670 мянган тонн дизель түлш, 107 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий болон бусад дагалдах химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Дэлхийн зах зээл дээр 1 баррель түүхий тосны үнэ 40-60 ам.доллар байх үед үйлдвэрийн нэгж бүтээгдэхүүний үнэ 866-1244 төг/л байхаар байна.

Нийгэм, эдийн засгийн үр ашгийн хувьд:

- Үйлдвэр ашиглалтад орсноор газрын тосны бүтээгдэхүүний импорт 1.2 тэрбум ам.доллараар буурч, энэ хэмжээгээр гадаад худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэнэ.
- Валютын гадагшаа урсгал 20 орчим хувиар буурч, ам.долларын ханш 18-25 хувиар буурна.
- Улсын болон орон нутгийн төсөвт бүх төрлийн татвар хураамж хэлбэрээр жил бүр ойролцоогоор 150 сая ам.доллар төвлөрүүлнэ.
- 600 гаруй шууд ажлын байр шинээр үүснэ.
- Үйлдвэрийг дагаж нийт 30 төрлийн будаг, автомашины дутуй, резинен эдлэл, хуванцар, хими- цэвэрлэгээний материал, үнэртэн гоо сайхан, эмийн үйлдвэрүүд байгуулагдана.
- Газрын тос боловсруулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдэгдэхээр болсон.

Хүнс, хөнгөн боловсруулах үйлдвэрийн салбар

Хүнсний үйлдвэрлэлийн салбарыг сүү, мах, гурил, исгэлт, хоол үйлдвэрлэл гэсэн дэд салбаруудаар ангилах нь зохимжтой бөгөөд хүнсний хангамж ба аюулгүй байдал зэрэг асуудлууд нь энэ дэд салбарын чухал асуудлуудад тооцогддог. Хүнсний үйлдвэрийн салбарын голлох үзүүлэлтүүдийг ҮСХ-ноос гаргасан аж үйлдвэрийн бүтээгдэхүүний сарын мэдээлэлд үндэслэн тооцов. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үнийн индексийг ашиглаж, 2010 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлэн жишив.

Зураг 19. Хүнсний бүтээгдэхүүн ундаа үйлдвэрлэлийн салбарын бүтцийн өөрчлөлт, нийт үйлдвэрлэл, 2010 оны үнээр, их наяд төгрөгөөр



2010 - 2018 оны хооронд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн дэд салбар даруй 3 гаруй дахин өсөж, 1.9 их наяд төгрөгт хүрээд байна. Хүнсний үйлдвэрлэлийн салбарын хувьд төрөөс дэмжлэггүйгээр хамгийн тогтвортой өсөж байгаа дэд салбар нь ундаа үйлдвэрлэл бөгөөд хэдийгээр хүнсний үйлдвэрлэлийн салбарт эзлэх хувийн жин нь буурсан мэт харагдаж байгаа ч биет үйлдвэрлэлийн хэмжээ нь тогтвортой өсөлттэй байна. Говийн дэд бүсийн аймгуудын хувьд статистикийн мэдээ хомс бөгөөд дэд салбаруудаар задарч гарахгүй байх тохиолдол гарч байна. Тухайлбал, Говьсүмбэр аймгийн статистик мэдээлэл нь дэд салбаруудаар задрахгүй байгаа тул үлдэх гурван аймгийн мэдээллийг жишив. Аймгуудын статистикийн хэлтсүүдийн мэдээллээр говийн дэд бүсийн хүнсний бүтээгдэхүүн ундаа үйлдвэрлэлийн улсын дүнд эзлэх хувийг авч үзвэл 2016 онд дөнгөж 0.3 хувийг эзлэж байсан бол 2017 онд 2.8 хувь болтлоо огцом нэмэгджээ. Гэхдээ энэ нь Дорноговь аймгийн үйлдвэрлэлийн хэмжээнээс шууд хамаарч байгаа бөгөөд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл бараг 16 дахин нэмэгдсэн шалтгаан нь мах бэлтгэлтэй холбоотой бөгөөд мах үйлдвэрлэл 32.4 тэрбум төгрөгөөр илэрхийлэгдэх мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

Хүснэгт 8. Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл

	2016	2017
Өмнөговь	551	337
Дорноговь	2058	33273
Дундговь	837	880
Улсын дүнд эзлэх хувь	0.3%	2.8%

Эх сурвалж: ҮСХ

Хүнсний үйлдвэрлэлийн салбарын голлох үзүүлэлтүүдийн нэг нь нийтийн хоолны салбар бөгөөд Хүснэгт 7-д нийтийн хоолны салбарын жилийн орлого зарлагын өөрчлөлт, ажиллагчдын тоо, багтаамж буюу суудлын тооны өөрчлөлтийг харуулав. Суудлын тоо 2016 онд 42.0 мянга байснаа 2017 онд 36.7 мянга болж буураад 2018 гэхэд эргээд өсч 46.2 мянгад хүрсэн байна.


Хүснэгт 9. Нийтийн хоолны салбарын голлох үзүүлэлтүүд

	2014	2015	2016	2017	2018
Орлого /тэрбум төгрөг/	201.5	205.5	231.4	298.8	397.2
Зардал /тэрбум төгрөг/	193.1	199.5	220.5	273.0	373.6
Ажиллагчдын тоо /мян.хүн/	7.7	8.8	9.2	9.2	11.0
Суудлын тоо /мян.хүн/	39.4	40.8	42.0	36.7	46.2

Эх сурвалж: ҮСХ

Хүнсний үйлдвэрлэлийн салбартай холбоотой төрийн бодлого нь хүнсний хангамж хүрэлцээ, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, хоол ундны шимт чанар гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Эдгээр асуудал нь өөр хоорондоо харилцан уялдаатай, аль нэгийг нь илүү түвшинд онцлон авч үзэх аргагүй хүчин зүйлсүүд боловч тоон мэдээллээр илэрхийлж болох нэг үзүүлэлт нь хүнсний хангамж юм.

Зураг 20. Хүнсний бүтээгдэхүүний хангамж



Эх сурвалж: ХХААХҮЯ

Манай улсын хувьд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, төмс ба хүнсний тосны хангамж нь 100 хувиас дээш байгаа бол хүнсний ногооны хангамжийн 82-88 хувийг, жимс, жимсгэний хангамжийн 14-24 хувийг, өндөгний хангамжийн 45-61 хувийг л хангах боломжтой байна. Иймээс хүнсний үйлдвэрлэлийн салбарт баримтлах бодлогыг дутуу хангамжтай байгаа хэсэг рүү түлхүү чиглүүлэх хэрэгтэй.

Хөнгөн үйлдвэрийн салбарын хувьд ноос ноолууран бүтээгдэхүүн, арьс ширэн бүтээгдэхүүн, өмол бүтээгдэхүүн, модон эдлэл, барилгын материал, сав баглаа боодол, хэвлэх цахилгаан хэрэгсэл гэсэн үндсэн дэд салбаруудад хуваагдана. Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг улсын дүнгээр аж үйлдвэрийн бүтээгдэхүүний дэд салбар ангиллаас ялган авч 2010 оны үнээр зэрэгцүүлэн Хүснэгт 8-д харуулав.

2017 оны байдлаар ноолуур боловсруулах салбарт угаах үйлдвэр 25, самнах (хялгас ялгах) үйлдвэр 6, иж бүрэн технологийн дамжлагатай цогцолбор үйлдвэр 8, самнах болон сүлжих 2, ээрэх болон сүлжих 1, сүлжихийн дунд үйлдвэр 6, жижиг үйлдвэр 250, нийт 298 үйлдвэр үйл ажиллагаа явуулж, угаасан ноолуурыг Хятад, самнасан ноолуурыг Итали, Англи, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Белги, Франц зэрэг 20 гаруй оронд экспортолж байгаа мэдээтэй байна.

Хүснэгт 10. Хөнгөн үйлдвэрийн салбарын голлох үзүүлэлтүүд, 2010 оны үнээр, тэрбум төгрөгөөр

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нэхмэлийн үйлдвэрлэл	203.6	267.0	227.3	294.7	409.9	396.4	524.5	522.8	711.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	7.8	18.2	16.4	34.5	37.7	36.0	45.7	64.9	61.9
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	7.5	12.7	12.9	15.2	17.1	35.7	13.2	33.3	21.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	7.3	14.1	15.6	16.1	7.4	5.3	9.7	16.7	21.0
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	14.5	15.2	29.8	29.5	28.4	29.9	28.1	28.5	41.9

Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа	9.7	13.0	14.3	9.9	7.3	9.1	8.9	17.4	24.1
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3.9	6.6	6.8	6.6	14.3	11.5	8.9	8.1	9.5

Тайлбар: ҮСХ-ны мэдээлэл ашиглан тооцов.

Ноолуурын салбарт 12980 тонн ноолуур угаах, 4606 тонн ноолуур самнах, 1280 тонн утас ээрэх, 2,8 сая ширхэг сүлжмэл үйлдвэрлэх, 1868 тууш метр нэхмэл эдлэл үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан боловч, угаах 100 хувь, самнах 20 хувь, ээрэх 34 хувь, нэхэх 25 хувь, сүлжих 70 хувьтай ашиглаж байна. 2017 оны байдлаар 5413 тн угаасан ноолуур, 509 тн самнасан ноолуур, 915.6 мянган ширхэг сүлжмэл хувцас үйлдвэрлэсэн нь түүхий эдийн нийт нөөцийн 90 хувийг анхан шатны боловсруулалт хийсэн байдлаар, 10 хувийг нэхмэл, сүлжмэл зэрэг эцсийн бүтээгдэхүүнээр экспортод гаргажээ. Харин ноос боловсруулах салбарт хивс үйлдвэрлэх 2 үйлдвэр, 4 нэхэх үйлдвэр, 8 ээрэх үйлдвэр, нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх 1 үйлдвэр, 19 угаах үйлдвэр, 16 хялгас ялгах үйлдвэр, 56 сүлжих үйлдвэр, эсгий эдлэл үйлдвэрлэх 16 үйлдвэр, 169 эсгийлэх үйлдвэр, нийт 291 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. (ХХААХҮЯ). Түүнчлэн тус яамны мэдээгээр сав баглаа боодлын үйлдвэрлэлийн салбарт 30 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 1000 гаруй хүнийг ажлын байраар ханган жилдээ 70,0 орчим тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан байна. Дотоодын сав баглаа боодлын хэрэгцээний 25 хувийг хангаж байна. Түүнчлэн Монгол улсын хэмжээнд жилд 1,4 сая тн хоёрдогч түүхий эд гардагаас 2018 оны байдаар хог хаягдал дахин боловсруулдаг 16 үйлдвэр 100 гаран бизнес эрхлэгч, ялган бэлтгэдэг 206 цэг, түүнд 20 мянган ажилтан ажиллаж байна.

Аялал жуулчлалын салбар

Монгол улсын алдарт 33 говийн нэг хэсэг болох хэдэн арван км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг сүүжийн алдарт их говиуд, 50-120 сая жилийн тэртээ амьдарч байсан эртний үлэг гүрвэлийн чулуужсан яс, өндөг, чулуужсан мод зэрэг палентологийн олдворууд олдсон Булган сумын Баянзаг, Дэлхийд ховорт тооцогдох Нэмэгт, хэрмэн цав, Шаригийн ганга, Бүгийн цав, зэрэг байгалийн тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд, онгон зэрлэг байгаль, Хутагт Данзанравжаагийн байгуулсан энергийн төв болох Дэмчогийн хийд, Өмнөговь аймгийн хамгийн баруун сум болох Гурвантэс сумын Хэрмэн цав, Даланзадгад сумаас баруун зүгт 220 км Сэврэй сумын нутагт 800 м өндөр, 150 км үргэлжилсэн Хонгорын голын үзэсгэлэнт элсэн уул, Өмнөговь аймгийн хамгийн зүүн сум болох Манлай сумын үлэг гүрвэлийн чулуужсан мөр, дэлхийд ховордсон ан амьтан, ховор төрлийн ургамлаараа гадаадын жуулчин, аялагчдын сонирхлыг ихээхэн татаж байна.

Говьсүмбэр аймгийн төв нь Чойр хот бөгөөд Улаанбаатар хотоос 238 км зайтай. Баянтал, Шивээговь, Сүмбэр гэсэн гурван сумаас бүрдсэн. 2011 онд тусгай хамгаалалтанд авсан Чойрын Богд уул, түүний ойр орчимд орших Зүүн Чойрын хийдийн туурь, Цагаан Дарь Эх бурхан, Дагвасүндэл бурхан, Хүүхдийн овоо, Хиагт-Өргөө-Бээжинг холбож байсан харилцаа холбооны төмөр утасны хорооны балгасууд, Зараагийн болон Хөшөөтийн Түрэгийн үеийн хөшөө, Баянбулаг, Чингэлийн хадны хиргисүүр зэрэг түүх соёлын үзмэрүүдтэй. Цайны зам дагуух өртөө хотуудыг тодруулахад Чойрын Богд уулын тусгай хамгаалалттай газар хамрагдсан. Одоогоор аялал жуулчлалын салбар хараахан сайн хөгжөөгүй байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгийн хэмжээ:

- 2017 онд 10,0 сая төгрөг
- 2018 онд 23,0 сая төгрөг


- 2019 онд 28,0 сая төгрөг /төлөвлөгөө/

Аймгийн хэмжээнд 3 зочид буудалтай /дэн буудал/ ба нэгэн зэрэг 74 хүнийг хүлээн авах хүчин чадалтай. Сүмбэр болон Шивээ овоо суманд нийтдээ 10 зоогийн газар нийт 486 хүн хүлээн авах хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Дорноговь аймгийн төв нь Сайншанд хот. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин суудаг. Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүдийн ба улирлын ажиллагаатай Баянбулаг-Мандалын боомтуудтай. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр Монгол улсын хөгжил дэвшлийн нэгэн үүд хаалга болж хөгжих ирээдүйтэй. Аймгийн төвд “Саран хөхөө” театр, нийтийн номын сан, Музей сургалт судалгааны төв, ноён хутагт Данзанравжаагийн музей, Хүүхдийн ордон, сумдад соёлын төвүүд ажилладаг. Нутаг дэвсгэр: 109,5 мянган кв км, Сайншанд хот нь Улаанбаатар хотоос 465 км зайтай, БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг. Засаг захиргаа 14 сум, 64 багтай. 2014 оны байдлаар хүн ам нь 63,500, хөдөлмөрийн насны хүн ам нь 41318, нийт өрх нь 19185 байна.

Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг, Сайншанд хотоос урагш 38 км-т орших Хамарын хийд нь говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн байгуулсан гурван хийдийн нэг юм. Хамарын хийдийг 1937-1938 оны үеэр галдан шатааж, лам нарыг баривчилсан. Харин 1999 оноос тус туурийг аймгийн хамгаалалтад авч нутгийн ард олон шашин номын үйл ажиллагааг нь сэргээж тус хийдийн Ламрин, Сансагтэгчилэн сүм, суврага зэргийг сэргээн босгосон бөгөөд эдүгээ дотоодын болон гадаадын олон мөргөлч, жуулчдын зорин очдог нэгэн сонирхолтой газар бол Хамарын хийд орчмын аялал жуулчлалын бүс нутаг юм. Мөргөлчид буюу жуулчид ихэвчлэн Улаанбаатар хотоос галт тэргээр Сайншанд хотод очиж цааш Хамарын хийдийн аялалаа түрээсийн машинаар хийдэг. Аялалын хөтөлбөр: Сайншанд хот - 1991 онд дахин сэргээж засварласан Данзанравжаа хутагтын музей, Хамарын хийд, Бурхан багшийн дүр, Хойд Шамбалын орон, түүний их 8 суврага, Шамбалын оронд эргэл мөргөл, тахил үйлдэх үйл ажиллагаа (Бирдийн ходоод, Цагаан хүрд, Алтан гавал овоо, Үлэмжийн чанар дуу, Цагаан чулуугаар цагийн хүрдээ арвитгах) ойр орчмын явган аялал – бясалгалын агуйнууд, тахилгатай Тонтой овоо, Ханбаянзүрх уул – түүний орчимд үйлдэх зан үйл зэрэг одоогийн санал болгож аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн юм. Бурхан шашны дурсгал, түүнийг тойрсон дурсгал олон бий. Аймгийн музейд Монгол улсын хосгүй үнэт үзмэрт багтдаг 3 дээл байдаг.

Зураг 21 Дорноговь аймаг, Гадаад, дотоодын жуулчны тоо, 2010-2018



Эх сурвалж: Дорноговь аймаг, БОАЖГ


2010 оноос Дорноговь аймаг руу аялах гадаад болон дотоод жуулчны тоо өсөж, 2014 онд 94553, 2015 онд 110574 дотоодын жуулчин, 2015 онд 2800 гадаад жуулчин хүлээн авч байсан бол сүүлийн 3 жилийн байдлаар дунджаар 68000 дотоод, 1600 гадаад жуулчин аялж байна. Энэ нь 2015 онотой харьцуулахад бараг 2 дахин буурсан үзүүлэлт юм. Сайншанд хотын хувьд нийтдээ 10 зочид буудал нийт 182 өрөө, 372 орны хүчин чадалтайгаар ажиллаж байгаа бөгөөд нийтдээ 100 хүн ажиллуулж байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгийн хэмжээ:

- 2018 онд 10,0 сая төгрөг
- 2019 онд 25,5 сая төгрөг /төлөвлөгөө/

Дундговь аймгийн төв Улаанбаатар хотоос 265 км зайд байрладаг, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг. Эртний далайн ёроолын үлдэц бүхий Өлзийт сумын нутаг Цагаан суварга, Морин толгойн цав, Өөш манхан зэрэг өвөрмөц тогтоцтой шавар цав, элсэн манхан, Их газрын чулуу, Бага газрын чулуу зэрэг боржин чулуун уул, заг, хайлаас, бударгана бүхий олон арван өргөн уудам говь гэх зэрэг байгалийн үзэсгэлэнт болон дурсгалт газрууд бий. “Их, Бага газрын чулуу” дурсгалын орчимд ландшафт хийх боломжтой. Мөн Өлзийт сумын нутагт орших Дэл уул орчмын дурсгалыг ЮНЕСКО-гийн хамгаалалтад оруулах урьдчилсан жагсаалтад багтсан байгаа. Өлзийт сумын Загын усны хоолой, Гурвансайхан, Говь-Угтаал сумын Их газрын чулуу, Дэлгэрхангай сумын Дэлгэрхангай уулыг улсын нөөц газраар, Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны уулыг байгалийн дурсгалт газраар улсын тусгай хамгаалалтад авсан, нийт талбайн хэмжээ 300000 гаруй га, мөн аймгийн тусгай хамгаалалттай Адаацаг сумын Сүм хөх бүрд, Өлзийт сумын Өөш манхан, Цагаан Суварга, Баянжаргалан сумын Аргийн хад, Хүрэн дух, Сайнцагаан сумын Тогоогийн хужир, Өлзийт сумын Дэл хөнжлийн уул, Сайхан-Овоо сумын Онгийн хийд зэрэг 100000 гаруй га газар байна. Эдгээр газарт зөвхөн 9 байгаль хамгаалагч ажилладаг.

Зураг 22 Дундговь аймаг, Гадаад, дотоодын жуулчны тоо, 2012-2018



Эх сурвалж: Дундговь аймаг, БОАЖГ

Дундговь аймаг нь Улаанбаатараас Өмнөговь аймаг руу явах замд байрладаг ба аялал жуулчлалын байгалийн үзэмжит газруудтай бөгөөд Улаанбаатар хотыг Өмнөговь аймагтай засмал замаар холбосон нь жуулчны тоо нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. 2016 оноос 2017 онд гадаад жуулчны тоо 32 хувиар 2017 оноос 2018 онд 42 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Мөн дотоодын аялагчдын хувьд ч өсөлттэй байгаа бөгөөд 2016 оноос 2017 онд 21 хувь, 2017 оноос 2018 онд 55 хувийн өсөлттэй байна. Нийт хүчин чадлыг тооцвол: Гэр баазууд - 245 гэр, 647 ор; Амралтын газар – 24; Зочид буудал – 79 өрөө, 179 ор; НИТАЖ –ын гэр буудал – 66 гэр, 264 ор; Дэн буудал – 24 өрөө, 72 орны хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгийн хэмжээ:

- 2018 онд 9,0 сая төгрөг
- 2019 онд 33,5 сая төгрөг /төлөвлөгөө/


Дундговь аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн худалдан авалтын явц дээр шууд болон шууд бус оролцогч талуудыг, хөгжүүлэх боломжтой аялал жуулчлалын бүтээгдэхүүн ба үйлчилгээний төрлийг, тэдгээр нь байгаа эсэхийг нэмүү өртгийн сүлжээтэй уялдуулж Хүснэгт 13 харуулсан болно.

Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай. Монгол улсын хэмжээнд хамгийн том 165000 кв.км нутаг дэвсгэртэй ба хүн амын суурьшил сийрэг 3.4 квадрат километр нутагт 1 хүн, 13.2 квадрат километр нутагт 1 өрх ноогдон хүн ам суурьшиж байна. Хадны зураг, палеонтологийн олдвор ихтэй, Говийн бүс нутгийг харуулсан онцлог байгаль нь өөрөө нөөц болно.

2018 оны байдлаар 25 жуулчны бааз үйл ажиллагаа явуулдаг ба нийт 610 гэрт нэгэн зэрэг 1,637 жуулчин хүлээн авах хүчин чадалтай бөгөөд жуулчны улиралд нийт 327 иргэнийг ажлын байраар хангаж үүнээс 247 орон нутгийн иргэн, бусад нь аймаг болон Улаанбаатар хотын харьяат 80 хүнийг ажлын байраар хангаж ажилласан. Аймгийн хэмжээнд 61 зочид буудалтай /дэн буудал/ ба нэгэн зэрэг 971 хүнийг хүлээн авах хүчин чадалтай 262 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Хан-Уул зочид буудал 3 од, Даланзадгад зочид буудал 2 одны зэрэглэлтэй үйл ажиллагаагаа явуулж

байна. 48 өрх гэр буудлын үйл ажиллагааг явуулж нийт 150 гэр нэгэн зэрэг 586 жуулчин хүлээн авах хүчин чадалтай. Аймгийн хэмжээнд 40 орон нутгийн жолооч жуулчин тээвэрт явсан. Зөвхөн жуулчны баазаар дамжин өнгөрсөн гадаадын жуулчдын тоо 2018 онд 45063, дотоодын жуулчид 11816 дамжин өнгөрсөн байна. Өмнөх онотой харьцуулахад 7622 жуулчнаар буюу 17 хувиар нэмэгдсэн судалгаатай байна.


Зураг 23 Өмнөговь аймаг, жуулчны баазуудаар үйлчлүүлсэн жуулчны тоо, 2012-2018



Эх сурвалж: Өмнөговь аймаг, БОАЖГ

Говь Гурвансайхан Байгалийн цогцолборт газарт тасалбар авч нэвтэрсэн нийт 28522 жуулчин, үүнээс гадаадын 17251, дотоодын 11271 жуулчид байна. Жилд тасалбарын орлого 16 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд 2018 онд орлого 21 сая төгрөг хүрсэн.


Зураг 24 Өмнөговь аймаг, Говь Гурвансайхан БЦГ-ын тасалбар авсан жуулчны тоо 2013-2018



Эх сурвалж: БОАЖЯ

Зөвхөн жуулчны баазуудаас орон нутагт оруулсан хөрөнгө оруулалт 1.684.320.581 төгрөг байна. /аймаг, тухайн сумаас мах сүү, цагаан идээ, бензин, тос, хүнсний бараа бүтээгдэхүүн, цалин, татвар, хандив тусламж гэх мэт /

Зураг 25 Өмнөговь аймаг, Жуулчны баазуудын зардал, 2018



Эх сурвалж: Өмнөговь аймаг, БОАЖГ

Аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгийн хэмжээ:

- 2017 онд 354,5 сая төгрөг
- 2018 онд 614,5 сая төгрөг
- 2019 онд 597,5 сая төгрөг /төдөвлөгөө/

Соёлын өвийг дагасан аялал жуулчлалд нише зах зээл үүсгэх нь оновчтой гэдэг санааг дэмжиж Говийн дэд бүсийн 4 аймгийн өвийг харуулъя. Үл хөдлөх дурсгалыг Соёлын өвийн үндэсний төвийн “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах”-д ангилсаны дагуу, хөдлөх дурсгалыг “Соёлын өвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т зааснаар хосгүй үнэт, үнэт гэж, биет бус өвийг ур чадварын үнэлгээгээр¹⁷ ангилан судалгааг нэгтгэлээ.

Хүснэгт 11 Аймгийн үл хөдлөх соёлын дурсгалын нэгтгэл

Аймгууд	Улсын хамгаалалтад байх	Аймгийн хамгаалалтад байх	Бусад	Нийт
Говьсүмбэр	0	2	53	55
Дорноговь	6	7	418	431
Дундговь	6	13	287	306
Өмнөговь	22	11	179	212

¹⁷ Улсын билэг авьяастны жагсаалт болон аймгийн комиссын үнэлгээ

Энэ дэд бүсэд ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгүүлсэн дурсгал одоогоор байхгүй тул Соёлын өвийн тухай хуулиар “улсын хамгаалалтад байх”, “аймгийн хамгаалалтад байх” болон бусад гэж ангилж харвал Өмнөговь аймагт улсын хамгаалалтад байдаг дурсгалт газар /22/ хамгийн олон байна. Эдгээр 4 аймагт булш оршуулгын дурсгал хамгийн олон байна. Дээр дурдсан аялал жуулчлалын мотивациас харахад жуулчин шууд очоод бэлэн харах зүйлд татагддаг гэж үзвэл аялал жуулчлал хөгжүүлэхэд бидэнд байгаа нөөц их хэмжээний хөгжүүлэлт шаардахаар харагдаж байна. Хэдийгээр барилга архитектурын нөөц 207 гэж байгаа ч дурсгалт газруудтай өрсөлдөхүйц “хүний нүдэнд харагдах” бэлэн нөөц байх хэрэгтэй.

Хүснэгт 12 Аймгийн үл хөдлөх дурсгалын нэгтгэл, төрлөөр

Аймгууд	Чулуун зэвсгийн үеийн дурсгалт газар	Хадны зураг, бичгийн дурсгал	Булш оршуулгын дурсгал	Тахил тайлгын байгууламж	Барилга, архитектур-ын дурсгал	Хөшөө дурсгал	Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар	Палеонтологийн дурсгалт газар
Говьсүмбэр	0	1	33	8	5	8	0	0
Дорноговь	1	35	166	99	96	13	3	18
Дундговь	2	36	151	63	44	6	1	3
Өмнөговь	0	51	43	24	62	13	3	16
Дүн	3	123	393	194	207	40	7	37

Соёлын аялал жуулчлал хөгжүүлэхэд бэлэн байгаа өв, түүнийг дагаж гарах үйлчилгээ, тоглолт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, жуулчныг оролцуулах арга хэмжээ чухал юм. Энэ утгаар авч үзвэл ардын язгуур урлагийн нөөц их байгаа нь сайн хэрэг. Ялангуяа Дундговь, Өмнөговь аймагт ЮНЕСКО-д бүртгэлтэй дараах төрлүүд түгээмэл байдаг нь давуу тал болж байна.

Төрөл	Бүртгэгдсэн огноо
Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг	2008
Монгол ардын уртын дуу	2008
Монгол тууль	2009
Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг	2009
Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг	2009
Монгол наадам	2010
Монгол ардын хөөмэйн урлаг	2010
Шувуучлахуй буюу бүтгэдээр ан хийх зан үйл	2010
Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил –битүү амьсгаа	2011
Алтан товч	2011
Монгол Данжуур	2011
Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл	2014
Монгол уран бичлэг	2014
Шагайн харваа	2015
Ботго авахуулах зан үйл	2015

Гэхдээ нише зах зээл үүсгэж жуулчин зорин очих газар болгон “хөгжүүлэлт” хийхэд ардын язгуур урлагийн тоглолтыг аймгийн театр, чуулга зохион байгуулах уу, жуулчны бааз зохион байгуулах уу гэдгээс эхлэн хөрөнгө оруулалт, тогтсон бизнес загварчлал хэрэгтэй болно.

Хүснэгт 13 Аймгийн биет бус соёлын өвийн нэгтгэл, төрлөөр

Аймгууд	Эх хэл аман уламжлал	Ардын язгуур урлаг	Үндэсний уламжлалт баяр, зан үйл	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, арга технологи	Ардын уламжлалт гар урлал
Говьсүмбэр	9	64	2	6	35
Дорноговь	6	24	10	5	9
Дундговь	5	124	29	14	59
Өмнөговь	15	97	8	3	76
Дүн	35	309	49	28	179

Өмнөговь аймаг 2018 онд зохион байгуулсан соёлын биет бус өвийн их наадамд 1-р байр эзэлсэн. Ингэ хөөслөх зан үйл, лимбийн битүү амьсгаа зэрэг ЮНЕСКО-д бүртгэлтэй яаралтай хамгаалах шаардлагатай өвийн их уламжлалтай (Г.Энхбат, 2018 Соёлын биет бус өвийн их наадам).

Хүснэгт 14 Өмнөговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар

Үзүүлэлт	Баяндай	Баяновоо	Булган	Гурвантэс	Даланзадгад	Мандаловоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогтсогоо	Цогтлэций
Биет бус өв	6	6	16	8	24	10	25	7	17	7	12	18	10	21	12
Биет үл хөдлөв өв	18	12	14	17	5	11	12	13	18	16	29	9	20	9	9
Биет хөдлөх өв	163	37	27	176		79	181		138	125	583	36	56	100	31

Тус аймагт байгаа нөөцийг тоогоор авч үзвэл Ханбогд сум соёлын аялал жуулчлалын “бүтээгдэхүүн” хөгжүүлэлт хийж үзэх хамгийн боломжтой нь харагдаж байна. Гэвч байгаа дурсгалын төлөөлөх цаг хугацаа, хүний сонирхол татах байдал, бүрэн бүтэн байдал, түүх, археологийн чанараараа бодит байдал ихээхэн өөр.

Хүснэгт 15 Дундговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар

Үзүүлэлт	Баянжаргал	Говь-Уултал	Дэлгэрцогт	Өндөршил	Эрдэнэдалай	Дэлгэрханга	Дэрэн	Луус	Өлзийт	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Сайнцагаан	Адаацаг	Гувансайха
Биет бус өв	26	17	6	24	12	17	15	13	15	10	30	12	14	8	12
Биет үл хөдлөв өв	20	16	28	22	13	17	21	11	15	11	24	14	44	23	27
Биет хөдлөх өв	31	27	54	311	212	21		188	60		69			31	

Дундговь аймгийн хувьд биет үл хөдлөх өвийн нөөцөөс гадна биет бус өвийн суурь сайтай бөгөөд өвлөн уламжлуулах дээр анхаарч ажиллаж байгаа давуу тал байна. 2018 онд зохион байгуулсан соёлын биет бус өвийн их наадамд 3-р байр эзэлсэн. Ингэ хөөслөх, уртын дуу, тэмээтэй холбоотой соёлын өвийн уламжлалтай.

Хүснэгт 16 Дорноговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар

Үзүүлэлт	Их хэт	Хөвсгөл	Сайншанд	Айраг	Алтанширээ	Даланжаргалан	Дэлгэрэх	Замын Үүд	Мандах	Өргөн	Сайхандулаан	Улаанбадрах	Хатанбулаг	Эрдэнэ
Биет бус өв	3	18	1	0	5	10	10	0	0	0	0	0	7	0
Биет үл хөдлөв өв	32	28	11	22	47	33	22	0	19	46	26	32	67	46
Биет хөдлөх өв	329	99		64	167	135	62		274	66	271	121	107	108

Дорноговь аймаг шашны зан үйлээр арвин уламжлалтай. Энэ чиглэлээр аялал жуулчлал хөгжүүлээд олон жил болж байгаа. Дорноговь аймагт биет өвийн нөөц илүү харагдаж байна. Хөвсгөл, Эрдэнэ, Хатанбулаг, Өргөн, Алтанширээ сумдад соёлын өвийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжтой байж магадгүй юм.

Хүснэгт 17 Говьсүмбэр аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар


Үзүүлэлт	Баянтал	Сүмбэр	Шивээговь
Биет бус өв	6	92	18
Биет үл хөдлөв өв	4	45	6
Биет хөдлөх өв	51	948	

Дэд бүтцийн салбар

Эрчим хүч


Говийн дэд бүсийн аймгуудад, тухайлбал, Мандах сумын Цагаансуврагын зэс молибдений үйлдвэр, Өргөн сумын цементийн үйлдвэр, Сайхандулаан, Улаанбадрах сумын Цагаанцавын цеолитын үйлдвэр, Алтанширээ сумын Тариачийн нефть боловсруулах үйлдвэр, Сайншанд сумын Зүүнбаянгийн нефть боловсруулах үйлдвэр, Сайхандулаан сумын Болорын үйлдвэр, Улаанбадрах сумын Уран олборлох үйлдвэр, Даланжаргалан сумын Элдэвийн нүүрсний уурхай, Даланжаргалан сумын Хөх цавын цемент-шохойн үйлдвэр, Хар-Айраг сумын Жонш баяжуулах үйлдвэр зэрэг үйлдвэрийн зарим нь баригдаж, үйл ажиллагаа явуулж эхлээд байгаа нь тус аймгуудын цахилгаан хангамжийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд хүргэж байна.

Зураг 26 Говийн бүсийн аймгуудын цахилгаан хангамжийн бүдүүвч



Говьсүмбэр аймгийн түгээх сүлжээ нь Сүмбэр сум, Найрамдал хотхон, Баянтал, Шивээговь сум, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил сум, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг, Иххэт сум, Хэнтий аймгийн Дархан, Бор-Өндөр гэсэн 13 сум, суурин газрууд, Бор-Өндөрийн УБҮ, МАК цементний үйлдвэр, Засаг Чандмань майнз, Арвин хүдэр, Кевин Инвест, Жин Тэй Хэй, Баяннексус, Жин Хуа орд, Алаг толгод, Алаг тогоо, Фриендшип, Чулуун-Овоо, Говьшоо, Билэгт баялаг зэрэг үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагууд болон Говьсүмбэр аймгийн хэрэглэгчидийн цахилгаан эрчим хүчний хангамжийг 220/110/35 10 кВ-ын Чойр дэд станцаас 35,15,10, 0,4 кВ-ын сүлжээгээр хангана.

Зураг 27 Говьсүмбэр аймаг




Эх сурвалж: МУИС. ЭЗХ-гийн зөвлөх Ц.Баярбаатар, Ц.Жаргалсайхан

Дорноговь аймагт **1191** аж ахуйн нэгж албан байгууллага, **10045** айл өрх, бүгд **11236** хэрэглэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Хэрэглэгчид дотор Сэнж сантын цементийн үйлдвэр, Цахиур чулууны үйлдвэр, Төмөр зам, Коже-говь ХХК, Доншен газрын тос Монгол ХХК, Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх боомт, Замын үүднэ Дулааны станц, цэвэршүүлэх станц, мөн Сайншанд, Зүүнбаянгын Халаалтын Зуухнууд, 260 айлын орон сууцны 4 хорооллууд Махны үйлдвэр зэрэг томоохон хэрэглэгчдийн худалдан авах ЦЭХүч жилээс жилд нэмэгдсээр 2018-19 онд ХАЦЭХ-ны хэмжээ **88,4** сая.кВт.цаг хүрээд байна.


2018 оны байдлаар 15/0,4 кВ-ын 16 дэд станц, 10/0,4кВ, 6/0,4кВ-ын 167 дэд станц, Нар салхи хосолсон 35 кВ-ын 417,7 км, 22кВ-ын 60,7км, 15кВ-ын 363,7км, 10кВ-ын 96,65 км, 6кВ-ын 90км, 0,4кВ-ын 67,77 км агаарын шугамуудыг хариуцан хэрэглэгчдийг ЦЭХ-ээр найдвартай ханган ажиллаж байна.

Зураг 28 Дорноговь аймгийн цахилгаан эрчим хүчний системд холбогдсон сумд



Эх сурвалж: МУИС. ЭЗХ-гийн зөвлөх Ц.Баярбаатар, Ц.Жаргалсайхан

Зураг 29 Дорноговь аймгийн сумдын 2014 - 2018 оны цахилгаан эрчим хүчний хэрэглээ, мян.кВт.цаг



Нийт хэрэглэгчдээ жийлийн хэрэглээний түвшингөөр нь ангилж үзвэл нийт борлуулсан ЦЭХ-ний 4621.5 мян.кВтц буюу 5.5%-ийг төсөвт байгууллага, ААНБ – 16507.6 мян.кВтц буюу 19.8%, томоохон ҮААГ – 45327.9 мян.кВтц буюу 54.3%-ийг, айл өрх – 17034.8 мян.кВт буюу 2.4% -ийг тус тус эзэлж байна.

Дундговь аймгийн төв, сум суурин газрууд нь 220 кВ-ын габариттай, 182,6 км урттай, АС-300/39 дамжуулагчтай, 110 кВ-ын Чойр-Мандалговь, 35 кВ-ын 522,4 км, 15 кВ-ын 263км ЦДАШ, 35 кВ-ын 12 ширхэг, 15 кВ-ын 4 ширхэг, 10 кВ-ын 1 ширхэг дэд станцаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. Тус аймгийн 15 сумын 5 нь буюу Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-Овоо сумдууд нь зэргэлдээ аймгуудаас эрчим хүчээр хангагдаж байна. Үлдсэн 10 сум нь 110 кВ-ын Мандалговь дэд станцаас эрчим хүчээр хангагдаж байна. Тус аймгаас Өмнөговь аймгийн Цогт-Овоо гэсэн ганц сум эрчим хүчээр хангагдаж байна.


Зураг 30 Дундговь аймгийн цахилгаан эрчим хүчний хангамж



Эх сурвалж: МУИС. ЭЗХ-гийн зөвлөх Ц.Баярбаатар, Ц.Жаргалсайхан

Өмнөговь аймаг Тавантолгой, Шинэ Оюутолгой, Цагаансуврага, Даланзадгад дэд станцуудаас тэжээгдэнэ. Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэврэй, Ноён сумаас бусад бүгд сум төвлөрсөн ЭХС-д холбогдсон байна. Тус аймагт Тавантолгой, Оюутолгой, Нарийнсухайт гэсэн гурван том ордуудын ашиглалт явж байна. Тус аймгийн хэрэглэгчид нэг талаас ТБЭХС-ээс 110 кВ МГ-ТТ ЦДАШ-аар Тавантолгой 220/35/10 кВ-ын дэд станцаас, нөгөө талаас ТБЭХС-тэй зэрэгцээ холбогдсон Ухаа худаг ДЦС, Даланзадгад ДЦС, Цэций СЦС, Гэгээн наран НЦС-аас ДҮТөвийн нэгдсэн удирдлагын дор цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. Найдвартай ажиллагааны хувьд ТБЭХС-ээс тусгаарлагдах үед Ухаа худаг ДЦС, Даланзадгад ДЦС-ууд бүх ачааллыг бүрэн авах боломжгүй болж эрчим хүчээр бүрэн тасалдах тохиолдлууд гарсаар байна. Иймд ТБЭХСистемтэй холбогдож байгаа 110, 220 кВ-ын цахилгаан дамжуулах сүлжээг найдваржуулах нь ойрын хугацааны чухал зорилт байх ёстой. 2019 онд Улаанбаатар-Мандалговь 220кВ ЦДАШ, 220/110/35 кВ Мандалговь дэд станц шинээр ашиглалтанд орж, Таван толгой Оюутолгой дэд станцууд 220/110/35 кВ болж өргөтгөгдсөнөөр говийг бүсийн цахилгаан хангамж сайжирна. Гурван тэс, Сэврэй, Ноён сумууд Нарийн сухайтын нүүрсний уурхайгаас Хятадаас хангагдаж байна. Эдгээр сум болон уул уурхайн хэрэглэгчид ТБЭХС –ээс алслагдсан, тэжээгдсэн ч алдагдал ихтэй эдийн засгийн хувьд үр ашиггүй юм. Харин Нарийн сухайтын нүүрсний орд газрыг түшиглэн 50-100 мВт-ын ДЦС барьж, Сэхээ боомтоор дайруулан Өвөр Монголын ЭХС-тэй зэрэгцээ ажиллах, цаашдаа /2030 он/ 220 кВ-ын дамжуулах сүлжээгээр Даланзадгад сумаар дайруулан ТБЭХС-тэй зэрэгцээ ажиллах төсөөллийг Эрчим хүчний хөгжлийн бодлого хөтөлбөрт тусгах нь зүйтэй.

Зураг 31 Өмнөговь аймгийн цахилгаан хангамжийн байдал



Эх сурвалж: МУИС. ЭЗХ-гийн зөвлөх Ц.Баярбаатар, Ц.Жаргалсайхан

Говийн дэд бүсийн тээврийн хэрэгцээ

Говийн дэд бүс нь дэд бүтэц, зам харилцааны хувьд сайн хөгжсөн бөгөөд тус бүсийн нутгаар Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон Транс-Сибирийн олон улсын транзит төмөр зам, агаарын коридор дайран өнгөрдөг.

Хүснэгт 18 Олон улс, улсын чанартай авто замын урт

Авто замын чиглэлийн нэр	Нийт замын урт	Хучлагатай	Хучлагагүй
Улаанбаатар-Замын Үүд боомт	661.9	661.3	0.6
Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад-Гашуунсухайт боомт	876.5	818.2	58.3
Даланзадгад-Шивээхүрэн боомт	306.2	88.3	217.9
Арвайхээр-Мандалговь-Сайншанд	626.5	5.1	621.4
Чойр-Өндөрхаан	225	-	225
Чойр-Говь-Угтаал-Мандалговь	184.3	-	184.3
Сайншанд-Даланзадгад	393.6	-	393.6
Сайншанд-Ханги боомт	328.3	24.5	303.8

Хүснэгт 19 Орон нутгийн чанартай замын нийт урт


Авто замын чиглэлийн нэр	Нийт замын урт	Хучлагатай	Хучлагагүй
Говьсүмбэр	364.2	8.0	356.5
Дорноговь	8858.8	15.7	8843.1
Дундговь	4944.4	12.5	4931.9
Өмнөговь	5236	46.0	5190.0

2017 онд орон нутагт авто тээврээр тээсэн ачааны хэмжээгээр Төвийн бүс тэргүүлж байгаа бөгөөд үүнд Өмнөговь аймгийн уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт нөлөөлсөн байна. 2017 онд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурван тэс, Ноён зэрэг сумдад үйл ажиллагаа явуулж байгаа Таван толгой, Оюутолгой, Ухаа худаг, Нарийн сухайт, Ноён уулын уурхайгаас нүүрс, зэс зэрэг бүтээгдэхүүнийг Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтоор дамжуулан БНХАУ руу тээвэрлэж байна. Тухайлбал, 2017 онд төвийн бүсэд нийт 24459.7 мянган тонн ачаа эргэлттэй байснаас 98.9% буюу 24212.1 мянган тонн ачаа зөвхөн өмнийн говийн дэд бүсэд тээвэрлэгджээ.

Говьсүмбэрийн логистикийн төв байгуулах төслийг Монгол улсын Засгийн Газар АХБ-тай хамтран санхүүжүүлж байгаа бөгөөд нийт төсөвт өртгийн 60 гаруй хувь буюу 45 сая ам.долларын хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийг АХБ-наас шийдвэрлүүлсэн. Төсөл хэрэгжиж логистикийн төв баригдсанаар Монгол улсын импорт, экспорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдэж эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой юм. Уг төсөл нь Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хэрэгжиж байгаа бөгөөд нийт 128 га талбайг хамрах бөгөөд чингэлгийн, хүнд даацын, агуулахын гэсэн 3 бүстэй байхаар төлөвлөгдсөн. Мөн 50 тн даацтай 2 гүүрэн кран, механизмын засварын төв, өргөн болон нарийн царигийн ачилт буулгалтын 11.5 км орчим төмөр зам, логистикийн төв руу орох гарах төмөр замтай 2 түвшинд огтлолцох хүнд даацын тээврийн хэрэгсэл явах боломжтой гүүрэн байгууламж, 1.6 км авто зам тус тус барихаар төлөвлөгдсөн. 2017 оны эцэс хүртэл Логистикийн төвийн барилга угсралтын ажил тодорхой үе шаттай хэрэгжиж ирсэн бөгөөд одоогийн байдлаар логистикийн төвийн үйл ажиллагаанд 11.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3.6 км цэвэр усны шугамын ажил, төмөр замтай 2 түвшинд огтлолцох гүүрэн байгууламж, 1.6 км авто замын барилга угсралтын ажил, 4.15 км гадна холбоо интернетийн шилэн кабель суурилуулах ажил, Гадна цахилгаан хангамжийн 110кВ ЦДАШ, дэд станцын өргөтгөл, дэд станцын барилга угсралт зэрэг ажлуудыг дотоодын гүйцэтгэгч 9 компани хийж байна. Цахилгаан эрчим хүчний дамжуулах станц нь Монгол улсын зүүн болон өмнөд бүсийн аймгуудын 19 төв суурийн газар, сумд, эдгээр сумын нутагт орших томоохон үйлдвэрийн газрууд, айл өрхийг цахилгаан эрчим хүчээр ханган ажилладаг. Ачаа тээврийн хэрэгцээний хувьд уул уурхайн бүтээгдэхүүн болон дамжин өнгөрөх тээврийн хэрэгцээг тооцож гаргах нь энэ бүсийн хувьд нэн ач холбогдолтой юм.

Говийн бүсэд байршилтай нүүрсний томоохон ордуудад Тавантолгой, Нарийн сухайтын ордууд хамаарна. Эдгээр ордоос олборлосон нүүрсийг гол төлөв Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтоор БНХАУ-д экспортлож байна. Нүүрсний экспортлох хэмжээнээс харахад төмөр замаар тээх нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой ч, хөрөнгө оруулалт ихээхэн шаардагдах тул нүүрсний төмөр зам баригдаагүй байна. Иймээс их даацын автомашинаар тээж байгаа нь үр ашиг багатайгаас гадна байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна.

Зураг 32 Нүүрсний уурхай болон тээвэрлэх чиглэлүүд



2010-2015 онд БНХАУ-д энэ чиглэлээр экспортолсон нүүрсний хэмжээ Хятадын нүүрсний импортын 7.68%-ийг эзлэж байв. Цаашид дунд болон урт хугацаанд БНХАУ-д экспорлох нүүрсний төсөөлөл, таамгийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 20 Нүүрсний экспортын төсөөлөл /мянган тонн/

Он	2017	2020	2023	2026	2029	2032
Экспортлох нүүрс	17,067	19,402	27,558	32,398	38,253	42,412

БНХАУ-ын төмрийн хүдрийн импортын хэмжээнд үндэслэн таамаглахад Монгол улс жилд Хятадын төмрийн хүдрийн 0.72%-ийг хангах төсөөлөл байна.

Хүснэгт 21 Төмрийн хүдрийн экспортын төсөөлөл /мянган тонн/

Он	2017	2020	2023	2026	2029	2032
Экспортлох төмрийн хүдэр	8,144	10,533	13,674	17,718	22,959	29,748

Зэсийн баяжмал нь Монгол улсаас экспортлох уул уурхайн гуравдах том бүтээгдэхүүн юм. Монгол улсын Говийн бүс нутагт орших Оюутолгойн зэсийн баяжмалын орд нь экспортын гол орд мөн. Одоогоор Оюутолгойн зэсийн баяжмалыг Гашуун сухайтын боомтоор БНХАУ руу автоашинаар экспортлож байна. Экспортын хэмжээ 10 саяас давсан үед төмөр замаар тээвэрлэх нь ашигтай.

Зураг 33 Зэсийн баяжмал, БНХАУ руу экспортлох чиглэл




Хүснэгт 22 Зэсийн баяжмалын экспортын төсөөлөл /мянган тонн/

Он	2017	2020	2023	2026	2029	2032
Экспортлох зэсийн баяжмал	2,179	3,585	5,544	8,271	12,068	17,354

Монгол улсын нутгаар ОХУ болон БНХАУ-ын хооронд дунд болон урт хугацаанд 2.5-аас 3.0 сая тонн ачаа дамжин өнгөрөх төсөөлөл байна.

Зураг 34 Дамжин өнгөрөх тээвэрлэлт



Хүснэгт 23 Дорноговь аймгийн ачаа тээвэрлэлтийн төсөөлөл, сая тн/жилд/

Тээвэрлэлтийн чиглэл	Ачааны төрөл	Тээврийн төрөл	Он			
			2013	2015	2020	2025
Тавантолгой-Сайншанд	Нийт		-	-	19,4	28,52
	Хүрэн нүүрс	Төмөр зам	-	-	5,8	8,53
	Коксжих нүүрс	Төмөр зам	-	-	12,6	18,52
	Зэсийн баяжмал	Төмөр зам	-	-	1,0	1,47
Сайншанд-Замын Үүд- БНХАУ руу	Нийт		1,63	1,73	2,03	2,05
	Коксжих нүүрс	Төмөр зам	-	-	7,7	11,3
	Хүрэн нүүрс	Төмөр зам	-	-	0,5	0,73
	Зэсийн байжмал	Төмөр зам	-	-	0,8	1,17
	Ган	Төмөр зам	-	-	2,0	2,94
	Түүхий эд	Төмөр зам	0,037	0,037	0,035	0,033
	Дамжин өнгөрөх ачаа	Төмөр зам	1,59	1,70	1,98	2,0
Замын-Үүд-Сайншанд	Нийт					
	Өргөн хэрэгцээний бараа	Төмөр зам	0,170	0,179	0,197	0,200
	Барилгын материал	Төмөр зам Автотээвэр	1,774 1,600	2,003 2,060	2,577 3,120	2,700 3,300
	Дамжин өнгөрөх тээвэр	Төмөр зам Автотээвэр	1,6 1,6	1,7 1,7	1,98 1,98	2,0 2,0
Сайншанд-Улаанбаатар-ОХУ руу	Нийт		5,14	5,88	9,47	13,56
	Коксжих нүүрс	Төмөр зам		-	1,4	2,05
	Зэсийн баяжмал	Төмөр зам	-	-	0,2	3,31
	Өргөн хэрэгцээний бараа	Төмөр зам	0,17	0,179	0,197	0,200
	Барилгын материал	Төмөр зам Автотээвэр	1,774 1,600	2,003 2,060	2,577 3,120	2,700 3,300
	Дамжин өнгөрөх тээвэр	Төмөр зам Автотээвэр	1,6 1,6	1,7 1,7	1,98 1,98	2,0 2,0
Сайншанд-Баруун Урт хот руу	Нийт		-	-	17,7	26,0
	Коксжих нүүрс	Төмөр зам	-	-	17,7	26,0
Төмөртэй-Улаанбаатар-Сайншанд руу	Нийт				6,2	9,11
	Төмрийн хүдэр	Төмөр зам	-	-	6,2	9,11
Баруун-Урт-Сайншанд руу	Нийт		1,00	1,20	1,20	1,30
	Төмрийн хүдэр	Автотээвэр Төмөр зам	1,00	1,20	1,20	1,30


Говийн бүс нутагт бизнесийн байгууллагууд өөрсдийн агуулахыг зохих зөвшөөрлийг авч ажиллуулж байна. Үүнийг дээрхи хүснэгтээс харж болно. Гэхдээ агуулахын аж ахуйг орчин үеийн өргөх буулгах хэрэгсэл, хөргөлтийн систем, цахим хэрэгсэл бүхий орчин үеийн бүтэцтэй байгуулах шаардлагатай байна.

Харилцаа холбоо, мэдээлэл

Говийн дэд бүсийн хүн амын Харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээнд хамрагдсан байдлыг 100 хүнд ногдох үзүүлэлтээр авч үзэхэд улсын дунджаас илүү төдийгүй Улаанбаатар хотын

дунджаас их байгаа нь тухайн дэд бүсийн Өмнөговь, Дорноговь аймгуудад ажиллаж байгаа уул уурхай, барилгын материалын үйлдвэрүүдийг дагасан суугуул иргэд хэрэглэгчдийн нягтаршил их байгаатай холбоотой бөгөөд цаашдаа өсөх хандлагатай байна. Тухайлбал, 3G хэрэглэгчийн 100 хүнд ноогдох дундаж нь улсын дунджаас хавьгүй илүү байгаа нь зүй ёсны үзүүлэлт юм.

Зураг 35 Говийн дэд бүсийн 100 хүнд ноогдох 3G хэрэглэгчийн харьцуулалт



Эх сурвалж: Мэдээлэл, харилцаа, холбооны хөгжил байршлын судалгаа, 2019


Харин суурин интернет хэрэглэгчийн тоог авч үзэхэд 100 хүнд ноогдох бүсийн дундаж нь улсын дунджаас 2.1 дахин бага байгаа нь бас л суурин бус үйлдвэржилтийг дагасан хэрэглэгчийн нягтаршилтай холбоотой.

Хүснэгт 24. Суурин интернет хэрэглэгчийн тоо

	Бүс, аймаг	Нийт хүн ам	Суурин интернет хэрэглэгч	
			Нийт	100 хүнд ноогдох
Өмнийн говийн дэд бүс	Дорноговь	68 147	3 682	5,40
	Дундговь	45 755	467	1,02
	Өмнөговь	65 314	1 869	2,86
	Говьсүмбэр	17 383	1 034	5,94
	Дундаж			3,8
	Улаанбаатар	1 462 973	236 064	16,13
	Улсын дүн	3 177 899	255 551	8,04

Эх сурвалж: Мэдээлэл, харилцаа, холбооны хөгжил байршлын судалгаа, 2019

Зураг 36 Говийн дэд бүс дэх 100 хүнд ноогдох суурин интернет хэрэглэгчийн харьцуулалт



Эх сурвалж: Мэдээлэл, харилцаа, холбооны хөгжил байршлын судалгаа, 2019

Дэд бүсийн хувьд Харилцаа холбоо мэдээллийн технологийн сүлжээ, үйлчилгээний хамрах хүрээ, хүртээмжийг тодорхойлох үндсэн үзүүлэлтийг харьцуулалтаар Улаанбаатарын түвшинд байгаа бөгөөд үүрэн холбооны хэрэглэгчийн нягтрал улсын дунджаас даруй 26.7 хувиар дээгүүр байгаа нь тухайн бүс нутаг дахь үйлдвэрлэлийн онцлого буюу удаан хугацааны ээлжээр зохион байгуулагддаг, ажиллагсад нь байнга оршин суух шаардлагагүй эсвэл хөдөлгөөнт ажлын байр зонхилсон байдагтай холбоотой юм. Харилцаа холбооны суурин үйлчилгээ цахим технологиор шинэчлэгдэн хумигдаж байгаа нийтлэг үзэгдэл энэ бүсэд мөн адил ажиглагдаж байна. Түүнчлэн суурин үйлчилгээг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа эсэх, төрийн болон орон нутгийн аливаа зорилт нь суурин гэхээсээ илүү хөдөлгөөнт үйлчилгээнд суурилах нь оновчтой байх зураглал харагдаж байна. Шилэн кабелийн сүлжээ сумын төвүүдэд хүрсэн нь цахим технологид суурилсан буюу түүнтэй хосолсон суурин үйлчилгээ хөгжүүлэх боломжийг ч нэмэгдүүлж байна. Улмаар Дорноговь аймгийн Хөвсгөл, Хатанбулаг сумдыг 2020-2021 онд гадаадын хөрөнгө оруулалтаар шилэн кабелийн үндсэн сүлжээнд холбох бол Дундговь аймгийн Өлзийт, Дэлгэрхангай сумдыг 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар холбосон байна.

Говийн дэд бүсийн нийгмийн цахимжих үйл явц нь эхний шат буюу бэлэн байдал шатанд явагдаж байгаа ч орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, зарим төрийн байгууллагын бэлэн байдлын талаарх статистик тоо баримт ховор байна. Иймээс дараа дараагийн шатны бэлтгэл бүрэн хангагдаагүй хэрэгцээ шаардлагын түвшинг үнэлэх цогц судалгаагүй байна. Аймаг сум хоорондын сүлжээ зах зээлийн хувьд өрсөлдөөн байхгүй, үйлчилгээ үзүүлэгч компаниуд харьцангуй бага ач холбогдол өгч шилэн кабелийн сүлжээний ашиглалт маш бага байсаар байгаа юм. Түүнчлэн аймаг сумын төвүүд дэх төрийн өмчийн өмчийн оролцоотой компаниудын салбар нэгжүүд бүрэн бус ачаалалтай боловч ашиглалт багатай барилга, байр талбай эзэмшиж байгаа зарим талаар хөрөнгө, үйлчилгээ эзэнгүйдэх нөхцөл байдал үүсгэж байна.

Байнгын тогвортой цахилгааны хангамжийн эх үүсвэргүйгээс шалтгаалан малчдын мэдээлэл, харилцаа холбооны хүссэн үйлчилгээг хүссэн цагтаа авах нөхцөл бүрдээгүй.

Судалгааны үр дүн

ХХААХҮ-ийн салбарын бүсийн эсвэл аймгийн түвшний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон гаргахад тулгамдаж буй хамгийн том асуудал нь тоо мэдээллийн дутмаг байдал бөгөөд аливаа төрлийн судалгааг хийхэд үндэслэл болох нарийвчилсан мэдээллийн санг үүсгэх нь амин чухал байна.

Говийн бүсийн хөдөө аж ахуйн салбарт газар тариалангийн салбар маш бага хувийн жин эзлэх бөгөөд төрөөс баримтлах бодлого нь хамгаалагдсан хөрсний (хүлэмжийн) аж ахуй, усалгаатай тариаланг түлхүү хөгжүүлэхээр тусгасан байгаа боловч хэрэгжилт нь хангалттай түвшинд биш байна.

Говийн бүсийн байгалийн нөхцөл байдлаас шалтгаалан өрхийн хэрэглээнд зориулсан шинжтэй, зах зээлд чиглэсэн бус төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл зонхилж байна. Хүлэмжийн аж ахуй эрхлэхэд хамгийн тохиромжтой бүс нутаг гэж үзэж байгаа ч хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлд ахиц бага гарчээ.

Хүнсний үйлдвэрлэлийн салбарын хувьд мах үйлдвэрлэл (Дорноговь аймагт мах экспорттой холбогдон өссөн дүнтэй байгааг эс тооцвол) тухайн бүсийн хувьд хүнсний салбарт бодлогын мэдэгдэхүйц нөлөө гарсан талаар ямар нэгэн тохиолдол харагдахгүй байна. Улсын хэмжээнд авч үзвэл мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, төмсний хангамж хэрэгцээт түвшнээс давсан байдалтай бол хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөгний хувьд дутуу байна. Бодлогын хувьд энэ тал дээр илүү анхаарсан зорилт, үйл ажиллагаанууд ажиглагдахгүй байна.

Төрөөс МАА-н салбарт баримтлаж байгаа бодлогуудыг нэгтгэн авч үзвэл дараах үйл ажиллагаагаар дамжуулан зохист хэмжээг үүсгэхээр төлөвлөж байна. Нэгдүгээрт, сүргийн зохист бүтцийг бий болгох (хонь ба ямааны харьцааг 2:1 болгохыг судлаачийн зүгээс санал болгож байна); хоёрдугаарт, малын сүргээс авах татвар бий болгох замаар олон малтай байх сонирхолыг бууруулах, гуравдугаарт, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар тооноос чанарт шилжих. Гэвч хийх ажлуудын уялдаа нийцлийг тодорхойлоход төвөгтэйгээр хэт ерөнхий байдлаар зорилт болон үйл ажиллагааны чиглэлийг тусгасан байгаа нь хөгжлийн бодлого, хөтөлбөрийн баримт бичгүүдийн ач холбогдолыг сулруулж байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарт өөр хоорондоо ялгаатай олон тооны дэд үйлдвэрийн салбарууд багтаж байгаа тул нэгдсэн нэг дүгнэлтэд хүрэхэд төвөгтэй. Гэвч малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн дэд салбарын хувьд малын тоо, толгойны өөрчлөлтөөс хамаарсан нийтлэг шинж чанар, чиг хандлага ажиглагдахгүй байна. Энэ нь түүхий эд бэлтгэл ба тэдгээрийн боловсруулалт хийгдэх үйл явцын хооронд үр ашигтай механизм ажиллахгүй байгааг харуулж байна.

Богино хугацаа буюу 2-3 жилийн хувьд аймгуудын түвшинд хийж болох ажил нь орон нутгийн онцлог нөөцөнд тулгуурлан (уул уурхай, ХАА, боловсруулах салбар, соёлын өв) инновацид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр эрэл хайгуул хийж, шинжлэх ухааны мэдлэг илүү шингэсэн салбарыг тодорхойлох шаардлагатай.

Уул уурхайн салбарыг бүхэлд нь цогцоор нь харсан салбарт чиглэсэн Алсын хараа, стратегийг тодорхойлж, зорилгодоо хүрэхэд шаардагдах зардал, үр ашгийн тооцооллыг хийж, ЗГ-аас бүх оролцогч талуудын оролцоотойгоор байгалийн нөөцийг хүн бүрт хүртээмжтэй, тогтвортой

хөгжлийг хангахуйцаар ашиглах бодлого, алсын хараа, стратегиа тодорхойлох нь салбарын үр ашгийг тогтвортой байлгахад ихээхэн нөлөөтэй.

Байгалийн баялгийн эзэмшлийн институцийн шинэчлэл удаашралтай байгаа нь байгалийн баялгийн үйлдвэр, хөрөнгө оруулалт, санхүүгийн орчинд сөрөг дам нөлөөг ихээхэн учруулах болсон. Дээрх урт хугацааны стратегийг хэрэгжих боломж бүхий хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх ёстой бөгөөд нөгөө талаас уул уурхайн салбарын эрхзүй нь олон улсын стандарт, гэрээнд нийцсэн, уялдаа холбоотой байх ёстойг анхаарах нь зүйтэй.

Хариуцлагатай уул уурхайн хөрөнгө оруулалтыг татахуйц Хөрөнгө оруулалтын стратеги дутагдаж байна. Хөрөнгө оруулалтыг татах бодлогыг хэрхэн тодорхойлсноос хамааран хариуцлагатай уул уурхайн салбарт орж ирэх ГШХО-ыг боомилох уу эсвэл татах уу гэдэг нь шууд хамаарна. ЗГ-ын зүгээс хөрөнгө оруулалтын бодлогоо олон улсын хөрөнгө оруулалтын хууль эрхзүй болон тогтвортой хөгжлийн хандлагад аль болох нийцүүлж, сайжруулж байх ёстой.

Эрдсийн баялаг, бүтээгдэхүүний худалдааны эрх зүй үгүй байна. Эрдэс баялгийн салбар дахь үйл ажиллагааны өнөөгийн хамрах хүрээ нь геологийн эрэл хайгуул, олборлолт, баяжуулалтын үйлдвэрлэлээр хязгаарлагдаж байгаа бөгөөд цаашид баримтлах төрийн бодлого нь боловсруулах аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд чиглэгдэх тохиолдолд ашигт малтмалын боловсруулаагүй болон баяжуулсан түүхий эд, боловсруулалт хийгдсэн эцсийн бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагааны хүрээн дэх төлөөлөлтийн харилцаа, худалдах, худалдан авах, арилжаа, зуучлал, тээвэрлэлт, хадгалалтын гэрээ, хэлцлийг зохицуулсан “Худалдааны хууль”-ийг боловсруулан батлах явдал нэн чухал юм.

Уул уурхайн салбарын нэг онцлог нь үндэсний, бүсийн, орон нутгийн засаг захиргаануудын бүх шат тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд болон бизнест шууд нөлөө үзүүлдэг. Тухайн салбарыг хариуцан ажиллаж буй төр захиргааны байгууллагуудын хариуцах асуудлууд хоорондоо давхцахгүй байхаар зохицуулах ёстой ба байгаль орчин, нийгэм, хүний эрхийн хууль эрхзүйг чанд сахиулж байх нь зүйтэй.

Салбарын татварын орлогын тодорхой хувийг өөрт нь зарцуулдаг хууль эрх зүйн механизм бүрдүүлэх нэн чухал юм.

Засгийн газраас байгалийн баялгийн ашиглалт, түүний удирдлага зохион байгуулалт, үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байлгаж шийдвэр гаргах явцад олон нийтийг оролцуулдаг механизмыг нэмэгдүүлэх, орон нутагтай хамтран ажиллах гэрээ бйагуулахыг шаарддаг ч энэ нь тодорхой загвар болон шалгуурт үндэслэж, ажлын байр, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, газрын эрх, орон нутгийн уламжлалт хөдөө аж ахуйтай уялдуулах талаар зохицуулалт дутагдаж байна.

Говьсүмбэр аймаг:

- Аймаг, сумдын хөгжлийн хөтөлбөрт уул уурхай хүнд үйлдвэрийн талаар баримтлах чиглэл бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй сайн туссан давуу талтай боловч хүнд болон дагалдах үйлдвэр хөгжүүлэх чиглэлийг нэмж тусгах нь зүйтэй.
- Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний уурхайг түшиглэн Өмнийн бүсийн түгээх сүлжээний эрчим хүчний дутагдлыг нөхөх хэмжээний цаашлаад эрчим хүч экспортлох талаар аймаг, сум нь санаачилга гарган хөрөнгө оруулагчдыг дэмжин ажиллах нь зүйтэй.
- Дэд бүтэц маш сайн хөгжсөн давуу талаа ашиглан Шивээ-Овоогийн хүрэн нүүрсийг хатаах, баяжуулах, хагас коксжуулах, шингэрүүлэх, хийжүүлэх зэргээр өртөг нэмэгдсэн боловсруулах

үйлдвэрийг барьж байгуулах үйл ажиллагааг дэмжих нь зайлшгүй. Тухайлбал, хий, хүчиллэг хий, нефть, давирхай, хүчиллэг ус, брикет, этилен, бензол, аммиак, фенол, нафталин зэрэг химийн аж үйлдвэрийн түүхий эдийг үйлдвэрлэх хөгжүүлэх боломжийг дэмжиж ажиллах хэрэгтэй байна.

- Засгийн газраас хувийн хэвшилтэй хамтран Монгол орны өмнөд бүсийн төмрийн хүдрийг баяжуулах, ган бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр гангийн үйлдвэрлэлийн цогцолбор, кокс-химийн үйлдвэр хөгжүүлэх төслийг бодлогоор дэмжин, орон нутгийн иргэдийг үйлдвэржилтийн талаар зөв мэдээллээр тогтмол хангаж ажиллах шаардлагатай.
- Говьсүмбэрийн МСҮТ-ийг түшиглэн дээрх үйлдвэрүүдэд шаардлагатай мэргэжилтэй ажилчидыг бэлтгэх чиглэлээр сургалтын хөтөлбөр агуулгыг шинэчлэх, багшлах хүний нөөцийг бэхжүүлэхэд нутгийн удирдлагын байгууллагын санаачилга идэвхжиж байна.

Дорноговь аймаг:

- Аймгийн хувьд тэргүүлэх чиглэл нь уул уурхай, хүнд үйлдэр, аялал жуулчлал, логиستيкийн төв байх эсэхээ маш ойлгомжтой тодорхойлох шаардлагатай. Эсвэл дээрх тэргүүлэх чиглэлүүдийг зэрэгцүүлэн авч үзэж хөгжүүлнэ гэвэл хэтийн ирээдүй бүхий эрдэсжилтийн бүс, аялал жуулчлалын бүсүүдийг тодорхой ялгаж өгөх зүйтэй. Тухайлбал, аймаг орон нутаг аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой эртний олдвор, соёлын биет болон биет бус өвүүдийн байршлыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах замаар хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохгүй байх. Эсвэл орон нутгийн иргэдийн саналыг хэлэлцүүлж зөвшөөрөл олгох институцийн бүтэцтэй болох нь чухал.
- Аймаг, сумын хувьд ач холбогдол бүхий ордод геологи, хайгуулын ажил гүйцэтгэх, цаашлаад олборлох, боловсруулах үйл ажиллагаа эхлэхээс өмнө аймаг, сумын түвшинд нийгэм-эдийн засгийн үнэлгээг мэргэжлийн хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлдэг байх нь чухал ач холбогдолтой.
- Геологийн илэрц бүхий нөөц өсөх боломжит газруудыг ялган уул уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас өөр чиглэлээр газрыг эзэмшүүлэхгүй байх нь өнөөгийн бодит нөхцөл.
- Дорноговь аймагт нүүрс, жонш, төмрийн илэрц байгаа ба эдгээр ордын заримд нь дахин хайгуул хийж полиметаллын нөөц батлуулах хандлага ажиглагдаж байна. Орон нутгийн удирдлага аж ахуйн нэгжүүдэд шаардлага тавьж хайгуулын ажлыг нарийвчлан дахин хийлгэж болох юм.
- Газрын ховор элементийн геологийн иж бүрэн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэж нөөцийг тодорхой болгон боловсруулах үйлдвэрийг төвлөрүүлэх чиглэлээр татвар, орон нутгийн төлбөр, хураамжаар зохицуулах боломжийг эрэлхийлэх шаардлагатай. Жишээлбэл, газрын ховор элементийг боловсруулах олон үйлдвэр бариулахгүйгээр нэг үйлдвэрт бусад аж ахуйн нэгжүүдийн хүдрийн боловсруулах нь байгаль орчин, эдийн засгийн олон давуу талтай байдаг.
- Нэг орд дээр хэд хэдэн тусгай зөвшөөрөл бүхий ашиглалтын үйл ажиллагааг эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг уурхайн байгууламжийн үе шатнаас нь эхлэн нэгдэж ажиллахыг хуулийн хүрээнд зөвлөж болно. Тухайлбал, гадаад тээврийн зам, дэд бүтцийн бусад байгууламж гэх мэт.
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын аймаг, сумын хэмжээнд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөг урт хугацаанд урьдчилан гаргах нь зайлшгүй чухал.
- Уул уурхайн салбарын орлого, татварын мэдээллийг сумын түвшинд гаргаж, ил тод болгоход аж ахуй эрхлэгчдэд олон боломжийг нээнэ.

- Уул уурхайн салбараас улсын болон орон нутгийн төсвөөр дамжин тухайн орон нутагт хуваарилагдаж буй хэмжээг тооцож иргэдэд нээлттэй мэдээлдэг байх механизм бүрдүүлж болно.
- Газрын тосны бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг түшиглэн дагалдах үйлдвэрүүдийг хөгжүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж, гадаад ба дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах чиглэлээр хөтөлбөр боловсруулан ажиллах нь аймгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нөлөөтэй.
- Тус үйлдвэрт шаардлагатай мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх сургалтын төвийг хөхүүлэн дэмжиж одооноос эхлэн бэлтгэх эхлэх нь ажиллах хүчний хомсдолоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Дундговь аймаг:

- Геологийн эрэл, хайгуулын ажлыг дэмжих чиглэлээр урт хугацааны хөтөлбөртэй болох хэрэгтэй байгаа.
- Төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авч хайгуулын ажил эхлүүлсэн компанийн үйл ажиллагааг хориглохгүйгээр аль болох судалгааг нь бүрэн гүйцэд хийлгэх, ингэснээр тухайн хайгуул хийсэн газрыг нарийвчлан судлах, эс судлах асуудлыг нэг мөр цэгцлэх шаардлагатай.
- Аймаг, сумдын ЗДТГ цаашид тогтвор суурьшилтай ажиллах нутгийн иргэдээс уул уурхайн мэргэжлийн инженер, техникийн ажилтныг зориудаар бэлтгэж, нутгийн удирдлагын аппаратад ажиллуулж болох юм.
- Төмрийн хүдрийн олборлолтыг дэмжих ба боловсруулах үйлдвэрийг Говьсүмбэрт аймагт баригдах ган бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрт нийлүүлэхийг худалдааны бодлогоор дэмжиж ажиллаж болно.

Өмнөговь аймаг:

- Аймгийн хувьд тэргүүлэх чиглэл нь уул уурхай, хүнд үйлдэр, аялал жуулчлал гэж тодорхойлсон бөгөөд аялал жуулчлалын бүсийн хүрээг маш яаралтай тодорхойлох шаардлагатай. Тухайлбал, аймаг орон нутаг аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой эртний олдвор, ховордсон биологийн олон янз байдал, соёлын биет болон биет бус өвүүдийн байршлыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах замаар хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохгүй байх, эсвэл орон нутгийн иргэний нийтийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэдэг системтэй байж болно.
- “Орхон-Говь”, “Хэрлэн-Говь”, “Сонгины саарал ус-Говь” зэрэг хэрэгжих боломжтой бодитой төслүүдээс улс төрийн лобби болон, орон нутгийн эсэргүүцэл багатай төслийг нэн тэргүүнд орон нутгийн нөөц бололцоогоо ашиглан эхлүүлэх /жишээлбэл, Таван толгой ХК-ийн орон нутагт оногдох ноогдол ашгаар санхүүжүүлэн эхлүүлэх/ боломжтой.
- Говийн дэд бүсийн аймаг, сумдуудын хөгжлийн хөтөлбөрт “Байгаль орчны нөхөн сэргээлт хийх” гэсэн заалт нийтлэг орсон байна. Эвдэрсэн газруудыг мэргэжлийн байгууллагуудаар үнэлүүлэх, эвдэрсэн газрын байршил, нэрийг тодорхой болгох, урд нь ямар аж ахуйн нэгж эсвэл хувь хүн ашиглаж байсныг ил тод болгож хариуцлага тооцох системийг ажиллуулах нь зүйн хэрэг.

- Ашигт малтмалыг олборлон баяжуулж буй аргаас нь хамааруулж нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг мэргэжлийн түвшинд гаргаж буй жишээг олон нийтэд өргөнөөр таниулж, уул уурхай дагасан боловсруулах салбарын хөгжлийн жишээний түүчээлэгч байж болно.
- Аймаг, сумдын ЗДТГ-аас хариуцлагатай уул уурхайн олборлолтын үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн иргэдийг бодит, зөв мэдээллээр тогтмол хангаж байгааг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай.
- Импортыг орлох бүтээгдэхүүн олборлож буй аж ахуйн нэгжүүдийг аль болох боловсруулалтын түвшинг ахиулах чиглэлээр нь дэмжиж ажиллах санаачилгыг өрнүүлж болно.
- Томоохон нөөц бүхий орд газруудыг түшиглэн хүнд үйлдвэр хөгжүүлэх бүс нутгаа төлөвлөж тодорхой болгох шаардлагатай. Тухайлбал:
 - Таван толгойн ордын эрчим хүчний нүүрсийг хэрэглэх цахилгаан станц барьж Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээний дутагдлыг нөхөж, улмаар Оюу толгой болон бусад томоохон үйлдвэрийн эрчим хүчийг дотоодоос хангах ажлыг нэн тэргүүнд эхлүүлэх,
 - Таван толгойн нүүрсийг баяжуулах, боловсруулах, шингэрүүлэх, кокс-химийн үйлдвэрийг барьж байгуулах, манай улсад химийн аж үйлдвэр хөгжих үндсийг эхлүүлэхэд бүхий л хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах ажлыг бодитой хийх,
 - Оюу толгойн уурайг түшиглэн Ханбогд суманд баригдахаар Засгийн газраас төлөвлөж буй “зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр”-ийн дагалдах үйлдвэрийг судалж орон нутгийн санаачилгаар барьж байгуулах ажлыг санаачлах, хөрөнгө оруулагчидтай бүхий л талаар хамтран ажиллах.

2012 оноос хойш хатуу хучилттай замуудыг аяллын гол бүс нутгуудад шийдэж өгснөөс үүдэн дотоодын аялагчдын тоо ихсэж байна. Гэтэл үйлчилгээний байгууллагын хэрэгцээ дутмаг, хатуу шингэн хог хаягдлын зохицуулалт муу, иргэдийн аялах соёл мэдлэг дутуу зэргээс үүдэн байгаль орчин, нуур, гол, уул усаа бохирдуулж байгаа зэрэг нь орон нутгийн захиргааны ажилтнуудын хүчин чадал мөхөсдөж, хүндхэн байдалд оруулж байна.

Тоон судалгаа дутмаг, бас нэг жигд бишээс үүдэн хяналт, зохицуулалтыг хийж чадахгүй байгаа нь тогтолцоо хоцрогдсоныг харуулж байна.

Салбаруудад маркетингийн нэгдсэн бодлого байхгүй тул ГХЯ, БОАЖЯ, Нийслэлийн АЖГ төсвөө тус тусдаа зарцуулж байгаа зэрэг нь төсвийн мөнгийг үр ашиг муутай зарцуулж байна. Мөн 2019 онд Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газраас Монгол улсын гадаад сурталчилгааг МОНЦАМЭ агентлаг хийнэ гэж тусгасан.

Төрийн албан хаагчид бодлогын бичиг баримт боловсруулах үндсэн ажлаа хийхгүй, хөтөч тайлбарлагчийн гэх мэт сургалтууд болон хурал чуулган зохион байгуулах, гадаад орнууд руу үзэсгэлэнд томилолтоор явах ажлыг илүүтэйгээр хийж хувийн хэвшилтэй шууд өрсөлдсөн үйл ажиллагаа явуулах асуудал ч өөрчлөгдөхгүй хэвээр байна.

Улс, аймаг, сумдын түвшинд бүгд л аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төлөвлөгөө гаргадаг ч нэгдсэн бус, хүчээ тарамдсан, төсөв мөнгө хүрэлцээгүй, ажил хийсэн төдий л байна.

Барууны орнуудын жуулчид манай улсад 12-21 хоног аялдаг, хамгийн их мөнгийг Монгол Улсад үлдээдэг, мөн монгол тур операторуудаар дамжин аялдаг гэдгийг нэг талаас бүгд мэддэг. Сүүлийн

үед Солонгос жуулчид Монголд харьцангуй бага мөнгө үлдээн аялж байгааг бас л мэддэг. Гэвч масс аялал жуулчлал, байгалийн аялал жуулчлал гэх мэт үндсэн зорилго тодорхойгүй, аль зах зээлд ямар бүтээгдэхүүн санал болгох, хэрхэн зар сурталчилгааг бодлоготойгоор хэрэгжүүлэх асуудал тодорхойгүй хэвээр байна.

Говийн дэд бүсийн аймгуудад их ачааллын үед шугамын төгсгөлд хүчдэлийн уналт шугамын урт, алдагдлаас хамааран -2,5%-иас хэтрэхгүй байхаар чадлыг тооцов.

2018 оны байдлаар эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал, нийт үйлдвэрлэлд хувийн хэвшлийн эзлэх хувь ердөө 14 % байна. Говийн аймгуудын цахилгаан түгээх сүлжээний хүчдэлийн горим ажиллагааг дээшлүүлэх, сүлжээний дамжуулах чадварыг дээшлүүлэх техник зохион байгуулалтын арга хэмжээ хэмжээ зөвлөмжийг хэрэгжүүлэх нь эрчим хүчний тогтвортой найдвартай ажиллагааг сайжруулж эрчим хүчний чанрыг стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд барих чухал ажил болно.

Монгол улсын эдийн засгийн хөгжил өмнөд бүс нутгийг түшиглэн хөгжих хэтийн бодлого чиглэлийн дагуу сүүлийн жилүүдэд шинээр нээгдэж байгаа нүүрс, төмөрлөг, жонш, алт зэсийн гэх мэт ордуудыг түшиглэн хөгжих үйлдвэржүүлэлт эрчимжиж байгаа тул тэдгээрийг цахилгаан эрчим хүчээр хангах зайлшгүй хэрэгцээ шаардлагын үүднээс тус дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх, тоноглолын шинэчлэлийг хийхдээ цогцоор нь шийдэх нь чухал юм.

“Монгол улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн төлөвлөгөө”-нд Чойрын 220 кВ-ын дэд станцыг өргөтгөн шинэчлэх /Хэрэгжсэн/, Улаанбаатар-Мандалговь 220 кВ-ын ЦДАШ дэд станц барих /Гүйцэтгэл 80%/, Багануур-Чойрын 220 кВ ЦДАШ болон дэд станц /эхлээгүй/, Оюу толгой, Тавантолгойн дэд станцыг өргөтгөх, Чойр-Сайншандын 220кВ-ын ЦДАШ дэд станц барих /эхлээгүй/ ажлууд орсон нь говийн дэд бүсийн 4 аймгийн цахилгаан эрчим хүчний ерөнхий хангамжинд онцгой чухал ач холбогдолтой юм. Эдгээр дамжуулах сүлжээ орсноор дамжуулах сүлжээний хүчин чадал нэмэгдэж, говийн аймгуудын эрчим хүчний чанар зөвшөөрөгдсөн хэмжээнд хүрч найдвартай, тогтвортой ажиллагаа сайжирна.

Улаанбаатар-Багануур-Чойр-Сайншанд-Замын-Үүдийн цахилгаан дамжуулах шугам дэд станцыг 220 кВ хүчдэлийн түвшинд шилжүүлсэн өргөтгөл хийснээр судалгаанд хамрагдсан түгээхийн шугамуудын нэвтрүүлэх чадварыг суурь болгон хэрэглэгчдийн чадалд тохирсон дэд станцыг суурилуулан шинэ хэрэглэгч хангах боломж байна.

Монгол улсын экспорт, импортын хувьд голлох үүрэгтэй Замын-Үүд, Гашуун сухайт, Шивээ хүрэн хилийн боомтуудыг эрдэс баялгийн экспортын болон автозам, төмөр замын сүлжээний зангилаа болгон хөгжүүлэх, тэнд логиستيкийн төвүүдийг байгуулан, агуулахын аж ахуйг хөгжүүлэх шаарлагатай байна. Өнгөрсөн онд Замын-Үүдэд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Бүс нутгийн логиستيкийн төв ашиглалтанд орсон.

Тээврийн ихэнх хэрэгцээ нь Дамжин өнгөрөх тээвэр байх болно. Энэ үүднээс улс хоорондын автозамын сүлжээг хөгжүүлэх талаар сүүлийн жилүүдэд багагүй ажил хийгдэж, Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүдийг холбосон хатуу хучилттай автозамыг ашиглалтанд оруулсан. Одоо энэхүү автозамын арчлалт үйлчилгээ, түүгээр явж байгаа тээврийн хэрэгсэлд тавих хяналтыг сайжруулж, замын дагуух төрөл бүрийн үйлчилгээг бий болгон шаардлагат түвшинд хүргэх асуудал тулгамдаж байна.

Аймгийн дотоодын тээврийн хувьд аялал жуулчлал хөгжүүлэх, ашигт малтмалыг төмөр зам болон гол автозамд хүргэх, шуудан, зорчигч тээвэр, болон өргөн хэрэгцээний барааг сумдад хүргэх зэрэг хэрэгцээ байна. Энэ нь аймгийн дамжин өнгөрөх тээврийн хэмжээтэй харьцуулахад бага юм. Гэхдээ энэ хэрэгцээнд тохирох автозамын төрлийг сонгон хөгжүүлэх шаардлага бий.

Санал зөвлөмж

Говийн дэд бүсийн хөдөө аж ахуйн нөөцийг бүрэн дайчилж ашиглах бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог эрс шинэчлэх шаардлагатай. Эдгээр аймагт хонины ноолуур, торомны ноос, ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн, үрийн үйлдвэрийг өртгийн сүлжээнд оруулж, тус бүрийн дэд кластерийн бодлогыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой хэдий ч хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний тогтолцооны суурь зах зээлийн зарчмаар ажиллахгүй байна. Гагцхүү хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний дэд кластерийн бодлого ба эрх зүйн зохицуулалт ихээхэн үгүйлэгдэж байна. Эдгээр онцлог бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ зах зээлийн тогтолцооны зарчмаар ажиллаагүйгээс сүүлийн 30 жилийн хугацаанд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, худалдаа, санхүүжилтийн тогтолцоо сэргэхгүй байсаар байна. Цаашилбал, хөдөө аж ахуйгаас түүхий эдээ бэлтгэх хөнгөн үйлдвэрийн салбарын бэлтгэн нийлүүлэлт тасрах, судалгаа ба хөгжүүлэлт багасах, шинэ бүтээгдэхүүн хөгжихгүй байх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агуулах ба тээвэрлэлт, логистикийн сүлжээ сэргэхгүй, улмаар өрсөлдөх давуу талаа ашиглах боломж хязгаарлагдмал хэвээр байгаа юм.

Уул уурхай, хүнд үйлдвэр нь говийн дэд бүсийн тэргүүлэх салбар учраас:

- Хангайн бүсийн голоос урсацын тохируулга хийх замаар говийн бүсийн унд, ахуй, үйлдвэрлэлийн усыг хангах ажлыг аймаг, нутгийн удирдлагын байгууллага санаачлан нэн тэргүүнд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.
- Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хөхүүлэн дэмжих, урамшуулах, тэдгээрийн үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд үнэн бодит мэдээллээр тогтмол системтэйгээр хүргэх ажил аймгуудад харилцан адилгүй байна. Тухайлбал, нөхөн сэргээлт хийдэггүй аж ахуйн нэгжүүдийг бүртгэх, олон нийтэд ил болгох, дахин зөвшөөрөл олгохгүй байх ажлыг зохион байгуулдаггүй, тиймээс уурхайн нөхөн сэргээлт хийхдээ тухайн аймаг, сумдын мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн болон иргэдийг оролцуулж болох юм.
- Говийн дэд бүсийн аймаг, сумдын хөгжлийн хөтөлбөрт уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ гэж маш ерөнхий заасан. Тиймээс эвдрэлийн шалтгааныг тодорхойлох /гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн/, эвдрэлийн цар хүрээг хэмжих, нөхөн сэргээх аргачлал, санхүүжилтийг мэргэжлийн байгаль орчны аудитын байгууллагаар үнэлүүлэх, гүйцэтгүүлэх нь зүйтэй.
- Цацраг идэвхит ашигт малтмалыг хайх, олборлох, туршилтын үйлдвэрлэл явуулах, шар нунтаг экспортлох Засгийн газрын чиглэлийн дагуу аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгаж өгч болно.
- Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төрийн захиргааны төв байгууллагыг бодит үнэн зөв мэдээллээр хангах, нягт хамтарч ажиллах шаардлагатай.
- Олборлох салбарын үйл ажиллагааг тухайн орон нутгийн хөгжил, иргэдийн амьжиргаанд хүртээмжтэй болгохын тулд ил тод байдлыг сайжруулах, нутгийн удирдлагын байгууллагыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх, уул уурхайн байгаль орчин болон нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж болно.

Нэн тэргүүнд Монгол улсын Аялал жуулчлалын хуулийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Аялал жуулчлалын салбарын хөгжил дэлхийн жишигт хүрч өрсөлдөх чадвараа нэмэгдэхээс гадна үндэсний, бүсийн болон аймгийн түвшинд үйлчлэх хууль эрх зүйн орчин боловсронгуй болж хэрэгжилтийн институцийг бий болгох юм. Түүнчлэн Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас улс орнуудын аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг тогтоодог эрэмбийг ахиулах шаардлагатай байна. Эхний ээлжинд олон улсад нээлттэй болох, хүрээлэн буй орны хамгаалалтаа сайжруулах мөн газар болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Р. Батлерын аялал жуулчлалын зорих газрын хөгжлийн загварын дагуу бусад орнуудын адил Монгол улсыг НЯГТАРШЛЫН шат руу чиглүүлж тус үе дээр байр суурийг нь бэхжүүлэхийн тулд дараах арга хэмжээг шат дараалалттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол улсын онцлогоос хамаарч аялал жуулчлалын салбарыг олон чиглэлээр хөгжүүлэх нь зүйтэй. Тоглоомын, зугаа цэнгэлийн, албан бизнесийн, малчин ахуйд суурилсан, адал явдалт, тусгай сонирхолын, хил орчмын гэх мэт ялгаатай, зах зээлийн онцлогт тохируулсан үйлчилгээ, стандартыг хэрхэн нэвтрүүлэх вэ гэдэг дээр бодлогыг цогц боловсруулах хэрэгтэй. Тэр бодлогыг үндэсний, бүсийн, аймгийн түвшинд хэрэгжүүлэх шатанд төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод хэрхэн яаж оролцох үүрэг хариуцлага хүлээх гэсэн асуудлыг хуулиар зохицуулах нь зүйтэй.

2018 оны байдлаар сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн нийт суурилагдсан чадал 190 мВт байгаа нь ТБЭХС-ийн нийт суурилагдсан чадлын 15,4 хувийн биелэлттэй байна. Гэхдээ нийт эрчим хүч үйлдвэрлэлийн 30%-д хүргэх заалтыг системийн тогтворжилтын тооцоог үндэслэн дахин нягтлах шаардлагатай. Энэ хувь ихсэх нь эрчим хүчний системийн тогтвортой, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Ер нь СЭХ-ний хууль өөрийн үүрэг зорилгоо биелүүлсэн тул одоо түүний хэрэгжилтийг зогсоож шаардлагатай заалтуудыг ЭХ-ний тухай хуулинд тусган цаашид хэрэгжүүлэх боломжтой юм. Ялангуяа үнэ тарифтай холбоотой заалтууд нь үнэ тарифын хөндлөн татаас нь нийгэм, эдийн засаг цаашилбал, олон улсын улсын хэмжээнд Монгол улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Тавантолгой, Оюутолгой, Чойр, Мандалговь дэд станцууд нь байршлын хувьд 4 аймгийн хэрэглээний эрчим хүч дамжуулах чухал зангилаа цэгүүд мөн бөгөөд эдгээр дэд станцын хүчин чадал нэмэгдэж байгаа нь эрчим хүчний хангамжийн чухал хэсэг болно. Ялангуяа Улаанбаатар – Мандалговийн 220 кВ-ын ЦДАШ, дэд станц ашиглалтанд орсноор 4 аймгийн цахилгаан хангамж сайжрах бөгөөд цаашид Багануур–Чойрын 220кВ-ын ЦДАШ орсон тохиолдолд ТБЭХС-ийн төв болон өмнөд хэсэгт тойрог сүлжээ үүсэж, дамжуулах чадвар болон найдвартай ажиллагаа эрс дээшилнэ. Мөрийн хөтөлбөрийн хугацаандаа багтааж, Чойр-Сайншандын 220кВ-ын ЦДАШ барьж гүйцэтгэх нь Дорноговийн Сайншанд чиглэлийн цахилгаан эрчим хүчний хангамжид чухал ач холбогдолтой. Мөн 2020 оноос цааш баримтлах засгийн газрын мөрийн хөтөлбөрт Сайншанд – Замын үүдийн 220 кВ-ын ЦДАШ барьж гүйцэтгэх ажлыг заавал оруулах шаардлагатай.

Говийн дэд бүсийн аймгийн төв, хилийн боомтуудад гаалийн баталгаат агуулах, хил гаалийн хяналт, хорио цээрийн хяналттайгаар байгуулах нь зүйтэй.

Говийн дэд бүс нь аялал жуулчлал хөгжих түүх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудтайн хувьд тээврийн хэрэгцээ ихтэй бүс нутаг болно. Энэ чиглэлээр аймгуудын аялал жуулчлалын хөтөлбөрийн дагуу замын сүлжээг хөгжүүлэх нь зүйтэй.


Шинэ Төмөр зам болон хурдны автозам зэрэг их бүтээн байгуулалтын ажил ойрын үед өрнөх тул түүнд нийгмийн асуудал, байгаль орчны хамгаалалтын шаардлагыг хангахуйц арга хэмжээг урьдаас сайтар төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.3 Нийгэм

Хүн ам нутагшил, суурьшил

Говийн дэд бүс нь нийт 4 аймгийн 47 сум, 196 багаас бүрдэх бөгөөд 2017 оны байдлаар нийт 62042 өрх, 196.5 мянган хүн амтай бөгөөд төвийн бүсийн хүн амын 38.9%-ийг эзэлж байна.

Зураг 37 Хүн амын нутагшилт



Эх сурвалж: МУИС. Геологи, газарзүйн тэнхимийн судалгааны баг, 2019

Хүснэгт 25 Аймгуудын хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ

	Аймаг	Нутаг дэвсгэрийн хэмжээ/ам.дөр км/	Сумын тоо	Багийн тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо
1	Говьсүмбэр	5540	3	10	5364	17383
2	Дорноговь	74700	15	66	14556	68147
3	Дундговь	109500	14	64	20844	45755
4	Өмнөговь	165400	15	56	21278	65314

Эх сурвалж: МУИС. Геологи, газарзүйн тэнхимийн судалгааны баг, 2019

Монгол улсын хүн ам 1990 оноос одоог хүртэл жилд дунджаар 1.8%-иар өссөн үзүүлэлттэй байхад тус бүсэд хүн ам 0.6%-иар өссөн бөгөөд 2005 оноос хүн амын тоо харьцангуй тогтмол өсөлттэй байна.

Зураг 38 Хүн амын ердийн цэвэр өсөлт




Эх сурвалж: МУИС. Геологи, газарзүйн тэнхимийн судалгааны баг, 2019


Говийн дэд бүсийн дундаж хүн амын нягтшил 1.2хүн/ам км байгаа нь улсын дундаж (2.0 хүн/ам км) нягтшилаас 1,6 дахин бага, төвийн бүсийн нягтшилтай ойролцоо байгаа нь хүн ам сийрэг суурьшилтайг харуулж байна. Чойр, Сайншанд, Замын-Үүдэд хүн амын нягтшил хамгийн их бөгөөд Дундговь аймгийн хойд талын сумд, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд хүн амын нягтшил харьцангуй шигүү, харин бусад сумдад хүн ам их сийрэг суудаг/Зураг 2/.Тус бүсийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 44% хувь нь хот, суурин амьдарч байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь дээрх 4 аймагт харилцан адилгүй байна. Тухайлбал, Дорноговь аймагт хамгийн өндөр үзүүлэлттэй буюу хүн амын 62.7% нь, харин Дундговь аймагт 26.3%, Өмнөговь аймагт 37.9%, Говьсүмбэр аймагт 40.6% нь хот суурин газарт амьдарч байна.

Төвийн бүсийн Говийн дэд бүс нь 2002 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор ихэнх сумд нь **IV-Б** бүс буюу аймаг, сумдын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говь цөлийн таруу нутагшилтын бүсэд, Дорноговь, Говьсүмбэр аймгийн цөөн сумд **I-Б** буюу аймгийн төв, төмөр замын дагуух суурин газруудын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говийн бүсийн бөөгнөрсөн нутагшилтын бүсэд хамаарч байсан.

Зураг 39 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүн амын нягтшил



Зураг 40 Монгол улсын хүн амын нутагшилтын тогтолцоо. 2017




Эх сурвалж: МУИС. ЭЗХ-гийн судалгааны баг, 2019

Говийн дэд бүсийн 2017 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоог харахад 2002 оныхоос эрс ялгаатай болсон. Тухайлбал, 2002 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор ихэнх сумд нь **IV-B** бүс буюу аймаг, сумдын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говь цөлийн таруу нутагшилтын бүсэд хамаарч байсан Өмнөговь аймгийн нийт сумд 2017 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор **II-B** буюу улсын хилд ойр, олон улсын болон улсын чанартай авто замд холбогдсон, аймгийн төв хотууд, сумын төвийн нөлөөлөл ихтэй, хээр, говийн нягтаршил ихсэж буй нутагшилтын бүсэд хамаарч байна. Мөн 2002 оны **IV-B** бүс буюу аймаг, сумдын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говь цөлийн таруу нутагшилтын бүсэд хамаарч байсан Дундговь аймгийн ихэнх сумд 2017 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор **III-B** буюу нэг ангиллаар ахисан байна.

Хот, суурины төвлөрлийн хувьд аймгийн төв хотуудаас гадна Өмнөговь аймгийн уул уурхайн үйлдвэрлэлд түшиглэсэн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Дорноговь аймгийн хилийн боомт, ачаа тээвэр логистикийн төв Замын-Үүд, Говьсүмбэр аймгийн уул уурхайд түшиглэсэн Шивээговь, Дундговь аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд түшиглэсэн Эрдэнэдалай сумын төвүүд хөгжлийн таталцлын төв болон хөгжиж эхлээд байна.

Хот, суурины төвлөрлийн хувьд Дорноговь аймгийн Сайншанд, Говьсүмбэр аймгийн Чойр хотууд аймгийн хүн амын төвлөрлийг татаж бусад аймгийн төв хотууд хүн амаа нийслэл хот руу алдах хандлагатай байсан.

Зураг 41 Хот суурины төвлөрөл. 2017



Эх сурвалж: МУИС. ЭЗХ-гийн судалгааны баг, 2019


Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Газрын үнэлгээний тойрог”-ийг шинээр баталсан. Төвийн бүсийн Говийн дэд бүс нь Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний Г-6, Г-9, Г-10 дугаар тойргуудад хамаарагдаж байгаа бөгөөд тус бүс нь бэлчээр, тариалан, хадлангийн ашиглалтын зориулалтын талбайн бага үнэлгээтэй тойрогт хамаарч байна.

Хүн амын өсөлт, ажил эрхлэлт, ажилгүйдэл

Говийн бүсийн аймгуудын хүн амын өсөлтийн төлөв байдал

Монгол улсын хүн ам 2017 онд 3.2 саяд хүрсэн нь сүүлийн 82 жилд ойролцоогоор 4.3 дахин өссөн буюу 1935 оноос хойш жилд дунджаар 4 орчим хувиар өсчээ. Харин 1991 оноос хойш улсын хэмжээний болон аймгуудын шилжих хөдөлгөөн, хүн ам зүйн бүтцэд ихээхэн өөрчлөлт орсон байна. Өөрөөр хэлбэл, 1991-2017 онд /сүүлийн 26 жилд/ Монгол улсын хүн ам жилд дунджаар 5.6 хувиар өссөн бол говийн дэд бүсийн аймгуудын хувьд 1 орчим хувиар өсчээ. Үүнээс Говьсүмбэр аймгийн хүн амын тооны дундаж өөрчлөлт 1.6 хувь, Дорноговь 1.7 хувь, Дундговь аймаг - 0.5 хувь, Өмнөговь аймгийнх 1.8 хувийн өөрчлөлттэй байна.


Зураг 42. Говийн бүсийн аймгуудын хүн амын өсөлтийн 2030 он хүртэлх төсөөлөл, хувиар



Тайлбар: *Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын хувьд тооцсон хүн амын тоо, хүйс, насны бүлэг, аймаг, нийслэлээр, дунд хувилбар 1Б, 2015-2030 он

Монгол улсын нийт хүн амд эзлэх хувь говийн дэд бүсийн хүн амын тоо жилээс жилд буурсаар байна. Тухайлбал, нийт хүн амд Дундговь аймгийн хүн амын эзлэх хувь 1990 онд 2.4 хувь байсан бол 2000 онд 2.1 хувь, 2010 онд 1.4 хувь болж буурчээ. Цаашид энэ хувь хэмжээ 2020 онд 1.4 хувь, 2030 онд 1.3 хувь, 2040 онд 1.2 хувь болж буурах төлөвтэй байна. Харин бусад аймаг, бүсүүдийн хувьд тус хувь хэмжээ харьцангуй өндөр үзүүлэлттэй байна.


Зураг 43. Монгол улсын нийт хүн амд говийн дэд бүсийн аймгуудын хүн амын эзлэх хувь



Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Говийн дэд бүсийн аймгуудад шилжин ирсэн /ШИ/ болон явсан /ШЯ/ хүн амын тооноос харвал, сүүлийн 10 жил буюу 2008-2017 онд илүү шилжин явалтын түвшин илүү өндөр байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн хувьд тус хугацаанд нийт 784 хүн шилжин ирж, 1660 хүн шилжин явсан тул шилжин явалтын түвшин 2.17 гарчээ.


Зураг 44. Аймгуудын хүн амын шилжилт хөдөлгөөнд гарч буй өөрчлөлт, сүүлийн 10 жилээр



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан 4 аймаг, 47 сумын буюу говийн дэд бүсийн хүн амын нягтралын дундаж нь 2.7 хувь байгаа нь улсын дундаж болох 2.0 хувиас 0.7 пунктээр өндөр байна. Харин хүн амын ачаалал 50.3 хувь байгаа нь улсын дундаж болох 50.8 хувьтай ойролцоо гарчээ. Хүн амын нягтрал хамгийн өндөртэй орон нутгууд нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад (50.5 хувь), Замын үүд (36.0 хувь), Сүмбэр (14.4 хувь), Сайншанд (10.3 хувь) зэрэг сумд байна.

Зураг 45. Говийн аймгуудын хүн амын нягтрал болон ачаалал, хувиар




Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд

Монгол улсын хэмжээнд 2017 онд 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 1238.3 мянгад хүрсэн нь 1991 онтой харьцуулахад 1.57 дахин өссөн үзүүлэлт юм. Харин Монгол улсын 15 ба түүнээс

дээш насны хүн амд говийн бүсийн аймгуудын эзлэх хувь хэмжээ сүүлийн 27 жилд дунджаар 7.2 хувь байгаагаас гадна 2001 оноос хойш буурах төлөв ажиглагдаж байна. Энэхүү хувь хэмжээг аймаг тус бүрээр авч үзвэл, 2017 онд Дорноговь аймаг 2.5 хувь, Өмнөговь аймаг 2.0 хувь, Дундговь аймаг 1.8 хувь, Говьсүмбэр аймаг 0.6 хувьтай гарчээ.


Зураг 46. 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын улсын нийт дүнд аймгуудын эзлэх хувь



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Сүүлийн 8 жилд буюу 2010 оны 4-р улирлаас 2018 оны 4-р улирлын хооронд 15 ба түүнээс дээш насны хүн амын тооны өөрчлөлтийг Монгол улсын хэмжээнд болон говийн дөрвөн аймгуудаар харьцуулан судлав. Тус хугацаанд улсын хэмжээнд 15-19, 20-24 насны хүн амын тооны өөрчлөлт тус бүр 4.6%, 26.7%-иар буурсан бол 25 ба түүнээс дээш насны хүн амын тоо дийлэнх аймагт өссөн.

Зураг 47. Говийн дэд бүсийн аймгуудын 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт




Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Говийн аймгуудаас 29 хүртэл насны хүн ам хамгийн их буурч, 30-аас дээш хүн амын тоо хамгийн ихээр өссөн нь Өмнөговь аймаг байна. Өөрөөр хэлбэл, тус аймгийн хувьд ойрын ирээдүйд

хөдөлмөрийн насны хүн амын тоо буурч, тэтгэврийн насны хүн амын тоо өсөх төлөвтэй байгааг илэрхийлж байна.

Зураг 48. Өмнөговь аймгийн 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол


2017 оны байдлаар, Монгол улс дахь 15 ба түүнээс дээш насны хүн амд, тухайн аймгийн эзлэх хувь хэмжээнээс үзвэл Дорноговь аймаг 2.5 хувь, Өмнөговь аймаг 2.0 хувь, Дундговь аймаг 1.8 хувь эзэлж байгаа бол Говьсүмбэр аймгийн хувьд 0.6 хувийг бүрдүүлж байна. Харин эдийн засгийн салбараар аваад үзвэл, Өмнөговь аймгийн хувьд хамгийн их хувь нь уул уурхайн салбарт (6.3 хувь) ажиллаж байна.

Хүснэгт 26 15-аас дээш насны ажиллагчдын тоонд тухайн салбарт ажиллагчдын эзлэх хувь

Эдийн засгийн салбарууд	Улс	Бүс	ГС	ДоГ	ӨГ	ДуГ
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	28.8	38.5	16.9	35.9	34.1	53.9
Уул уурхай, олборлолт	4.2	6.4	10.8	3.7	12.9	1.5
Боловсруулах үйлдвэрлэл	7.5	4.0	2.8	3.7	4.2	4.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.4	2.2	4.3	2.7	1.8	1.2
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент	0.4	0.5	0.3	0.4	0.2	0.9
Барилга	5.7	1.7	1.3	2.2	1.8	1.2
Бөөний, жижиглэн худалдаа, машин засвар, үйлчилгээ	16.5	13.2	12.5	13.3	14.7	11.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.9	6.8	13.1	11.4	2.6	3.1
Зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны үйлчилгээ	2.9	2.2	4.0	2.1	2.0	2.1
Мэдээлэл, холбоо	1.2	1.0	1.6	1.7	0.8	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.9	1.7	2.2	1.6	1.7	1.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа	1.0	0.6	0.6	0.5	0.8	0.5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.7	0.7	0.3	0.9	0.8	0.3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгэм хамгаалал	6.6	6.9	12.1	6.8	7.1	5.1
Боловсрол	8.0	8.0	9.7	7.0	9.2	7.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3.2	3.0	3.4	3.8	2.0	3.2
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.8	1.0	2.2	0.5	1.1	1.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.8	1.5	1.8	1.7	2.1	0.5
Хүн хөслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.2	0.2	0.0	0.3	0.2	0.0
ОУ-н байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0

Сүүлийн 7 жилийн хугацаанд буюу 2010 оноос хойш говийн бүсийн аймгуудын 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо хамгийн их өсөлттэй байсан салбарууд нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа (149.1 хувь), урлаг, үзвэр, тоглоом, наадам (59.0 хувь), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа (58.3 хувь) зэрэг салбарууд байна. Харин тус хугацаанд хамгийн их буурсан салбар нь олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбар байна. Өөрөөр хэлбэл, тус салбарт 2010 онд нийт 183 хүн ажиллаж байсан (Дорноговьд 51 хүн, Өмнөговьд 132 хүн) бол 2017 онд 4 аймагт тухайн салбарт нэг ч хүн ажиллаагүй байна.


Зураг 49. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин, 2001, 2009, 2017 оноор, мян төгрөг



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2007-2017 оны хооронд буюу сүүлийн 10 жилд Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгийн цалингийн дундаж өсөлт харьцангуй өндөр байгааг уул уурхайн салбарын хөгжилтэй холбон тайлбарлаж болох юм. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалинг улсынхтай харьцуулахад Өмнөговь аймгийнх дээгүүр (харьцуулсан оноор харгалзан 2.7 мян.₮, 51.9 мян. ₮, 31.6 мян.₮) байхад Дундговийн хувьд харьцангуй доогуур (харьцуулсан оноор харгалзан 8.9 мян.₮, 24.5 мян. ₮, 304.6 мян.₮) байна. Ялангуяа 2017 онд улсын дунджаас 32.2 хувиар бага байна. Улс болоод говийн аймгуудын ажилгүйдлийн түвшин 2008 он хүртэл буурах төлөвтэй байсан ч 2009 онд дунджаар 7 орчим пунктээр өсчээ. Харин 2009 оноос хойш дийлэнх аймгийн ажилгүйдлийн түвшин буурах төлөвтэй байгаа ч Өмнөговь аймгийн ажилгүйдлийн түвшин 2013 оноос өссөн.


Зураг 50. Ажилгүйдлийн түвшин, хувиар, аймаг тус бүрийн 1992-оос 2017 оны үзүүлэлт



Ажилгүй байгаа иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 20-49 хүртэлх насны иргэд хамгийн их ажилгүй байна. Мөн говийн дэд бүсийн аймгууд дахь ажилгүй иргэдийн улсын нийт ажилгүй

иргэдийн тоонд эзлэх хувийг насны бүтцээр нь авч үзвэл, 40-өөс дээш насны иргэд хамгийн их хувийг бүрдүүлж байна. 2018 оныг 2008 онтой харьцуулбал говийн дэд бүсийн аймгуудын бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоонд 25-34 насны залуучуудын эзлэх хувь 26.8 хувиар өссөн бол 35-аас дээш насны ажилгүй иргэдийн тоо 54 хувиар өсчээ.

Зураг 51. Говийн дэд бүсийн аймгуудын бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн салбарын үзүүлэлтүүд улсын нэгдсэн дүнтэй харьцуулбал ажиллах хүчний оролцооны түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь тус бүр 10 болон 8.9 хувиар өндөр байгаа ч ажилгүйдлийн түвшин нь улсын дүнгээс 0.3 пунктээр бага гарчээ. Сүүлийн 10 жилд буюу 2007 оноос хойш говийн дэд бүсийн аймгуудын ажилгүй иргэдийн тоо 5.8 дахин, ажилгүйдлийн түвшин нь 4.34 дахин өсчээ. Тухайн хугацаанд ажилгүй иргэд, ажилгүйдлийн хувь хэмжээ хамгийн их өсөлттэй гарсан нь Өмнөговь аймаг байна.

Хүснэгт 27 Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн өөрчлөлт, 2007-2017

Хөдөлмөрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд	Улсын дүн		Говийн бүс		Говьсүмбэр		Өмнөговь		Дундговь		Дорноговь	
	2017	Δ	2017	Δ	2017	Δ	2017	Δ	2017	Δ	2017	Δ
15-аас дээш насны хүн ам, мян.хүн	2,220	1.35	133.7	1.31	11.2	1.30	44.0	1.53	30.5	1.00	48.0	1.40
Эдийн засгийн идэвхтэй хүн ам, мян.хүн	1,357	1.29	95.1	1.35	7.7	1.77	30.3	1.35	23.7	1.00	33.4	1.66
Ажиллагчид, мян.хүн	1,238	1.21	86.5	1.25	7.1	1.70	25.3	1.14	22.6	0.98	31.4	1.59
Ажилгүй иргэд, мян.хүн	119	3.98	8.6	5.84	0.6	3.68	5.0	14.66	1.0	1.76	2.0	5.26
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, мян.хүн	863	1.47	38.6	1.22	3.5	0.82	13.7	2.16	6.8	0.99	14.6	1.04
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	61.1	0.95	71.1	1.03	69.0	1.36	68.8	0.88	77.6	1.00	69.7	1.18
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	55.8	0.89	64.7	0.96	63.6	1.30	57.5	0.75	74.2	0.98	65.5	1.13
Ажилгүйдлийн түвшин, хувь	8.8	3.09	9.1	4.34	7.8	2.08	16.4	10.89	4.4	1.75	6.1	3.17

Тайлбар: Δ-нь Тухайн үзүүлэлт нь 2007 оноос 2017 оны хооронд хэд дахин өссөн болохыг харуулна.

Өмнөговь аймагт ажилгүй иргэд болоод ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын тоо өсөж байгаа ч шинэ ажлын байр цөөн, ажил хийх сонирхолгүй, их дээд сургууль төгсөгчдөд мэргэжлийн дагуу ажил олдохгүй, өндөр цалин хөлстэй ажил хийх сонирхол ихэссэн зэрэг хүчин зүйлээс хамаарч байна¹⁸.

¹⁸ Өмнөговь аймгийн ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн 2017 оны танилцуулга, х.21

Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй иргэдээр тус тус тооцдог. Бид зорилтот аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийг 2016-2018 оны 12-р сарын байдлаар тооцов.

Хүснэгт 28 Зорилтот аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, 2016-2018

Аймаг	2016.12			2017.12			2018.12		
	Ажлын байрны захиалга	Бүртгэлтэй ажилгүй иргэд	ХЗЗ-ийн тэнцвэр	Ажлын байрны захиалга	Бүртгэлтэй ажилгүй иргэд	ХЗЗ-ийн тэнцвэр	Ажлын байрны захиалга	Бүртгэлтэй ажилгүй иргэд	ХЗЗ-ийн тэнцвэр
Говьсүмбэр	156	197	41	371	320	-51	639	157	-482
Дорноговь	731	1338	607	1263	952	-311	1158	901	-257
Дундговь	310	519	209	1101	633	-468	847	358	-489
Өмнөговь	921	414	-507	1605	386	-1219	2190	258	-1932
Дүн	2118	2468	350	4340	2291	-2049	4834	1674	-3160

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Сүүлийн 2 жилд зорилтот аймгуудын хөдөлмөрийн эрэлт буюу ажлын байрны захиалга нэмэгдэж, харин нийлүүлэлт хомсдолтой байна. Ялангуяа Өмнөговь аймагт гэхэд ажилгүйдлийн түвшин бусад 3 аймагтай харьцуулахад хамгийн өндөр байгаа атал (Хүснэгт 3) хөдөлмөрийн нийлүүлэлт хамгийн олон (1932) хүнээр хомсдолтой байна. Иймээс хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж шалтгааныг тодруулах шаардлага байна.

Ажлын байрны захиалга болон ажилд зуучлагдсан иргэд

Улсын хэмжээнд аваад үзвэл, 2018 онд 64.5 мянган ажлын байрны захиалга ирсэнээс 54.0 хувийг Улаанбаатар хот, Төвийн бүс 29.6 хувийг бүрдүүлж байгаа бол ажилд зуучлагдсан иргэдийн 15 хувийг эзэлж байна.

Говийн дэд бүсийн аймгуудын ажлын байрны захиалгын байдлыг сүүлийн 4 жилийн байдлаар авч үзэхэд, 2016 онд хамгийн бага буюу өмнөх оныхоосоо бараг 50 хувь буурсан байсан бол 2018 онд өмнөх оноосоо 11.4 % (494)-аар өсчээ. Аймгууд дотроос 2018 онд Өмнөговийн хувьд 2017 онтой харьцуулахад 36.4% (585)-иар, Говьсүмбэр 72.2% (268)-иар тус тус өссөн байхад Дундговийнх 29.9 % (254)-иар буурсан байна.

Ажлын байрны захиалгыг 2016-2018 оны дунджаар эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр аваад үзвэл, Говьсүмбэр аймгийн хувьд үйлчилгээний бусад үйл ажиллагаа (17.2%), боловсруулах үйлдвэр (10.9 %), бөөний болон жижиглэн худалдаа (9.7%); Дорноговьд уул уурхай, олборлолт (26.7%), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (26.2%), төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа (12.5%); Дундговьд үйлчилгээний бусад үйл ажиллагаа (21.8%), боловсруулах үйлдвэр (17.9 %), ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (13.3 %); Өмнөговь аймгийн хувьд уул уурхай, олборлолт (56.6%), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (11.5%), боловсрол (4.9%) тус тус давамгайлж байна. Аймгийн хувьд үйлчилгээний бусад үйл ажиллагаанд ажлын байрны эрэлт өндөр байгаа нийтлэг дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 29 Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, хүнээр

Аймаг	2015		2016		2017		2018	
	Ажлын байрны захиалга	Зуучлагдсан иргэд	Ажлын байрны захиалга	Зуучлагдсан иргэд	АБ ашиглалтын хувь	Ажлын байрны захиалга	Зуучлагдсан иргэд	АБ ашиглалтын хувь
Говьсүмбэр	549	328	156	62	39.7	371	359	96.8
Дорноговь	1743	1039	731	376	51.4	1263	1243	98.4
Дундговь	673	576	310	299	96.5	1101	790	71.8
Өмнөговь	1248	954	921	835	90.7	1605	892	55.6
Дүн	4213	2897	2118	1572	74.2	4340	3284	75.7

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажлын байр ашиглалтын байдал 2018 оны 12-р сарын байдлаар аваад үзэхэд, говийн дэд бүсийн аймгуудын дундаж (67.6%) улсын дундаж (66.8%)-тай ойролцоо байгаа ч аймгуудаар ялгаатай байна. Тухайлбал, Дорноговь аймгийн ажлын байр ашиглалтын түвшин хамгийн өндөр буюу 94.8 хувь байхад, Өмнөговийнх хамгийн бага (45.6%) байна.

Зуучлагдсан иргэдийн тоог ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд, сүүлийн 4 жилд Говьсүмбэр аймгийн хувьд нийт 1234 хүнийг ажилд зуучилж оруулсанаас хамгийн олон хүнийг энгийн ажил мэргэжилд (290), мэргэжилтэн (232) байсан бол Дорноговьд мөн адил 3756 хүнийг ажилд зуучилсанаас 31% (1159)-ийг энгийн ажил мэргэжилд, 15% (545)-ийг мэргэжилтний ажлын байранд оруулсан байна. Дундговь аймагт сүүлийн 4 жилд нийтдээ 3008 хүн зуучлагдсанаас 20% (608) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 19 хувийг мэргэжилтэн эзэлж байгаа бол Өмнөговь аймагт 3679 хүнээс 32% (1172)-ийг худалдаа, үйлчилгээний ажилтан байна (Хавсралт 14). Эндээс харахад, тэднийг гол төлөв мэргэжилтэн, энгийн ажил мэргэжил болоод худалдаа үйлчилгээний ажилтны ажлын байранд зуучилжээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан

Олон жил боловсрол судлаачдын дунд сургуулийн хэмжээ боловсролын үр дүнд хамаатай эсэх тухай мэтгэлцээн явсан. Энд хоёр өөр ойлголт байгаа. Олон бүлэгтэй “том” сургууль байх, бүлэг дүүргэлт өндөр байхыг “том” сургууль гэж хэлэх нь өөр ойлголтууд.

Бүлэг дүүргэлтийн тухайд, ерөнхийдөө багш нарт цөөн байх тусмаа амар, мөн нэг хүүхдэд тавих анхаарал, халамж нэмэгдэнэ. Ялангуяа бага ангид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чухал болох нь судалгаагаар харагддаг.¹⁹ Харин дунд болон ахлах ангид бүлэг дүүргэлт бага байвал сайн гэж баталж чадаагүй.²⁰ Гэхдээ олон хүүхдтэй ангид шинжлэх ухааны хичээлүүдийг уламжлалт лекцийн аргаар /хүүрнэх хэлбэрээр/, ширээ, сандалыг уламжлалт хэлбэрээр байрлуулан заагаад нэмэргүй гэдэг нь

¹⁹Бүлэгт дүүргэлтийн нөлөөллийг тооцох зорилгоор 1979-2014 онуудад хийсэн судалгаануудын үр дүнг нэгтгэсэн тойм судалгаагаар “Australian Association for Research in Education”, Prof. David Zyngier

I have just completed a comprehensive review of 112 research papers on class sizes written between 1979 and 2014. I found that reducing class size in the first four years of school can have an important and lasting effect on student achievement.

²⁰“STAR” төслийн зохиогч ингэж бичжээ:

“Despite the many studies that show positive effects, research has yet to come up with a consistent, integrated explanation for the gains attributable to reduced class size,” according to the paper, published in the journal [Review of Educational Research](#).

тодорхой. “Ангид хүүхдүүд араар дүрсгүйтэж, ярьж, тоглож цагийг өнгөрөөх нь элбэг” хэмээн бүлэг дүүргэлт болон сургуулийн хэмжээ боловсролын үр дүнд хамаатай эсэхийг судалсан боловсролын түүхэнд хийгдсэн хамгийн том судалгааны нэг болох “STAR”-ийн тайланд бичжээ.²¹

Манай улсад олон бүлэгтэй төрийн өмчийн “том” сургуулийн сурлагын амжилт аймгуудад сайн байсаар ирсэн. Бидний хийж буй энэ судалгааны өнөөгийн нөхцөл байдлын үзүүлэлтээс ч мөн ингэж харагдаж байна.²² Эсрэгээрээ, анги дээшлэх тусам “том” нь дээр юм байна гэдэг дүгнэлт ч²³ орон нутагт үнэн байдаг. Энэ нь, тухайлбал, нэг сургуульд 6-р ангийн хоёроос дээш бүлэг хичээллэх тухай ойлголт. Сумдад цөөхөн хүүхэдтэй анги хичээллэх нь хүүхдийн эрх ашигт нийцэж байна гэж бодлого боловсруулагчид тайлбарладаг боловч харин ч эсрэгээрээ хүүхдийн эрхийг зөрчиж хүүхдэд тэгш боломж олгох үүргээ биелүүлж чадахгүй байгаа хэрэг. Гэрээсээ сургуульд явж байгаа нь түүнд тэгш боломж олгож байгаа мэт боловч тухайн сургуульд 6-р ангийн нэг бүлэг байдаг, тэр нь 8 хүүхэдтэй (зарим сургуульд түүнээс ч цөөн хүүхэд байх нь элбэг) бол тэр институт зарчмын дагуу ажлаа хийх, мөн хийж байгааг нь хянах (institutional legitimacy) тогтолцоо алдагдах эрсдэл өндөр.²⁴ Нэг хичээлийг заадаг хоёр багш байвал бие биедээ туслахаас гадна хяналт тавьж чадна. Иймд бид бага ангид аль болох бүлэг дүүргэлтийг багасгаж, дунд болон ахлах ангид бүлэг дүүргэлтийг нэмэгдүүлэх, бага сургууль бол тэр хэмжээндээ олон бүлэгтэй, дунд сургууль мөн нэг анги нь хоёроос дээш бүлэгтэй байхаар тухайн сургуулийн хэв шинжид тохирсон “том” байх нь боловсролын үр дүнд нөлөөлж байна гэж үзлээ. Хүүхэд цөөн байхад заавал 9 жилийн сургууль байх гэж, 12 жилийн сургууль байх гэж хичээх нь эдийн засгийн хувьд ч үр ашиг муутай, хамгийн гол нь хүүхдийн эрх ашиг хохирно. Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу хил зааг хамааруулахгүйгээр кластер хэлбэрээр сургуулийг зохион байгуулах эрхзүйн үндэс байдаггүй байх. Гэхдээ хамгийн чухал нь хүүхдийн эрх ашиг тул хүүхдэд ээлтэй байдлаар шийдэх эрх нь орон нутгийн удирдлагад нээлттэй.

Ахлах сургуулийн хамран сургалт бидний судалсан 4 аймагт бага байна. Ялангуяа Дундговь аймагт 48 хувь нь 10-р ангид элсчээ. Мөн хүн амын тоо эрс нэмэгдэж байгаатай холбоотой Дорноговь аймаг, хамран сургалт тааруу болох шинж байгаа тул эдгээр аймагт зарим сургуулийг өргөтгөж 12 жилийн сургууль болгон элсэлтийг нь нэмэгдүүлэх хэрэгтэй болжээ. Олон улсад хүүхдүүдийг 12 жилийн сургуулиар бүрэн дунд боловсрол эзэмшүүлж, мөн мэргэжлийн чиг баримжаатай болгож төгсгөх бодлого баримталж байгаа. Бүрэн дунд боловсрол бол маргаангүй хүнийг маш сайн төлөвшүүлдэг хамгийн чухал шат гэдэг нь тодорхой. Өмнө нь манай улс 10-р ангид элсэгчдийг 75 хувьд хүргэхээр төлөвлөдөг байсан гэтэл одоо 50 орчим хувьтай, аймгуудын хувьд үлдсэн 50 хувийн хэд нь МСҮТ-д элсэж байгаа нь тодорхойгүй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны МСҮТ-ийн статистикийн мэдээ хангалтгүй байдаг учраас элсэлтийг аймгаар гаргаж харах өгөгдөл байхгүй байна. Иймд боловсролын мөшгих (Cohort) шинжилгээ энд ирээд алдагддаг. МСҮТ-ийн ерөнхий боловсролын сургалтын чанар маш муугаас гадна БСШУС-ын Сайдын 2018 оны А/453 тоот

²¹ Finn, Jeremy D.; Pannozzo, Gina M.; Achilles, Charles M. The "Why's" of Class Size: Student Behavior in Small Classes *Review of Educational Research*, v73 n3 p321-368 2003.

²² Гэхдээ нийслэлд энэ дүгнэлт батлагдахаа больдог.

²³ <https://www.gatesnotes.com/Education/UCF-Digital-Learning>

²⁴ Suchman, M. (1995). Managing legitimacy: Strategic and institutional approaches. *Academy of Management Review*, 20(3), 571–610.

тушаалаар 1225 цаг жилд тавигдсан байдаг бол мэргэжлийн боловсролд ерөнхий эрдмийн энэ цагийн ердөө 20 орчим хувийг судлаад мэргэжлийн боловсролоос гадна ерөнхий боловсрол эзэмшсэн гэрчилгээ авдаг нь хэтэрхий гажуудуулсан хэрэг болдог. Иймд аль болох олон хүүхдийг ахлах сургуулиар бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхгүй бол хожим засахад хэцүү алдаа эндээс гарна.

Соёл бол аливаа өөрийн гэсэн онцлог бүхий үндэстэн оршин тогтнох үндсийн нэг. Монгол улсын **“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ийн 3.1.4 дугаар зүйл заалт тэр чигээрээ соёлыг хамгаалах тухай юм.**

Институцийн талаасаа соёлын аливаа бодлогыг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх, төр, орон нутгийн засаг захиргаа туслах тал дээр илүү хүчтэй институц бий болгох заалт хэрэгтэй байж болохоор байна. Тиймгүйсэн бол улс үндэстэн дотроо үйл ажиллагаа явуулахад олон улсын конвенцийг тогтмол иш татах²⁵ шаардлага үүсэхгүй байх байсан болов уу. Мэдээж олон улсын конвенцээр хүлээсэн үүргээ биелүүлэх нь чухал ч соёлоо хамгаалах нь үндэстний заавал хүлээх ёстой хариуцлага юм.

Статистикийн зорилгоор соёлыг тодорхойлох нь соёлын үндсэн салбаруудад тушиглэсэн прагматик ойлголт юм.²⁶ Өртгийн сүлжээний (value chain) загвараар авч үзвэл, загвар, санаа гаргахаас эхлэн бүтээх, үйлдвэрлэх, түгээх, үзүүлэх, дамжуулах, хэрэглэх үе шатыг багтаасан соёлын бүхий л үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хамарна. Соёлын өргөн хүрээний тодорхойлолтод аялал, жуулчлал, чөлөөт цагийн үйл ажиллагаа ч багтжээ.

Соёлын үндсэн салбар:

- A: Соёлын болон байгалийн өв (Cultural and Natural Heritage)
- B: Урлагийн тоглолт, баяр наадам (Performance and Celebration)
- C: Дүрслэх урлаг, гар урлал (Visual Arts and Crafts)
- D: Ном, хэвлэл (Books and Press)
- E: Аудио, видео, интерактив медиа (Audio-visual and Interactive Media)
- F: Загвар, бүтээлч үйлчилгээ (Design and Creative Services)
- Биет бус соёлын өв (Intangible Cultural Heritage)

Холбоотой салбар:

- G: Аялал жуулчлал (Tourism)
- H: Спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа (Sports and Recreation)

Дараах гурван салбар мөн соёлын үйлдвэрлэл, тархалтад гол хувь нэмэр оруулдаг. Эдгээр нь:

- Боловсрол, сургалт (Education and Training)
- Архив, хадгалалт (Archiving and Conservation)
- Тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл (Equipment and Supporting Materials)

²⁵ Үндэслэл болгох өөр хууль, эрхзүй дутмаг гэсэн үг.

²⁶ 2009 FCS (UNESCO-UIS, 2009)

Монгол улс өнөөг хүртэл соёлын салбарыг хэт явцуу хүрээнд ойлгож ирсэн. Соёлыг хүн төрөлхтний амьдрах хэв маяг, арга ухаан гэдэг утгаар ойлгох нь чухал. Хүн төрөлхтөн өнөөдрийг хүртэл хэрхэн амьдарч ирсэн нь соёл юм. Соёл хүний суурь эрх, соёл үндэстний оршин тогтнох үндэс гэдэг утгаараа төрөлхийн үнэ цэнэтэй²⁷ (intrinsic value) буюу зардал, үр өгөөж болон үр ашгийг тооцож харьцуулсны үндсэн дээр санхүүжилтийг шийдэх албагүй юм. Харин соёлын өвийн талаарх хууль эрхзүйн тогтолцоо харьцангуй сайн тавигджээ. **Монгол улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйл**

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.
2. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол улсын үндэсний баялаг мөн гэж заасан нь соёлын өв, түүнтэй холбоотой үйл ажиллагааг төр хариуцна гэсэн үг.

ЮНЕСКО-гийн “Соёлын бодлогын дахин тодорхойлох нь” хэмээх 2015 оны тайлангаас харахад соёлын бодлогодоо дараах зорилт дэвшүүлэхийг санал болгосон. Үүнд:

1. Соёлын засаглалын тогтвортой системийг дэмжих,
2. Соёлын бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгалыг бий болгох хийгээд уран бүтээлч болон соёлын мэргэжилтнүүдийн хөдөлгөөнийг нэмэгдүүлэх,
3. Соёлыг тогтвортой хөгжлийн хамрах хүрээнд багтаах,
4. Хүний эрх болоод суурь эрх чөлөөг хөхүүлэн дэмжих.

Шинэ хууль батлагдсанаар эдгээр асуудлыг хамгийн гол нь орон нутгийн соёлын байгууллагуудын санхүүжилтийн асуудлыг баталгаатай болгоход чухал ач холбогдолтой юм.

Улс орны соёлын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг бүхлээр нь харах үүднээс бидний судалгааны зорилготой нийцтэй байгаа дараах 3 чиглэлийг сонголоо. Үүнд:

- Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд (Culture for development indicators)
- Төрөөс үзүүлж буй соёлын үйлчилгээ
- Соёлын өвийн ашиглалт (Economics of Heritage)

Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд (Culture for development indicators)-ийг НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжилд соёлын бодлого хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор ЮНЕСКО-оос 2014 онд боловсруулсан. Харин улс орнууд эдгээр үзүүлэлтийг ажлын хэсэг байгуулан тусгайлан судалж гаргадаг юм байна. Үүний ач холбогдол нь тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлт, нийгмийн ахиц дэвшилд соёл хэрхэн хувь нэмэр оруулж байгааг эмпирик байдлаар баталгаажуулж, хөгжлийн стратегид соёлыг багтаах асуудлыг чухалчилж харуулдаг.²⁸

Хүснэгт 30 Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд

Д	Үзүүлэлтүүд	Салбар	Дорноговь	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь
1	Соёлын эдийн засаг	0.06	0.03	0.03	0.03	0.03
2	Соёлын боловсрол	0.5	0.5	0.5	0.5	0.5
3	Соёлын засаглал	0.5	0.2	0.2	0.2	0.2
4	Нийгмийн оролцоо	0.8	0.7	0.8	0.9	0.7

²⁷ Жон Дью (1906) Ардчилал ба боловсрол, 18-р бүлэг

²⁸ The CDIS thus facilitates the operationalization of the 2005 Convention and the **United Nations 2030 Sustainable Development Agenda**

5	Хүйсийн тэгш байдал	0.4	0.3	0.6	0.3	0.4
6	Харилцаа холбоо	0.2	0.2	0.2	0.2	0.2
7	Соёлын өв	0.9	0.3	0.3	0.2	0.2
Дүн		3.37	2.23	2.57	2.39	2.23
Институцийн бэлэн байдал, оролцоо		48.2%	31.9%	36.8%	34.2%	31.9%

Дээрх 7 бүлгийн нийт 22 үзүүлэлтийг аймгийн түвшинд тооцоолсон. Ихэнх үзүүлэлт нь соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, бүтээлч сэтгэлгээ явагдах институцийн тогтолцоо байна уу гэдгийг харуулах үзүүлэлт юм. Дээрх хүснэгтээс орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд соёлын оролцоо 30 орчим хувь байна гэж дүгнэж болохоор байв.

Хүснэгт 31 Соёлын эдийн засгийн үзүүлэлтүүд

Соёлын үзүүлэлтүүд	Улс/Салбар	Дорноговь	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь
Эдийн засаг	0.06	0.03	0.03	0.03	0.03
Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний жин	0.03	0.02	0.01	0.01	0.02
Соёлын салбарт хөдөлмөр эрхлэгчид	0.03	0.03	0.03	0.04	0.01
Соёлын үйл ажиллагаанд зарцуулж буй өрхийн зардлын жин*	0.10	0.05	0.05	0.05	0.05

*Тайлбар: ҮСГ-гийн өрхийн амьжиргааны судалганаас соёлын үйл ажиллагаанд зарцуулж буй өрхийн зардлын жинг улсын дунджаар аймгуудад ижил тавилаа.

Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээнээс ДНБ-д оруулж буй хувь нэмэр аймгуудад 1-2 хувь, харин улсын хэмжээнд 3 хувь, нийт ажил эрхлэгчдийн 3 орчим хувийг соёлын салбарт бизнес, хөдөлмөр эрхлэгчид эзэлж байна.

Төрөөс үзүүлэх соёлын үйлчилгээ: үнэлгээ ба үр дүн

Монгол улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Засгийн газрын тухай хуулиар төрөөс соёлын үйлчилгээний хүртээмж, оролцоо, тэгш байдлыг хангах үүрэгтэй. Төр энэ үүргээ институцээр дамжуулан хийдэг. Орон нутагт театр, чуулга, музей, номын сан, соёлын төв нь төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг.

Аймгийн урлагийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээ

Аймгийн төвд орших мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээг дараах шалгуураар үнэлж өнөөгийн нөхцөл байдлыг 2016 оны байдлаар²⁹ харуулав.

Хүснэгт 32 Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний шалгуур

Үзүүлэлт	Хэмжүүр	2030 оны зорилт	Өнөөгийн үнэлгээ		
			Сайн=1	Дунд=0.5	Муу=0
Хүртээмж	6-аас дээш насны хүн амд үйлчилсэн хувь /нэг тоглолтоор/	5%	k>=0.03	0.01	k<=0.01
Суудал ашиглалт	Нэг тоглолтын суудал ашиглалт	90%	k>=0.9	0.6	k<=0.5

²⁹ 2017, 2018 оны статистик мэдээлэл байхгүй.

Шинэ уран бүтээл	Тоо	20	k>=11	10	k<=9
Дэд бүтэц	Шийдвэрлэх асуудлын тоо шаардлагатай	0	0	1	k<=1

Хүснэгт 33 Музейн үйлчилгээний шалгуур

Үзүүлэлт	Хэмжүүр	2030 оны зорилт	Өнөөгийн үнэлгээ		
			Сайн=1	Дунд=0.5	Муу=0
Үзэгчдийн сонирхол	Нэмэгдсэн жин	d=0.2	d=0.1	d=0.05	d<0.04
Үзмэрийн баяжилт	Нэмэгдсэн тоо	d=20	d=10	d=5	d<5
Дэд бүтэц	Шийдвэрлэх асуудлын тоо шаардлагатай	0	0	1	k<=1

Аймгуудын театр, чуулгын тоглолтыг давхардсан тоогоор нийт 6-аас дээш насны хүн амын 80 орчим хувь үзэж сонирхжээ. Энэ үзүүлэлт Говьсүмбэр аймагт хамгийн өндөр байна.

Хүснэгт 34 Аймгийн төвүүдийн театр, чуулгын үзүүлэлтүүд

Аймгийн төв	6-гаас дээш насны хүн ам	Шинэ уран бүтээл	Нийт тоглолт	Нийт үзэгчид	Суудлын тоо	Нэг тоглолтыг үзсэн	Хүртээмж	Суудал ашиглалт
Сүмбэр	15064	2	43	21226	246	494	0.033	2.01
Сайншанд	60142	3	147	35700	360	243	0.004	0.67
Сайнцагаан	41123	33	193	54600	396	283	0.007	0.71
Даланзадгад	57403	5	73	26105	350	358	0.006	1.02

Музейн үйлчилгээг аймгийн үзүүлэлт дээр нэгтгэж харуулсан. Дундговь аймагт музейн үзмэр хамгийн олон тоогоор нэмэгдэж, үзэгчдийн тоо мөн 14 хувиар өссөн.

Хүснэгт 35 Аймгийн төвүүдийн музейн үйлчилгээ

Аймгийн төв	6-аас дээш насны хүн ам	Үзэгчдийн тоо			Үзмэрийн тоо		
		2016	2017	Нэмэгдсэн жин	2016	2017	Нэмэгдсэн тоо
Сүмбэр	15064	3154	7800	1.47	929	821	-108
Сайншанд	60142	9005	10100	0.12	8343	8456	113
Сайнцагаан	41123	9388	10700	0.14	5695	5878	183
Даланзадгад	57403	19403	19300	-0.01	4495	4322	-173

Аймгийн мэргэжлийн байгууллагуудын өнөөгийн байдалд хийсэн үнэлгээгээр Говьсүмбэр аймгийн театр чуулгын үйлчилгээний хүртээмж маш сайн, Дорноговь аймгийнх тааруу гэсэн дүн гарчээ.

Хүснэгт 36 Аймгийн урлагийн мэргэжлийн байгууллагын үнэлгээ

Д/д	Аймаг	2016 оны байдал			Дундаж үнэлгээ
		Театр, чуулгын хүртээмж	Суудал ашиглалт	Дэд бүтэц	

1	Говьсүмбэр	1	1	0.5	0.83
2	Дорноговь	0	0.5	0.5	0.33
3	Дундговь	0	0.5	1.0	0.50
4	Өмнөговь	0	1	0.5	0.50

Харин музейн хувьд Дундговь, Дорноговь аймаг хүртээмжтэй байсан бол Өмнөговь аймаг хамгийн тааруу үзүүлэлттэй ажиллаж байна.

Хүснэгт 37 Аймгийн музейн үнэлгээ

Д/д	Ай маг	2016-2017 оны байдал			Дундаж үнэлгээ
		Үзэгчдийн сонирхол	Үзмэрийн баяжилт	Дэд бүтэц	
1	Говьсүмбэр	1	0	1.0	0.67
2	Дорноговь	1	1	1.0	0.83
3	Дундговь	1	1	1.0	0.83
4	Өмнөговь	0	0	0.5	0.17

Сумдын соёлын төв, номын сангийн үйлчилгээ

Сумдад номын сан, музей (ихэнх сумдад орон нутаг судлах танхим нэртэй), соёлын төвөөр дамжуулан урлаг, соёлын үйлчилгээ хүргэдэг.

Хүснэгт 38 Сумдын соёлын үйлчилгээний шалгуур

Үзүүлэлт	Хэмжүүр	2030 оны зорилт	Өнөөгийн үнэлгээ		
			Сайн=1	Дунд=0.5	Муу=0
Номын сангийн хүртээмж, оролцоо	6-аас дээш насны хүн амд үйлчилсэн жин	0.8	$k \geq 0.8$	0.6	$k \leq 0.5$
Соёлын төвийн хүртээмж	Нэг арга хэмжээнд оролцсон хүний тоо нийт 6-аас дээш насны хүн амд эзлэх жин	0.2	$k \geq 0.08$	0.04	$k \leq 0.02$
Дэд бүтэц	Шийдвэрлэх шаардлагатай асуудлын тоо	0	0	3	$k \leq 5$

Говьсүмбэр аймаг соёлын төвийн үйлчигээний хүртээмжээ сайжруулвал төрийн соёлын үйлчилгээ зорилгоо сайн биелүүлж чадахаар байна.

Дорноговь аймгийн сумдын номын сан, соёлын төвийн барилгын дэд бүтэц буюу байшин барилгын засвар, шинэчлэл /Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлээр ангилагдах асуудал, мөн 4 дүгээр зүйлээр ангилагдах төвлөрсөн болон төвлөрсөн бус шугам/ дээр шийдэх асуудал олон байна. Номын сангийн үйлчилгээний хүртээмж сайн, соёлын төвийн үйлчилгээний хүртээмж тааруу байжээ.

Дундговь аймгийн сумдын номын сан, соёлын төвийн барилга, түүний дэд бүтэц буюу байшин барилгын засвар, шинэчлэл, шугам сүлжээ /Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлээр ангилагдах асуудал, мөн 4 дүгээр зүйлээр ангилагдах төвлөрсөн болон төвлөрсөн бус шугам/ дээр шийдэх асуудал олон байна. Соёлын төвийн үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн байгаа ч, номын сангийн үзүүлэлт тааруу байжээ.

Өмнөговь аймгийн сумдын номын сангийн хүртээмж сайн байсан, соёлын төв, номын сангийн барилга, түүний дэд бүтэц дээр шийдэх асуудал Дорноговь, Дундговь аймгуудтай харьцуулахад цөөн байна.

Хүснэгт 39 Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо (аймаг, бүсээр)

Аймаг, бүс	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	10,849	9,576	11,422	11,342	13,591	12,527	14,107	12,676	12,746	14,609
Баруун бүс	1,772	810	1,058	2,123	1,625	1,368	685	1,215	1,572	1,258
Зүүн бүс	608	577	1,082	539	731	802	700	931	342	561
Улаанбаатар	5,879	5,919	6,330	5,997	8,164	7,567	8,581	8,233	7,507	10,400
%	54.2%	61.8%	55.4%	52.9%	60.1%	60.4%	60.8%	64.9%	58.9%	71.2%
Хангайн бүс	915	1,310	1,455	983	1,308	1,019	1,712	798	1,244	959
Төвийн бүс	1,675	960	1,497	1,700	1,763	1,771	2,428	1,499	2,081	1,431
Өмнийн говийн дэд бүс	912	326	225	795	835	818	407	579	516	411
Говьсүмбэр	87	40	66	90	-	19	20		44	48
Дорноговь	356	167	-	158	194	309	174	142	154	125
Өмнөговь	250	70	114	247	477	263	134	235	198	113
Дундговь	219	49	45	300	164	227	79	202	120	125

Эх сурвалж: ҮСХ www.1212.mn

ҮСХ-ноос гаргасан тоогоор мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо улсын хэмжээгээр өсөж байгаа хэдий ч нийт эдийн засгийн салбарт ажиллагсдын дунд эзлэх хувийн жин нь 1.0-1.2 хувьд хэлбэлзэж буй нь бага үзүүлэлт бөгөөд харьцангуй өсөлтгүй байгааг харуулж байна.

ШУТ-ийн салбарын боловсон хүчин Улаанбаатар хотод төвлөрч байгаа, өнгөрсөн 10 жилийн хугацаанд энэ төвлөрөл нэмэгдэх хандлагатай байгаа нь нэг талаас хүний нөөцийн бөөгнөрөл үүсэх давуу талтай боловч орон нутгийн хөгжилд сөрөг нөлөөтэй байх магадлалтай. Бидний судалж буй 4 аймгийн хувьд ШУТ-ийн салбарын ажиллагсдын тоо буурах хандлагатай байна. Энэ нь салбарын хувьд нэн чухалд тооцогдох хүний нөөц орон нутгийн хувьд цөөрч байгаа нь цаашид ШУТ болон инновацийн бүсийн хөгжилд сөргөөр нөлөөлөхийг сануулж байна.

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д заасанчлан, технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг шат дараалалтай нэмэгдүүлж, 2016-2020 онд ДНБ-ий 2 хувь, 2021-2025 онд 2.5 хувь, 2026-2030 онд 3 хувь хүртэлх түвшинд хүргэх зорилтыг хүрээнд санхүүжилтийн болон бусад бодлого огт хэрэгжихгүй байна. Энэ томоохон зорилгын хүрээнд ШУТ-ийн талаар баримтлах бодлогод “I үе шат: 2017-2020 онд шинжлэх ухаан, технологийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчин, бүтэц, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, дэд бүтцийг сайжруулан санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлж, шинжлэх ухааны паркийн дэд бүтцийг байгуулах ажлыг эхлүүлж, эрдэм шинжилгээний ажлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэсэн зорилтууд мөн биеэллээ олоогүйг тоон мэдээлэл нотолж байна. Эхний үе шат дуусах гэж буй өнөөгийн нөхцөлд энэ чиглэлээр гарсан ахиц дэвшил ховор байна.

Өнөөгийн байдлаар суурь нь ийнхүү сул байгаа тохиолдолд “II үе шат: 2021-2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүнд шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн эзлэх хувийг зорилтот түвшинд хүргэж, салбарын чадавх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, улсын эдийн засгийн

хөгжлийн тулгуур хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлнэ” хэмээх зорилтод хүрэх боломж бага харагдаж байна. ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгийн инновацийн түвшнийг хэмжих үзүүлэлтүүдийг боловсруулж, 2010 оноос хойш мэдээллийг системтэйгээр цуглуулж эхэлснийг дээр дурдсан. Монгол улс энэ судалгаанд хараахан хамрагдаагүй байна. Тиймээс инновацийн чиглэлийн тоон мэдээлэл хомс байна.

Орон нутгийн түвшний инновацийн асуудлаар Инновацийн тухай хуульд “инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг бий болгох” зорилтыг дэвшүүлсэн билээ. Говийн дэд бүсийн хувьд зарим аймгийн хувьд орон нутгийн брэнд болох бүтээгдэхүүнийг өөрийн нөөц болон уламжлалт мэдлэгт суурилан, шинжлэх ухааны дэмжлэгтэйгээр зах зээлд гаргах боломж бүрэн бий. Тухайлбал, Өмнөговь аймаг ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж “дэлхийн брэнд”-тэй болох зорилт тавьсан нь үүний нэг жишээ юм.

Эрүүл мэнд

Говьсүмбэр аймгийн хувьд бие даасан дэд хөтөлбөрүүд байхгүй, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрт зарим заалтууд туссан бөгөөд тодорхой байршил заагаагүй, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна.

Дундговь аймгийн хувьд 2017 оноос өмнө аймгийн дэд хөтөлбөрүүдийг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байсан боловч Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд хийсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитын дүгнэлтээр бодлогын баримт бичгүүд зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан боловч хууль журамд бүрэн нийцэхгүй байна гэж үзсэн. Өнөөгийн байдлаар Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон “Эрүүл иргэнтэй Дундговь” дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Байршлын хувьд Эрдэнэдалай суманд шинэ эмнэлэг, Говь Угтаал, Гурвансайхан, Өлзийт сумын эмнэлгийг их засварын ажил хийхээр тусгасан ч үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна.

Дорноговь аймгийн хувьд Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр, Эх хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр, Элэг бүтэн Дорноговь дэд хөтөлбөр, Эрүүл насжилт, настны эрүүл мэнд дэд хөтөлбөрүүд болон “Эрүүл ирээдүй – Дорноговь” аймгийн дэд хөтөлбөр, “Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах” аймгийн дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Эдгээр дэд хөтөлбөрүүдэд тодорхой байршил заагаагүй боловч үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдтэй байна.

Өмнөговь аймгийн хувьд Халдварт бус өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөр, Эх хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр, Элэг бүтэн Өмнөговь дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Аймгийн засаг даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөрт холбогдох заалтууд туссан.

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдлын хувьд эрүүл мэндийн тэгш бус байдал, хүрээлэн буй орчны бохирдол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар зэрэг нь бүс нутгийн хувьд маш ялгаатай, олон асуудлууд тулгамдсан хэвээр байна. Өнөөгийн тусламж үйлчилгээ нь хүн амын хэрэгцээтэй нийцэхгүй байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй, халдварт болон халдварт бус өвчний тархалт (double burden of disease) өндөр байна. Дундаж ор хоног ихэнх орнуудаас өндөр (9-өөс дээш) байгаа нь эмчилгээний арга барил үр дүн, үр ашиг муутай,

амбулаторийн эмчилгээ үйлчилгээ (өдрийн мэс засал, өдрийн эмчилгээ) дутагдалтай, анхан шатны тусламж үйлчилгээний чанар төдийлөн сайн биш, зохицуулалт сул, хамралт хангалтгүй байгаатай холбоотой. Нөгөө талаас иргэдийн нийгмийн шалтгааны улмаас эмнэлэгт хэвтэх шаардлага өндөр байгаа нь нөлөөлж байна.

Хүний нөөцийн хуваарилалтад тэнцвэргүй байдал ажиглагдаж байна. Эмч ба сувилагчийн харьцаа (1:1.2) нь ихэнх орнуудаас өндөр байгаа бөгөөд эмнэлгийн 1 оронд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо хот, хөдөөд зөрүүтэй байна. Санхүүжилтийн болон нөөц хуваарилалтын одоогийн тогтолцоо нь тусламж үйлчилгээний тэгш байдал болон хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

Эрүүл мэндийн 29 үзүүлэлт бүхий матриц аргаар үнэлгээ хийхэд төв, хангайн бүсийн аймгуудын (Архангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Баянхонгор, Төв, Өвөрхангай, Увс, Дорноговь) эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэргүүний ээлжинд анхаарах шаардлагатай байна.

Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) аймгийг эрүүл мэндийн 6 бүлэг 35 үзүүлэлтээр үнэлэхэд эдгээр үзүүлэлтийн 23 нь 1996 – 2017 оныг дуустал буюу 22 жилээр, 8 үзүүлэлт нь 11- 20 жилээр, 4 үзүүлэлт нь 1-3 жилээр байна. Эдгээр матрикс үзүүлэлтийг дээрх хугацааны аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Говьсүмбэр аймгийн үзүүлэлтүүдийн 58%, Дорноговь аймгийн 65%, Дундговь аймгийн 20%, Өмнөговь аймгийн 71% нь аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй гарсан.

Орны тоо, вируст гепатитын өвчлөлийн үзүүлэлт нь эдгээр 4 аймагт бүгдэд нь улсын дунджаас өндөр байна. Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад үндсэн оношийн зөрүү, 10000 хүн амд ногдох хүн амын өвчлөл, амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах тогтолцоо, зүрх судасны өвчлөл, гадны шалтгаант нас баралт, үр хөндөлт зэрэг нь улсын дунджаас өндөр байна. 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Өмнөговь аймагт 83,2 буюу аймгийн дунджаас 21,8-аар илүү, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34,1 байгаа нь нь цаашид анхаарах асуудлын нэг мөн байна. Говьсүмбэр аймагт их эмчийн тоо, үндсэн оношийн зөрүү аймгийн дунджаас өндөр, 10 000 хүн амд ногдох орны тоо аймгийн дунджаас бараг 2 дахин өндөр байна.


Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дундаж наслалтын хувьд Дорноговь аймаг (70.6), 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин Өмнөговь аймаг (76,9), 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд Дундговь (15,9), Өмнөговь аймаг (20), нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд Өмнөговь аймаг (16.1), зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт Говьсүмбэр (18.6), Дундговь (21.7), Өмнөговь аймаг (18.6), хорт хавдраас шалтгаалсан нас баралт баралт Говьсүмбэр (15.1), Дорноговь (12.3), Дундговь (14.4), 10 000 хүн амд вируст сүрьеэгийн өвчлөл Говьсүмбэр аймаг (16.3) байгаа нь 2016-2020 онд дэвшүүлсэн зорилтод хүрээгүй байна.

Сэргийлж болох нас баралт нь тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг үр дүнтэй, цаг алдалгүй үзүүлж чадаж буйг харуулдаг үзүүлэлт бөгөөд 10 бүлэг өвчнийг авч үздэг. Эдгээр үзүүлэлтийг 100,000 хүн амд авч үзэхэд Өмнөговь аймагт хамгийн өндөр буюу 321,9, Дундговь аймагт 312,2, Говь сүмбэр аймагт 208, Дорноговь аймагт 205,7 байсан нь Улаанбаатар хотын дундажтай (226,2) харьцуулахад тусламж үйлчилгээний чанар ихээхэн ялгаатай байгааг харуулж байна. Эмнэлгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан тохиолдолд сэргийлж болох нас баралтын дийлэнх хувийг зүрх судасны тогтолцооны өвчин дангаараа эзэлж байна.

Судалгааны үр дүн

Говийн дэд бүсийн хүн амын нутаг суурьшилд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан.


Зураг 52 Говийн дэд бүсийн бичил бүсийн төв, бүлэг суурингууд



Эх сурвалж: Монгол улсын хүн амын нутагшил суурьшлын төсөл. 1996. МУИС. ЭЗХ 2020


Энэ бүсэд тэнхлэг дагасан бүсчлэл үүссэн.

Зураг 53 Давхаргуудын давхцуулалт, Өмнийн Говийн дотоод бүсчлэлийн урьдчилсан төсөөлөл



Говийн дэд бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ хийж үзэхэд хоёр тэнхлэг дагасан бүс үүссэн.

Зураг 54 Говийн дэд бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ



Эх сурвалж: “Говийн бүсийн Тавантолгой, Оюутолгой, Цагаан суваргын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөө” БХБЯ, “Шинэ хотжилт” ХХК. 2008

Хүн ам зүйн болоод хөдөлмөрийн үндсэн үзүүлэлтүүдийн 2-10 жилийн өөрчлөлтөөс харахад, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал говийн дэд бүсийн аймгуудад харилцан адилгүй дүр зураг харагдаж байна. **Говьсүмбэр аймгийн** хувьд говийн аймгууд дотроос ЭЗИХА болоод ажиллагчдын тооны өсөлтийн дундаж хурд өндөр (1.11), ажиллах хүчний оролцооны түвшин 2007 онтой харьцуулахад 2017 онд 36 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 38 хувиар тус тус өссөн, харин дундаж цалин 2.8 дахин өсөлттэй ч улсын дунджаас 7.4 хувиар доогуур байна. Ажилгүйдлийн түвшин 2017 оны байдлаар 7.8 хувь байгаа нь улсын дунджаас 1 пунктээр доогуур байна. **Дорноговь аймаг** говийн аймгуудаас ажилгүйчүүдийн тооны дундаж хурд (0.97) бага, 2007 онтой харьцуулахад 2017 онд ажиллах хүчний оролцооны түвшин 18 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 13 хувиар тус тус өссөн, дундаж цалингийн өсөлт өндөр (4.7 дахин) байгаа ч улсын дунджаас 11 хувиар бага байна. Сүүлийн 2 жилийн байдлаар ажилгүйдлийн түвшин буурч 2017 онд 6.1 хувь байгаа нь улсынхтай харьцуулахад 1.7 пунктээр бага байна. **Дундговь аймгийн хувьд** говийн аймгууд дотроос сүүлийн 10 жилийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин болоод ажилгүйдлийн түвшний өөрчлөлт хамгийн бага (1.75), 2017 оны байдлаар ажилгүйдлийн түвшин хамгийн бага (4.4), хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж ойрын 3 жилийн хөдөлмөрийн эрэлт ба нийлүүлэлтээ ажил мэргэжлээр тодорхойлсон зэрэг онцлог давуу талууд байгаагийн зэрэгцээгээр хүн амын тооны өсөлт дэд бүсийн дунджаас 50 хувь бага, Монгол улсын нийт хүн амд эзлэх хувь

эрс буурсан, мөн цаашид буурах төлөвтэй байгаа (1990 онд 2.4 % байсан бол 2010 онд 1.4, 2030 онд 1.3 %), сарын дундаж цалингийн хэмжээ улсын дунджаас эрс доогуур (32.2 хувь) байна. **Өмнөговь аймгийн хувьд** говийн аймгууд дотроос сарын дундаж цалингийн түвшин өндөр, хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн тоо болоод эзлэх хувь хамгийн өндөр (улсын хэмжээнд ажиллаж буй нийт гадаадын иргэдийн ¼ нь Өмнөговь аймагт ногдож байна), орон нутгийн түвшинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олон дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа зэрэг давуу талуудтай боловч ажиллах хүчний оролцооны түвшин 2007 онтой харьцуулахад 11.8 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 25.1 хувиар буурч, 2017 оны ажилгүйдлийн түвшин (16.4)-г улсынхтай харьцуулахад өндөр (1.86 дахин), шилжин явалтын түвшин ирэлтээсээ их байна. Түүнчлэн 15 ба түүнээс дээш ажиллагчдын тооны өөрчлөлтөөс ойрын ирээдүйд хөдөлмөрийн насны хүн амын тоо буурч, тэтгэврийн насных өсөх төлөв ажиглагдаж байгаа тул хөдөлмөрийн нөөцийн дутагдалд орох магадлал өндөр байна.

Говийн дэд бүсийн хувьд сүүлийн 3 жилээр аваад үзэхэд, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдал алдагдаж, нийлүүлэлтийн хомсдол аймаг бүрт байгаагийн зэрэгцээ ажлын байр ашиглалтын түвшин буурч байна. Үүнийг аймаг бүрээр авч үзвэл: **Говьсүмбэр аймгийн хувьд** сүүлийн 2 жилд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр алдагдаж, хөдөлмөрийн нийлүүлэлтийн хомсдол 2018 онд өмнөх оны мөн үеэс 9.4 дахин нэмэгдсэн байна. Ажлын байр ашиглалтын хувь эрс хэлбэлзэлтэй байна. 2016 онд говийн аймгуудаас хамгийн бага (39.7%) байсан бол 2017 онд өмнөх оноосоо 2.4 дахин нэмэгджээ. Ажил мэргэжлийн ангиллаар аваад үзвэл, сүүлийн 3 жилд хамгийн олон хүнийг энгийн ажил мэргэжилд (290), мэргэжилтэн (232)-г ажилд зуучлан оруулжээ. **Дорноговь аймаг** говийн аймгуудаас сүүлийн 2 жилд ажлын байр ашиглалтын түвшин өндөр (96.6%) байгаа нь 2016 онтой харьцуулахад 45 пунктээр нэмэгджээ. Энэ хугацаанд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр алдагдсан байгаа ч нийлүүлэлтийн хомсдол 2018 онд 17.3 хувиар буурсан байна. **Дундговь аймгийн хувьд** 2018 онд ажлын байрны захиалгыг 2017 онтой харьцуулахад буурсан (29.9 %) ч ашиглалтын түвшин нэмэгдсэн дүр зураг харагдаж байна. **Өмнөговь аймгийн хувьд** сүүлийн 3 жилийн байдлаар ажлын байрны ашиглалтын хувь эрс буурч байгаа (90.7-45.6 %) төдийгүй говийн аймгууд дотроос хамгийн бага (45.6 %), мөн хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр алдагдаж, нийлүүлэлт хамгийн олон (1932) хүнээр хомсдолтой байна.

Салбар хоорондын балансын тооцооллоос харахад, улсын хэмжээнд эдийн засгийн 20 салбар тус бүрд 1 тэрбум төгрөгийн хөрөнө оруулалт нэмэгдвэл нийт 1268 ажлын байр шинээр бий болж байгаагаас гадна үйлчилгээний бусад, ХАА, боловсрол зэрэг салбарт хамгийн их ажлын байр нэмэгдэж байна. Харин говийн дэд бүсийн аймгуудаас салбар хоорондын тэнцэл дэх ажил эрхлэлтийн үржүүлэгч хамгийн өндөртэй нь Говьсүмбэр, хамгийн бага гарсан нь Өмнөговь аймаг байна. Говийн дэд бүсийн 4 аймагт нийт 17 төрлийн 127 ЖДҮ баригдвал 1870 хүн шууд ажлын байртай болохоос гадна шууд бус байдлаар нийт 6258 хүн тус өгөөж хүртэх боломжтой ба эдгээрийг барихад 20,76 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна. Шинээр үүсэх 1870 ажлын байрны 80 орчим хувийг дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн зах зээлд байгаа ажилгүйчүүдийг давтан сургалтад хамруулах болоод МСҮТ-ээр дамжуулан бэлтгэх боломжтой. Харин хүнс ба хөнгөн үйлдвэрийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх боломжийг эрэлхийлэх шаардлага байна.

Манай улсын боловсрол бага багаар сайжирч байгаа. Багахан хичээл зүтгэл их хэмжээний өөрчлөлт авчирч чаддаг онцлогтой. Иймд илүү хүүхэд рүү, судлагдахуун руу нарийн орсон эсвэл багшийн мэргэшил рүү хандсан, хүүхдийн хоцрогдолтод, мөн илүү хурдтай хүүхдийг уйдаахгүй байхад, нөгөө талд хэнийг ч хөтөлбөрөөс хоцроохгүй байхад анхаарсан зорилт дэвшүүлэх хэрэгтэй.

Жишээлбэл, газарзүйн нийт 56 багшийг программ хангамж ашиглан заах аргазүйд сургана, бүх сургуулийг хөгжмийн хичээл заах акустик шаардлага хангасан хөгжмийн хичээл хийх танхим, хөгжмийн зэмсгээр хангана гэх мэт.³⁰

Боловсролын салбарын хувьд:

1. Хуулиудын боловсролын талаарх заалт, үндэсний хэмжээний БББ-ыг хэмжиж болохуйцаар зорилтот бүлэг, шалгууртайгаар аймгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах боломжтой. Орон нутагт адил хэрэгжиж байж л үндэсний хэмжээнд хэрэгжинэ.
2. Өнөөг хүртэл хүртээмж, оролцоо олон улсын түвшинд хүрэхгүй байна. 98-аас бууж болохгүй. Монгол улс 2015 онд хэрэгжүүлж дууссан “Боловсролын мастер төлөвлөгөө”-нд дэвшүүлсэн зарим зорилтоо 2018-2019-оны хичээлийн жилд ч бүрэн хангаагүй байна.
3. Сургуулийн өмнөх боловсролд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Ялангуяа Дундговь аймгийн үзүүлэлтүүд улсын дунджаас бага байна. 2015 оны мастер төлөвлөгөөний зорилтод хүртэл хүрээгүй байна. Малчдын хүүхдийн хувьд зуны сургалтаас гадна, байнгын эцэг эхэд нь сургалт хийх тогтолцоо хэрэгтэй. Хүүхдийн тархийг багаас нь хөгжүүлэх арга техникүүд (whole brain development), синапсис явагдах үед нь тархийг хөгжүүлэх аргуудыг заавал эцэг эхэд нь зааж өгөх хэрэгтэй байдаг.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ бүрэн хамруулах, анхаарал хадамж тавьж мэргэжлийн чиг баримжаатай болгох³¹. ОХУ-ын туршлага: Код бичигч (Java, python программын хэл), зохиолч, хөгжимчин, анимейшн график дизайнер, эм зүйч зэрэг биеийн хөдөлгөөн бага ажил мэргэжил эзэмшүүлэхэд анхаарсан – үр дүн нь их сайн байгаа.
5. Боловсролын орцын чанарын асуудлуудыг шийдвэрлэж дуусах шаардлагатай. Шийдэх ёстой асуудал гэдэг нь Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хөрөнгө оруулалтууд хэрэгтэй байгаа, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан эрхийг хангаж чадахгүй байгаа тухай юм. 21-р зуунд хүний амьдралын хамгийн суурь хэрэгцээг хангаж чалахгүй байх нь утгагүй юм. Иймд барилга шинээр барина гэхээсээ илүү сургалтын орчны, эрүүл ахуйн асуудлыг эхний ээлжинд яаралтай шийдвэрлэмээр байна. Ялангуяа Дундговь /сургуулиудад 54 асуудал, цэцэрлэгүүдэд 22 асуудал/, Дорноговь аймагт /сургуулиудад 57 асуудал, цэцэрлэгүүдэд 21 асуудал/ дулаан хангамж, усан хангамж, ариутгах татуурга нь инженерийн болон инженерийн бус төвлөрсөн шугамд холбогдоогүй, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, орчны тохижилтын асуудалтай сургууль, цэцэрлэг олон байна.
6. Боловсролын үр дүнг сайжруулахад удирдлагын зүгээс багахан анхаарал тавихад л хангалттай байдаг.

Говийн дэд бүсийн 4 аймгийг (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) эрүүл мэндийн 6 бүлэг 35 үзүүлэлтээр үнэлсэн. Эдгээр үзүүлэлтийн 23 нь 1996 – 2017 оныг дуустал буюу 22 жилээр, 8 үзүүлэлт нь 11- 20 жилээр, 4 үзүүлэлт нь 1-3 жилээр байна^{32 33}. Эдгээр үзүүлэлтийн матрицыг дээрх хугацааны аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Говьсүмбэр аймгийн эдгээр 35

³⁰ Аймгийн удирдлага энэ дээр “Teach like Finland” by Timothy D. Walker (2017)-г жишээ нь уншиж санаа авч болно.

³¹ Soresi, Nota, Ferrari, & Solberg, (2008) Career Guidance for Persons with Disabilities, [International Handbook of Career Guidance](#) (pp.405-417).

³² Эрүүл мэндийн үзүүлэлт 2007-2017

³³ Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 1996 – 2015, 2016

үзүүлэлтийн 58%, Дорноговь аймгийн 65%, Дундговь аймгийн 20%, Өмнөговь аймгийн 71% нь аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй гарсан.

Орны тоо, вирүст гепатитын өвчлөлийн үзүүлэлт нь эдгээр 4 аймагт бүгдэд нь улсын дунджаас өндөр байна.

Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад үндсэн оношийн зөрүү, 10 000 хүн амд ногдох хүн амын өвчлөл, амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах тогтолцоо, зүрх судасны өвчлөл, гадны шалтгаант нас баралт, үр хөндөлт зэрэг нь улсын дунджаас өндөр байна.

100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Өмнөговь аймагт 83,2 буюу аймгийн дунджаас 21,8-аар илүү, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34,1 байгаа нь нь цаашид анхаарах асуудлын нэг мөн байна.

Говьсүмбэр аймагт их эмчийн тоо, үндсэн оношийн зөрүү аймгийн дунджаас өндөр, 10 000 хүн амд ногдох орны тоо аймгийн дунджаас бараг 2 дахин өндөр байна.

Сэргийлж болох нас баралт нь тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг үр дүнтэй, цаг алдалгүй үзүүлж чадаж буйг харуулдаг үзүүлэлт бөгөөд 10 бүлэг өвчнийг авч үздэг. Эдгээр үзүүлэлтийг 100,000 хүн амд авч үзэхэд Өмнөговь аймагт хамгийн өндөр буюу 321,9, Дундговь аймагт 312,2, Говь сүмбэр аймагт 208, Дорноговь аймагт 205,7 байсан нь Улаанбаатар хотын дундажтай (226,2) харьцуулахад тусламж үйлчилгээний чанар ихээхэн ялгаатай байгааг харуулж байна. Эмнэлгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан тохиолдолд сэргийлж болох нас баралтын дийлэнх хувийг зүрх судасны тогтолцооны өвчин дангаараа эзэлж байна³⁴.

2005 онд хийгдсэн “Монгол улсын булгийн чанарын усны эрүүл ахуйн үнэлгээ”³⁵-гээр эдгээр 4 аймгийн булгийн усны 40-80% нь гадаргын усны цэврийн зэргийн ангиллаар 3-5 зэрэгт үнэлэгдсэн нь унд, ахуйн усны шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарч байжээ. 2009 онд хийгдсэн “Өрхийн усны чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх судалгаа”-нд³⁶ зөвхөн Дундговь аймгийн өрхүүдийн 34,8% нь долоо хоногт 3-4 удаа усаа авдаг, 7,2% нь ундны усыг огт буцалгаж хэрэглэдэггүй байсан ба 44,2% нь ус уудаггүй, 39,5% нь усыг буцалгаж хэрэглэхгүйгээр сурчихсан гэсэн өгүүлэмжтэй байсан. Бие засах газар, бохир усны нүхний үнэлгээгээр 69% муу үнэлэгдсэн нь өрхүүдийн ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ, ашиглалт, эрүүл ахуйн шаардлага хангасан байдал хангалтгүй байгааг илтгэж байна.

Санал зөвлөмж

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын судалгааны үр дүнд Монгол улсын бүсчилсэн хөгжлийн бодлогод өгөх санал

1. ШУТ нь шинэ тутам хөгжих гэж буй салбар бөгөөд ихээхэн хэмжээний санхүү, дэд бүтэц, хүн хүчний нөөц шаарддаг учир шинжлэх ухааны бодлогыг төвлөрсөн байдлаар хэрэгжүүлэх нь

³⁴ Эрүүл мэндийн салбар 2012. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил, 2013

³⁵ Монгол улсын булгийн чанарын усны эрүүл ахуйн үнэлгээ, 2005

³⁶ Өрхийн усны чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх судалгаа, 2009

дунд хугацаандаа оновчтой байх магадлалтай. Судалгаа шинжилгээтэй холбоотой орон нутгийн оролцоо цаашид ч харьцангуй хязгаарагдмал байх болов уу.

2. Урт хугацаандаа “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасанчлан **“шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ”** гэсэн зорилт тавигдаж байгаа нөхцөлд энэ зорилт нь бүс нутаг, аймаг, орон нутгийн түвшинд ямар хэлбэрээр хэрэгжихийг илүү дэлгэрэнгүй тодорхойлох шаардлага гарахаар харагдаж байна.
3. Бүс нутагт шинжлэх ухааны парк байгуулах асуудал хүндрэлтэй, биелэгдэх магадлал багатай харагдаж байна. Учир нь хүний нөөц болон дэд бүтэц нь нийслэл хотод төвлөрсөн, орон нутагт энэ чиглэлээр ажиллах дэд бүтцийн орчин бүрдээгүй, ажилладаг хүмүүсийн тоо цөөрсөөр байгаа нь сөрөг суурийг бүрдүүлж байна. Ийм нөхцөл байдалд орон нутагт шинжлэх ухаан, технологийн паркийг байгуулах асуудал хэт өндөр зардалтай, үр өгөөж багатай байх магадлалтай юм.
4. Технологийн шийдэл нь орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх бөгөөд нутгийн болон соёлын онцлогийг тусгасан байх нь илүү оновчтой гэж үздэг. Иймээс бүсчилсэн хөгжлийн бодлогод орон нутгийн түвшинд тулгарч буй асуудлыг шийдэх технологийн шинэ шийдэл гаргах талаас дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгах шаардлагатай. Эдгээр нь заавал өөрийн бүс нутагт ШУТ-ийн парк байгуулах замаар шийдвэрлэгдэх албагүй юм. ШУТ-ийн дэд бүтэц болон холбогдох хүний нөөц төвлөрсөн газартай хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар шийдэх боломжтой юм.

Салбарын бодлогод өгөх санал

1. ШУТ-ийн чиглэрээр томоохон зорилт тавьсан нь өнөөгийн байдлаар тунхаглалын шинж чанартай хэвээр байна. Энэ нь өөрөө шинэ тутам хөгжих гэж буй салбар учир бодлогын бодит арга хэмжээ авч эхлээгүй хэвээр байна. Цаашид тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тавьсан мэдлэгт суурилсан эдийн засаг болон хөгжих зорилт хэвээр хадгалагдах тохиолдолд энэ чиглэлээр бодлогын дорвитой арга хэмжээ авах шаардлага байна.
2. 2017 онд батлагдсан төрөөс ШУТ-ийн талаар баримтлах бодлогод тусгагдсан арга хэмжээнүүд мөн биеэллээ олоогүй, цаасан дээр хэвээр байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, энэхүү бодлогыг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдээр суурь он болох 2017 оноос хойш гарсан ахиц дэвшил хомс байгаа анхаарах.
3. ШУТ-ийн салбарт тэргүүлэх үүргийг өнөөгийн нөхцөлд төр гүйцэтгэх шаардлага хэвээр үлдэхээр байна. Энэ нөхцөлд төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлага байна. Дунд хугацаандаа төр энэ салбарт гоцлох тоглогч байх бөгөөд ШУТ болон инновацийг дэмжих дэд бүтэц, боловсон хүчин, санхүүжилтийн асуудлыг хариуцахаас өөр аргагүй юм. Гэтэл санхүүжилт нь сүүлийн жилүүдэд өсөөгүй төдийгүй, харьцангуй хувь нь буурах хандлага ажиглагдаж байгаа нь хэтдээ сөрөг үр дагавартай байх болно.
4. ШУТ болон инновацийн чиглэлээрх өнөөгийн санхүүжилтэд хувийн сектор болон их сургуулиудын хувийн жин бага байгаа нь бизнес эрхлэгчдийн дунд өрсөлдөх чадвар бүхий шинэ бүтээгдэхүүн боловсруулах чадвар болон сонирхол бага байгаагийн илрэл юм. Энэ нь гадаадын зах зээлд бага нэвтэрсэн, үүнээс үүдэн инновацийн хэрэгцээ шаардлага сул, өрсөлдөөний шахалт дарамт бага байгаатай холбоотой гэж үзэж болно. Иймээс цаашид

Монголын аж ахуйн нэгжүүд шинэ санаа, инновацийг өөрийн үйлдвэрлэлдээ нэвтрүүлэхэд дэмжлэг, хөшүүргийг нээлттэй ашиглах хэрэгцээ шаардлага бодитой үүсээд байна.

5. ШУТ-ийн мэдээллийг илүү өргөн хүрээнд цуглуулах, энэ салбарт гарч буй өөрчлөлт, ахиц дэвшлийг хянах, олон улсын жишигт нийцсэн мэдээлэлтэй байх нь бодлогыг илүү оновчтой тодорхойлох, бодлогын үр өгөөжийг тооцох, өөрийн давуу болон сул талыг тодорхойлох зэрэг олон талын ач холбогдолтой учир чанартай, тогтмол мэдээллийн санг бүрдүүлэхэд анхаарах шаардлага байна.
6. Инноваци нь өнөөгийн байдлаар манай улсад цоо шинэ ойлголт бөгөөд энэ талаар мэдээлэл үндсэндээ байхгүйтэй адил байна. Цаашид ямар салбарт, ямар байгууллага, пүүсүүд шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн, шинэ процессийг нэвтрүүлж буй, хаана ямар боломж байгаа талаар судалгаа хийж мэдээлэл цуглуулах шаардлага байна. Улмаар ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгийн инновацийн судалгаанд хамрагдаж, олон улсын жишигт нийцсэн мэдээллийг цуглуулж, боловсруулдаг болох хэрэгтэй. Энэ нь микро буюу пүүсийн түвшний түүвэр судалгаа хийхийг шаардах ба энэ нь өндөр ач холбогдолтой байх болно.

Аймгийн хөгжлийн бодлогод өгөх санал

1. Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүрээнд ШУТ-ийн парк нь бие даасан хэлбэрээр байх нь боломж муутай харагдаж байна. Шинжлэх ухаан, шинэ технологи нь аж үйлдвэрийн цогцолбор (парк эсвэл кластер)-ын хүрээнд хөгжих боломж байж болно.
2. Орон нутгийн хувьд өөрийн байгаль цаг уур, уламжлалт мэдлэг, байгаа нөөцийн онцлогт тохирсон бүтээгдэхүүнийг шинжлэх ухааны аргаар боловсруулан зах зээлд, ялангуяа гадаад зах дээлд нэвтэрч чадах шинэ бүтээгдэхүүнийг боловсруулах ажлыг орон нутгийн уламжлалт мэдлэгийг тээж буй хүмүүс, холбогдох чиглэлээр шинжлэх ухааны мэдлэг, чадварыг эзэмшсэн байгууллага, судлаач нартай хамтын ажиллагаа өрнүүлэх, судалгаа шинжилгээ хийх, зах зээлд нэвтрэх бүтээгдэхүүн болгон хувиргах (product commercialization) ажил дээр хамтрах нь орон нутагт инновацийг нэвтрүүлэх нэг боломжит арга зам гэж харагдаж байна. Өмнөговь аймгийн ингэний сүүнээс гадна бусад аймгуудын хувьд ч ийм боломж байгаа.

БҮЛЭГ II. ГОВИЙН БҮСИЙН ДӨРВӨН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Аймгуудын хөгжлийн бодлогод хийсэн шинжилгээ

Бүсчилсэн хөгжлийн агуулгаар боловсруулсан 26 чанарын шалгуур үзүүлэлтээр Төвийн бүсийн говийн дэд бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөрийн орчинд бодлогын шинжилгээ хийлээ.

Хүснэгт 40 Бодлогын шинжилгээ хийсэн баримт бичгүүд

Д.д	Хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр	Аймаг	Хэрэгжих хугацаа
ГС1	Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр	Говьсүмбэр	2003-2020
ГС2	Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого	Говьсүмбэр	2010-2021
ДО1	Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого	Дорноговь	2002-2020
ДО2	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө	Дорноговь	2011-2021
ДУ1	Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого	Дундговь	2003-2020
ӨМ1	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр	Өмнөговь	2010-2020

Эх сурвалж: Судалгааны баг

Хүснэгт 41 Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд (салбараар)


№	Аймаг	Хөгжлийн баримт бичгийн нэр	Зорилтууд	Нийгмийн хөгжлийн бодлого		Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлого		Байгаль орчны бодлого		Нутгийн удирдлага, нийгмийн оролцоо, түншлэлийг хангах бодлого		Нийт	
				Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт
1	Говьсүмбэр	Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)	тоо	20	212	27	174	5	39	4	29	56	454
			хувь	35.7			38.3	8.9	8.6	7.2	6.3		
2	Дорноговь	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021)	тоо	27	124	72	371	7	73	9	56	115	624
			хувь	23.5	19.9			6.1	11.7	7.8	8.9		
3	Дундговь	Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого	тоо	26	194	18	180	1	17	0	0	45	391
			хувь			40.0	46.0	2.2	4.3	0	0		
4	Өмнөговь	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)	тоо	17	134	28	135	50	67	0	0	95	336
			хувь	17.9			29.5	39.8	52.6	20.3	0		
Нийт			тоо	90	664	145	860	63	196	13	85	311	1805
			хувь	28.9	36.8	46.6	47.6	20.3	10.9	4.2	4.7		

Эх сурвалж: Судалгааны баг

Говийн дэд бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын дунд хугацааны бодлого төлөвлөлтөнд нийт 311 стратегийн зорилт, 1805 дэд зорилт, арга хэмжээг тусгасан байна.


Стратегийн зорилтын 28.9 хувь нь нийгмийн, 46.6 хувь нь эдийн засгийн, 20.3 хувь нь байгаль орчны, 4.2 хувь нь нутгийн удирдлага, нийгмийн оролцоо, түншлэлийн бодлогын хүрээнд хамаарч байна. Харин дэд зорилтын 36.8 хувь нь нийгмийн, 47.6 хувь нь эдийн засгийн, 10.9 хувь нь байгаль орчны, 4.7 хувь нь нутгийн удирдлага, нийгмийн оролцоо, түншлэлийн бодлогын хүрээнд хамаарч байна.

Зураг 55 Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд (салбараар, хувиар)




Эх сурвалж: Судалгааны баг


Зураг 56 Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2003-2020)
Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)




Зураг 57 Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого (2002-2020), Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021)



Зураг 58 Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого



Зураг 59 “Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр 2010-2020



Эх сурвалж: Судалгааны баг

Монгол улсын ТХҮЗ-2030-ийг аймгуудын мастер төлөвлөгөө эсвэл цогц бодлогын зорилтуудын уялдааны нийцэл говийн дэд бүсийн хувьд 72.2 хувь, харин Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцлийн хувь (аймгуудын дүн) хамгийн бага буюу 54.2 хувь байна. Гэтэл Монгол улсын засаг

захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай уялдах уялдаа хамгийн бага буюу нийцлийн ерөнхий хувь 16.7 хувь байна.

Аймгуудын хөгжлийн бодлого, төлөвлөгөө нь МУЗГ-ын мөрийн хөтөлбөр болоод төрөөс хүн ам болоод хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой уялдаж байгаа эсэхийг харахад говийн дэд бүсийн нийцлийн ерөнхий хувь 68.5 хувь байна. Аймаг бүрээр харилцан адилгүй байгаагаас Дорноговь аймаг 74.2%, Говьсүмбэр -64.5%, Дундговь-58.1%, Өмнөговь -77.4 % байна.

ОУХБ-ын гурван үндсэн конвенцийг Монгол улс соёрхон баталсан байна: Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай ОУХБ-ын 122 дугаар конвенци (1976), Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай ОУХБ-ын 88 дугаар конвенци (2016), Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай ОУХБ-ын 181 дүгээр конвенци (2016). Монгол улсад хөдөлмөрийн харилцааг шууд зохицуулах Хөдөлмөрийн тухай хууль (1999), Төрийн албаны тухай хууль (2017), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008), үндсэн 4 хуулиас гадна Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001), Нийгмийн даатгалын тухай багц хууль (1994), Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015), Хувь хүний орлогын албан татварын тухай (2006), Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль (2010), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009), Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль зэрэг дагалдах хуулиуд үйлчилж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хууль 1999 онд батлагдсанаас хойш 18 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Одоо энэ хуулийн шинэчилсэн найруулга УИХ-д өргөн баригдсан байна. Хөдөлмөрийн салбарт Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар 2016-2025 онд баримтлах бодлого (2016), Ажил, мэргэжлийн чиг баримжааг 2016-2020 онд хөгжүүлэх чиглэл (2016), Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого (2012) гэсэн дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүд хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас гадна 2015 оноос хойш богино хугацааны Ажлын байрыг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, Нийтийг хамарсан ажил зохион байгуулах, Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг хөтөлбөрүүд үндэсний хэмжээнд хэрэгжсээр байна.

Дээрх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдээс гадна аймаг орон нутгийн төрийн албан хаагч, иргэд, сурагч, оюутан залуучуудын авъяас чадварын хөгжил, хөдөлмөрийн дадал туршлага олгох, иргэдийн эрүүл зан үйл, амьдрах зөв арга барил болоод шинээр ажлын байр бүтээхэд чиглэсэн дараах хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна. **Говьсүмбэр аймагт** “Боловсролыг дэмжих”, “Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулах”, “Залуучуудын хөгжлийг дэмжих”, “Зорилтот бүлэгт чиглэсэн”, ЖДҮҮ-г хөгжүүлэх дэд хөтөлбөрүүд; **Дорноговь аймагт** “Хөрш орноосоо суралцъя”, “Орлоготой залуу”, “Оюутан ажлын байр”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”, “Ажлын байр” зэрэг дэд хөтөлбөрүүд; **Дундговь аймагт** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих”, “Архидалтгүй аймаг-Дундговь”, “Тэрээт малчин-Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл; **Өмнөговь аймагт** “Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх”, “Дадлагажигч оюутан”, “Оюутан залуусыг дэмжих”, “Говийн тэтгэлэг”, “Шинэ төгсөгчид”, “Мэргэжил олгох”,

“Оюуны хурд”, “Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх”, “Зөгийн үүр”, “Англи хэлтэй Өмнөговьчүүд”, “Говийн дэмжлэг”, “Хүүхэд хөгжлийн түлхүүр” хөтөлбөрүүд тус тус хэрэгжиж байна.

Бодлогын хэрэгжилтийн тухайд соёлын салбарын бараг бүх баримт бичигт шалгуур үзүүлэлт байдаггүй учраас хүндрэлтэй байна. Жишээ болгож Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын /ТСТББ/ хэрэгжилтийг гаргаж болох үзүүлэлтийг харлаа.

Хүснэгт 42 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн шалгуур

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого	Тооцох түвшин	Үзүүлэлт
Хоёр. Соёлын талаар баримтлах бодлогын зорилт		
2.1.1. үндэсний хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг нэмэгдүүлэх;	Аймаг	Аймгийн үйлчилгээний хүртээмж
	Сум	Сумдын үйлчилгээний хүртээмж, дэд бүтэц
2.1.2. соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, орчин, нөхцөл бүрдүүлэх;	Аймаг	Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хамааралтай ажил эрхэлдэг хүний тоо /жин/
2.1.3. соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх;	Аймаг	Бүртгэгдсэн өвийн хулгайн гэмт хэргийн тоо
	Сум	Зарцуулсан урсгал төсөв
2.1.4. үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг өргөжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах.	Аймаг	Мэргэжлийн урлагийн тоглолтод
	Сум	Соёлын нэг арга хэмжээнд оролцогчдын жин /6-аас дээш насны хүн амд/

Зарим үзүүлэлт нь бидний судалгааны богино хугацаанд олоход хүндрэлтэй байсан. Ер нь соёлын салбар өнөөг хүртэл соёлын мэдээллийн цуглуулах, шинжилгээ хийх систем бүрдүүлж чадаагүй байна.

Хүснэгт 43 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилт

Бодлогын баримт бичгийн нэр	Дорноговь	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь
Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн өнөөгийн үнэлгээ	0.42	0.27	0.36	0.34

Дундговь аймгийн хувьд соёлын үйлчилгээ үзүүлдэг барилга байгууламжийн чанар, орчин үеийн үйлчилгээ, хүний тав тух, соёлтой орчинд тавигдах наад захын шаардлагыг хангах асуудал хүндрэлтэй байгаа нь эндээс ч мөн харагдаж байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарын хувьд үндэсний түвшинд нийт 27, бүс нутгийн түвшинд 1, аймгийн түвшинд 10, сумын түвшинд 2, нийт 40 бодлогын баримт бичиг байгаад дүн шинжилгээ хийж судлав.

Хүснэгт 44 Шинжлэх ухаан, технологитой холбоотой бодлогын баримт бичиг

Ангилал	Урт	Дунд хугацааны		Богино	Нийт
	15-20 жил	8-10 жил	3-5 жил	1 жил	
Нийт	3	10	21	6	40
Үндэсний, бүсийн түвшин	3	6	17	2	28
Үндэсний түвшний	3	5	17	2	27
Бүсийн түвшний	0	1	0	0	1
Аймгийн түвшин	0	2	4	4	10
Говьсүмбэр		1	1	1	3
Дорноговь		1	1	1	3
Дундговь			1	1	2
Өмнөговь			1	1	2
Сумын түвшин /Зарим нь батлагдсан эсэх нь тодорхойгүй	0	2	0	0	2

ШУТ-ийн салбарын бодлогын уялдаа холбоо

Аймгуудын хөгжлийн бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологитой холбоотой зорилтууд ховор байгаа нь ажиглагдаж байна. Энэ чиглэлээр аймгуудын түвшинд батлагдсан баримт бичиг нь үндсэндээ Засаг даргын мөрийн хөтөлбөр байна. Дорноговь, Говьсүмбэр аймгийн хувьд 10 жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж баталсан нь нөгөө хоёр аймагтай харьцуулахад давуу талтай байна. Дундговь аймгийн хувьд цаг хугацааны хувьд давхардалтай хоёр ч дунд хугацааны баримт бичгийн төсөл байгаа хэр нь батлагдсан эсэх нь тодорхойгүй байна. Хууль болон бодлогын баримт бичгийн уялдааг шинжлэх ухааны салбарт авч үзэхдээ холбогдох 4 хуулиас “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль”-д орон нутагтай холбоотой заалт байгаа учир сонгож авсан. Бусад хуулийн хувьд орон нутагтай холбоотой заалт байхгүй учир орхив. Бодлогын хувьд Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/ болон өмнөхийн адил Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг авч үзэв.

Хүснэгт 45 Шинжлэх ухаан, технологийн баримт бичгийн уялдаа

	Дундговь	Дорноговь	Өмнөговь	Говьсүмбэр
Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль	0.00	0.67	0.00	0.33
Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030	0.00	0.00	0.00	0.00
Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/	0.00	0.42	0.06	0.17
МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	0.00	0.08	0.00	0.08

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/-ын хүрээнд “Баянтал суманд мал аж ахуй, үйлдвэрлэл технологийн, Алтанговь технологийн паркийн хүрээнд Чойрын технологийн их сургууль, Химийн аж үйлдвэрийн эрдэм шинжилгээний үндэсний хүрээлэн байгуулах” зорилтуудыг

тавьсан байгаа нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль болон Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/-той уялдаж байна. Харин Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт эдгээр зорилт нь цааш ажил болон тусгагдаагүйн улмаас бодлогын ерөнхий нийцэл доогуур байна.

Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/-ний 2.2.1.4, 2.2.1.2.5, 2.2.1.2.6 заалтуудад Сайншандын аж үйлдвэрийн парк байгуулах талаар зорилт тавьсан байгаа нь дээр заасан хууль болон Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/-д заасан зорилтуудыг тодорхой хэмжээнд тусгажээ гэж дүгнэлээ. Харин Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хувьд орон нутагтай холбоотой 4 заалт байгаагаас аймгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “4.2.2 Бизнес инкубатор төв байгуулах” гэсэн ганц заалт орсон нь нийцэл багатайг харуулж байна. Дорноговь аймгийн хувьд шинжлэх ухааны чиглэлээр цөөн ч болов зорилт тавьсан байгаа нь бусад гурван аймагтай харьцуулахад илүү өндөр үзүүлэлттэй байна. Гэвч Дорноговь аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “1.3.1 Паркаар дамжуулан “Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөр” хэрэгжүүлэх, 1.2.3 ШУА бусад байгууллагуудтай хамтрах” гэсэн зорилтууд орсон нь хэт ерөнхий бөгөөд шинжлэх ухаан гэхээс илүүтэй аж үйлдвэржилт талруу чиглэсэн зорилт учир үүнийг шууд утгаар нь өндөр гэж ойлгож болохгүй юм.

Дундговь аймгийн хувьд шинжлэх ухаан, технологийн салбарт үндсэндээ ямар нэг зорилт тавигдаагүй нь харагдаж байна. Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр /2012-2031/ гэсэн баримт бичиг батлагдсан эсэх нь тодорхойгүйн улмаас тухайн хөтөлбөрт заасан “Дундговь” үйлдвэрлэл, технологийн паркийг өргөтгөн хөгжүүлэх гэсэн зорилтыг хүчингүй гэж үзэн тооцоогүй болохыг анхаарна уу.

Өмнөговь аймгийн хувьд шинжлэх ухааны салбарын бодлого чухал баримт бичигт тусгагдаагүй байгаа нь Дундговь аймгийн нэгэн адил уялдаа холбоо доогуур байхад хүргэж байна. Шинжлэх ухаантай ямар нэг байдлаар холбоотой зорилт гэвэл аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгалаа олсон “66. Ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж “дэлхийн брэнд”-тэй болох” зорилт юм. Үүнийг эс тооцвол энэ салбарын чиглэлээр ямар нэг өөр зорилт тавигдаагүй байна. Урт хугацааны бодлогын баримт бичгээ боловсруулсан Номгон, Цогт-Овоо сумдын хувьд эртний амьтан, ургамлын үлдвэр, хот балгасны суурь, түүх соёлын дурсгалт Сангийн далай хийд, Зүүн баруун бичигт, Чингисийн Хар улаан балгас, уртын сүг зураг гэх мэт газрыг палеонтологийн судалгаанд хамруулж тэмдэгжүүлэн хамгаалах чиглэлээр Шинжлэх ухааны академийн эрдэмтэдтэй хамтран ажиллах зорилтыг дэвшүүлсэн. Энэ нь шинжлэх ухаан гэхээсээ илүү аялал жуулчлалын маршрут тогтоох зорилготой ажээ.

Шинжлэх ухаан, технологийн салбар нь хууль эрхзүй талаасаа харьцангуй сүүлд зохицуулалт хийгдсэн салбар юм. Энэ салбарт бодлогоор хангах, дэд бүтэц бүрдүүлэх, тэргүүлэх чиглэл тогтоох, хөшүүрэг бий болгох зэрэг төрийн үүргийг нилээд тодорхой заасан бөгөөд ингэхдээ Засгийн газар буюу төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэгт түлхүү анхаарчээ. Цэвэр шинжлэх ухаантай холбоотой орон нутгийн үүрэг үндсэндээ байхгүй бөгөөд ямар нэг хэмжээгээр шинжлэх ухаан, технологитой холбогдох зорилтууд нь үйлдвэрлэл, технологийн парк, өндөр технологийн кластер байгуулах гэсэн чиглэлээр тавигдсан байна. Эдгээр нь цэвэр шинжлэх ухааны зорилт биш хэдий ч “шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах” зорилготой гэдэг утгаар нь энэхүү тайланд авч үзэв.

Орон нутгийн түвшинд үйлдвэрлэл, технологийн паркийн асуудлыг бодлогын 8-10 жилийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хоёр аймаг байгаа нь Дорноговь болон Говьсүмбэр аймгууд юм. Говьсүмбэр аймгийн “Алтанговь технологийн паркийн хүрээнд Чойрын технологийн

их сургууль, Химийн аж үйлдвэрийн эрдэм шинжилгээний үндэсний хүрээлэн байгуулах” зорилт нь илүү хэтийн бөгөөд өргөн хүрээтэй байна. Иймээс эдгээр нь хэрэгжих боломжтой эсэхийг нягтлах шаардлага харагдаж байна. Нөгөө хоёр аймгийн хувьд парк болон шинжлэх ухаантай холбоотой зорилт тусаагүй байна. Өмнөговь аймаг ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж, “дэлхийн брэнд” бүтээх зорилт нь тодорхой хэмжээний инновацийг шаардах зорилт гэж харагдаж байна. Нэгтгэн дүгнэхэд, шинжлэх ухаан, технологийн бодлого нь өнөөгийн байдлаар улсын хэмжээнд ерөнхий байдлаар цаасан дээр буусан төдий байна. Иймээс орон нутгийн түвшинд битгий хэл үндэсний түвшинд ч хэрэгжилт үндсэндээ эхлээгүй, хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

2.2 Бүсийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахад зайлшгүй анхаарал хандуулах асуудлын тухайд

“Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийн “Үзэл баримтлалын судалгаа” гэсэн хэсэгт бүхэлдээ Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь дөрвөн аймгийг хөгжлийн нэгэн бүс болгон хооронд нь болон Төвийн бүс /Улаанбаатарт таталцуулан/-тэй хоршин хөгжүүлэх чиглэлд үндэслэж, энэхүү стратегид суурилан энэ бүсэд байгаа байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, боломжийг дотоод, гадаад зах зээлд бүрэн, үр өгөөжтэй хамтран ашиглаж, улс орон, бүс нутгийн эдийн засгийн өсөлт, тогтвортой байдал, аймаг бүр хуримтлалыг нэмэгдүүлэх үндсэн дээр Говийн дэд бүсийн үйлдвэр, худалдаа, санхүүгийн сүлжээг бүрдүүлэх урт хугацааны чиглэлийг тодорхойлж, энэ зорилгод аймгуудын аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчдын хамтын хүч чармайлт, харилцан дэмжлэгийг нэгтгэн чиглүүлэх санааг агуулж байгаа юм. Энэ санааг хэрэгжүүлж эхлэснээр Говийн дэд бүсийг хөгжүүлэх талаар төр, иргэн, ААНБ, хөрөнгө оруулагчдын тус бүрийн сонирхол, эрэлт хэрэгцээ, бодлого, шийдвэрийн уялдаа зохицуулалтыг хангахад нөлөөлнө (тусална) гэж үзсэн болно.

Говь нутгийг тогтвортой хөгжлийн нэгэн бүс болгон эрчимжүүлэхийг хэн сонирхож байгаа, хэнд ашигтай бэ?

- Нутгийн иргэд –малчид, албан хаагч, байгаль хамгаалагч, ажил эрхлэгчид ба тогтвортой орлоготой ажил хийхийг хүсэгчид;
- Нутгийн захиргаа- Иргэдийн Хурал, Засаг дарга, түүний тамгын газар, салбарын бодлого боловсруулагчид;
- Төрийн төв байгууллагууд – УИХ, Засгийн газар, яам, агентлаг;
- Нутгийн зөвлөл – Сумын уугуул иргэд, улс төр, нийгэм, урлаг, соёл, шинжлэх ухааны зүтгэлтнүүд, тэргүүний малчид, төрийн бус байгууллагууд;
- Бизнес эрхлэгчид – үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй том компаниуд, ЖДҮ, үйлчилгээ эрхлэгчид, санхүүгийн байгууллагууд, дотоод ба гадаадын хөрөнгө оруулагчид ба бусад;
- Эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагууд – аймаг бүрт байгаа МСҮТ гэх зэрэг сургалтын байгууллагууд, судалгаа хөгжүүлэгчид, боловсруулагчид, туршигчид, технологи дамжуулагчид;

Энэ бүгдээс харахад тухайн байршил дахь хөгжлийн үйл явцын олон талт оролцогсад бүгд сонирхох болно. Гол нь говийн онцлогт тулгуурлан өрсөлдөх давуу талаараа өрсөлдөж, бусад бүс нутгаас ялгарах, ялгаатай нише зах зээлийг салбар болтол тэлж өргөжүүлэх нь урт хугацаандаа хүн амын амьжиргааны түвшинг тасралтгүй, тогтвортой дээшлүүлж, нийгмийн үнэт зүйлсийг хамтран бүтээлцэх ёстой.

Говийн дэд бүстэй холбоотой, 2000 оноос хойшхи хугацаанд боловсруулсан Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр, Өмнөд говийн бүсийн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр (2011 онд Засгийн газраас баталсан), мөн Дэлхийн банкны дэмжлэгээр хийсэн Өмнөт говийн дэд бүсийн хөгжлийн стратеги (2010), тухайн үеийн яам газар (ҮХЯ, БХБЯ г.м)-аас төсвийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн олон ажлууд (Галбын говийн хөгжлийн хөтөлбөр, Замын-Үүдийн чөлөөт бүс байгуулах ерөнхий төлөвлөгөө, Говийн бүсийн уул уурхайн ордод түшиглэн хот байгуулах төлөвлөгөө, зураг төсөл г.м.) нь өөр хоорондоо болон аймгуудын хөгжлийн цогц бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй, цаг хугацаа агуулгын хувьд уялдаагүй болсон байна. Эдгээр ажилд тусгагдсан бүс нутаг, бүсчлэн хөгжүүлэх олон арга хэмжээ тус хөтөлбөрт хамрагдаж буй Говийн дэд бүсийн 4 аймгийн хөгжлийн албан ёсны баримт бичиг болон Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрүүд, аймгуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд бүрэн тусгагдаж, хэрэгжиж чадаагүй байна. Тус хөтөлбөрт 2040 он хүртэлх хугацааг алсын чиг баримжаа болгож, дор дурдсан хоорондоо уялдаатай, гурван түвшний гол зангилаа зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэхэд суурь үндэс болох бүсчилсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн цогц төсөл арга хэмжээг томъёолсон болно.

Үндэсний хэмжээнд, Говийн дэд бүсийн газар нутаг дахь байгалийн эрдсийн баялаг нөөцийг нь үр өгөөжтэй ашиглан, тус улсын дотоод, гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээг зүй зохистой хангаж, эдийн засгийн өсөлт, хуримтлалыг нэмэгдүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэх эрчимтэй хөгжлийн нэг гол талбар, шинэ технологи, орлого сайтай ажлын байранд залуу үе өндөр мэргэшин бүтээлчээр ажиллах тав тухтай орчин бүрдсэн таталцлын бүс нутаг байгуулах;

Говийн дэд бүсийн хэмжээнд, нутаг дэвсгэрийн хойт, төв, өмнөд бүрдэл хэсгүүдийн тогтвортой хөгжлийн дотоод уялдаа, хоршилт холбоог сайжруулах замаар нийслэл Улаанбаатарын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрлийг бүсийн хэмжээнд задалж, уг бүсийн цогц хөгжлийг хангах орон зайн нэгдсэн, оновчтой менежментийг хэрэгжүүлэх;

Орон нутгийн түвшинд, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн нийгэм соёл, экологийн нэгдмэл байдлыг хангах зорилт тавьж, байгалийн эрдсийн баялаг нөөц, мал аж ахуйн түүхий эдийг эрэмбэ дараатай бүрэн, үр өгөөжтэй ашиглах замаар, эдгээр аймгийг харилцан нэгнээ нөхөн хангах чадвартай, эдийн засгийн хувьд харьцангуй бие даасан цогцолбор нутаг болгон хөгжүүлэх, харилцан сонирхол нэгдсэн хамтын ажиллагааны шинэ бүс үүсгэх нийгмийн шаардлага үүсээд байгааг анхаарахгүй байхын аргагүй юм. Говийн экосистемийг хамгаалах, хүн амын аж байдлыг дээшлүүлэх зорилгод “байгаль – нийгмийн хамгааллын хамтын менежмент”, “эдийн засаг, нийгмийн үнэт зүйлсийг хамтран бүтээх зохион байгуулалт, манлайлал”, “байгалийн нөөцийг бохирдолгүй, хаягдалгүй ашиглах тойрог эдийн засаг”-ийн арга ухааныг ашиглан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан сонирхолыг хангаж чадвал Монголын Говийн дэд бүсэд тогтвортой, ногоон хөгжлийн урт хугацааны хамтын ажиллагааны үлгэр загвар болох шинэ бүс нутаг бүрэлдэх үндсийг тавих боломжтой гэж төсөөлсөн болно.

Бодлогын хувилбарууд:

- **Инерцийн** буюу Говийн дэд бүсийн дөрвөн аймгийг оруулаад Монголын Төвийн бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн одоогийн ерөнхий төлөв, бэрхшээл сорилтууд, Улаанбаатар хотын хэт бөөгнөрөл хэвээр үргэлжлэх хандлага;
- **Эрчим хүч - нүүрсний** (“шинэ үйлдвэржүүлэлтийн хувилбар”), бүс нутгийн хөгжүүлэх бодлого нүүрс - эрчим хүчний аж үйлдвэр, түүнд шаардлагатай дэд бүтцийн хөрөнгө

оруулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд голлон чиглэгдэх бөгөөд 2025 он хүртэл эрдсийн баялгийг олборлож, анхан шатны боловсруулалт хийж, цаашид дахин боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлыг бүрдүүлэх үе шатанд аажмаар шилжиж, шинэтгэл болон дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын боломжуудыг аль болох бүрэн ашиглах;

- **Шинэтгэл (инноваци)-ийн буюу тэнцвэрт хөгжил, хуримтлалын хувилбар.** Энэ бүс нутгийн хүн хүч, байгалийн баялаг, түүний дотор эрчим хүчний нөөц, мал аж ахуйн түүхий эдийн нөөцийг иж бүрэн хоршин ашиглаж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай нише бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тус бүсийн экспортын боломжийг өсгөн нэмэгдүүлэх;

Дээрх 3 хувилбарыг хөгжлийн үе шат бүрээр хослуулан хэрэгжүүлэхэд анхаарах:

- 1.) Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх явцад хувилбаруудыг улс орны эдийн засгийн цаашдын өсөлт, хязгаарлагч болон дэмжигч хүчин зүйлтэй холбож, сонгон авах (зонхилох буюу хослуулах);
- 2.) Байгаль, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн шалгуур, үзүүлэлтийг харилцан хамаарлаар нь буюу тогтвортой болон ногоон бодлогын хувилбарт ялгавартай тооцох;
- 3.) Аймгуудын (доороос гаргасан) өөрсдийн санаачилга, тооцоог хувилбаруудтай харьцуулан үзэж сонгох;
- 4.) Аймаг бүр хүрсэн түвшин, чадавхиас хамааруулан дотоод бүсчлэлийг хийж, тэргүүлэн хөгжүүлэх төрөлжсөн бүс нутгуудыг тогтоох зураглах /үзэл баримтлалын төсөлд эдгээр бүсийг Сайншанд, Замын – Үүд, Даланзадгад, Тавантолгой – Оюутолгой, Мандалговь – Говьсүмбэр гэх мэт чиглэлээр авч үзэх/;

I. Үндэсний түвшинд:

Говийн дэд бүсийн Монгол улсын эдийн засгийн өсөлт, экспортын боломжийг нэмэгдүүлэхэд тээвэр – газарзүйн байрлал, байгалийн эрдсийн баялгийн ашиглалт талаасаа онцгой хувь нэмэр оруулах боломжтойг харгалзан “Говийн дэд бүсийн дэд кластерийн хөгжлийн бодлого” (цаашид “КХБ”)-ыг “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”-ийн 10-р зүйлд заасны дагуу үндэсний хэмжээний “зорилтот хөтөлбөр”-ийн түвшинд авч үзэж, Засгийн газраар батлуулан, төв орон нутгийн төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын бүх талын оролцоо, харилцан дэмжлэгээр хэрэгжүүлэх зохицуулалтыг бүрдүүлэх;

II. Бүсийн түвшинд:

Говийн дэд бүсийн хөгжлийн асуудлыг Монголын Төвийн, Хангайн бүсийн хөгжил (ялангуяа улс хоорондын худалдаа, дэд бүтцийн асуудал), Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах хэрэгцээ шаардлагатай бодлогын түвшинд уялдуулах, Засгийн газраас боловсруулж байгаа “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлого”-ын болон “Хүн амын нутагшилт, хот байгуулалтын Ерөнхий төсөл”-зураг төслийн баримт бичиг, тэдгээрийг аймаг, салбар яамд хөтөлбөр, төслүүд, Байгаль орчны стратегийн үнэлгээ, Оюутолгой, Эрдэнэс Таван толгой болон цаашид улс, бүсийн ач холбогдолтой томоохон компани, ААН-ийн бизнесийн тэлэх, өргөжих стратеги – техник, технологи - санхүүгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байхаар санал болгож, Засгийн газрын “Зөвшилцөл зохицуулалтын байнгын ажлын хэсэг” буюу Зөвлөлд даалган арга хэмжээний хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээг ханган ажиллах;

III. Аймгийн түвшинд:

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн 4 дүгээр зүйлд заасан “аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт”-ын дагуу Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг хэлэлцэн хэрэгжүүлэхдээ дэд бүсийн түвшний нийтлэг төсөл арга хэмжээг нэгтгэн зөвшилцөж, бусад бүс нутаг, тухайлбал, төвийн, хангайн, зүүн, Улаанбаатарын бүсийн ойролцоох бусад аймаг, сумдын хөгжилтэй уялдуулах үүднээс яам, аймаг, сум, мэргэжлийн холбоод орсон ажлын нэгдсэн хэсгийг цаг тухайд нь байгуулж ажиллах;

Санал болгож буй бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийн ач холбогдол

Энэхүү үзэл баримтлалыг батламжлан хэрэгжүүлснээр Говийн дэд бүсийн аймгуудын байгаль, эдийн засаг, нийгмийн харилцан шүтэлцээнд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг ногоон хөгжлийн үзэл баримтлалаар сайжруулан тэлж, уур амьсгалын өөрчлөлт болон экологийн тэнцвэрт байдлыг хамгаалан аж байдлаа дээшлүүлэх, нийгмийн үнэт зүйлсийг говийн дэд бүсийн онцлогтойгоор бүтээж, дотоод ба гадаад зах зээлээс орлого татан, аймаг, дэд бүс, үндэсний эдийн засгийн өсөлт, хуримтлалыг нэмэгдүүлэх, түүнийг хүн амын аж байдлыг дээшлүүлэхэд оновчтой хуваарилах бодит боломжийг хөгжлийн үе шатаар төсөөлөн харах, мөн энэ бүсийн ашигт малтмалыг эзэмших, ашиглах, байгаль орчныг хамгаалах талаар олон нийтийн дунд гарч буй маргаан, зөрүүтэй ойлголтыг цэгцэлж, төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын дунд нийтээр баримтлах урт хугацааны бодлогын чиг баримжаа, нэгдмэл нэг үзэл ойлголтыг төлөвшүүлж, хөтөлбөрийн үзэл баримтлалыг бодитой ажил хэрэг болгох чиглэлээр хамтын ажиллагаа, харилцан дэмжлэгийн таатай орчин бүрдэж, цаашид гарч болзошгүй аливаа эрсдэлийг багасгахад хамтын оролцоо чухал ач холбогдолтой гэж төсөөлж байна.

Говийн дэд бүсийн байгаль ба эдийн засаг, эдийн засаг ба нийгэм, нийгэм ба хүрээлэн буй орчин гэсэн ногоон хөгжлийн харилцан шүтэлцээг ханган тогтвортой болон ногоон хөгжлийн зорилгод хүрэхэд төвлөрөх салбар, тэдгээрийн холбоотой байдал хийгээд бие биенийгээ дэмжих байдлыг илүү нухацтай авч үзэх нь хамтын ажиллагааны институцийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Соёлын бүтээлч салбар. Энэ салбар нь Говийн дэд бүсийн байгаль ба эдийн засаг, эдийн засаг ба нийгэм, нийгэм ба хүрээлэн буй орчин гэсэн ногоон хөгжлийн харилцан шүтэлцээг хангахад тэргүүлэх ач холбогдолтой. Тиймээс судалгааны баг говийн дэд бүсийн *соёлын салбарын бодлого, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт дараах санал ба зөвлөмжийг тусгайлан* хүргэж байна.

1. Стратеги, бодлого, төсөл хөтөлбөрүүдэд байгаль ба эдийн засаг, эдийн засаг ба нийгэм, нийгэм ба хүрээлэн буй орчин харилцан хамаарлыг хэмжих шалгуур үзүүлэлтийг заавал багтаах, мөн хүн рүү чиглэсэн байх хэрэгтэй байна. Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөнд хэмжих шалгуур үзүүлэлт огт байгаагүй. Тухайлбал, 6-гаас дээш насны сумын хүн амын 80 хувьд соёлын төвийн үйлчилгээ хүрсэн байх ёстой, дор хаяж 60 хувь нь номын сангаар үйлчлүүлсэн байх ёстой, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд соёлын үйлдвэрлэл үйлчилгээний эзлэх хувийг 10 хувьд хүргэнэ гэх мэт.
2. Соёлын бүтээлч салбарт төр удирдан хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, төлөвлөгөөг заавал шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн шийдэлтэй оруулах хэрэгтэй.
3. Соёлын бүтээлч салбар нь бие биенийгээ дэмжих болон харилцан холбоотой байдлыг зангидаж, уялдуулах, мөн хөдөлгөгч хүч болох талтай. Иймд Говийн дэд бүсийн хэмжээнд “Соёлын бүтээлч салбарын дэд кластер”-ийг хөгжүүлэх, дэд кластерийн хөгжлийн стратегитэй болох хэрэгтэй. “Хөгжилд хувь нэмэр оруулах соёлын үзүүлэлтүүд”-ийг орон нутагт гаргах мэдээлэл хангалттай байна. Иймд соёлын бүтээлч салбарын институцийг бүхлээр нь харах, улмаар хаана сул тал байгааг тодорхойлох боломжтой, соёлын эдийн

засгийн үр ашгийг дээшлүүлэх, ажилгүйдэлтэй тэмцэх, хүний хөгжлийг хангах гээд олон талын бодлогоо сайжруулахад тустай байх болно.

4. Соёлын бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Хөгжилд хувь нэмэр оруулах соёлын үзүүлэлтүүд” (CDIS) багтсан үзүүлэлтүүдээр хэмждэг болохын тулд эхлээд соёлын үйлдвэр, соёлын ажил мэргэжлийн лавлагаа гаргах хэрэгтэй байна.
5. Нөөцийн талаарх тоон мэдээг харвал Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн хувьд нэгдсэн маршрут бүхий (кластер) аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжтой харагдаж байна. Үүнд соёлын биет өв дээр хөгжүүлэлт хийгээд, палеонтологийн нөөцийн газрын доорхи зураглалыг технологийн тусламжтай музей болгон харуулж, Өмнөговь, Дундговь аймагт соёлын биет бус өвийн үзүүлбэр, тоглолт үзүүлэх цогц бүтээгдэхүүний хөгжүүлэлт бүхий нише зах зээл үүсгэж болохоор байна.

Хэрэгжүүлэлт, зохион байгуулалтын талаарх дэлгэрэнгүй тайлбарыг Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлалын төслөөс харах боломжтой.

Дараагийн нэг чухал салбар бол **Нийгмийн хамгааллын салбар** юм. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-н 2.2.1. Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал хэсэгт зааснаар Зорилт 1-д ядуурлыг эцэс болгох, Зорилт 2-д хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, Зорилт 3-д нийгмийн даатгалын сангийн бие даасан тогтолцоог бүрдүүлэхээр заасан байдаг. Зорилт 3-д заасан үзүүлэлтийг үндэс болгон салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг боловсруулж тооцоолол хийснийг танилцуулж байна. Тооцооллын хувьд аймгийн түвшинд боловсруулагдсан бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудлыг урт, дунд, богино хугацаанд хэрхэн тусгагдсан байдлаар онооны системийг тооцож авч үзсэн.

Хүснэгт 3.1. Бодлогын баримт бичигт хугацааны ач холбогдлоор оноо өгсөн байдал

Урт хугацаанд	Дунд хугацаанд	Богино хугацаанд
0.5	0.3	0.2

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Энд урт хугацааны бодлогын баримт бичиг нь цаашдын нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн алсыг харах үндсэн бааз суурь тул ач холбогдол өндөртэй гэж үзэж 0.5, дунд хугацааны урт хугацааны зорилгыг хэрэгжүүлэх дунд хугацаанд нийгмийн хамгааллын салбар хөгжил ямар байхыг тодорхойлж байгаа тул 0.3, богино хугацаанд аймгийн түвшинд нийгмийн хамгааллын салбарын бодлого хэрхэн хэрэгжиж байгааг тодорхойлж байгаа тул 0.2 гэсэн үнэлгээг өгсөн болно.

Нийгмийн хамгааллын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг тооцоход Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан дараах 5 шалгуур үзүүлэлтийг авч үзсэн болно.

1. Нийгмийн даатгал (нийгмийн даатгалтай холбоотой үйл ажиллагаа)
2. Нийгмийн халамж (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа)
3. Жендер (хүйсийн тэгш байдал)
4. Хүн амын өсөлтийг дэмжих бодлого
5. Мэргэжлийн боловсрол (Мэргэжлийн боловсрол болон МСҮТ-ийн талаарх бодлого)

Эдгээр үзүүлэлтийг нийгмийн хамгааллын салбар дахь ач холбогдолын түвшингөөр дараах байдлаар жин бүхий онооны системийг тооцож үзэв.

Хүснэгт 46 Нийгмийн хамгааллын салбар дахь ач холбогдлоор оноо өгсөн байдал

Нийгмийн даатгал	Нийгмийн халамж	Жендер	Хүн амын өсөлт	Мэргэжлийн боловсрол
0.5	0.2	0.1	0.1	0.1

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хүснэгтэд харуулсан жинг ашиглан аймгийн болон сумдын бодлогын баримт бичигт тусгагдсан нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийх боломж бүрдлээ. Аймгийн түвшинд урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудал бүрэн тусгагдсан бол 1 гэсэн оноог авна. Сумдын бодлогын баримт бичиг нь аймгийн бодлогын баримт бичигтэй уялдсан, түүнд тулгуурласан байна гэдэг үүднээс аймгийн авсан оноог сумдын бодлогын баримт бичигт тусгагдсан оноогоор үржүүлж гаргана. Энэ тохиолдолд сумдын хувьд авах боломжит дээд оноо нь 1*1 буюу 1 гэсэн оноог авна. Энэ оноог говийн 4 аймгийн сумдын хувьд эрэмбэлэх замаар нийгмийн хамгааллын салбарын бодлогыг хамгийн сайн, муу тусгасан сумыг тодорхойлох боломжтой болох юм.

Аймаг, сумдын нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

Өмнөх арга зүйд тусгагдсан онооны системийг ашиглан нөлөөллийн урьдчилсан үнэлгээг тооцсон үр дүнг харуулав.

Хүснэгт 47 Говийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын оноо

Дорноговь аймаг	Өмнөговь аймаг	Дундговь аймаг	Говьсүмбэр аймаг
0.54	0.38	0.42	0.45

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Өмнөговь аймгийн хувьд хамгийн бага оноо авсан бөгөөд гол шалтгаан нь урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын асуудлыг орхигдуулсантай холбоотой юм. Дундговь аймгийн хувьд бодлогын баримт бичигтээ урт хугацаанд нийгмийн хамгааллын асуудлыг огт тусгаагүйтэй холбоотойгоор онооны түвшин бага гарсан. Говьсүмбэр аймгийн хувьд дунд болон богино хугацаанд нийгмийн даатгалын талаарх бодлогыг тусгаж өгөөгүй байна. Хамгийн өндөр оноог Дорноговь аймаг авч байгаа боловч урт хугацааны бодлогын баримт бичигтээ нийгмийн даатгалын талаар тусгаагүй байна.

Сумын түвшинд нийгмийн хамгааллын салбарын асуудал бодлогын баримт бичигт тусгагдсан байдлын талаарх тооцоог урт, дунд, богино хугацаагаар гэж авч үзэх боломж байхгүй тул 2016-2020 оны сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн бодлогын баримт бичгийн тоон үнэлгээний жинг ашиглан тооцсон.

Хүснэгт 48 Говьсүмбэр аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо
Баянтал	0.45
Сүмбэр	0.14
Шивээговь	0.18

Хүснэгт 49 Дунговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо	Сум	Оноо	Сум	Оноо
Баянжаргал	0.00	Дэлгэрхангай	0.34	Хулд	0.38
Говь-Угтаал	0.13	Дэрэн	0.42	Цагаандэлгэр	0.34
Дэлгэрцогт	0.34	Луус	0.17	Сайнцагаан	0.13
Өндөршил	0.38	Өлзийт	0.34	Адаацаг	0.21
Эрдэнэдалай	0.21	Сайхан-Овоо	0.17	Гурвансайхан	0.21

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хүснэгт 50 Дорноговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо	Сум	Оноо	Сум	Оноо
Их хэт	0.49	Даланжаргалан	0.49	Сайхандулаан	0.49
Хөвсгөл	0.43	Дэлгэрэх	0.54	Улаанбадрах	0.49
Сайншанд	0.22	Замын-Үүд*	-	Хатанбулаг**	-
Айраг	0.43	Мандах	0.43	Эрдэнэ	0.49
Алтанширээ	0.43	Өргөн	0.43		

Эх сурвалж: Судлаачийн тооцоо *-файл нээгдээгүй, **-баримт бичиг байхгүй.

Хүснэгт 51 Өмнөговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо	Сум	Оноо	Сум	Оноо
Даланзадгад	0.11	Баян-Овоо	0.15	Номгон	0.11
Манлай	0.11	Булган	0.11	Ханбогд	0.15
Сэврэй	0.30	Гурвантэс	0.11	Ханхонгор	0.34
Цогтцэций	0.11	Мандал-Овоо	0.11	Хүрмэн	0.11
Баяндалай	0.30	Ноён	0.11	Цогт-Овоо	0.11

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Онооны эрэмбээр Дорноговь аймгийн Дэлгэрэх сум 0.54 оноо авсан байдлаар бодлогын баримт бичигтээ нийгмийн хамгааллын салбарын талаар илүү тусгасан байна. Эсрэгээрээ Дунговь аймгийн Баянжаргал сум бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудлыг огт тусгаагүй 0 оноо авсан байна.

Улс орон бүрийн нийгмийн хамгааллын бодлого нь өөрийн орны онцлогоос хамаараад ялгаатай байдаг тул олон улсад харьцуулалт хийх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход дараах 3 аргыг түлхүү ашигладаг.

1. Тухайн улсын нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь

Өндөр хөгжилтэй орнуудын хувьд нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь өндөр байдаг ба 2017 оны байдлаар ЭЗХАХБ (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага)-ын дунджаар 20.1 хувьтай бол манайд 7.7 хувь байна.

2. Тухайн улсын нэг хүнд ногдох нийгмийн хамгааллын зардлыг худалдан авах чадварын тэнцвэр (PPP)-ээр илэрхийлж харьцуулах, ЭЗХАХБ-ын нэг хүнд ногдох нийгмийн хамгааллын зардал нь 2015 оны дунджаар авч үзэхэд 7819.6\$ байгаа бол Монголын хувьд 2015 оны байдлаар ойролцоогоор 890.6\$ байгаа нь 8.8 дахин бага байна.
3. Нийгмийн хамгааллын индекс (SPI) Нийгмийн хамгаалалд зарцуулж буй зардлыг нийгмийн хамгааллаас өгөөж хүртэж буй хүмүүсийн тоонд харьцуулдаг.

Энэ индексийг Ази, номхон далайн орнуудад түлхүү хэрэглэдэг. Манай орны хувьд энэ үзүүлэлтээр Ази, номхон далайн орнууд дотроо харьцангуй өндөр байдаг бөгөөд 2007 онд хийсэн судалгаагаар Монгол улс 4-д, 2009 оны судалгаагаар Япон, Узбекистаны дараа 3-рт бичигдэж байна. Засгийн газраас НДШ-ийг 2018 онд 2 хувиар, 2019 онд 1 хувиар, 2020 онд 2 хувиар үе шаттайгаар нэмэхээр шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу 2018 онд нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оноос 55 хувиар нэмэгдэж зарлагаасаа 257.3 тэрбум төгрөгийн ашигтай гарсан. Нийгмийн даатгалын сангийн орлогыг 2017 он хүртэлх 10 жилээр авч үзэхэд жилийн дундаж өсөлт нь 16.8 хувь, жилийн зарлага нь 19.8 хувийн өсөлттэй байсан нь орлогын хурдаасаа зарлагын хурд илүү байсныг илэрхийлж байна.

Говийн дөрвөн аймгийн бодлогын баримт бичгүүдийг харвал батлагдсан хугацаа ялгаатай, 3 аймагт стратегийн бодлогын баримт бичгийн хугацаа дуусч байгаа бол нэг аймагт шинээр урт хугацааны стратегийн бодлогын баримт бичгээ тодорхойлон гаргажээ. Эдгээр бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын талаар тусгасан асуудал нь харилцан адилгүй. Тухайлбал шинээр батлагдсан Дундговь аймгийн 2018-2028 оны хөгжлийн хөтөлбөрт нийгмийн хамгааллын талаар бодлогын асуудал огт тусгаагүй байна.

Өмнөговь болон Дундговь аймгийн хувьд нөгөө хоёр аймагтай харьцуулахад нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт өндөр хэлбэлзэлтэй байна. Аймгийн түвшний бодлогын баримт бичгүүдээс харахад одоогийн байгаа түвшин, ирээдүйд хүрэх түвшинг нарийн зааж өгөөгүй байна. Сумдын бодлогын баримт бичгийн хувьд гол төлөв аймгаас гаргасан бодлогын баримт бичгээс улбаалсан хэлбэртэй зарим бодлогыг шууд авч тавьсан байна. Бодлогын баримт бичигт тусгагдсан нийгмийн хамгааллын талаарх бодлогыг тэгээс нэгийн хооронд утга авахаар оноожуулсан системийг ашиглан үр дүнг тооцож үзэхэд Дорноговь аймаг 0.54 (хамгийн өндөр), Өмнөговь аймаг 0.38 (хамгийн бага), Дундговь аймаг 0.42, Говьсүмбэр аймаг 0.45 гарчээ. Говийн 4 аймгийн сумдын хувьд улсын хэмжээний болон аймгийн бодлогын баримт бичигт тулгуурлаж өөрийн сумын бодлогын баримт бичгийг боловсруулсан гэж үзэж оноожуулалтыг тооцсон болно. Онооны эрэмбээр Дорноговь аймгийн Дэлгэрэх сум 0.54 оноо авсан байдлаар бодлогын баримт бичигтээ нийгмийн хамгааллын салбарын талаар илүү тусгасан байна. Эсрэгээрээ Дундговь аймгийн Баянжаргал сум бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудлыг огт тусгаагүй 0 оноо авсан байна.

Монгол улс 2030 онд ядуурлыг бүх түвшинд устгах, нийгмийн хамгаалалд зарцуулж байгаа зардлын хэмжээг ЭЗХАХБ-ын дундаж хэмжээнд хүргэхийн тулд нийгмийн хамгааллын зардлыг жил бүр 24 хувиар нэмэгдүүлэх шаардлага гарч байна. Монгол улсад нийгмийн хамгааллын чиглэлийн хуулиуд нь нийгмийн хамгааллын чиглэлийн хөтөлбөр, бодлогын баримт бичигтэй зөрчилдөх байдал харьцангуй бага байна. Нийгмийн хамгааллын чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд нь улсын хэмжээний бодлогын баримт бичгээр гаргасан бөгөөд үүнийг бүсийн түвшинд, аймгийн

түвшинд хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийн тусгасан зүйл байхгүй. Говийн 4 аймгийн нийгмийн халамжийн үйл ажиллагааны талаар ихэнх бодлогын баримт бичигт хангалтгүй тусгасан байгаа нь нийгмийн халамжийн босоо тогтолцоотой холбоотой байж болох юм.

Нийгмийн даатгалын сангийн орлого эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаатай боловч орлогын тогтмол өсөлт эргээд нийгмийн даатгалын сангийн зардлын тогтвортой байдлыг хангах өсөлт болдог. Өмнөговь болон Дундговь аймгийн хувьд нөгөө хоёр аймагтай харьцуулахад нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт өндөр хэлбэлзэлтэй байгаа нь зарцуулалтыг урт хугацаанд төлөвлөхөд бэрхшээл учрах талтай юм. Аймгийн түвшний бодлогын баримт бичгүүдээс харахад одоогийн байгаа түвшин, ирээдүйд хүрэх түвшинг нарийн зааж өгөөгүй байгаа нь Мянганы хөгжлийн зорилтууд, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийг хэмжихэд бэрхшээлтэй болгож байна. Сумдын бодлогын баримт бичгийг харахад Өмнөговь аймгийн хувьд бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ дутагдалтай байна. Нийгмийн хамгааллын салбарт хийсэн шинжилгээний үр дүнд үндэслэн говийн 4 аймаг тус бүрээр, говийн дэд бүсийн түвшинд, улсын хэмжээний буюу бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах гэсэн 3 түвшинд санал боловсруулж хүргүүлж байна.

Говьсүмбэр аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Урт, дунд, богино хугацааны хөгжлийн хөтөлбөрийн үзүүлэлтүүдэд жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын асуудлыг огт тусгаагүй байгааг анхаарч бодлогодоо тусгах
3. Аймгийн түвшинд тусгаадаагүй бодлогууд сумдын түвшинд батлагдсан байгааг анхаарах
4. Сумдуудад нийгмийн халамжаас бусад нийгмийн даатгал, жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын талаарх бодлогууд огт тусгаадаагүй буюу маш бага тусгагдсан байгаа тул бодлогын баримт бичигт нь энэ талын бодлогыг тусгуулах

Дорноговь аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Сумдын түвшинд нийгмийн хамгааллын салбарын бодлогын 5 үзүүлэлтээс нийгмийн даатгал, халамжийн асуудал харьцангуй сайн тусгагдсан байгаа ч жендер, мэргэжлийн боловсрол, хүн амын өсөлтийг дэмжихтэй холбоотой бодлого ихэнх сумдад байхгүй буюу дутуу байгааг анхаарч бодлогын баримт бичигтээ тусгах

3. Онооны системд оруулсан үнэлгээгээр аймгийн хувьд бусад аймгаас хамгийн өндөр байгаа боловч урт хугацааны бодлогын баримт бичигтээ нийгмийн даатгалын талаар тусгаагүйг анхаарч тусгаж ажиллах

Дундговь аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Шинээр боловсруулсан аймгийн урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийгмийн хамгааллын салбарт шалгуур болгон авсан 5 үзүүлэлтээс алийг нь ч тусгаагүй байгаа нь нийгмийн хамгааллын талаар бодлогогүй болж байгаа тул хөтөлбөрөө дахин авч үзэж бодлогодоо тусгах
3. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт мэргэжлийн боловсролын талаар бодлого байхгүй ч жилийн ажлын үндсэн төлөвлөгөөнд тусгагдсан байгаа нь бодлогын хувьд уялдаагүй тул засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах, мөн хүн амын өсөлтийг дэмжих бодлого бүх түвшинд оруулах
4. Сумдуудад нийгмийн халамжаас бусад нийгмийн даатгал, жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын талаарх бодлогууд огт тусгагдаагүй буюу маш бага тусгагдсан байгаа тул бодлогын баримт бичигт нь энэ талын бодлогыг тусгуулах

Өмнөговь аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Аймгийн хөгжлийн хөтөлбөр болон засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Нийгмийн даатгал, хүн амын өсөлтийг дэмжих, талаар баримтлах бодлогыг аймгийн хөгжлийн хөтөлбөртөө оруулах.
3. Аймгийн хөгжлийн жилийн үндсэн чиглэлдээ аль болох нийгмийн хамгааллын салбарт авч үзсэн 5 чиглэлийг хамруулах
4. Онооны системд оруулсан үнэлгээгээр аймгийн хувьд бусад аймгаас хамгийн бага оноо авсан. Гол шалтгаан нь урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын асуудлыг орхигдуулсантай холбоотой тул нийгмийн даатгалын бодлогоо тодорхойлж оруулах
5. Сумдуудад нийгмийн халамжаас бусад нийгмийн даатгал, жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын талаарх бодлогууд огт тусгагдаагүй буюу маш бага тусгагдсан байгаа тул бодлогын баримт бичигт нь энэ талын бодлогыг тусгуулах

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгах санал

1. Аймаг бүрийн бодлогын баримт бичгүүдийн хугацаа ялгаатай байгааг анхаарч урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг ижил хугацаанд гаргах, авч үзэж буй хугацааны интервалыг ижил болгох
2. Нийгмийн хамгааллын салбарт гол болгон авсан 5 үзүүлэлт болох нийгмийн даатгал, нийгмийн халамж, мэргэжийн боловсрол, жендер, хүн амын өсөлтийг дэмжих бодлогуудыг аймаг, сумын түвшинд жигд тусгуулах;

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд тусгах зарчмын санал

1. Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийгмийн хамгааллын салбарын бодлогыг тусгах. Ингэхдээ нийгмийн даатгал, нийгмийн халамж, жендер, мэргэжлийн боловсрол, хүн амын өсөлтийг харгалзаж үзэх.
2. Одоог хүртэл батлуулж чадаагүй байгаа “Бүсийн нэмэгдлийн тухай” хуулийг УИХ-аар хэлэлцүүлж батлуулах

Өмнөх бодлогын баримт бичигт боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн бага зэрэг тусгагдсан боловч нийгмийн халамж, жендерийн асуудлын талаар тусгагдаагүй байна.

БҮЛЭГ III. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР (төсөл)

3.1 Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн логик хүрээ

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 151 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж байсан. Энэхүү баримт бичгийг боловсруулснаас хойш НҮБ-ын ТХЗ, Монгол Улсын урт хугацааны үзэл баримтлал 2030 батлагдсан. Түүнчлэн Барилга хот байгуулалтын яам, Үндэсний хөгжлийн газар болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах төсөл”-ийг хэрэгжүүлээд үр дүнг хүлээлгэж өгөөд байна. Энэхүү судалгаа нь Монгол улсын өнөөгийн хөгжлийн нөхцөл байдал нь хэвээр хадгалагдвал ТХЗ, ТХҮБ 2030-ын хэрэгжилт хангагдахгүй байх магадлалтай гэдгийг харуулж, хөгжлийн шинэ загвар шаардлагатай болохыг харуулсан. Байгалийн хувьд, ТХЗ-д хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжиж, газрын доройтлыг бууруулан биологийн олон янз байдлыг мөхөж, устахаас сэргийлнэ гэж тусгасан. Бодит байдалд эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор эрдэс баялгийг хэтрүүлэн ашиглаж, зарим газарт бэлчээрийн талхагдлын улмаас хөрсний доройтол үүсээд байгаа болно. Эдийн засгийн хувьд, нэмүү өртөг өндөртэй ажиллах хүч их шаарддаг салбаруудад анхаарал хандуулан бүтээмжийг дээшлүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ гэж ТХЗ-д тусгасан ч практикт, ашигт малтмал, мал аж ахуйгаас хэт хамааралтай болж, ажилгүйдэл, ядуурал буурахгүй байгаа билээ. Иймд мал аж ахуйн салбарыг тогтвортой, өрсөлдөх чадвартай, байгальд болон зах зээлд ээлтэйгээр хөгжүүлэхийн тулд түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг эрс шинэчлэх, ногоон эдийн засаг, ногоон худалдааны бодлогыг хэрэгжүүлэх, улмаар кластерийн бодлогоор нэгтгэн зангидах шаардлагатай болж байна. Нийгмийн хувьд, ТХЗ-д хүн бүрт чанартай боловсролыг ижил тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, насан турш сурч боловсрох боломжийг дэмжихээр дэвшүүлсэн ч хүний хөгжлийн индекс, амьдралын чанарын индексийг газарзүйн байршлаар улам сайжруулж байж, Монгол улс дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх болно.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол улсын хөгжлийн “Алсын хараа 2050” УИХ-аар хэлэлцэж байгаа энэ цаг хугацаанд “Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг хэлэлцүүлэх гэж байна.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн үндсэн зорилго нь байгаль орчны доройтлыг саармагжуулж, дэд бүсийн тэнцвэртэй, тогтвортой, ногоон хөгжлийг дэмжин Монгол улсын өсөлт хөгжлийг тогтвортой хөгжлийн замд хөтлөхөд чиглэнэ. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн дагуу ТХЗ, ТХҮБ 2030, Алсын хараа 2050 руу хөтлөхдөө ТХЗ-оос тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэл (ТХЗ 12), тогтвортой дэд бүтэцтэй холбоотой зорилгод төвлөрч, эдийн засгийн орчил хөдөлгөөний эргэлтийн эрчмийг сайжруулахад чиглүүлэх юм.

Говийн дэд бүс нутаг нь:

1. Монгол улсын эрдэс баялгийн болон хүнд үйлдвэрийн хөгжлийг залах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татсан зангилаа бүс нутаг болохын зэрэгцээ хил залгаа бүсийн байгаль орчин эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд чухал ач холбогдолтой.
2. Бүс нутаг дамнасан эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, байгалийг хүндэтгэн хамгаалах уламжлалт соёлыг хадгалан хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн техник, технологид суурилсан, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, өндөр ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэхэд тэргүүлэх байр суурь эзэлнэ.
3. Аймаг, хот суурингийн хөгжлийн стратеги бодлогыг уялдуулах, бүсийн хөгжлийн бичил төвүүдийг хөгжүүлэх үндсэн дээр нийслэлийн хүн ам ба нийгэм эдийн засгийн хэт төвлөрлийн

ачааг үүрэлцэх, бусад бүс нутагтай харилцан үр ашигтай хамтран ажиллаж, бүс нутгийн тэнцвэрт өсөлтийг хангана. Тиймээс говийн дэд бүсийн хөгжлийн санал болгож буй стратеги нь:

1. Нутагшил, суурьшлын оновчтой тогтолцоо бүрдүүлсэн бүс нутаг
2. Байгаль хамгаалал, рекреаци – аялал гээд соёлын бүтээлч кластерийг онцолсон бүс нутаг
3. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлын найдвартай орон зай бүрдүүлсэн бүс нутаг
4. Шинэ технологи, инновацид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлсэн бүс нутаг
5. Институцийн хамтын ажиллагааны үндсэн дээр худалдааны таатай орчин бүрдсэн бүс нутаг болох чиглэлтэй байж болно.

Тодотговол,

1. Нутагшил, суурьшлын оновчтой тогтолцоо бүрдүүлсэн бүс нутаг зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.
 1. Говийн онцлог өв соёлын бүтэцтэй хот суурингууд, бүлэг суурингийн байгаль, эдийн засаг, нийгэм, соёл ахуйн орон зайн бүтэцлэг тогтолцоог бүрдүүлэх замаар бичил бүсүүдийн эдийн засаг, нийгмийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжих,
 2. Бүсийн хүрээнд зам тээвэр, холбоо, эрчим хүч зэрэг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийг сайжруулах, дээд зэрэглэлийн тээвэрлэлт /логистикийн коридорыг өрсөлдөх давуу тал болгох;
 3. Хот тосгод, бичил бүсийн тулгуур төвүүдийн үүрэг бүтэц, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бичил бүсүүдийн төрөлжилтөнд тулгуурлан бүсийн хэмжээний интеграци, нийгэм, эдийн засгийн чиг, үүргийг тодорхой, ил тод болгох;
2. Байгаль хамгаалал, рекреаци – аялал гээд соёлын бүтээлч кластерийг онцолсон бүс нутаг зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.
 1. Бүс нутгийн хүрэн дэх улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт рекреаци-аялал жуулчлалын нөөцийг харгалзан олон улс, улс, орон нутгийн чанартай аялал жуулчлалын бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор”-ыг хөгжүүлж, соёлын бүтээлч дэд кластераар төрөлжих;
 2. Аялал-рекреацийн бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор” байгуулах ажлыг улс үндэстний хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалт, хот байгуулалт, бүс, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө болон байгаль хамгаалал, түүх, соёл-биеийн тамир, спортын зэрэг салбарын төлөвлөгөө, ОНБ-ын төсөл хөтөлбөртэй нягт уялдуулж, өрсөлдөх чадвартай соёлын бүтээлч дэд кластертай болох;
 3. Бүс нутаг ба орон нутгаас гарч буй хөгжлийн төлөвлөгөө, тодорхой үүсгэл санаачилга бүхий төсөл, хөтөлбөрүүдийг төр засгийн газраас дэмжих, аялал-рекреацийн бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор” байгуулж, хэрэгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах институцийн тогтолцоо, менементийн системийг бүрдүүлж, аж ахуйн нэгжүүдийн манлайллыг дэмжих;
3. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлын найдвартай орон зай бүрдүүлсэн бүс нутаг
 1. Говийн дэд бүсийн онцлог бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг зах зээлийн зарчмаар ажиллуулах орон зайн бүтцийг төгөлдөржүүлэх үндсэн дээр бүс нутгийн хүнсний найдвартай орон зай бүрэлдүүлэх;
 2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, боловсруулалт, дахин боловсруулалт, түгээлтийн орон зайн конвэрчилсон бүтэцлэг, тогтолцоог бүрдүүлэх;

3. Бичил бүсийн төвүүдэд хүнс, хөнгөн үйлдвэрийн газруудыг байгуулах, агро үйлдвэрлэлийн цогцолбортой болох;
4. Шинэ технологи, инновацид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлсэн бүс нутаг зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.
 1. Тэргүүний технологи, инновацид суурилсан үйлдвэрийг үйлдвэр технологийн парк, инкубатор төв гэх зэрэг ухаалаг бизнесийн төвийн загварыг аймгуудад нийцэх байдлаар өөр өөр өвөрмөц бүтэцтэй бизнесийн загваруудыг хөгжүүлэх;
 2. Экосистемийн үйлчилгээг мэдээллийн технологийн ололттой хослуулан нийгэмших, соёлжих ухаалаг системийг эрчимтэйгээр нэвтрүүлж, хотын амьдралын хэв маягтай болгох;
 3. Ашигт малтмал, байгалийн нөөцийг хуулийн хүрээнд ашиглах, хариуцлагатай уул уурхайн зарчмаар ажиллах уул уурхайн кластерийг худалдааны кластер болгон тэлж өргөжүүлэх;
5. Институцийн хамтын ажиллагааны үндсэн дээр худалдааны таатай орчин бүрдсэн бүс нутаг зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.
 1. Говийн дэд бүсийн кластерийн меморандум байгуулах;
 2. Кластерийн бодлогод салбарын хөгжлийн бодлогуудыг уялдуулан зохицуулах зөвлөлийг байгуулах;
 3. Кластерийн хөгжлийн төвтэй болох;

3.1.1 Алсын хараа 2050 ба говийн дэд бүсийн хөгжлийн гол утга

Глобал өөрчлөлтийн нөлөөгөөр дэлхийн эдийн засагт эерэг болон сөрөг дам нөлөө ихсэж, хөгжсөн болон хөгжиж буй орнуудад харилцан адилгүй үр нөлөөг үзүүлж байна.

Монгол улсын урт хугацааны үзэл баримтлал буюу Алсын хараа 2050-д харуулснаар: "... 2008 оны санхүүгийн хямрал нь эрэлтийн шалтгаанаар өдөөгдөж байсан сүүлийн жилүүдэд АНУ-Хятадын хоорондын худалдааны, ханшны болон технологийн дайнаас үүдэлтэй хямрал олон хүчин зүйлсээс хамаарч байна. Худалдааны дайн нь эрчим хүчний нөөцийн эрэлтийг бууруулж, үнэ, ханш буурахад сөргөөр нөлөөлж болзошгүй. Худалдааны, ханшийн дайн болон технологийн өрсөлдөөн улс орнуудад эдийн засгийн уналт, өндөр инфляцид нэгэн зэрэг хүргэж, импортын хэрэглээний бүтээгдэхүүн, завсрын орцууд, технологийн бүрдлүүд болон энергийн үнийг өсгөн глобал нийлүүлэлтийн сүлжээг тасалдуулах замаар үйлдвэрлэлийг бууруулахад хүргэж болзошгүй юм. Түүнчлэн дэлхийн тавцанд улс орнууд харилцан нэг нэгэнтэйгээ сөргөлдөх нөлөө үүсэж, энэ нь удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд мөнгөний болон төсвийн бодлого тэлэх нь өмнөх хямралтай адил нөлөөтэй эсэх нь эргэлзээтэй болно.

Сүүлийн 30 орчим жилийн хугацаанд тогтолцооны өөрчлөлтөөс шалтгаалан Монгол улсын эдийн засаг 1.3 хувь хүртлээ унаж байсан бол Оюу Толгойн зэсийн ордыг ашиглах ажил эхэлснээс хойш уул уурхайн салбарын өсөлт нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлж, 2011 онд эдийн засгийн өсөлт 17.3 хувьд хүрч дэлхийд хамгийн өндөр өсөлттэй гарч байв. Гэвч уул уурхайн түүхий эдийн үнэ буурахтай зэрэгцэн эдийн засгийн өсөлт унаж, улсын төсөв буурч, Засгийн газрыг өрийн дарамтад оруулах болсон нь дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрсний үнийн хэлбэлзэл, экспортоос ихээхэн хамааралтайг илтгэсэн томоохон сургаж юм.

ДНБ-ий өсөлт 2017 онд 5.3 хувь, 2018 онд 7.2 хувь, 2019 онд 6.5 хувь орчим өсөхөөр байгаа нь сүүлийн жилүүдэд эдийн засаг сэргэж буйг илтгэж байгаа бөгөөд эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайжирч 2020 онд үргэлжлэх төлөвтэй байна. Гэхдээ цаашид эдийн засгийн өсөлт уул уурхайн салбар, гадаадын шууд хөрөнгө оруулалт, глобал нөхцөл байдлаас ихээхэн хамаарах магадлал хэвээр байна.

Монгол Улсын эдийн засгийн бүтцэд 1994 онд хөдөө аж ахуйн салбар 32.3 хувийг эзэлж байсан бол 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.8 хувь болж буурсан байхад уул уурхайн өсөлтийн нөлөөгөөр аж үйлдвэр, барилгын салбар 28.5 хувиас 39 хувь болж өссөн. Уул уурхайн хөгжлөөс хэт хамааралтай манай улсын эдийн засгийн бүтэц нь эдийн засгийн өсөлт тогтвортой байж, нийгмийн үзүүлэлтүүдэд шилжих боломжийг хязгаарлаж иржээ. Сүүлийн 20 жилийн байдлаас харахад манай улсын эдийн засагт 3-4 жил тутамд өрнөл, уналтын мөчлөг тохиолдож байгаа нь өрхийн амьжиргаа, нийгмийн үзүүлэлтүүдийг сайжруулах боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт нь уул уурхайн зэрэг капиталын багтаамжтай цөөн салбар, компаниудад бий болж байгаа нь хүртээмжтэй өсөлт сул байх, өсөлтөөс бий болсон орлого нь импорт (машин тоног төхөөрөмж, шатахуун, эрчим хүч гэх мэт), үйлчилгээ (тээврийн, зураг төсөл, барилга байгууламж зэрэг зөвлөх үйлчилгээ), ногдол ашгийн төлбөрт эргээд гадагшаа гарахад хүргэдэг. Энэ нь нөгөө талаас гадаад худалдааны бодлого, зохицуулалт дутагдсантай холбоотой байна.

Монгол Улсын эдийн засаг өсөхийн хэрээр нэг хүнд ногдох ДНБ хэмжээ нэмэгдэж 1994 онд 174.5 мян.төг байсан бол 2018 онд 10.1 сая төгрөгт хүрч 58.3 дахин нэмэгдсэн нь зах зээлд шилжиж эхэлсэн эхний үетэй харьцуулахад том ахиц боловч Дэлхийн банкны Атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох орлого 3660 ам доллар байгаа нь дундаж-доогуур орлоготой орны ангилалд орж байна. Үүнийг дэлхийн түвшинд эрэмбэлэхэд тийм ч өндөр түвшин биш юм.

Тэгш бус байдлаас улбаатай хүндрэл Монгол Улсын хувьд ч өнгөрсөн 30 жилийн үндсэн сорилтуудын нэг мөн. Манай улсад ядуурлыг бууруулахад чиглэн халамжийн бодлого хангалттай үр дүнд хүрч чадаагүйг хөгжлийн суурь үзүүлэлтүүд нотолж байна. Цаашид нийгмийн дундаж давхаргаа дэмжих цогц бодлого баримталж ажиллах бодит шаардлага үүсэж байна.

Сүүлийн жилүүдийн төсвийн хэт тэлэлтийн үед аж ахуйн нэгжүүд болон өрхүүдийн өрийн дарамт илт нэмэгдэв. Орон сууцны 8 хувийн зээлийн хөтөлбөр 2013 онд хэрэгжиж эхэлснээс хойш өрхүүдийн дарамт илт нэмэгдэж эхлэн өрхийн өр, ДНБ-ий харьцаа 40 хувьд дөхөж ирээд байна. Ийнхүү өртэй байдал нэмэгдэхийн хэрээр өрхүүд хэрэглээгээ хумих, эдийн засгийн өсөлтийг сааруулах үзэгдэл эхэндээ ажиглагдсан ба цаашдаа ч давтагдахаар байна. Эдийн засаг сэргэж эхлэх үед орон сууцны зээлийн төлбөрийн дараа үлдэх хэсэг бусад хэрэглээний өсөлтийг хангахад хүрэлцэхгүй байсан тул өрхүүд нэмж хэрэглээний зээл илүүтэй авч эхэлснээр өрхийн өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх хандлага ажиглагдав. Энэхүү өрийн дарамт нь дараагийн эдийн засгийн хүндрэлийн үед өрхийн санхүү улам муудах, улмаар банкны салбарт зээлийн эрсдэл хуримтлагдах нөхцөл бүрдүүллээ. Түүнчлэн өрхүүд илүү өндөр хүүтэй зээл авч (банк бус санхүүгийн байгууллагын дундаж хүү нь банкны салбарынхнаас 2.5 дахин өндөр буюу жилийн 40 гаруй хувь байна) өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх нь түгээмэл байна. Тиймээс урт хугацааны үзэл баримтлал нь эдийн засгийн төрөлжилтийг сайжруулж, тэргүүлэх салбаруудыг бодлогоор дэмжүүлэн хөгжүүлэх, экспортын шат дараалсан өсөлтийг хангах, ерөнхийдөө кластерийн бодлогыг өрсөлдөх чадварын суурь зарчимд тулгуурлан авч үзэх рүү чиглэх болж байна. Монгол Улсын цаашдын ирээдүйн макро эдийн засгийн бодлого нь урт хугацаанд тогтвортой, мөчлөг сөрсөн, өрийн дарамт болон зардлын өсөлтийн нарийвчлан тооцсон аргачлалаар дунд хугацаанд эдийн засгийг

тогтворжуулж, улмаар урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангасан өөрөө өөрийгөө тэтгэсэн, гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтөөс дархлагдсан байх шаардлагатай бөгөөд эдийн засгийн өсөлт хүний хөгжил, дундаж орлоготой иргэдийг тэтгэх цогц бодлого руу илүүтэй чиглэх болж байна. Эл утгаар өнгөрсөн 30 жилийг бүхэлд нь дүгнэж, ирэх 30 жилийг урт хугацаагаар төсөөлөх урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал боловсруулах түүхэн шаардлага үүссэн” гэж дүгнэжээ.

3.1.2 Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн тулгуур зарчим

Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн гол баримт бичгүүд нь УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас батлан мөрдүүлсэн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр байлаа. Эдгээр баримт бичгийн хүчинтэй хугацаа 2018-2020 онд дуусгавар болж, үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг шинээр боловсруулах эрхзүйн хэрэгцээ шаардлага байна. Мөн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, түүнийг хэрэгжүүлэх бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш 15-20 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дотоод, гадаад орчин, түүнд нөлөөлөх орон зайн хүчин зүйлсийн харьцаа, үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийг зохицуулах арга механизм, түүнд оролцох төрийн оролцоо, чиг үүрэг ихээхэн хувьсан өөрчлөгдсөн. Иймээс Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинээр боловсруулах, макро болон микро бүсүүдийг шинэчлэн тогтоох практик шаардлага үүсэж байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулахдаа эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох, бүс нутаг, орон нутаг, салбар хоорондын уялдаа, холбоог нягтруулах, хөрш улсуудын болон бүс нутгийн онцлогтой эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгалийн нөөц, газар нутгийн даац, чадавхыг улс орны эдийн засгийн тогтвортой өсөлт, нутаг дэвсгэрийн харьцангуй тэнцвэрт хөгжлийг хангах зорилгод бүрэн, үр ашигтай ашиглах зарчим шалгуурыг үндэс болгоно.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл нь дараах зарчимд үндэслэсэн болно. Үүнд:

1. үндэсний аюулгүй байдлын;
2. байгаль, эдийн засаг, нийгмийн;
3. улс төр, засаг захиргааны;
4. түүх, нийгэм соёлын;
5. чиг үүргийн (функционал буюу үйлдвэрлэл, үйлчилгээний байршил, төрөлжилт);
6. дэд бүтэц, орон зайн зохион байгуулалтын гэх мэт.


Эдгээр зарчмын үндсэн дээр Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр нь олон улсын хэмжээнд санал болгож буй тогтвортой ба ногоон хөгжлийн суурь шалгуур ба үзүүлэлтийг баримтална.

Зураг 60 Монгол улсын эдийн засгийн макро бүс



Эх сурвалж: ҮХГ 2020

Зураг 61 Монгол улсын эдийн засгийн макро бүс



Эх сурвалж: ҮХГ 2020

3.1.3 Тэргүүлэх болон дэд чиглэлийн үндэслэл

Дэлхийн зах зээл дэх үнийн түвшин тогтвортой байх нөхцөлд суурь хувилбараар хийсэн тооцооллоор манай улсын экспорт 2018-2030 онуудад жилд дунджаар 4.2-6.3, импорт 4.0-6.8 хувиар өсөхөөр байна. Дурдсан хугацааны үргэлжлэлд экспорт 1.71, импорт 1.77 дахин өсөж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр экспорт 13.9 тэрбум ам.долларт, оны үнээр 17.1 тэрбум ам.долларт, импорт 1.77 дахин нэмэгдэж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.4 тэрбум ам.долларт, оны үнээр 14.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гаргасан.

“Ногоон эдийн засаг” хувилбараар 2018-2030 онуудад экспорт жилд дунджаар 4.0-6.8 хувь, импорт жилд дунджаар 4.1-6.3 хувь, дурдсан хугацааны туршид экспорт 1.69 дахин, импорт 1.75 дахин өсөх тооцоо гарч байна. Ийнхүү 2030 он гэхэд манай улсын экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 13.4 тэрбум ам.долларт, оны үнээр 16.9 тэрбум ам.долларт, импорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.3 тэрбум ам.долларт, оны үнээр 14.3 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Харин томоохон төслүүдийг оруулсан тооцоогоор, тэдгээр төслийн нөлөөгөөр экспорт жилд 2.2-31.6 хувь, импорт 3.5-32.9 хувиар өсөж, дурдсан хугацааны туршид экспорт 2.56 дахин, импорт 2.62 дахин өсөх тооцоо гарч байна. 2030 он гэхэд экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 20.1 тэрбум ам.долларт, импорт 16.9 тэрбум ам.долларт, оны үнээр экспорт 25.6 тэрбум ам.долларт, импорт 21.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарсан.

Монгол улсын Засгийн газрын Алсын хараа 2050-д авч үзсэнээр:

- 2020-2030 оны эхний үе шатанд Түүхий эд экспортлогчоос боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч,
- 2031-2040 оны дараагийн үе шатанд Зүүн Хойд Азийн органик хүнс, эрчим хүчний идэвхтэй тоглогч,
- 2041-2050 оны сүүлийн үе шатанд Олон тулгуурт эдийн засагтай Монгол улс болох тэргүүлэх зорилтыг дэвшүүлээд байна.

Эхний үе шатанд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлж:

1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх;
2. ХАА-н бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах болон ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;
3. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх;
4. Бүтээлч аж үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурийг тавих;
5. Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;
6. Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх;
7. Эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх;
8. Хөгжлийг тэтгэх холимог тээврийг хөгжүүлэх;
9. Иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх гэх зэрэг зорилтыг тодорхойлсон.

Дараагийн үе шатанд хүнд, хөнгөн болон эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх үе шат руу шилжиж:

1. Боловсруулах салбар давамгайлсан эдийн засгийн бүтцийг бүрэлдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах;
2. Бүтээлч аж үйлдвэрийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх;
3. Эрчим хүчний эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж, экспортлогч орон болох;
4. Олон улсын стандартад нийцсэн холимог сүлжээ бүрдүүлэх зорилттой.

Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, олон тулгуурт тогтвортой эдийн засагтай улс болох үе буюу 2050 он хүртэл эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэлхийн зах зээл дэх байр суурийг бэхжүүлэх зорилтыг дэвшүүлээд байна.

3.1.4 Говийн дэд бүсийн хөгжлийн институцийн шинэчлэл, тулгарч буй асуудал

Говийн дэд бүсийг хөгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулахад одоо хүчин төгөлдөр байгаа эрхзүйн дор дурдсан үндсэн баримт бичгүүдэд үндэслэсэн. Үүнд:

- 1.) Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;
- 2.) УИХ-аас 2003 оны 5 дугаар сарын 30-нд баталсан "Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль";
- 3.) УИХ-ын 2015 оны 2-р сарын 12-нд баталсан "Чөлөөт бүсийн тухай хууль";
- 4.) Монгол улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын Засгийн газрын 2016-2020 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор засгийн газраас баталсан/ 2018 оны 42 дугаар тогтоол/ "Гурван тулгуурт хөгжлийн бодлого";
- 5.) УИХ-ын, Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай 2007 оны 02-р сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоол;
- 6.) Монгол улс, ОХУ, БНХАУ –ын төрийн тэргүүн нарын 2016 оны 06.23-нд Узбекистаны Ташкентийн уулзалтын үеэр үзэглэсэн Ази, Европыг холбосон гурван улсын "Эдийн засгийн хамтарсан коридор байгуулах хөтөлбөр";
- 7.) "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай" хууль / УИХ-ын 2015 оны 11-р сарын 26-ны өдөр/, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас баталсан /2016 оны 249-р тогтоол/ "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам";
- 8.) Монгол улсын Их Хурлын 2016 оны 19-р тогтоолоор батлагдсан "Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" баримт бичиг.

Бүсийн хөгжил цэцэглэлт суурь бол тогтвортой хөгжил юм. Бүсийн тогтвортой хөгжлийг хангахын тулд ногоон хөгжлийн гол санааг авч үзнэ. Энд байгаль-эдийн засаг, эдийн засаг-нийгэм, нийгэм-байгаль гэсэн харилцан хамаарал чухал үүрэгтэй. Нийгмийн хөгжлийн түүхэн явцад нэг суурь шинжлэх ухааны ололт амжилт нь глобал өөрчлөлтийг танин мэдэхүйц хангалттай бус, мөн хүрэлцээтэй ч биш байгаа юм. Мэдээллийн технологийн өөрчлөлтийн улмаас глобал өөрчлөлтөнд дасан зохицохын тулд хэд хэдэн суурь шинжлэх ухааны огтлолцол дээр хөгжлийн үйл явцыг танин

мэдэх хэрэгтэй болсон. Иймээс эдийн засгийн үйл ажиллагаанд шууд ба шууд бус арга замаар хүчтэй нөлөө үзүүлж буй хүмүүс болон байгууллагуудын үйлдэл, хандлагыг илүү нарийвчлан шинжилж, хөгжлийн бодлогын шийдвэр гаргалтанд ашиглах нь зайлшгүй.

Зураг 62 Говийн дэд бүсийн зорилтот хөтөлбөрийн пирамид



Эх сурвалж: Судалгааны баг, 2020

Говийн дэд бүсийн хөгжлийн институцийн шинэчлэлд гадаад ба дотоод хүчин зүйлс нөлөөлнө. Дотоод хүчин зүйлст Говийн дэд бүсийн нутаг дэвсгэрт тогтвортой ба ногоон хөгжлийн зарчмыг баримтлан үйлдвэрлэл ба хэрэглээг хариуцлагатай байх асуудал, түүнд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг гүнзгийрүүлэн шинжлэх нөхцөл байдал нөлөөлж байна. Гадаад хүчин зүйлст Говийн дэд бүсийн өрсөлдөх давуу талд тулгуурласан санхүү-үйлдвэр-худалдааны урсгал, тэдгээрийг шийдэх арга барил хүчтэй нөлөө үзүүлж байгаа юм. Иймд институцийн шинэчлэл нь байгальд ээлтэй, зах зээлд ээлтэй, нийгэмд хүртээмжтэй байх нөхцөлийг хангахад чиглэх болно.

Байгаль - эдийн засгийн харилцан тогтвортой уялдааг хангасан, эдийн засаг – нийгмийн хүртээмжтэй харилцан үйлчлэлд төвлөрсөн, нийгэм – хүрээлэн буй орчны тэнцвэртэй, тогтвортой шүтэлцээг уялдуулсан соёлын бүтээлч кластерийн хөгжлийн санхүүжилтийг дан ганц Засгийн газрын төсөв, орон нутгийн төсвөөр хангахад хүндрэлтэй. Кластерийн хөгжлийн санхүүжилт нь “Бүсийн хөгжлийн сан”-гийн удирдлагатай байх боломжтой. Энэ бол шинэ тогтолцоо, тиймээс Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн боловсруулах явцад илүү тодорхой болно. Гэсэн хэдий ч говийн дэд бүсэд соёлын бүтээлч кластерийг хөгжүүлэх бол хөгжлийн санхүүжилтийн хувьд хувийн, төрийн, олон нийтийн түншлэлийн хамтарсан санхүүжилт зайлшгүй.

Бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх журамд салбарын хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг илүү нарийвчлан үзүүлэх боломжтой. Гол нь хүрэх үр дүнг хэмжихүйц, үр нөлөө ба үр дагаврыг тодорхойлохуйц, цаг хугацааны хүрээг тодорхой авч үзэхэд чиглэсэн байвал институцийн тогтолцоог нягтаршуулах нөлөөтэй.

Говийн дэд бүсийн талаар урт хугацааны бодлого боловсруулах ажил цаг хугацаа алдаж, хэрэгжилт хангалтгүй болоход дор дурдсан сорилттой тулгарч болзошгүй байна. Үүнд:

- 1.) Хүмүүсийн харилцан ойлголцол, хамтын ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд их цаг хугацаа шаардах говийн аймаг, алслагдсан сумдын хөгжлийн түвшин доогуур, хүмүүсийн зах зээлд өрсөлдөн амьдрах сонирхол, чадвар сул; энэ хутагт ажиллаж байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн харилцан ойлголцол, дэмжлэг хангалтгүй байгаа г.м;
- 2.) Монгол улсын эдийн засаг, нийгмийн хүндрэл, бэрхшээлтэй холбоотой энэ бүсийг хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх хөрөнгө санхүүгийн дэмжлэг сул, харин ч ашигт малтмал, бусад баялгийг ашиглуулснаас авах орлогыг нэмэгдүүлэх эрэлт ихтэй байгаа;
- 3.) Хөдөө аж ахуй, бусад салбарын хөгжил доогуур байгаагаас аймаг орон нутгийн уул уурхайгаас хамаарсан байдал нилээд урт хугацаанд үргэлжилж болзошгүй;
- 4.) Бодит амьдрал дээр үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж, өндөр мэргэшлийн бүтээлч ажиллах хүч бэлтгэн түүхий эдийг гүн боловсруулж, өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргахад олон жил шаардагдаж байгаа;
- 5.) Энэ бүсийн нийт аймагт усны нөөц хомсдолтой, чанар хангалтгүй байгаа, бүтээн байгуулалтыг цаашид өргөжүүлэхэд хэрэгцээтэй усны хэрэгцээг дотроос нь болон бусад нутгаас шийдэхээр яригдаж байгаа төслүүд урьдчилсан хайгуул, үнэлгээний шатанд байгаа бөгөөд тэдгээрийг сонгож, зохистой хэрэгжүүлэхэд их урт хугацаа, хөрөнгө мөнгө шаардах төлөвтэй байгаа;
- 6.) Уул уурхайн олборлолт, уур амьсгалын дулаарал, усны хомсдолоос шалтгаалан говь нутгийн байгаль орчин доройтож, түүнийг нөхөн сэргээхэд улам их хөрөнгө хүч шаардагдаж байгаа. Ялангуяа цөлжилт гүнзгийрч, шороон шуурганы давтамж, хамрах хүрээ тэлж, усны чанар, хомсдолтой нэгдээд хүн ам эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг цаашид хязгаарласаар байна;
- 7.) Говийн дэд бүсийн хөгжилд цаашид зайлшгүй харгалзаж байх нэг томоохон сорилт бол олон улсын зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнийн болзошгүй хэлбэлзэл юм. Экспортын гол бүтээгдэхүүн нүүрс, зэс, түүхий ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ цаашид буурах хандлагатай байгаа бөгөөд эдгээрийг экспортлогч гол орон Хятад улс аль болох түүхийгээр нь хямд авах сонирхолтой байгаа нөхцөлд манай улсын эдийн засаг, төсөв, иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа юм. Иймд, энэ бүс нутгийн гол салбар уул уурхайн үйлдвэрлэлээс орж ирэх орлогыг тухайн аймаг, орон нутаг, нийт улсын хэрэгцээнд нийцүүлэн зохистой хуваарилж, ухаалаг зарцуулах сорилттой тулгарч байна.

Эдгээр сорилтоос үүдээд энэ бүс нутгийн хөгжлийн асуудлаар Засгийн газар, аймаг, орон нутаг, дотоод, гадаадын бусад төрөлжсөн байгууллага, компаниудын зүгээс боловсруулж, дэвшүүлж ирсэн олон чухал хөтөлбөр, төслүүд, тэдгээрт тусгагдсан аймаг дундын салбар хоорондын ач холбогдолтой үйлдвэр барих, усжуулах, дэд бүтэц байгуулах томоохон арга хэмжээнүүд цаг тухайдаа хэрэгжиж чадаагүй, тулгамдсан асуудал болон хуримтлагдаж ирсэн байна.

Сангийн яам, Дэлхийн банк, Үндэсний статистикийн хороо, Үндэсний хөгжлийн газраас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хийсэн Монгол улсын макро эдийн засгийн өсөлтийн төсөөллөөс үндэслэн Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлалыг санал болгож буй 5 дэд бүсийн стратегид тулгуурлан хэрэгжүүлснээр ДНБ энэ бүсэд 2017 онд (Оюутолгойн зэс боловсруулах үйлдвэр, Тавантолгойн нүүрс цэвэршүүлэх үйлдвэр ба эрчим хүч, Дундговийн Тэвшийн говийн эрчим хүчний үйлдвэр, Дорноговийн Алтанширээний газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүдийг ашиглалтанд оруулснаар) 10 гаруй хувиар өсөж байсан бол цаашид 2030

он хүртэл жил бүр 10 – 15 хувиар өсөх боломжтой гэж төсөөллөө. Говийн дэд бүс нь энэ хугацаанд улсын эдийн засгийн өсөлтийн 15-аас (2023 он) 30 хувийг хангах юм.

Дэд бүсийн ДНБ-ий дээр төсөөлж буй өсөлтийн хурдыг хангахын тулд бүс нутгийн хөдөлмөрийн бүтээмжийг 2020 оноос цааш улсын дунджаас дээгүүр байхаар нэмэгдүүлэх шаардлагатай болно. Хөдөлмөрийн бүтээмжийн энэхүү харьцангуй өндөр өсөлтийг хангахын тулд мал аж ахуйн түүхий эдийн бирж, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог эрс шинэчлэн үйлдвэрүүдийг кластерийн бодлогоор дэмжих хэрэгтэй болно. Үүний зэрэгцээ байгалийн эрдсийн баялгийн салбарт орчин үеийн өндөр бүтээмжтэй техник технологи нэвтрүүлэх, олборлолт, анхан шатны боловсруулалтын ажиллагааг механикжуулах, үйлдвэрлэлийн үндсэн болон, туслах, үйлчлэх үйл ажиллагааны бүтээмжийг нийтэд нь сайжруулахыг шаардах болно. Мөн нүүрс, зэс зэрэг эрдсийн баялгийг дан ганц олборлох аргаар буюу байгалийн түүхий эд байдлаар нь гадаадад гаргаж байгааг аль болох багасгаж, 2020 оноос цаашид боловсруулалт хийж, ДНБ-д эзлэх үйлдвэрлэсэн капитал болон нийгмийн цэвэр орлого /хүний болон удирдлагын чадавхиар бүтээгдсэн/-ыг нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй болно. Цаашид үйлдвэрлэсэн жинхэнэ орлогыг тооцохдоо ч хөрс хуулалт, тээвэрлэлтээс үүссэн агаар орчны бохирдол, хөрсний эвдрэлийн хохирлыг тооцож, байгалийн баялгийг үр өгөөжтэй ашиглаж бүтээх, өсгөх, хуримтлуулах менежментийг ААНБ-ын үйл ажиллагаанд тэдгээрийн урт хугацааны зорилтот түвшин болгон хэрэгжүүлэхийг төрийн зохицуулалтын нэг гол чиглэл гэж үзэж байна.

Говийн дэд бүсийн аймгууд хөдөлмөрийн бүтээмж, орлогыг нэмэгдүүлснээр энэ бүс нутгийн төдийгүй тус улсын нийт хүн амын мөнгөн орлого, хуримтлалыг өсгөх боломжтой гэж төсөөлж байна. Энэ бүс нутгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх нийлбэр үзүүлэлтийн нэг нь хүн амын дундаж наслалт улсын дундажтай харьцуулахад өндөр /хамгийн өндөр нь Дундговь аймаг – 2017 онд 73,8, улсын дундаж -69,8/ буюу амьдралын үргэлжлэх хугацаа 2-оос 3 жилээр урт байгаа явдал юм. Төлөвлөлтийн хугацаанд бүс нутгийн нийт аймгийн нийгэм, соёл, ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, тоосжилт, ундны усны чанар, хүнс тэжээлээс хамаарсан өвчлөлтийг багасгаж чадвал хүн амын дундаж наслалтыг 2025 онд 78, 2030 онд 80-д хүргэж, улсын дундажаас илүү буюу хөгжингүй орнуудын дундаж түвшинд ойртуулах боломжтой болно.

Говийн дэд бүсийн аймгуудыг эрчимтэй хөгжүүлэх шаардлагаар уугуул хүн ам, ялангуяа хүүхэд залуучуудыг ажиллуулж, мэргэшүүлэх, бусад аймаг, хотоос ирж буй ажиллах хүчийг тогтвор, суурьшилтай ажиллуулахын тулд 2020 онд 2017 онтой харьцуулахад ажлын байрыг 1.5 дахин, тохилог орон сууцны хангамжийг 20%-иар нэмэгдүүлж, 2030 он хүртэл жил бүр тогтвортой нэмэгдүүлэхээр тооцож байна. Үүний тулд аймгийн төвүүд, тээврийн зангилаа, хилийн боомтуудын хот нийтийн ахуй үйлчилгээний дэд бүтцийг шинэчлэх байгуулах, уул уурхайн томоохон орд газар, тэдгээрийн ойролцоох сууринг тохижуулж, түр сууцуудыг байнгын тохилог орон сууцаар эрэмбэ дараатай солиход оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. 2025 он хүртэлх эхний үе шатанд энэ асуудлыг шийдэх үндсэн чиглэл болгон орон нутгийн элс шохойн чулуу, цементийн үйлдвэрлэлийн хүчин чадалд тулгуурлан дээр дурдсан газруудад инженерийн төвлөрсөн систем бүхий 4-5 давхар тохижсон нийтийн сууцуудыг барьж ашиглах төсөөллийг хийж байна.

3.2 Говийн дэд бүсийн зорилтот хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, гол зорилго ба зорилтууд

2020 он хүртэл өмнөд говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсний дүнд Монгол улсын Говийн бүсэд тэнхлэг даган хөгжих чиг хандлага тогтсон.

2030 он хүртэл Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо байгалийг хүндэтгэн үзэх Монгол уламжлал хийгээд тогтвортой ба ногоон хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан. Үүнээс гадна нөхцөл байдал болон бодлогын шинжилгээний үр дүнд үндэслэвэл 2030 он хүртэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хийгээд говийн байгаль, цаг агаарын нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдөж, эрсдэлтэй бүс нутгийн хэмжээ ихэссэн. Үүнээс гадна байгалийн болон эдийн засгийн нөөцийг өрсөлдөх давуу талдаа тулгуурлан бүрэн гүйцэд, зохистой ашиглаж, кластерийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн дээр говийн онцлог бүхий дэд кластер, нийлүүлэлтийн сүлжээг зах зээлийн өрсөлдөөний стратеги, бодлогоор дэмжин ажиллах нь бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх юм. Энэхүү зорилтот хөтөлбөрт гурван тэргүүлэх чиглэлийг байгаль орчинд ээлтэй, зах зээлд ээлтэй, нийгэмд хүртээмжтэй байдлаар төлөвлөж, энэ хүрээнд тэргүүлэх чиглэл бүрд хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагаа/арга хэмжээг тус тус тусгалаа.

Говийн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахад үндэсний язгуур эрх ашигт нийцсэн, нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, нөөц бололцоонд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, ил тод, нээлттэй, олон нийтийн оролцоог хангасан байх зарчмыг баримталсан.

Монгол Улсын Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн үндсэн зорилго бол говийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, тогтвортой, хариуцлагатай үйлдвэрлэл ба хэрэглээнд хүрэхүйц ажил эрхлэлттэй, дундаж орлогын түвшинд хүрэх бүс нутаг болон хөгжинө.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг 2030 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ: 2021-2025, 2026-2030.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл бол байгаль - эдийн засгийн харилцан тогтвортой уялдааг хангасан, эдийн засаг – нийгмийн хүртээмжтэй харилцан үйлчлэлд төвлөрсөн, нийгэм – хүрээлэн буй орчны тэнцвэртэй, тогтвортой шүтэлцээг уялдуулсан соёлын бүтээлч салбарын кластер байна.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд гурван зорилгыг хэрэгжүүлнэ:

1. Байгаль-эдийн засгийн харилцан тэнцвэртэй, хариуцлагатай уялдааг ханган ажиллах;
2. Эдийн засаг-нийгэмд үнэт зүйлс хамтран бүтээж, хүн амын амьдралын түвшинг ахиулах;
3. Нийгэм-хүрээлэн буй орчинг харилцан тэнцвэртэй, тогтвортой байлгах;

Эдгээрийг гурван зорилгыг харилцан уялдаатай, цогц байдлаар хэрэгжүүлснээр ТХЗ, Ногоон хөгжлийн бодлого, Алсын хараа 2050-ийн үзэл баримтлалыг бодит хөрсөнд буулгах нөхцөл бүрдэнэ.

Дээрх гурван зорилго тус бүрдээ зорилт ба үйл ажиллагаа/арга хэмжээнээс бүрдэж байгаа. Ногоон хөгжлийн хүрээнд Говийн дэд бүсийн суурь асуудал бол усны нөөц тул энд нилээд олон арга хэмжээ төлөвлөгдөхөөр байна.

Байгаль ба эдийн засгийн харилцан тэнцвэртэй, хариуцлагатай үялдааг ханган ажиллах зорилгын хүрэн дэх зорилтууд нь:

1. Говийн бүсийн "Ногоон хөгжил, ногоон эдийн засаг"-ийн удирдамжийг баталж, хэрэгжүүлэх;
2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон говийн бүсийн унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, даацын үнэлгээг шинэчлэн, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;
3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүрээлэн буй орчны мониторинг сүлжээг өргөтгөх, болзошгүй ба тодорхойгүй аюул, гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн тогтолцоотой болох;
4. Говийн бүсийн ландшафтын муж, сав газруудын экосистемийн зүй тогтолд нийцсэн байгаль хамгаалал, ашиглалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх;
5. Говийн онцгой үнэ цэнэ бүхий экосистемүүдийг тусгай хамгаалалтад авах сүлжээг өргөтгөж, газрын нөөцийн ашиглалт хамгаалал, бэлчээрийн менежментийг сайжруулах;
6. Цэнгэг усны нөөцийн хадгалалт, хамгаалал, ус ашиглалтын ухаалаг тогтолцоо бүрдүүлэх;
7. Ашиглалтад бэлтгэгдсэн орд газар болон хэтийн ирээдүй бүхий судалгааны талбайн эрдэс баялаг, нөөцийн ашиглалтын менежментийн шинэлэг тогтолцоо бүрдүүлэх;
8. Бүс нутгийн онцлогт нийцсэн биологийн төрөл зүйлийн хамгаалал, нөхөн сэргээлт, ашиглалтын эрх зүйн зохицуулалтыг баримтлан ажиллах;
9. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хог хаягдлын менежмент, нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх.

Эдийн засаг – нийгэмд үнэт зүйлс хамтран бүтээж, хүн амын амьдралын түвшинг ахиулах зорилгын хүрэн дэх зорилтууд нь:

1. Уламжлалт ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний өрсөлдөх давуу талд тулгуурлан нөөцийн үр ашгийг хангаж, орон нутгийн эрэлт, экспортод чиглүүлэн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах;
2. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олборлолт, боловсруулалтын түвшинг ахиулж, өртгийг өсгөх;
3. Өндөр технологи, инновацид тулгуурласан боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, лаборатори, судалгаа хөгжүүлэлт, шинэ бизнесийг эрчимжүүлэх;
4. Говийн бүсэд тогтвортой аялал жуулчлалын өртгийн сүлжээг соёлын болон бүтээлч үйлдвэрийн салбарын хүрээнд хөгжүүлж, "Монгол говь" маркетингийг хэрэгжүүлэх;
5. Говийн хөгжлийг тэтгэх эдийн засгийн коридор, нэгдсэн дэд бүтэц, логистикийн сүлжээг бэхжүүлэх, бүсийн кластерийн оролцогсдын бизнес эрхлэх зардлыг бууруулах;
6. Дотоод, гадаад худалдааны бараа эргэлтийг хурдасгах, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг олон улсын стандарт, зохицуулалтын түвшинд хүргэх;
7. Бүс нутгийн /гадаад ба дотоод хөрөнгө оруулалт, худалдаа, тээвэр, хил гааль, боомт гэх зэрэг/ хэлэлцээрийг харилцан үр ашигтай, эрх тэгш, тэнцвэртэй хийхэд анхаарал хандуулж, худалдааг хөнгөвчилөх үйл ажиллагааг эрчимжүүлэх;
8. Говийн бүсийн онцлогтой кластерийн эрх зүй, хамтын ажиллагааны институци /Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, санхүүгийн байгууллага, салбарын мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, олон улсын байгууллага/-ийн орчинд оролцогч бүх

талуудын чиг үүргийг уялдуулах механизмыг шинэчлэн тодорхойлж, зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлэх;

9. Санхүүгийн зах зээл/Говийн хөгжлийн сан, тэтгэврийн сан, даатгалын сан, хөрөнгийн сан/-ийг бүсийн кластерийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх.

Нийгэм – хүрээлэн буй орчинг харилцан тэнцвэртэй, тогтвортой байлгах зорилгын хүрэн дэх зорилтууд нь:

1. Бүсийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөжийг сайжруулж, нийгмийн эрүүл мэндийг бататгах;
2. Бүсийн хүн амын насан туршийн боловсролыг дэмжиж, эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх;
3. Үндэсний соёлын дархлааг бүсийн хэмжээнд бэхжүүлэх;
4. Иргэндээ ээлтэй, ил тод, үр ашигтай төрийн үйлчилгээг хүргэж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
5. Бүсийн хүн амын үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнес эрхлэх идэвх санаачилгыг бүх талаар дэмжин, ажилтай орлоготой хүн амын тоог тасралтгүй нэмэгдүүлэх;
6. Бүсийн аймгуудад эдийн засгийн үр ашгийг хангах замаар иргэн бүрт сонголт боломж олгож, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан дундаж давхаргыг нэмэгдүүлж, амьдралын чанарыг сайжруулах;
7. Бүсийн нийгмийн хамгаалал ба халамжийн тогтолцоог зах зээлийн зарчмаар бэхжүүлэх;
8. Бүсийн ахмад үеийнхний туршлагад тулгуурлан мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн боловсрол олгох тогтолцоог боловсронгуй болгох;
9. Нутагшил суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хот суурин газрын хөгжлийг дэмжих, амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлэх.

3.3 Говийн дэд бүсийн зорилтот хөгөлбөрийн зорилтууд ба арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнгийн төсөөлөл

Байгаль - эдийн засгийн харилцан тэнцвэртэй, хариуцлагатай үялдааг ханган ажиллах зорилгын хүрэн дэх зорилтууд ба үйл ажиллагаа

1. Бүсийн "Ногоон хөгжил, ногоон эдийн засаг"-ийн удирдамжийг баталж, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 1.1 Бүсэд ногоон эдийн засгийг дэмжсэн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх;
- 1.2 Бүсийн хэмжээнд байгалийн нөөц, үйлдвэрлэгдсэн нөөц, биет бус нөөц, цэвэр гадаад хуримтлагдсан нөөцийг үйлдвэржилт, аж ахуй эрхлэлтэд үр ашигтай ашиглаж, байгаль орчинд ээлтэй технологийн шийдэл бүхий бүс болох;
- 1.3 Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрт голлон төвлөрч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хог хаягдал багатай үйлдвэрлэл хэрэглээг хөгжүүлэх эдийн засаг /circular economy/ руу шилжихэд бэлтгэх;
- 1.4 Ногоон бизнесийн олон төрлийн загварыг хөгжүүлэх санаачилгыг хэрэгжүүлэх;
- 1.5 Үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог бүсийн хэмжээнд бэхжүүлж, олон улсын санхүүгийн механизмын санхүүжилтийг нэмэгдүүлж үр өгөөжтэй ашиглах, өндөр хөгжилтэй орнуудын зүгээс ногоон худалдаа болон техникийн туслалцааг хэрэгжүүлэх;
- 1.6 Төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтыг нүүрстөрөгчийн ялгарлыг багасгах, нөөц баялгийг хэмнэлттэй ашиглах, эрчим хүч ба усыг хэмнэх, экосистемийн үйлчилгээ ба

биологийн олон янз байдлын алдагдлыг бууруулах, хүн амын орлого, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд зориулах;

1.7 Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх;

1.8 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлэн дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх;

1.9 Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан үндэсний ногоон хөгжлийг дэмжин олон улсын санхүүгийн механизмыг ашиглан байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх;

2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон говийн бүсийн унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, даацын үнэлгээг шинэчлэн, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

2.1 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон цөлжилтгүй бүс нутгийн үзэл санааг олон нийтэд дэлгэрүүлэх;

2.2 Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадавхийг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах сантай болох;

2.3 Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах;

2.4 Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх;

2.5 Генетик нөөц, түүнтэй холбоотой мэдлэгийн судалгаа хийж бүртгэлжүүлэх, нөөц тогтоох, бүртгэл мэдээллийн цахим сан бүрдүүлэх;

2.6 Уур амьсгалын ажиглалтын сүлжээг өргөтгөх, технологийн шинэчлэл хийх, судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;

2.7 Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг салбаруудын дасан зохицох үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах (эрүүл мэнд, мал аж ахуй, газар тариалан, усны нөөц, хангамж зэрэг);

2.8 Орон нутаг, бүс нутгийн хэмжээнд агаар мандлыг хамгаалах, түүнд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах чиглэлээр шинэ техник-технологийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх;

2.9 Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх;

3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүрээлэн буй орчны мониторинг сүлжээг өргөтгөх, болзошгүй ба тодорхойгүй аюул, гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн тогтолцоотой болох зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

3.1 ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр, логистикийн нөхцөл боломж, цаг агаарын аюулаас амжиж анхааруулах мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэж, бэлэн байдлаа хангах боломж бүрдүүлдэг орон нутгийн мэдээллийн эргэх холбоо бүхий цогцолборыг эдийн засгийн микро бүсийн төвүүд болон зарим сумдад байгуулах;

3.2 Цаг агаарын аюулт үзэгдлийг илрүүлэх Доплерийн радарын станц байгуулах /Өмнөговь/;

3.3 Агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээ, цаг уурын ажиглалтын сүлжээг өргөжүүлж, автоматжуулах;

3.4 Байгаль, цаг уурын онц аюултай үзэгдлийг урьдчилан тооцоолох, олон нийтэд мэдээлэх чиглэлээр аймаг, сумдын цаг уурын албаны чадавхийг дээшлүүлэх;

3.5 Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх;

3.6 Байгалийн гамшиг тохиолдсон үед хохирлыг зохих хэмжээгээр арилгах зорилгоор байгууллага, иргэдийг эд хөрөнгө, амь насны даатгалд хамруулах ажлыг сайжруулах;

3.7 Гамшгаас хамгаалах тухай болон холбогдох зарим хуулийг дагаж мөрдөн гамшгаас хамгаалах бүтцийг боловсронгуй болгож, олон нийтэд тулгуурласан гамшгийн менежментийг хөгжүүлэх;

3.8 Гамшгийн мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг боловсронгуй болгож мэдээллийн нэгдсэн сан байгуулах;

3.9 Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээг хүлээн авах, хэрэглэх, гамшгаас сэргийлэн хамгаалах бэлтгэлийг урьдчилан хангах арга ажиллагаанд нийт хүн ам, ялангуяа хөдөөгийн иргэдийг сургах, багаж хэрэгслээр хангах ажлыг сайжруулах;

4. Говийн бүсийн ландшафтын муж, сав газруудын экосистемийн зүй тогтолд нийцсэн байгаль хамгаалал, ашиглалтын эрх зүйн зохицуулалтыг баримтлан ажиллах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

4.1 Говийн бүсийг ойжуулах говийн ногоон хэрэм төсөл хэрэгжүүлэх;

4.2 Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлэх;

4.3 Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх;

4.4 Уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, хот байгуулалт, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгож эргэлтэд оруулах, ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлэх;

4.5 Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангахад чухал нөлөө үзүүлэх зарим газар нутгийг улсын болон орон нутгийн хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах;

4.6 Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангах;

4.7 Экосистемийн үйлчилгээг үнэлэх зохицуулалтыг боловсронгуй болгож үнэлэх, экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэх, экосистемийн үйлчилгээ, түүний үнэ цэнэ, ач холбогдлыг олон нийтэд таниулах;

4.8 Цөлжилт, хөрсний эвдрэл үүсэж байгаа, бэлчээрийн даац хэтэрсэн газарт ногоон бүс, ойн зурвас байгуулах, газрын хөрсийг нөхөн сэргээх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар байгаль орчны доройтлыг сааруулах;

4.9 Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлэх;

5. Говийн онцгой үнэ цэнэ бүхий экосистемүүдийг тусгай хамгаалалтад авах сүлжээг өргөтгөж, газрын нөөцийн ашиглалт хамгаалал, бэлчээрийн менежментийг сайжруулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

5.1 Экосистемийн үйлчилгээний нэгдмэл, харилцан үйлчлэх байдлыг хангах;

- 5.2 Газрын нөөцийн ашиглалт хамгаалал, бэлчээрийн менежментийг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр үйл ажиллагаа хэрэгжүүлэх;
 - 5.3 Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулах;
 - 5.4 Бүсийн аймаг, сум бүрийн нутаг дэвсгэрийн газрын төлөв, чанарын хянан баталгааны дүгнэлтийг мэргэжлийн байгууллагуудаар гаргуулж, салбарын хөгжил байршлын төлөвлөлтийг системчилэх;
 - 5.5 Ашигт малтмалыг ашиглахаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагуудаар хийлгүүлж, экологийн хувьд эмзэг газрын нөөцийн ашиглалтыг хязгаарлах;
 - 5.6 Малыг өсгөх, үүлдэр угсааг сайжруулах зорилтуудыг бэлчээрийн даац, ус, тэжээлийн хангамж зэрэгтэй уялдуулан оновчтой төлөвлөлт, арга механизмыг боловсронгуй болгох;
 - 5.7 Худаг ус гаргах ажлыг сайжруулах замаар бэлчээрийг усжуулж, бэлчээр ашиглалтад эдийн засгийн оновчтой хөшүүргүүдийг хэрэглэх;
 - 5.8 Бэлчээрийн талхагдал, хөрсний эвдрэлийг хөрс хамгаалах дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, байгаль орчинд хоргүй бордоог хэрэглэж эхлэх;
 - 5.9 Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайд олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд шилжүүлэх, тэжээлийн болон эмийн ургамал тариалах;
- 6. Цэнгэг усны нөөцийн хадгалалт, хамгаалал, ус ашиглалтын ухаалаг тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:**
- 6.1 Говийн ус ашиглалт, ухаалаг усны менежмент бүхий бүс нутаг болох;
 - 6.2 Гидрогеологийн 1:200000 дунд масштабын зураглал, хот суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөцийн хайгуул судалгаа /Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр/ хийх;
 - 6.3 Усны нөөцийг хуримтлуулах Хөх морь төсөл /урсацын тохируулгатай усан сангууд/, Хөх сувд төсөл /хөв цөөрмүүд/ хэрэгжүүлэх;
 - 6.4 Говийн баян бүрдүүдийг хамгаалж, нөхөн сэргээх;
 - 6.5 Говийн бүсийн уул уурхайн төслүүдэд үйлдвэрийн технологийн ус нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх /Дундговь, Өмнөговь аймаг/;
 - 6.6 Говь, хээрийн бүсэд газрын доорх усны ордын орчимд үерийн усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэх цөөрөм байгуулах замаар усны нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх арга технологи нэвтрүүлэх;
 - 6.7 Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаалах;
 - 6.8 Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулах, усыг хуримтлуулах, нөөцийг арвижуулахад чиглэсэн олон төрлийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх;
 - 6.9 Хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлэх;

- 6.10 Хөв цөөрөм, урсацын тохируулгатай усан сан, ус нөөцлөх, дамжуулах далд систем байгуулах ажлыг эрчимжүүлж усны хуримтлалыг нэмэгдүүлэх;
- 6.11 Инженерийн хийцтэй уст цэгийг засварлах, шинээр гаргах ажлыг жил бүрийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, бэлчээр усжуулалтын түвшинг дээшлүүлэх;
- 6.12 Төвлөрсөн усан хангамжийн системийн шугам сүлжээнд усны алдагдал гаргахгүй байх, суурин газрын усны зарцуулалтыг тоолууржуулах, гэр хорооллын усан хангамжийг сайжруулах;

7. Ашиглалтад бэлтгэгдсэн орд газар болон хэтийн ирээдүй бүхий судалгааны талбайн эрдэс баялаг, нөөцийн ашиглалтын менежментийн шинэлэг тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 7.1 Бүсийн УТХГН-ын тогтолцоо, геологийн тогтоц, палентологийн өвийг хамгаалах системийг бүрдүүлэх;
- 7.2 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлэх;
- 7.3 Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулах эрх зүйн зохицуулалтыг хүчтэй болгох;
- 7.4 Бүсийн уул уурхайн үйл ажиллагаанд байгаль болон зах зээлтэй техник, технологи, инноваци нэвтрүүлэхийг дэмжин ногоон эдийн засгийн үзэл баримтлалд нийцүүлэн ажиллах;
- 7.5 Орон нутгийн нүүрсний уурхайнуудын техник, технологи, инноваци шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөдөө орон нутгийн түлшний хангамжийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 7.6 Ашигт малтмалыг ашиглахаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, газрын төлөв байдал чанрын хянан баталгааг эрх бүхий байгууллагуудаар хийлгүүлж, экологийн хувьд эмзэг газрын нөөцийн ашиглалтыг хязгаарлах;
- 7.7 Оюутолгой, Цагаансуварга, Тавантолгойн зэрэг ашигт малтмалын томоохон орд газруудыг түшиглэн уул уурхайн аж үйлдвэрийг, мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалт бүхий боловсруулах үйлдвэрийг тус тус түргэн хурдацтай хөгжүүлэх;
- 7.8 Аймгуудын нутаг дэвсгэрт илэрсэн ашигт малтмалуудын нөөцийг нарийвчлан тогтоож байгаль орчинд халгүй арга технологээр ашиглах, лиценз олголтыг оновчтой олгох;
- 7.9 Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан гадаргын болон газрын доорх усны экосистем доройтох, бэлчээр хомсдох зэрэг сөрөг нөлөөллийг багасгах;

8. Бүс нутгийн онцлогт нийцсэн биологийн төрөл зүйлийн хамгаалал, нөхөн сэргээлт, ашиглалтын тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 8.1 Олон талт байгаль хамгааллын менежмент, техник технологийн хөгжлийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигтай байдлыг хангах;

- 8.2 Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлэх;
- 8.3 Сум бүрийн газар ашиглалтын төлөвлөлтөд биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах асуудлыг тусгаж хэвшүүлэх;
- 8.4 Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авч, агнах, ашиглахыг тодорхой хугацаагаар түр хориглох хүртэл арга хэмжээ авах;
- 8.5 Бүсийн амьтан, ургамал, ой, бичил биетний мэдээллийн санг бүрдүүлэх;
- 8.6 Мазаалай, хандгай, буга, тарвага, аргаль, угалз, янгир, ирвэс, минж, булга, хар сүүлт, гахай, зээр зэрэг ан амьтныг хууль бусаар агнах, зөвшөөрөлгүй загас барих, эмийн ургамлыг ашиглах явдалтай хийх тэмцлийг эрчимжүүлэх;
- 8.7 Биологийн төрөл, зүйлийг ашигласны төлбөрийн тодорхой хувийг тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах;
- 8.8 Байгаль орчны доройтлоос сэргийлэх, ховор болон нэн ховор биологийн төрөл, зүйлийг хамгаалах, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдол бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах;
- 8.9 Зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнах, барих, байгалийн ургамал ашиглах зэрэгт тавих хяналтыг чангатгах, ховордсон болон устаж болзошгүй амьтан ургамлыг хамгаалахад биотехникийн арга хэрэглэх;

9. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хог хаягдлын менежмент, нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 9.1 Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж, бүсийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- 9.2 Хог хаягдлын зориулалтын ландфиллийн байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламжийг төлөвлөн байгуулах;
- 9.3 Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хүн амыг хангах;
- 9.4 Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль орчинд хоргүй, өндөр үр ашигтай, дэвшилтэт техник, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бохирдуулагч эх үүсвэрүүдийг шүүлтүүрийн төхөөрөмжтэй болгох, шаталт сайтай зуух, түлшийг өргөн хэрэглэх, хог хаягдлыг дахин ашиглах, хот, суурин газрын хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулж зүлэгжүүлэх зэрэг ажлыг дэс дараатай хийж хэвшүүлэх;
- 9.5 Бүсийн аймгийн төвүүдэд хог хаягдал ялган боловсруулах жижиг үйлдвэрийг байгуулах;
- 9.6 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлэх, дахин боловсруулах, эрчим хүч гаргах байгаль орчинд халгүй үйлдвэрийг байгуулах;
- 9.7 Химийн хорт болон аюултай бодисын бүртгэх, шилжилт хөдөлгөөнийг хянах, мөшгөх бүртгэл, мэдээллийн цахим системийг бий болгож хөгжүүлэх
- 9.8 Барилга, зам, тээврийн салбарын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.
- 9.9 Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, байгальд халгүй аргаар устгах технологи,

менежмент нэвтрүүлэх; хот суурин газрууд хог хаягдлын зориулалтын байгууламжтай болох;

Эдийн засаг – нийгэмд үнэт зүйлс хамтран бүтээж, хүн амын амьдралын түвшинг ахиулах зорилгын хүрэн дэх зорилтууд ба үйл ажиллагаа

1. Уламжлалт ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний өрсөлдөх давуу талд тулгуурлан нөөцийн үр ашгийг хангаж, орон нутгийн эрэлт, экспортод чиглүүлэн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 1.1. Бүсийн хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдааны эрх зүйн орчинг сайжруулж, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- 1.2. Бүсийн ХАА-н нийлүүлэлтийн сүлжээний анхан шатны үйл ажиллагаанд судалгаа хөгжүүлэлт, боловсруулалт, технологи, дамжуулалт, инновацид түшиглэн хөгжүүлэх стратегийн зураглалыг гаргаж, кластерийн бодлогыг хэрэгжүүлэх;
- 1.3. Бүсийн хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний дэмжих үйл ажиллагааны чиг үүргийг тодорхой гаргах;
- 1.4. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн парк”-ийг байгуулж, бүсийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг ажиллуулах эдийн засгийн эрх зүйн шинэчлэл хийх;
- 1.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл – өртгийн сүлжээний холбогдох шат дамжлагад зохистой дадлыг нэвтрүүлж, хэрэгжилтэд үндэслэн өрсөлдөөний бодлогоор дэмжих;
- 1.6. Бүсийн хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний хүний нөөцийг ХАА-н салбарын ААН-үүдийн захиалгаар бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог мэргэжлийн байгууллагуудад түшиглэн чадавхижуулах;
- 1.7. Аймгийн бичил, жижиг, дунд үйлдвэрийг ХАА-хүнс-аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ рүү татаж, холбогдох салбаруудын тогтвортой үйл ажиллагааг хангах;
- 1.8. Бүсийн хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний стратегийг бусад бүс нутаг болон үндэсний түвшний ХАА-н нийлүүлэлтийн сүлжээтэй уялдуулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн завсрын үнэлгээг 2 жил тутамд хийж, үр дүнг салбарын хөгжлийн бодлогын шийдвэр гаргалтад ашиглах;
- 1.9. Бүсийн хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг аймаг бүр хүртэж буй эсэхийг жил бүр үнэлж, төсвийн төсөлд холбогдох асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;

2. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олборлолт, боловсруулалтын түвшинг ахиулж, өртгийг өсгөх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 2.1. Усны нөөцийг нарийвчлан тогтоож, уул уурхай болон газрын тосны үйлдвэрлэлд ашиглах, дахин ашиглах усны хангамжийн нэмэлт эх үүсвэрийг шийдвэрлэх;
- 2.2. Шинжлэх ухаан – үйлдвэрлэл, үйлчилгээ – сургалтын оновчтой бүтцэд суурилан уул уурхай, газрын тосны салбарын хүний нөөцийг байнга, тасралтгүй чадавхижуулан хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг олон улсын жишигт нийцүүлэн бүрэн нэвтрүүлэх;

- 2.3. Томоохон ордуудын дэд бүтцийг сайжруулах ажлыг нийгмийн түншлэлийн үндсэн дээр хэрэгжүүлэх;
- 2.4. Баяжуулах болон боловсруулах үйлдвэрийн үр өгөөжийг нэмэгдүүлж, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг цогц байдлаар хэрэгжүүлэн эдийн засаг-нийгэм-экологийн нэгдмэл байдлыг хангах;
- 2.5. Уламжлалт ба уламжлалт бус газрын тосны эрэл хайгуул, олборлолт, ашиглалтын түвшинг олон улсын стандарт, зохицуулалтын түвшинд хүргэх;
- 2.6. Эрчим хүчний нэмэлт эх үүсвэрийг нүүрсний ордуудад түшиглэн нэмэгдүүлж цахилгаан станц байгуулах;
- 2.7. Геологи, эрэл хайгуул, ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг бүсэд хэрэгжүүлэн геологийн мэдээллийн санг үүсгэж, иргэд, олон нийт, байгууллагыг ил тод, ойлгомжтой мэдээллээр хангах боломж бүрдүүлэх;
- 2.8. Уул уурхай, газрын тосны салбарын төрөлжсөн бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхижуулан орон нутгийн эдийн засгийн үр ашгийг тогтмол дээшлүүлэх;
- 2.9. АМНАТ-ын 30 хувийг “Бүсийн хөгжлийн сан”-д төвлөрүүлэн хуримтлуулж, болзошгүй эрсдэл, шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлт, боловсруулалт, туршилтад зориулан үр дүнг салбарын үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

3. Өндөр технологи, инновацид тулгуурласан боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, лаборатори, судалгаа хөгжүүлэлт, шинэ бизнесийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 3.1. Говийн бүсэд инновацид суурилсан аж үйлдвэр, үйлчилгээний кластерийн өртгийн сүлжээний анхан шатны үйл ажиллагаанд том компаниудыг зөөлөн дэд бүтцийн зохицуулалтаар дэмжих;
- 3.2. Бүсийн онцлог экспортын бүтээгдэхүүний өртгийн сүлжээнд шинжлэх ухааны үйлдвэр /шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлт, боловсруулалт, туршилт/-ийг идэвхжүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах;
- 3.3. Уламжлалт бичил, жижиг, дунд үйлдвэр, бизнест бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа, зохион байгуулалт, маркетингийн инновацийг нутагшуулж дэлгэрүүлэх;
- 3.4. Уламжлалт салбарт зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, ус хангамж зэрэг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийн үр ашгийг хангах, үйлдвэрлэл, тээвэрлэлт, логистикийн коридорыг хөгжлийн таталцлын бүстэй холбох;
- 3.5. Уламжлалт кластерт орон зайн конверчилсон, бүтэцлэг тогтолцоог хадгалах ба инновацийн кластертай хоршин ажиллах худалдаа, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн эрх зүйн тогтолцоог шинэчлэн боловсруулах;
- 3.6. Хот, бичил бүсийн тулгуур төвүүдийн үүрэг, бүтэц, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, орон нутгийн онцлог бүхий нөөцийг илрүүлэн ашиглах, боловсруулах чиглэлээр шинжлэх ухааны шинэ мэдлэг бүтээх, мэдлэг илүү шингэх салбарт хөрөнгө оруулалт хийх;
- 3.7. Инновацийн ба уламжлалт кластерийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, чадавхижуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
- 3.8. Бүсийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өртгийн сүлжээний анхан шатны үйл ажиллагааны шат дамжлага бүрт нийцэх экспортын стандарт, зохицуулалтыг зардал багатайгаар нэвтрүүлэх;
- 3.9. Европын худалдааны бүсэд нэгдэх талаарх платформын бэлтгэл ажлыг эхлүүлэх;

4. Говийн бүсэд тогтвортой аялал жуулчлалын өртгийн сүлжээг соёлын болон бүтээлч үйлдвэрийн салбарын хүрээнд хөгжүүлж, "Монгол говь" маркетингийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 4.1. Бүсийн байгаль, газар зүй, түүх, соёлын өв, нүүдэлчин ахуйн этно шинжлэх ухааныг орчин үеийн шинжлэх ухааны шинэ мэдлэгээр баяжуулан хөгжүүлж, бүсийн байгаль, нөөц, нийгэм, соёл, эдийн засгийн даацыг зохистой ашиглах;
- 4.2. Тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлж, бүсийн байгаль, нийгэм, соёл, эдийн засгийн нөөцийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх;
- 4.3. Соёлын болон бүтээлч үйлдвэрийн салбарын кластерийг хөгжүүлэх стратегид нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх;
- 4.4. Бүсийн бүтээлч соёлын салбарын өртгийн сүлжээний анхан шатны үйл ажиллагааны шат дамжлага бүрт аялал жуулчлалын стандарт, зохицуулалтыг нэвтрүүлж, үйлчлүүлэгчдийг татах өөрийн өвөрмөц онцлог ялгарал бүхий эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;
- 4.5. Бүсийн бүтээлч соёлын салбарын хүний нөөцийг шат дараалалтай бэлдэж, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжлийн ур чадварыг олон улсын түвшинд өрсөлдөхүйц болгох;
- 4.6. Сонгосон аймгийн автозам дагуух үйлчилгээний цогцолбор, дамжин өнгөрөх цэг болон зорих газрын менежмент, маркетингийг дотоод ба гадаад зах зээл рүү чиглүүлэн тухайн байршлаар төрөлжүүлэх;
- 4.7. Соёлын болон бүтээлч үйлдвэрийн салбарын кластерийн дэмжих үйл ажиллагааг анхан шатны үйл ажиллагаатай нягт уялдуулан нийгмийн түншлэлийн зарчмаар ажиллах;
- 4.8. Соёлын болон бүтээлч үйлдвэрийн салбарын кластерт инноваци, шинэ технологийн нэвтрэлтийг хөхүүлэн дэмжиж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;
- 4.9. Бүсийн аялал жуулчлалын дагуул ба туслах дансыг нэвтрүүлж, аялал жуулчлалын статистик мэдээ, мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;

5. Говийн хөгжлийг тэтгэх эдийн засгийн коридор, нэгдсэн дэд бүтэц, логистикийн сүлжээг бэхжүүлэх, бүсийн кластерийн оролцогсдын бизнес эрхлэх зардлыг бууруулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 5.1. Замын-Үүд чөлөөт бүсийн хот байгуулалтын төслийг хэрэгжүүлэхдээ бүсэд төрөлжүүлэх кластерийн тээвэр, худалдаа, логистикийн урсгалыг чөлөөтэй нэвтрэх нөхцөлөөр хангах;
- 5.2. Аймгийн эдийн засгийн үр ашигт, өрсөлдөх давуу талд тулгуурлан бүсийн эдийн засгийн коридорын тээвэр, худалдаа, логистикийн сүлжээнд холбох;
- 5.3. Бүсийн эдийн засгийн коридорт урт хугацаанд жигд, тогтвортой, найдвартай экспорт хийх хатуу болон зөөлөн дэд бүтцийн төлөвлөлттэй уялдуулах;
- 5.4. Бүс болон бичил бүсийн төвд орон нутгийн хүн амын хүнсний хэрэгцээг жилийн туршид жигд хангах, хүн амыг хэрэгцээт бүх төрлийн хүнсээр тогтмол, найдвартай хангах худалдааны тогтолцоог бүрдүүлэх;
- 5.5. Бүс болон бичил бүсийн төвд орон нутгийн болон бүс, үндэсний хэмжээнд хүнс, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хэрэгцээг жилийн туршид жигд хангах логистикийн сүлжээнд мэдээлэл, инноваци, технологид зохистой дадлыг хэрэгжүүлэх;

- 5.6. Бүсийн эдийн засгийн коридорт төрийн болон хувийн хөрөнгө оруулалтыг нийгмийн түншлэлээр байгуулах ажлыг эхлүүлж, олон улсын болон донор байгууллагуудын дэмжлэгийг системтэй хэрэгжүүлэх;
- 5.7. Бүсийн хэмжээнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шууд худалдаа - интернетээр борлуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, худалдааны урсгалыг нэмэгдүүлэх;
- 5.8. Ногоон зээл, ногоон худалдааны бодлогоор дамжуулан хаягдал, бохирдолгүй цэвэр үйлдвэрлэлийн технологийг боловсруулах үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 5.9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих бүс, байршлыг тогтоож, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, тээвэр логистик, мэдээллийн сүлжээний дэд бүтцийг уялдуулж хөгжүүлэх;

6. Дотоод, гадаад худалдааны бараа эргэлтийг хурдасгах, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг олон улсын стандарт, зохицуулалтын түвшинд хүргэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 6.1. Бүсийн хилийн хяналт, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичиг, дүрэм журмыг хялбаршуулах, уялдуулах талаар БНХАУ-тай хамтран ажиллах;
- 6.2. БНХАУ-тай худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, далайн боомтыг нь ашиглах, нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- 6.3. Бүсийн экспортыг өсгөхдөө худалдааны тэргүүлэгч орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжыг судлах;
- 6.4. Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд худалдаа, тээврийг хөнгөвчлөх бүсийн гадаад худалдааны бодлогыг шинэчлэн боловсруулах;
- 6.5. Бүсийн гадаад худалдааг төрөлжсөн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх замаар экспортын бүтээгдэхүүнийг үнэгүйдлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 6.6. Бүсийн гаалийн тусгай нутаг дэвсгэрт хийгдэх хөрөнгө оруулалтыг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх;
- 6.7. Бүсээс экспортлох хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг Гаалийн уялдуулан кодчилсон барааны ангиллын дагуу бүртгэж, экспортын мэдээллийг ил тод, нээлттэй болгох;
- 6.8. Гадаадын зах зээлд экспортлох боломжтой программ болон техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- 6.9. Бүсээс экспортлох хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх;

7. Бүс нутгийн /гадаад ба дотоод хөрөнгө оруулалт, худалдаа, тээвэр, хил гааль, боомт гэх зэрэг/ хэлэлцээрийг харилцан үр ашигтай, эрх тэгш, тэнцвэртэй хийхэд анхаарал хандуулж, худалдааг хөнгөвчилөх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 7.1. Бүсийн бизнесийн чадавхитай жижиг, дунд үйлдвэрийг бүс нутгийн тээвэр, худалдаа, дэд бүтцийн эдийн засгийн интеграцид нэгдэж, гадаад худалдааны бодлогоор бүсийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах;
- 7.2. Бүсийн бизнесийн чадавхитай жижиг, дунд үйлдвэрийг бүс нутгийн тээвэр, худалдаа, дэд бүтцийн нэгдмэл кодчиллыг олон улсын аргачлалын дагуу нэвтрүүлэх;

- 7.3. Бүсийн бизнесийн чадавхитай жижиг, дунд үйлдвэрийн нийлүүлэлтийн сүлжээг Дэлхийн худалдааны байгууллага болон Европын холбооны стандарт, зохицуулалтын дагуу бэхжүүлэх;
 - 7.4. Бүсийн бизнесийн чадавхитай жижиг, дунд үйлдвэрийн нийлүүлэлтийн сүлжээг БНХАУ-ын худалдааны hub руу татагдан орох бэлтгэл ажлыг эхлүүлэх;
 - 7.5. Бүсийн нийлүүлэлтийн сүлжээнд гадаадын шууд хөрөнгө оруулалт, инноваци, технологи нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
 - 7.6. Улс орны эрчим хүчний аюулгүй байдалд нөлөөлөхүйц том чадлын болон стратегийн ач холбогдол бүхий эрчим хүчний эх үүсвэрүүд барих ажлыг эхлүүлэх;
 - 7.7. Шударга бус худалдааны нөхцөл байдлыг тодорхойлж, худалдааны эрх зүйн орчинд шинэчлэл явуулж, худалдааны урсгалыг тогтвортой нэмэгдүүлэх;
 - 7.8. ААН-үүдийн өрсөлдөөнийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - 7.9. Бүсээс экспортлох хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- 8. Говийн бүсийн онцлогтой кластерийн эрх зүй, хамтын ажиллагааны институци /Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, санхүүгийн байгууллага, салбарын мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, олон улсын байгууллага/-ийн орчинд оролцогч бүх талуудын чиг үүргийг уялдуулах механизмыг шинэчлэн тодорхойлж, зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:**
- 8.1. Говийн бүсийн кластерийн меморандум байгуулах;
 - 8.2. Говийн бүсийн кластерийн бодлого, экспертийн зөвлөл байгуулж, бүсийн ногоон хөгжил/ногоон худалдааны стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн тогтолцоог зөвшилцөх;
 - 8.3. Говийн бүсийн кластерийн төвийг байгуулж, кластерийн өртгийн сүлжээний мэдээллийн санг бүрдүүлж, хэрэглэх;
 - 8.4. Бүсийн кластерийн (ногоон) худалдаа, дэд бүтцийн бодлого болон эрх зүйн зохицуулалтын тэнцвэртэй байдлыг хадгалах судалгаа хөгжүүлэлт, боловсруулалт, туршилт, дамжуулалт, нэвтрүүлэлтийг дэмжих;
 - 8.5. Бүсийн уламжлалт болон орчин үеийн салбарын стратегийн хослолыг ханган өртгийн сүлжээний манлайлагчдыг бэлтгэн, бусад бүсийн кластерийн манлайлагчидтай сүлжээ үүсгэн ажиллах;
 - 8.6. Бүсийн худалдааны кластерийг олон улсын худалдааны таатай нөхцөлөөр хангах;
 - 8.7. Бүсийн кластерийн орчинд компаниуд нэгдэн нийлэх зэрэг өрсөлдөөний орчны зохицуулалтыг ханган ажиллах;
 - 8.8. Бүсийн кластерийн орчинд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах стратеги, бодлого, хөтөлбөр, төслийг бүсийн хувийн хэвшлийн том компаниудтай зөвшилцөж шийдвэрлэх;
 - 8.9. Бүсийн нийгмийн ба нийтийн хөрөнгө оруулалтыг хамгийн бага үр өгөөжийн түвшинд байлгах;
- 9. Санхүүгийн зах зээл/Говийн хөгжлийн сан, тэтгэврийн сан, даатгалын сан, хөрөнгийн сан/-ийг бүсийн кластерийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:**
- 9.1. Бүсэд санхүүгийн салбарын тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх;

- 9.2. Стратегийн ордод үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг санхүүгийн арга хэрэгсэлд тулгуурлан удирдах;
- 9.3. Стратегийн ордын АМНАТ-ын орлогоос татан төвлөрүүлэн бүсийн хөгжлийн сан байгуулж, баялгийн сангийн зарчимд тулгуурласан мэргэжлийн санхүүгийн байгууллагаар удирдуулах;
- 9.4. Бүсийн баялгийн сангийн стратеги, санг өсгөх хувийг УИХ-аар батлуулах;
- 9.5. Бүсийн экспортын бүтээгдэхүүний санхүүжилт, батлан даалт, даатгалын тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- 9.6. Бүсийн үйлдвэрлэлийн салбарын нийлүүлэлтийн сүлжээг дэмжих хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлэх;
- 9.7. Бүсийн уламжлалт салбарын нийлүүлэлтийн сүлжээнд банкны салбарыг татан оролцуулж, өртгийн сүлжээний санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээгээр кластерийн оролцогсдыг дэмжих;
- 9.8. Олон тулгууртай даатгалын салбарыг хөгжүүлэх;
- 9.9. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

Нийгэм – хүрээлэн буй орчинг харилцан тэнцвэртэй, тогтвортой байлгах зорилгын хүрээнд хэрэгжүүлэх зорилтууд ба үйл ажиллагаа

1. Бүсийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөжийг сайжруулж, нийгмийн эрүүл мэндийг бататгах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 1.1. Хүн амын эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал зуршилд дэмжлэг үзүүлж, иргэний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, санхүүгийн эрсдэлээс хамгаалсан эрүүл мэндийн даатгалын тогтолцоо бүрдүүлэх;
- 1.2. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах тусламж, үйлчилгээний тогтвортой, оновчтой бүтцийг тогтоох, гэнэтийн аюул, байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт гэх мэт нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлэх;
- 1.3. Хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, оношлогоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 1.4. Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд төвлөрч, өртөг үнэ бүрдэлтэд эрс өөрчлөлт хийх;
- 1.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо бүрдүүлэх;
- 1.6. Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг гаргаж, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн төвийг байгуулах, энэ чиглэлд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оролцоог хангах;
- 1.7. Эрүүл мэндийн салбарт нотолгоонд суурилсан орчин үеийн оношлогоо, эмчилгээний техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх;
- 1.8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төлөвлөх, сургах, зохистой ажлын байрны нөхцөлөөр хангах, ур чадвар, туршлагыг бэхжүүлэн нийгмийн хамгааллыг сайжруулах;
- 1.9. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

2. Бүсийн хүн амын насан туршийн боловсролыг дэмжиж, эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 2.1. Бүсийн боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагыг аж үйлдвэрийн IV хувьсгалын шинэчлэлд нийцүүлэн хэрэгжүүлэх;
- 2.2. Иргэдийн боловсролоо байнга, тасралтгүй дээшлүүлэх хэрэгцээг нь тандан судалж, цаашид тэдний хэрэгцээнд нийцсэн насан туршийн боловсролын тогтолцоог төлөвлөх, хөгжүүлэх стратеги, арга зам, сургалтын чиглэл хөтөлбөр, агуулгыг тодорхойлон боловсруулах;
- 2.3. Бүх шатны боловсрол сургалтын байгууллагын байршил, хүчин чадал, нөөц, нормативын нэгдсэн зураглал, судалгаа, шинжилгээний мэдээллийн санг эрхлэн хөтөлж, судалгаа, нотолгоо, үр дүнд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог сайжруулах;
- 2.4. Боловсролын салбарын хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлж, чадварт суурилсан мерит зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох боломжийг нээлттэй, ойлгомжтой болгох, салбарын хүний нөөцийн жендерийн тэгш байдлыг хангах, хөдөө орон нутагт очиж ажиллах хүний нөөцийг орон байраар хангах зэрэг арга хэмжээ авах;
- 2.5. Иргэн бүрд насан туршийн чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн тэгш хамруулж, ургийн үеэс эхлэн монгол хүний насны онцлогт тохирсон эрүүл мэнд-бие бялдар, боловсрол-эх оронч хүмүүжил олгоход чиглүүлэн, бүх шатны боловсролын залгамж холбоог ханган ажиллах;
- 2.6. Зах хязгаар нутгийн болон малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжийг нээлттэй бүрдүүлэн тэгш хамруулах;
- 2.7. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын агуулгыг орон нутгийн онцлог, суралцагсдын хэрэгцээ, нас, сэтгэхүйн онцлогт нь нийцүүлж уян хатан олон хувилбартай байхаар хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- 2.8. Нас, хүйс, яс, үндэс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, ажил мэргэжил, оршин суугаа газар нутгаасаа үл хамааран нийгмийн бүхий л орчин цаг хугацаанд өөрийнхөө хэрэгцээ, боломжид нийцүүлэн насан туршийн боловсрол эзэмших тэгш боломжийг хүн бүрд адил тэгш олгох, үүнд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах;
- 2.9. Сургалтын төрөлжсөн төв, виртуал сургалт, уулзалт-хурлын танхимыг бүсийн тулгуур төв хотууд, аймгийн төвүүдэд байгуулж, аймаг, сумдын төвийн номын санг мэдээлэл, олон нийтийн нээлттэй төв болгон хөдөөгийнхөнд хүрч үйлчлэх нөхцөлийг сайжруулах;

3. Үндэсний соёлын дархлааг бүсийн хэмжээнд бэхжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 3.1. Экосистемийн үйлчилгээний соён гэгээрүүлэх үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх;
- 3.2. Олон ястан, үндэстний түүх, урлаг, хэл, соёлын өвийг хадгалж хамгаалах, судлан шинжлэх, сурталчлах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- 3.3. Үндэсний хэл, бичгийн хэрэглээний уламжлалыг хадгалж, шинэчлэлийг хийхэд шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллах;
- 3.4. Монгол хэл, бичгийн хэрэглээнд учирч буй бүх төрлийн алдаа, гажуудлуудыг арилгах, хүн бүр эх хэл, соёлоо дээдэлж зөв бичиж хэрэглэж хэвших, байгууллага, хамт олон нийгмийн

хариуцлагын хүрээнд монгол хэл, бичгээр зөв бичсэн мэдээ, мэдээлэл нийтэлдэг болгон хэвшүүлэх;

- 3.5. Иргэн бүрийг угийн бичигжүүлэх, өвөг дээдэс, угийн хэлхээгээ мэддэг болгохоос гадна иргэний бүртгэлийн мэдээллийн системд угийн хэлхээг тодорхойлон монгол хүний удмын санг хамгаалах;
- 3.6. Иргэн бүрийн нүүдэлчин ахуй, зан заншил, үндэсний түүх, өв соёл, уламжлалт тоглоом наадгай, дуу хөгжмийн мэдлэг, чадварыг тасралтгүй, тогтмол сайжруулах;
- 3.7. Бүсийн түвшинд говийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, соёл өв уламжлалыг орчин үеийн соёл, урлагийн танин мэдэхүйтэй хослуулахад мэдээллийн технологийн ололтыг өргөн ашиглаж, сумдын соёлын төвүүдийн байрны хангамж, материаллаг баазыг шат дараатай бэхжүүлэх;
- 3.8. Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, соёлын дурсгалт зүйлсийг сурталчлах ажлыг эрчимжүүлэх;
- 3.9. Үндэсний археологийн хөгжлийг дэмжиж, үнэт зүйлсийг хадгалан, археологи, палеонтологи, угсаатны зүйн чиглэлээр төрөлжсөн музей, сан, судалгааны төвүүдийг архитекторын шийдэлтэйгээр байгуулах;

4. Иргэндээ ээлтэй, ил тод, үр ашигтай төрийн үйлчилгээг хүргэж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 4.1. Шийдвэр гаргах бүх түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг сайжруулан “нийгэмшсэн соёлтой, нийгэм дэх олон нийтийн оролцоотой бүс” болох;
- 4.2. Орон нутгийн байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах, эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотой шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нутгийн иргэдийн идэвх санаачилга, хамтын оролцоог хангах;
- 4.3. Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэд, малчид, тариаланчдыг өөрсөдтэй нь холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд өргөнөөр оролцуулж, тэдгээрийн эрх ашгийг тусгах;
- 4.4. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхэд бизнес эрхлэгчдийг оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- 4.5. Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах;
- 4.6. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих, үр дүнг харуулах механизмыг нээлттэй болгож, иргэдэд хүргэх арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх;
- 4.7. Орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийг ашиглан бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж, олон нийтийн оролцоонд тулгуурлан хүнд суртлыг бууруулах, улмаар устгах;
- 4.8. Төрийн үйлчилгээг чирэгдэл багатай, шуурхай, хүртээмжтэй үзүүлэхэд орчин үеийн мэдээллийн техник, технологийг ашиглах;
- 4.9. Төрийн үйлчилгээ иргэн бүрд шуурхай, чирэгдэлгүй хүрдэг тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлэх;

5. Бүсийн хүн амын үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнес эрхлэх идэвх санаачилгыг бүх талаар дэмжин, ажилтай орлоготой хүн амын тоог тасралтгүй нэмэгдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 5.1. Бүсийн ногоон салбар, ногоон үйлдвэрийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан аж үйлдвэрийн IV хувьсгалын технологийн хүрээнд хөгжлийн урт хугацааны үзэл баримтлалд нийцэх ногоон ажлын байрыг нэмэгдүүлэн хүн амын бүлэг бүрийн онцлогт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх; (Аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран хадлан бэлтгэх, малын тэжээл үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг зохион байгуулах гэх мэт)
- 5.2. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахуйц ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд дотоодын ААН-үүдийг уялдуулан хамтран хэрэгжүүлэх;
- 5.3. Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санал санаачилгыг урамшуулах, дэмжих замаар бүсийн кластерийн хөгжлийг хангах;
- 5.4. Залуучуудад энтрепренерал зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх орчин нөхцөл бүрдүүлэх;
- 5.5. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын хууль эрх зүйн шинэчлэлд шилжих хөдөлгөөн, хүн амын насжилт, ажилгүйдэл, бүтээмж, хөдөлмөрийн нөөц ашиглалт ба үйлдвэрлэлийн өсөлтийн харилцан үйлчлэлийг авч үзэх, холбогдох өөрчлөлт, нэмэлт, шинэчлэлийг тусгах;
- 5.6. Жижиг, дунд үйлдвэрлэлд шаардлагатай техникийн болон мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээг тодорхойлох, тэднийг давтан сургах, бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох;
- 5.7. Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэхийг санхүүгийн болон зах зээлтэй холбох,
- 5.8. Аймгийн өртгийн сүлжээний анхан шатны үйл ажиллагаанд зохион байгуулалттай ажлын байр гаргах төсөл, санаачилгыг дэмжин улс, бүсийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбох;
- 5.9. Бичил, жижиг, дунд бизнест чиглэсэн санхүүгийн урамшууллыг өргөжүүлж, санхүүгийн байгууллагын нийлүүлж буй өртгийн сүлжээний анхан шатны үйл ажиллагаанд дахь зээлийн бүтээгдэхүүнийг бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй ба нийцэмжтэй болгох талаар санхүүгийн салбарынхантай хамтран ажиллах;

6. Бүсийн аймгуудад эдийн засгийн үр ашгийг хангах замаар иргэн бүрт сонголт боломж олгож, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан дундаж давхаргыг нэмэгдүүлж, амьдралын чанарыг сайжруулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 6.1. Аймаг, сумын ядуу өрхийн шинж байдлыг гүнзгийрүүлэн шинжилж, хөдөөгийн ядуу өрхийн ногоон үйлдвэрлэл эрхлэх ур чадвар, арга барилыг дээшлүүлэх, ажлын байр, иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 6.2. Хөдөлмөрийн оролцооны түвшинг жил бүр үнэлж, ажилгүйдлийн шинж байдлыг нарийвчлан тодорхойлж, зохистой ажлын байрны нөхцөлөөр хангах, ажилгүйдлийн тэтгэмжийн тогтолцоог зах зээлийн зарчмаар ажиллуулах;
- 6.3. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг аймгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;

- 6.4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлэн ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийг багасгах;
 - 6.5. Нүүдлийн мал аж ахуйд түшиглэн соёлын болон бүтээлч салбарын кластерт төрөлжсөн бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхижуулан дундаж давхаргын бүлгийг дэмжих;
 - 6.6. Бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх замаар эрэлтэд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт, хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх;
 - 6.7. Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтыг түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлал, томоохон уул уурхайн бүтээн байгуулалтыг дагасан гео аялал жуулчлал (geotourism)-ын шинэ төрлийг дэмжиж, шинэ орлого бүтээх урсгалыг тэлэх;
 - 6.8. Орон нутгийн иргэний бие даасан, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” аяныг тогтмол удирдан зохион байгуулж, ногоон худалдааг дэмжин бизнес эрхлэгчдийн орлогын урсгалыг нэмэгдүүлэх;
 - 6.9. Хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 7. Бүсийн нийгмийн хамгаалал ба халамжийн тогтолцоог зах зээлийн зарчмаар бэхжүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:**
- 7.1. Хүн амын өсөлтийг дэмжих, нэмэгдүүлэх хүн ам зүйн бодлого /хүн амын өсөлтийн прогноз/ баримтлах;
 - 7.2. Ахмад настны тусламж, үйлчилгээний тогтолцоог бүрдүүлж, ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх бүсийн хөгжлийн төвийг байгуулах;
 - 7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн хөгжлийн бүсийн төвийг ажиллуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах үйлчилгээг дэмжих төсөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах төсөл хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх тогтолцоог бүрдүүлэх;
 - 7.4. Асрамжийн газраас 18 нас хүрсэн залуучуудыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх тогтолцоотой болох;
 - 7.5. Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах;
 - 7.6. Сайн дурын хөдөлмөр эрхэлж байгаа иргэд болон малчдыг нийгмийн даатгалд даатгуулах;
 - 7.7. Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг өрх, иргэдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэж, гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх механизм ажиллах;
 - 7.8. Ядуу өрхийн сургуулийн бага ангийн хүүхдийн ном, сурах бичгийн түрээсийн тогтолцоо, эргэлтийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хүүхдийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлэх, дотуур байранд амьдрах хоол, унааны зардлын тодорхой хувийг улсаас төлөх;
 - 7.9. Жендерийн эрх тэгш байдлын талаарх олон нийтийн үзэл бодол, мэдлэг, чадвар, хандлагыг жендерийн мэдрэмжтэй байхад чиглүүлж, харилцан хүндэтгэх, харилцах зөвшөөрөх, харилцан санал бодлоо илэрхийлэх арга барилд бүх түвшинд суралцах;

8. Бүсийн ахмад үеийнхний туршлагад тулгуурлан мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлэхийн хэрэгцээ мэргэжлийн боловсрол олгох тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 8.1. МСҮТ-ийг ногоон хөгжил, ногоон салбарт шаардлагатай шинэ ажлын байрны (хөдөө аж ахуй, эрчим хүч, боловсруулах үйлдвэр, барилга, аялал жуулчлалын) чиглэлээр дэмжин ажиллах;
- 8.2. МСҮТ-ийн багшлах хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төлөвлөх, сургах, зохистой ажлын байрны нөхцөлөөр хангах, ур чадвар, туршлагыг бэхжүүлэн нийгмийн хамгааллыг сайжруулах;
- 8.3. МСҮТ-үүдийн сургалтын байрны хангамж, материаллаг баазыг шат дараатай бэхжүүлэх;
- 8.4. Аймаг, сумдын төвийн номын санг мэдээлэл, олон нийтийн нээлттэй төв болгон МСҮТ-д хүрч үйлчлэх нөхцөлийг сайжруулах;
- 8.5. Ахмадуудыг дахин мэргэшүүлэх төсөл хэрэгжүүлэх;
- 8.6. Насан туршийн боловсролын боловсролын үнэ цэнэ тасралтгүй байдлыг хангаж, олон нийтийн хандлага оролцоог нэмэгдүүлэх, сургалтын материал, гарын авлагыг боловсруулах, сургалтын орчинг тогтвортой сайжруулах;
- 8.7. XXI зууны шинэ ажил мэргэжлийн талаар соён гэгээрүүлэх үйл ажиллагааг аймаг, бүсийн түвшинд цогц байдлаар хэрэгжүүлж, дутагдалтай, огт байхгүй мэргэжлийн чиг баримжааг тогтооход төвлөрч, ажил олгогчидтой хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- 8.8. Виртуал орчинд мэргэжлийн дадлага олгох, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, туршилтийн үр дүнг бодит харуулах механизмыг бүрдүүлэх;
- 8.9. Шинэ үеийнхэнд ногоон хөгжил, ногоон үйлдвэр, ногоон ажлын байрыг мэдээллийн технологи, инновацид тулгуурлан дамжуулах, нэвтрүүлэх, турших төв байгуулах;

9. Нутагшил суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хот суурин газрын хөгжлийг дэмжих, амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ/үйл ажиллагаа нь:

- 9.1. Нутагшил суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийг үе шаттай барьж байгуулах;
- 9.2. Сумын төвүүдийн инженерийн шугам сүлжээний зураглал хийх;
- 9.3. Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах;
- 9.4. Аймаг, сумдын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах;
- 9.5. Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг улсын хэмжээнд хийж, бүсийн түвшинд хэрэглэх;
- 9.6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах;
- 9.7. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлж, бүлэг суурингийн хөгжил, байршлын төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх;

- 9.8. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, дэлхийн жишигт хүргэх;
- 9.9. Хот төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, гамшгаас сэргийлэх үндэсний болон орон нутгийн чадавхийг бэхжүүлж, гамшигт тэсвэртэй дэд бүтэцтэй болох.

Хүрэх үр дүнгийн төсөөлөл бол:

1. Засгийн газраас хэрэгжүүлэх урт хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Говийн дэд бүсэд тогтвортой дэд бүтцийг хангах;
2. Говийн дэд бүсийн дөрвөн аймгийн хөгжлийн үнэт зүйл бол говийн байгалийн өвөрмөц онцлогтой нөөцийг экологийн тэнцвэрт байдлыг хадгалахаар үр өгөөжтэй ашиглаж, өрсөлдөх давуу талаа бэхжүүлэхээр аж ахуй эрхлэн амьжиргааны түвшний дээшлэлтийг өвлүүлэн үлдээхэд чиглэх;
3. Говийн бүсийн дөрвөн аймгийн хүн амын хүний хөгжлийн индекс, амьдралын чанарын индекс, нийгмийн хөгжил цэцэглэлтийн индекс тасралтгүй өсөн нэмэгдэж, эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд гүйцэтгэх үүргээ ухамсарлан ажиллаж амьдрах;
4. Говийн бүсийн дөрвөн аймгийн залуу үеийнхэн XXI зууны өөрчлөлтөд бэлэн байж, аж үйлдвэрийн IV хувьсгалын техник, технологийн мэдлэг, ур чадвар, чадамжийг байнга дээшлүүлэн хувь хүн, аймаг орон, бүс нутгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах;
5. Хөдөө аж ахуйн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бүсийн соёлын бүтээлч салбарын кластерийг хөгжүүлэх замаар сайжруулан ажилтай, орлоготой байхын тулд бизнесийн санаа, санаачилгыг хөхүүлэн дэмжих;
6. Бүсийн үнэт зүйлийг хадгалах, өвлүүлэх, арвижуулан нэмэгдүүлэхэд чиглэсэн институцийн тогтолцоонд зөөлөн дэд бүтцийг суулгах;
7. Тогтвортой, ногоон хөгжил, ногоон худалдааны ойлголт, мэдлэг туршлага, дэлхийн улс орнуудын сайн туршлага, экосистемийн үйлчилгээг хүн амд таниулж, соён гэгээрүүлэх;
8. Сум, аймагтаа аюулгүй, амар тайван, тав тухтай амьдрах орчин бүрдүүлэх;
9. Говийн бүсийн онцлогийг бусад бүс нутагт таниулах, хамтран ажиллах боломжийг үргэлж нээлттэй байлгах;

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санхүүжилт нь сангийн зарчимд тулгуурлана. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санхүүжилтийн санг улсын болон орон нутгийн төсөв ба төсвийн бус эх үүсвэрээр бүрдүүлнэ.

Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө санхүүжилтийн санг ил тод, ойлгомжтой бүрдүүлж, хэрэгжилт ба гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх механизмыг зайлшгүй зөвшилцөнө.

Эх сурвалж

С. Намжилмаа, М. Алтанбагана, Х. Билгүүн “Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршлын судалгаа”, Улаанбаатар, 2019

У.Батсүх. Төвийн бүсийн говийн дэд бүсийн гадаад харилцаа, худалдаа, эдийн засгийн интеграцийн салбарын хөгжил байршлын бодлогын судалгаа, Эцсийн тайлан, Улаанбаатар, 2019

МУИС-ийн багш, Др.Дэд проф.Г.Гантулга, МУИС-ийн багш, Мр.Д. Дорлигжав, “Өмнийн говийн дэд бүсийн хот байгуулалтын салбарын судалгаа”, Улаанбаатар, 2019

Б.Батболд, Д. Далайцэцэг “Төвийн бүсийн Говийн дэд бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын бодлогын судалгаа”, Улаанбаатар, 2019

Б. Чинбат, В. Батцэнгэл, Д. Энхжаргал, Ц. Базарханд, Ч.Заяа “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн онол, арга зүй, орон зайн төлөвлөлт, эдийн засгийн загварчлалыг судлах судалгаа”, Улаанбаатар, 2019

Ц.Баярбаатар, Ц.Жаргалсайхан “Говийн бүсийн аймгуудын эрчим хүчний хангамж, Улаанбаатар, 2019

Н. Мөнхнаран, “Төвийн бүсийн говийн дэд бүсийн газар зохион байгуулалтын салбарын бодлогын судалгаа”, Улаанбаатар, 2019 о

Ж.Батсуурь, Ж. Гэрэлчулуун, Н.Төмөрсүх, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэх, Өмнийн говийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах судалгаа: Усны салбар”, Улаанбаатар, 2019

Б.Нямдаваа, О.Алтанболд, “Төвийн бүсийн говийн дэд бүсийн ландшафтын хөгжил байршлын бодлогын судалгаа”, Улаанбаатар, 2019

Д.Насанжаргал, С.Амартүвшин, Б.Цогт-Эрдэнэ “Бүсчилсэн хөгжлийн болон ХХААХҮ-ийн салбарын одоо мөрдөгдөж байгаа хууль, бодлогын баримт бичгүүдийн уялдаж буй байдалд дүн шинжилгээ хийсэн санал, дүгнэлт, зөвлөмж”, Улаанбаатар, 2019

Ч.Нарантуяа, А.Заяадэлгэр, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, хөгжлийн бодлогын үр нөлөөний үнэлгээ”, Улаанбаатар, 2019

Б.Цэцэгсайхан, А.Өнөржаргал, “Төвийн бүсийн говийн н дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа”, Улаанбаатар, 2019

Д.Готов, И.Базаррагчаа, М.Дэлгэрсайхан, “Төвийн бүсийн говийн дэд бүсийн Зам тээвэр, логикийн салбарын хөгжил байршлын бодлогын судалгаа”, Улаанбаатар, 2019

Ц.Цэцэгмаа, С.Цолмон, “Төвийн бүсийн говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн салбарын хөгжил, байршлын бодлогын судалгаа”, Улаанбаатар, 2019

Б.Энх-Амгалан, Төвийн бүсийн говийн дэд бүсийн Нийгмийн хамгааллын салбарын хөгжил байршлын бодлогын судалгаа, Улаанбаатар, 2019

Т.Энэбиш, “Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлалын судалгаа”, Улаанбаатар, 2019

Б.Индраа, Б.Эрдэнэчимэг, “Төвийн бүсийн говийн дэд бүсийн аялал жуулчлалын салбарын хөгжил байршлын бодлогын судалгаа”, Улаанбаатар, 2019

Р.Ринчинбазар, Д.Эрдэнэбаяр Бүс нутгийн шинжлэх ухааны үндэс. 2019

Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. УБ.

“Бүс нутгийн онцлогт тохирсон хот байгуулалтын бодлого, барилгын архитектур төлөвлөлтийн үндсэн зарчим”. БАК. 2001 он.

Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги. УИХ-ын 2003 оны 24 дүгээр тогтоол. УБ.

Бүсийн тулгуур төв хот тогтоох тухай. УИХ-ын 2003 оны 01 дүгээр тогтоол. Улаанбаатар.

Зүүн, Баруун, Төвийн, Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр (2006-2015). Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоол. УБ.

Улаанбаатар бүсийн хөгжлийн хөтөлбөр (2006-2015). Засгийн газрын 2005 оны 45 дугаар тогтоол. УБ.

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол. УБ.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. УИХ 2020

Засгийн газар. Алсын хараа 2050: Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал. 2020

“Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх онол аргазүйн үндэслэл, боломжит хувилбар” эрдэм шинжилгээний тайлан. Газарзүйн хүрээлэн. 2006 он. УБ

Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай. Монгол улсын Их хурлын 2007 оны 27-р тогтоол. УБ.

Үндэсний статистикийн хороо. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал. Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/152 тоот тушаалын хавсралт. УБ.

Монгол улсын Үндэсний атлас. Газарзүйн хүрээлэн. 2009 он. УБ.

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого. Аймгийн ИТХ-ын 2011 оны 3 дугаар тогтоол. Говьсүмбэр.

Говьсүмбэр аймгийн 21 зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2003-2020

Говьсүмбэр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 12-р хуралдааны тогтоол- 2010-2021

Говьсүмбэр аймгийн Сүмбэр хонь 2010-2019

Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого. Аймгийн ИТХ-ын 2002 оны 18 дугаар тогтоол. Сайншанд.

Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр-2002-2020

Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/. Аймгийн ИТХ-ын 2011 оны 26 дугаар тогтоол. Сайншанд.

Дорноговь аймгийн Эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө-2009-2021

Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого 2003-2020

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө 2009-2021

“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он). Аймгийн ИТХ-ын 2009 оны 5/11 дүгээр тогтоол. Даланзадгад.

Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр-2010-2020

Монгол улсын “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль. Монгол улсын Их хурал 2015 оны 11 дүгээр сарын 26. УБ.

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл. Дунд хугацааны тайлан 1. ЖАЙКА-гийн төслийн баг. 2019

М.Алтанбагана, Б.Хэрлэнбаяр. 2015. “Экологийн эмзэг байдал шилжилт хөдөлгөөн, ядууралд нөлөөлөх нь”. Нийгэм эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэсвгэрийн онцлогийг харгалзан үзэх нь сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний 3-р бага хурал. УБ.

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. Монгол улсын Их хурлын 2015 оны 62-р тогтоол. УБ.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030 он). Монгол улсын Их хурлын 2015 оны 62-р тогтоол. УБ.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр. Монгол улсын Засгийн газрын 2015 оны 324-р тогтоол. УБ.

M.Altanbagana et al. 2016. Consulting on “National Report of Urban Development of Mongolia for UN HABITAT III” and “Current Assessment for Regional and Human Settlements Development in Mongolia”. Funding by Ministry of Construction and Urban Development and UNDP and Introduced to the *United Nations* Conference on Housing and Sustainable Urban Development in Quito, Ecuador, from 17-20 October, 2016.

Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 142-р тогтоол. УБ.

Гурван тулгуурт хөгжлийн бодлого. Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоол. УБ.

M.Altanbagana. 2018.03.10. “Sustainable Development Vision 2030 and Challenges in Mongolia: Zud Impact on Social-Economic Issues”. Symposium on “Changing Environment and People's live of Mongolia” in Tottori University. Japan

Уул уурхайн салбарын өрхийн амжиргаанд үзүүлэх нөлөө урьдчилсан тайлан. Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн. 2018 он. УБ.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбарт 4 аймгийн ЗДТГ-аас ҮХГ-т ирүүлсэн саналууд. 2019

Хавсралт

Хавсралт 1. Стратегийн ордууд

№	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Нөөцийн хэмжээ	Байршил
1	Таван толгой	Чулуун нүүрс	6420 сая тн	Өмнөговь, Цогцэций
2	Нарийн сухайт	Нүүрс	125.5 сая тн	Өмнөговь, Гурван тэс
3	Шивээ-Овоо	Хүрэн нүүрс	564 сая тн	Говьсүмбэр, Шивээговь
			2675 сая тн хүдэр,	
4	Оюутолгой	Зэс, молибдени	25 сая тн зэс, 1028 тн алт, 6144 тн мөнгө 1.2 сая тн зэс,	Өмнөговь, Ханбогд
5	Цагаан суварга	Зэс, молибдени	43.62 мян тн молибден	Дорноговь, Мандах
6	Өвдөг худаг	Нүүрс		Дундговь, Баянжаргалан
7	Тэвшийн говь	Нүүрс		Дундговь, Сайнцагаан
8	Хөөтийн хонхор	Нүүрс		Дундговь, Баянжаргалан
9	Алаг тогоо	Нүүрс		Дундговь, Даланжаргалан
10	Ширээ уул	Гөлтгөнө		Дундговь, Дэлгэрхангай
11	Өвдөг худаг	Хүрэн нүүрс		Дундговь, Өндөршил
12	Цагаан цав	Цеолит		Дорноговь, Сайхандулаан
13	Луугийн гол	Газрын ховор элемент		Дорноговь, Хатанбулаг
14	Хонгор	Жонш		Дорновь, Даланжаргалан, Айраг

Хавсралт 2. Өмнийн говийн бүлэг суурингийн тогтолцоо

№	Бүлэг суурингийн төвийн нэр	Хот суурингийн нэр	Хот суурингийн ангилал	Хот суурингийн үүргийн ялгаа
1	САЙНШАНД	Сайншанд Алтанширээ	Амйгийн төв Хөдөөгийн тосгон	Засаг захиргаа, үйлдвэр, тээвэр, соёлын төв Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

		Дэлгэрэх	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Өргөн	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Эрдэнэ	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Чойр	Орон нутгийн хот	Засаг захиргаа, тээвэр, хөнгөн хүнс
		Шивээговь	Хоторхуу тосгон	Эрчим хүч, уул уурхай, тээвэр
		Айраг	Хоторхуу тосгон	Эрчим хүч, уул уурхай, тээвэр
2	ЧОЙР	Халзан-Уул	Хоторхуу тосгон	Аялал жуулчлал, амралт сувилал
		Даланжаргалан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Өндөршил	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Баянжаргалан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Говь-Угтаал	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Цагаандэлгэр	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Цагаансуварга	Орон нутгийн хот	Засаг захиргаа, эрчим хүч, уул уурхай
3	ЦАГААНСУВАРГА	Сайхандулаан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Мандах	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Зүүнбаян	Орон нутгийн хот	Засаг захиргаа, эрчим хүч, уул уурхай
4	ЗҮҮНБАЯН	Улаанбадрах	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Хөвсгөл	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн төв
5	ХӨВСГӨЛ	Хатанбулаг	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
6	ЗАМЫН-ҮҮД	Замын-Үүд	Хоторхуу тосгон	Засаг захиргаа, тээвэр
		Даланзадгад	Аймгийн төв	Засаг захиргаа, үйлдвэр, соёлын төв
		Цогт-Овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Номгон	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
7	ДАЛАНЗАДГАД	Хүрмэн	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Баяндалай	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Булган	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Мандал-Овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

		Ханхонгор	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Сэврэй	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн төв
8	СЭВРЭЙ	Гурвантэс	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Ноён	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
9	ТАВАНТОЛГОЙ	Тавантолгой	Орон нутгийн хот	Засаг захиргаа, эрчим хүч, уул уурхай
		Цогтцэций	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Манлай	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Ханбогд	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Баян-овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
10	МАНДАЛГОВЬ	Мандалговь	Аймгийн төв	Засаг захиргаа, үйлдвэр, соёлын төв
		Тэвшийн говь	Хоторхуу тосгон	Эрчим хүч, уул уурхай
		Дэлгэрцогт	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Адаацаг	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Сайнцагаан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Дэрэн	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Гурвансайхан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Хулд	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Луус	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
11	ЭРДЭНЭДАЛАЙ	Эрдэнэдалай	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн хот
		Дэлгэрхангай	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Сайхан-Овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
12	ӨЛЗИЙТ	Өлзийт	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн хот

Хавсралт 3. Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд

Д/Д Баримт
бичгийн нэрс

Холбогдох заалт

1

НҮБ-ийн
Ерөнхий
ассемблейн
чуулганаар
2015 онд
батлагдсан
“Тогтвортой
хөгжлийн
зорилтууд
2030”

- Зорилт 11.3. 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах
- Зорилт 11.4. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах
- Зорилт 11.5. 2030 он гэхэд нас барсан болон байгалийн гамшигт өртсөн хүмүүсийн тоог үлэмж хэмжээгээр бууруулж, ядуу болон эмзэг бүлгийн хүн амыг голлон анхаарч байгалийн гамшиг, түүний дотор устай холбоотой гамшгийн улмаас ДНБ-тай харьцуулсан эдийн засгийн алдагдлыг [х] хувиар бууруулах
- Зорилт 11.a. Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хагас суурин газар, хөдөө орон нутгийн хооронд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр дүнтэй уялдаа холбоо дэмжих
- Зорилт 11.b. 2020 он гэхэд бүх талын оролцоог хангах, хөрөнгө баялгийг үр ашигтай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, гамшигт даван туулах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, төлөвлөгөө батлан хэрэгжүүлдэг хот, хүн амын суурьшлын тоог [х] хувиар нэмэгдүүлж, удахгүй гарах Хёгогийн үйл ажиллагааны баримт бичигтэй уялдуулан бүх түвшинд гамшгийн эрсдэлийн цогц менежментийг боловсруулж, хэрэгжүүлэх
- Зорилт 11.c. Орон нутгийн материалыг ашиглан даац сайтай, гамшгийн үед тэсвэртэй, эдийн засгийн хэмнэлттэй барилга байгууламж барихад санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэх замаар нэн буурай хөгжилтэй орнуудыг дэмжих
- 4.7.5. хүн амын нутагшил, хот байгуулалтын хүрээнд:
 - 4.7.5.a. бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх агуулгаар "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг"-ыг боловсруулж, шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх;
 - 4.7.5.b. бүс нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, хүн амын тоо, түүх, соёлын уламжлал, хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх хүрээ зэргийг харгалзан Монгол улсын хот, тосгоны зохистой хэмжээ, бүтцийн загварыг боловсруулж, хот, тосгоныг үе шаттайгаар сэргээн хөгжүүлэх;
 - 4.7.5.v. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх шаардлагын дагуу бүсийн төв болгон хөгжүүлэх хотуудын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
 - 4.7.5.g. Улаанбаатарын болон бусад бүсийн хэмжээнд Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрлийг задлах зохистой чиглэл, хотын оршин суугчдын амьдрах орчны чанар, аюулгүй байдлыг хангах, хотын газрыг үр ашигтай ашиглах, инженерийн шугам сүлжээ, замын байгууламжийг шинэчлэх шаардлагыг бодолцон нийслэл хотын хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж,

Монгол улсын
Их Хурлын
2001 оны 57
дугаар
тогтоолоор
батлагдсан
“Монгол улсын
бүсчилсэн
хөгжлийн үзэл
баримтлал”

3

		хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулах;
		• 4.7.5.д. эрх зүй, эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн зохих нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Монгол улсын нийслэлийг Улаанбаатар хотоос тус улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт шилжүүлэн байршуулах асуудлыг иж бүрнээр судалж 2020 он хүртлэх хугацаанд шийдвэрлэх; • 4.7.5.е. улсын хэмжээнд эдийн засгийн бүсчлэл, хот байгуулалтын стратегийн удирдлага, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, нутаг дэвсгэр зохион байгуулалтын товчоод байгуулах ажлыг дэмжих;
4	Монгол улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”	• Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ. • монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх, үйлчилгээг нь олон улсын түвшинд хүргэх, олон улсын сүлжээнд хамрагдах, соёлын бүтээгдэхүүнийг гадаадад борлуулахад дэмжлэг үзүүлэх • гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцлүүдийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэх; • ."Ногоон", "Цэнхэр" эдийн засгийг хөгжүүлэх, уул уурхайн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад дэмжлэг үзүүлэх; • Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; • Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх • Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлж, хүн амын 90-ээс доошгүй хувийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангаж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг 60-аас доошгүй хувьд хүргэх • Банк, санхүүгийн байгууллагын байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгож, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх; • Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх; • Хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх
5	Монгол улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”	

Монгол улсын
Их Хурлын
2016 оны 19
дугаар
тогтоолоор
батлагдсан
6 “Монгол улсын
тогтвортой
хөгжлийн үзэл
баримтлал-
2030”

- эрх зүйн зохицуулалтыг бий болгож агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах;
- Улаанбаатар хот болон бусад хот сууриныг дахин төлөвлөж эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 15 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх;
- Үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохистой менежментийг төлөвшүүлж, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувь бууруулах;
- Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, найдвартай, эрсдэлгүй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд тав тухтай зорчих орчныг бүрдүүлэх
- Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна.
- Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.
- Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.
- Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно.
- Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно.
- Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно.
- Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна.
- Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэх
- Жилд 100.0 мянган тонн ган туйван, барилгын болон төмөр замын металл хийц үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулах.
- Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана.

- Тээвэр ложистикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай авто замын уртыг 470 км-ээр нэмэгдүүлж, бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах.
- Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах.
- Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг хот, суурин газруудад хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 25 хувиар бууруулах.
- Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, олон улсын стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлсэн хот, суурин газруудыг хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 40 хувиар бууруулах.
- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ.
- Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох.
- Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх.
- Хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсээр иргэдээ хангах;
- Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, хүнс экспортлогч орон болох;
- Бүс нутаг, хөрш орнуудтай эдийн засгийн интеграцид нэгдэх замаар гадаад худалдааны шинэчлэл хийж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдааны сүлжээг бий болгох;
- Аялал жуулчлалын дэд бүтэц, өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, тухайн орон нутгийн онцлогт тулгуурласан иргэдийн оролцоотой тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх.
- Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нэгдсэн тээвэр, логистик, дэд бүтцийг хөгжүүлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх.
- Эдийн засгийг бүсчилж хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого хэрэгжүүлэх.

- Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж, хүн амд эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх;
- Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот, суурин газрын хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах
- Жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацаргана үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр хангаж, экспортын орлогыг нэмэгдүүлэх
- Аж үйлдвэрийн салбарыг борлуулалтаар дэмжих тээвэр, логистикийн сүлжээг байгуулах ажлыг эхлүүлэх
- Импортыг орлох барилгын материалын үйлдвэрийг бодлогоор дэмжих;
- Эрэлт хэрэгцээг харгалзан барилгын материалын логистикийн сүлжээг үндэсний хэмжээнд төлөвлөж, цементийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах;
- Зочид буудал, хоол үйлдвэрлэлийн салбар дахь эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэрлэгээний нэгдсэн үйлдвэрийг хүн ам ихтэй хот, суурин газарт байгуулахыг дэмжих
- Төв, суурин газарт нийтийн хоолны үйлдвэрийн цогцолбор байгуулахыг бодлогоор дэмжих;
- Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хөдөө аж ахуй, түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглах;
- Хот байгуулалт, дэд бүтэц, барилга бүтээн байгуулалтын тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх;
- Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хот байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх;
- Хот, суурин газрын хог хаягдлыг цуглуулах, ангилах, боловсруулах, дахин ашиглах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгаль орчинд ээлтэй арга, технологи, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулал, татаасын бодлогоор дэмжих;
- Орон нутгийн хөгжлийн загварт тулгуурласан нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй болгох, нийгмийн үйлчилгээний болон үйлдвэрлэл, бизнесийн барилга байгууламжийн нэг маягийн загвар зураг, түүний урсгал зардлын тооцоог төсвийн төлөвлөлтөд нэвтрүүлэх;

Хавсралт 4. Бүсчилсэн хөгжлийн агуулгаар орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн үндэслэл, холбоотой бодлого, хөтөлбөрийн зорилт	Шалгуур үзүүлэлтээр бодлогын шинжилгээ хийх баримт бичиг	
			Үндэсний болон бүс нутгийн түвшинд	Орон нутгийн түвшинд
1	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож, өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2, 4.7.1.е, 4.7.1.ж - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
2	Бүсийн түвшинд өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дэмжих, дотоод, гадаад зах зээлтэй холбох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2, 4.7.2.г, 4.7.2.д, 3.14 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
3	Хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2 - Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого	- Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого ³⁷ - Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого ³⁸	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
4	Бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.4, 4.7.3.е - НҮБ-ын ТХЗ-ын 10	- Ногоон хөгжлийн бодлого ³⁹	
5	Бүсүүдэд Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТИПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.а. - НҮБ-ын ТХЗ-ын 4 - ТХҮБ 2030-ын 2.1.3-ын зорилт 4, 5	- Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого ⁴⁰ - Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого ⁴¹ - Судалгаанд суурилсан их их сургуулийг	

³⁷ Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоол. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр.

³⁸ Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоол. Ноолуур хөтөлбөр (2018-2021).

³⁹ УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого.

⁴⁰ Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоол. Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого.

⁴¹ Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.

			хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр ⁴²	
6	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.б. - НҮБ-ын ТХЗ-ын 3 - ТХҮБ 2030-ын 2.2.2-ын зорилт 1	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
7	Бүс нутгийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бий болгох бүс нутаг-хотжилтын нэгдмэл орчныг бий болгох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.5 - НҮБ-ын ТХЗ-ын 11 - ТХҮБ 2030-ын 2.1.5-ын зорилт 5, 6	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
8	Эдийн засаг, тээврийн коридорын дагуух бүс нутгуудыг олон улсын худалдаа-эдийн засгийн сүлжээнд зохистой холбож, гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.6 - НҮБ-ын ТХЗ-ын 17	- МУ-ын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр ⁴³ - Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр - Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ⁴⁴ - “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр ⁴⁵	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
9	Бүс нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 3.2.1, 3.2.2	- Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ⁴⁶	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
10	Бүсийн онцлог, давуу талд тулгуурлан төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн харилцан адилгүй, явгавартай бодлогоор дэмжих зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.в, 4.7.1.г. - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4	- Төсвийн тухай хууль - Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр ⁴⁷	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
11	Бүс нутгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог	- БХҮБ-ын 4.7.1.д	- Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр ⁴⁸	аймгийн хөгжлийн хэтийн зорилт

⁴² УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол. Ногоон хөгжлийн бодлого.

⁴³ Засгийн газрын 2015 оны 474 дүгээр тогтоол. МУ-ын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр.

⁴⁴ УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

⁴⁵ Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол. “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр.

⁴⁶ УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

⁴⁷ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр.

⁴⁸ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр.

	дэмжих, татах зорилт, арга хэмжээ			(бодлого, хөтөлбөр)
12	Үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум сууринг тодорхойлох, тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлэх арга хэмжээ	- БХҮБ-ын 3.5, 3.8	- Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ⁴⁹ -	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
13	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.е, 4.7.1.ж	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
14	Бүсийн түвшинд салбар болон бизнес эрхлэгч хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.г, 4.7.2.д, 3.14 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4	- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ⁵⁰	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
15	Бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.з.	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
16	Бүс нутгийн түвшинд орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн чадавхийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийн сүлжээг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.а.	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
17	Гадаад, дотоод хэрэгцээг харгалзан бүсийн түвшинд импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.б. - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2	- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ⁵¹	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
18	Бүсийн түвшинд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.е.		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)

⁵⁰ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого.

⁵¹ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого.

19	Бүсийн түвшинд хүн амын ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүс, аймаг, сум дундын санхүүгийн механизм бий болгох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.д. - НҮБ-ын ТХЗ-ын 1 - ТХҮБ 2030-ын 2.2.1-ын зорилт 1, 2	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого ⁵²	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
20	Хил орчмын болон алслагдсан бүс нутагт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтыг татах, урамшуулах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.д.		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
21	Бүсийн түвшинд аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- ТХҮБ 2030-ын 2.1.3-ын зорилт 1	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ⁵³	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
22	Бүсийн хэмжээнд ХАА болон үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилт, арга хэмжээ			аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
23	Бүс нутгийн өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл-кластер хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
24	Бүсийн түвшинд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
25	Бүсийн түвшинд аялал жуулчлалыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- ТХҮБ 2030-ын 2.1.2-ын зорилт 1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр ⁵⁴	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
26	Бүсийн түвшинд зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- ТХҮБ 2030-ын 2.1.5-ын зорилт 3	“Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр ⁵⁵	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)

Эх сурвалж: М.Алтанбагана. 2018.

⁵² Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.

⁵³ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого.

⁵⁴ Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоол. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр.

⁵⁵ Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол. “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр.

Хавсралт 5. Аймгуудын хөгжлийн бодлогын шинжилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтуудын график
■ Говьсүмбэр ■ Дундговь ■ Дорноговь ■ Өмнөговь		
1	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож, өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	
2	Бүсийн түвшинд өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дэмжих, дотоод, гадаад зах зээлтэй холбох зорилт, арга хэмжээ	
3	Хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилт, арга хэмжээ	
4	Бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	
5	Бүсүүдэд Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	
6	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээ	
7	Бүс нутгийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бий болгох бүс нутаг-хотжилтын нэгдмэл орчныг бий болгох зорилт, арга хэмжээ	
8	Эдийн засаг, тээврийн коридорын дагуух бүс нутгуудыг олон улсын худалдаа-эдийн засгийн сүлжээнд зохистой холбож, гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах зорилт, арга хэмжээ	
9	Бүс нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах зорилт, арга хэмжээ	
10	Бүсийн онцлог, давуу талд тулгуурлан төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн харилцан адилгүй, явгавартай бодлогоор дэмжих зорилт, арга хэмжээ	

11	Бүс нутгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих, татах зорилт, арга хэмжээ	
12	Үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум сууринг тодорхойлох, тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлэх арга хэмжээ	
13	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	
14	Бүсийн түвшинд салбар болон бизнес эрхлэгч хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
15	Бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	
16	Бүс нутгийн түвшинд орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн чадавхийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийн сүлжээг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ	
17	Гадаад, дотоод хэрэгцээг харгалзан бүсийн түвшинд импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
18	Бүсийн түвшинд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих зорилт, арга хэмжээ	
19	Бүсийн түвшинд хүн амын ядуурдыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүс, аймаг, сум дундын санхүүгийн механизм бий болгох зорилт, арга хэмжээ	
20	Хил орчмын болон алслагдсан бүс нутагт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтыг татах, урамшуулах зорилт, арга хэмжээ	
21	Бүсийн түвшинд аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
22	Бүсийн хэмжээнд ХАА болон үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилт, арга хэмжээ	
23	Бүс нутгийн өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл-кластер хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	



Эх сурвалж: Судалгааны баг

Хавсралт 6. Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах санал

2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр

Чойр хот

ГОВЬСҮМБЭР АЙМАГ		
№	Бүсчилсэн хөгжлийн баримт бичигт тусгах санал	Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх
1.	Гаалийн хяналтын бүсийг өргөтгөж, тээвэр ложистикийн төв байгуулах	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил
2.	Уул уурхай, инженерийн их дээд сургуулийг Шивээ Овоо хувьцаат компани, Политехник коллежид түшиглэн байгуулах	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил
3.	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн парк байгуулах - / Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ачих буулгах цэг байгуулах/ - /Мах махан бүтээгдэхүүн, ноос нолууран бүтээгдэхүүн/	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил
4.	Кокс, ган боловсруулах үйлдвэр байгуулах	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил
5.	Мал, мах бэлдэж малын түүхий эд боловсруулах мал эмнэлэгийн төвийн лаборатори байгуулах	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил
6.	Кокс, ган боловсруулах үйлдвэр байгуулах	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил
7.	Бүсчилсэн аймгуудтай аялал жуулчлалын маршрутын сурталчилгааны цэг байгуулах	2 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил
8.	Баянтал сумын айрдромыг түшиглэн онгоцны буудалтай болох	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил

Хавсралт 7. Говьсүмбэр аймгийн санал


**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3005,
И-мэйл: zdtg.gea@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn
2020.01.20 № 5/61
танай _____ -ны № _____ -т
Санал хүргүүлэх тухай

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАРТ

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.Аймаг, сумдын нэрийг албан ёсны нэршлээр бодлогын баримт бичигт тусгах. Жишээ нь: Говьсүмбэр аймаг, Чойр, Өндөрхаан, Чингис г.м,

2.Мандалговь-Говь-Угтаал- Чойрын чиглэлийн авто замын хэмжээг нэмэгдүүлж бүрэн оруулах,

3.Говьсүмбэр аймаг нь олон улсын босоо тэнхлэгт төмөр зам, авто зам, агаарын зам дайран өнгөрдөг, Оросын цэргийн ангийн ашиглаж байсан нисэх онгоцны буудал, ангариуд болон газар зүйн байршлын давуу талд суурилж Говьсүмбэр аймагт тээвэр, логикийн томоохон төв байгуулах,

4.Уул, уурхайн жишиг полетихник коллеж, сэргээгдэх эрчим хүчний станцуудад газар зүйн байршилд суурилан Уул уурхай, Эрчим хүч, Хөдөө, аж ахуйн чиглэлд мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэх их дээд сургуулийг байгуулах, энэ чиглэлийн боловсруулах үйлдвэрүүдийг Говьсүмбэр аймагт байгуулах.

Дээрх саналууд бодлогын баримт бичгийн төсөлд ерөнхий агуулгаараа тусгагдсан боловч Говьсүмбэр аймагт барьж байгуулах гэсэн санааг нэмж оруулах саналтай байна.

ОРЛОГЧ ДАРГА

Ш БИЛЭГГҮМБЭРЭЛ



Хавсралт 8. Дундговь аймгийн санал


МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
48000 Сайнгатан сум, Дундговь аймаг,
Утас: 7000-2000, Факс: 7000-2000,
E-mail: zsdg@dundgov.gov.mn

Г ҮНДСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАРТ 7

2019.08.09 № 4/1050

талай _____ -ны № _____ -т

Г Санал хүргүүлэх тухай 7

"Бүсчилсэн хөгжлийн бодлого"-д аймаг, орон нутгаас тусгах дараах саналыг хүргүүлж байна.

- Бодлогын баримт бичиг туслах санал
 1. Борхион ёс заншлыг өвлүүлэх, уламжлуулах бодлого
 2. Говийн бүсийн тэмээ өсгөх тусгай сан байгуулах
 3. Говийн бүсэд дутагдалтай хүнэй нөхцийн сан байгуулах (дутагдалтай боловсон хүчин бэлтгэх, эргэн төлөгдөх сан)
 4. Цогжилтийн эсрэг хөтөлбөр
- Хөрөнгө оруулалтын төсөлд туслах санал
 1. Хэрлэн, Орхон голын урсацыг түшиглэн шавар ус татах төсөл
 2. Хадлангийн салаа байгуулж, тоног төхөөрөмжөөр хангах
 3. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах савдах үйлдвэр байгуулах
 4. Томоохон их дээд сургуулийн байр сургуулийг аймагт байгуулах
 5. Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөх, эер эрчим хүч, гэр ашиглах нөхцөл бүрдүүлэх
 6. Мандалговь-Говь-Угтаал-Говьсүмбэр аймгийг холбосон хатуу хүчилтэй авто зам
 7. Бүсийн ахмад барон хөдөлмөр бэрхшээлтэй иргэдийн сувилал, эмчилгээ үйлчилгээний төв байгуулах
 8. Борхион ёс заншлыг тусгасан ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах
 9. Малын гаралтай туухай эдийн анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр байгуулах
 10. Арвайхээр-Сэлэнгэдийг холбосон Гурвансайхан, Өндөршил сумдаар дайран өнгөрөх хатуу хүчилтэй авто зам
 11. Өвдөг судалгаа нүүрсний ордыг түшиглэн үйлдвэр байгуулах
 12. Цогцзолуурас Шинэханговь хургагч улсын чанартай хатуу хүчилтэй авто зам
 13. Сүмдэг холбосон хатуу хүчилтэй авто зам
 14. Дэлгэрхангай сумын галтганний ордыг түшиглэн барилгын материалын үйлдвэр байгуулах
 15. Төвөрлөгийн үйлдвэр байгуулах
 16. Мөх, мөхөн бүрээгдэхүүний үйлдвэр

ЗАСАГ ДАРГА  О. БАТ-ЭРДЭНЭ

434190367

Хавсралт 9. Дорноговь аймгийн санал



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,
И-мэйл: zdtg@domogovi.gov.mn, Вэбсайт: domogovi.gov.mn

2020.01.17 № 3/101

танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА**

Үндэсний хөгжлийн газар, аймгийн Засаг даргатай 2020 онд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах гэрээ болон "Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар төсөл"-д тусгах санал байхгүй болно.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ

44 8200661

Хавсралт 10. Өмнөговь аймгийн санал



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГА
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

"Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар төсөл"-ийн Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүсийн хөгжлийн хөтөлбөрт дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. 8.2.1 дэх заалтын ЦДАШ хэсэгт Баруун сумдыг 110 кВ-ын төмөр бетон тулгуур бүхий 220 км ЦДАШ-аар холбох;
2. 8.2.1 дэх заалтын ЦДАШ хэсэгт Таван толгой- Даланзадгадыг холбосон 110 кВ-ын ЦДАШ-аар 2 хэлхээ агаарын шугам болгон өргөтгөх;
3. 8.2.1 дэх заалтын Уул уурхайн ордууд хэсэгт Сэргээгдэх эрчим хүчнийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах хангалттай нөөцийг ашиглан Өмнөговь аймгийн 300 МВт гаруй салхины нөөцийг ашиглаж, Булган, Баян-Овоо, Ханбогд, Хүрмэн сумдад салхин цахилгаан станц байгуулах;
4. 8.2.1 дэх заалтын Эх үүсвэр хэсэгт Нарийн сухайт нүүрсний орд газрыг түшиглэн 65 мВт-аас доошгүй хүчин чадалтай цахилгаан станцыг барьж байгуулна;
5. 8.2.2 дахь заалтын Төмөр замын бүтээн байгуулалтын "Шивээ хүрэн-Тавантолгой" гэснийг "Шивээ хүрэн-Даланзадгад-Тавантолгой чиглэл" гэж өөрчлөх;
6. 8.2.14 дэх заалтын Хүнд үйлдвэр хэсэгт Тавантолгой нүүрсний уурхайг түшиглэн химийн үйлдвэр байгуулна;
7. 8.2.4 дэх заалтын Уул уурхайн ордууд хэсэгт ханын материалын, шохойн, төмөр бетон болон модон эдлэлийн үйлдвэрүүдийг өргөтгөн аймгийн хэрэгцээг хангаж эхэлнэ;
8. 8.2.4 дэх заалтын Уул уурхайн ордууд хэсэгт Нарийн сухайтын орд газрын олборлолтыг нэмэгдүүлэн экспортыг бүс нутгийн эдийн засгийн хөгжилд чиглүүлнэ;

465200039

2.

9. 8.2.4 дэх заалтад Уул уурхайн үйлдвэрлэлийн үр ашгаас бүсийн баялгийн сан байгуулж ашиглах;

10. 8.2.4 дэх заалтын Уул уурхайн ордууд хэсэгт Нүүрсний ордуудын метан хийн нөөцийг зөв зохистой тодорхойлж, олборлох нөхцөлийг хангана;

ЗАСАГ ДАРГА



Н.НАРАНБААТАР

Хавсралт 11. Аймгуудын Бүсийн хөгжлийн бодлогод ирүүлсэн саналыг Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал төсөлд тусгасан байдлын товъёог

2020 оны 5 дугаар сарын 25

Улаанбаатар хот

д/д	здтг	Албан бичгийн огноо, дугаар	Саналын утга	Үзэл баримтлалд	Тайлбар үндэслэл
1.	Говьсүмбэр аймаг	2020.01.20 Б/61	1. Аймаг, сумдын нэрийг албан ёсны нэршлээр бодлогын баримт бичигт тусгах	Говьсүмбэр аймаг найруулгын шинжтэй засвар	-
			2. Мандалговь-Угтаал-Чойрын чиглэлийн авто замын хэмжээг нэмэгдүүлж бүрэн оруулах	Үзэл баримтлалын төслийн 3.1.2-ын 5 дугаар зорилгод туссан.	ҮХГ. УХОХ
			3. Оросын цэргийн ангийн ашиглаж байсан нисэх онгоцны буудал, анггарууд болон газарзүйн байршлын дагуу талд суурилж, Говьсүмбэр аймагт тээвэр, логистикийн томоохон төв байгуулах		ҮХГ. УХОХ
			4. Уул уурхайн жишиг политехник коллеж, сэргээгдэх эрчим хүчний станцуудад газарзүйн байршилд суурилан Уул уурхай, Эрчим хүч, Хөдөө аж ахуйн чиглэлд мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэх их сургуулийг байгуулах, энэ чиглэлийн боловсруулах үйлдвэрүүдийг Говьсүмбэр аймагт байгуулах		ҮХГ. УХОХ
2.	Дорноговь аймаг	2020.01.17 3/101	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбарт тусгах санал байхгүй.		
3.	Дундговь аймаг	2019.08.07 1/1050	1. Бодлогын баримт бичигт тусгах санал: а. Боржигон ёс заншлыг өвлүүлэх, уламжлуулах бодлого б. Говийн бүсийн тэмээ өсгөх сан байгуулах в. Говийн бүсэд дутагдалтай хүний нөөцийн сан байгуулах д. Цөлжилтийн эсрэг хөтөлбөр	Үзэл баримтлалын төслийн 3.1.2-ын 4 дүгээр зорилгод тусгасан. Үзэл баримтлалын төслийн 3.1.1-ийн 2,3 дугаар	-

				зорилгод тусгасан.	
			2. Хөрөнгө оруулалтын төсөлд тусгах санал		
			Нийтдээ 16 төслийн санал байна.	Үзэл баримтлалын төслийн 3.1.2-ын 5 дугаар зорилгод туссан.	-
4.	Өмнөговь аймаг	2020.01.20 1/118	1. Баруун сумдыг 110 квт-ын төмөр бетон тулгуур бүхий 220 км ЦДАШ-аар холбох 2. Таван толгой-Даланзадгадыг холбосон 110 квт-ын ЦДАШ-аар 2 хэлхээ агаарын шугам болгон өргөтгөх 3. Уул уурхайн ордууд хэсэгт Сэргээгдэх эрчим хүчнийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах хангалттай нөөцийг ашиглан Өмнөговь аймгийн 300 Мвт гаруй салхины нөөцийг ашиглаж, Булган, Баян-Овоо, Ханбогд, Хүрмэн сумдад салхин цахилгаан станц байгуулах 4. Эх үүсвэр хэсэгт Нарийн сухайт нүүрсний орд газрыг түшиглэн 65 мВт-аас доошгүй хүчин чадалтай цахилгаан станц барьж байгуулах 5. Төмөр замын бүтээн байгуулалтын “Шивээ хүрэн-Тавантолгой” гэснийг “Шивээ хүрэн-Даланзадгад-Тавантолгой чиглэл” гэж өөрчлөх 6. Хүнд үйлдвэр хэсэгт Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн химийн үйлдвэр байгуулах 7. Уул уурхайн ордууд хэсэгт ханын материалын, шохойн, төмөр бетон болон модон эдлэлийн үйлдвэрүүдийг өргөтгөн аймгийн хэрэгцээг хангаж эхлэх 8. Уул уурхайн ордууд хэсэгт Нарийн сухайтын орд газрын олборлолтыг нэмэгдүүлэн экспортыг бүс нутгийн эдийн засгийн хөгжилд чиглүүлэх	Үзэл баримтлалын төслийн 3.1.2-ын 5 дугаар зорилгод туссан.	ҮХГ. УХОХ.

			9. Уул уурхайн үйлдвэрлэлийн үр ашгаас бүсийн баялгийн сан байгуулж ашиглах	Үзэл баримтлалын төслийн 3.1.2-ын 9.4 арга хэмжээнд туссан.	
			10. Уул уурхайн ордууд хэсэгт Нүүрсний ордуудын метан хийн нөөцийг зөв зохистой тодорхойлж, олборлох нөхцөлийг хангах	Үзэл баримтлалын төслийн 3.1.2-ын 2 дугаар зорилгод туссан.	
	Нийт саналын тоо		34		
	Үүнээс:				
	Найруулгын шинжтэй саналын тоо		1		
	Зарчмын шижтэй саналын тоо		33		

Хавсралт 12. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт 2018

Зөвлөгөөн зохион байгуулах хуваарь:

- | | |
|----------------------|---------------------|
| 1. Дундговь аймагт | 2018.10.31-ний өдөр |
| 2. Өмнөговь аймагт | 2018.11.01-ний өдөр |
| 3. Дорноговь аймагт | 2018.11.04-ний өдөр |
| 4. Говьсүмбэр аймагт | 2018.11.04-ний өдөр |



Зураг 1. Дундговь аймгийн зөвлөлдөх уулзалтын үеэр



Зураг 2 Хуралд оролцсон төлөөлөгч нар



Зураг 3. Үндэсний хөгжлийн газрын болон аймгийн удирдлагууд



Зураг 4. Өмнөговь аймаг зөвлөгөөний үер



Зураг 5. Үндэсний хөгжлийн газрын болон Дорноговь аймгийн удирдлагууд



Зураг 6. Дорноговь аймаг дахь уулзалтын хэсгээс

2018 оны 11 дүгээр сарын 04 –нд Говьсүмбэр аймагт



Зураг 7. ҮХГ-ын болон МУИС, ЭЗХ-гийн удирдлагууд



Зураг 8. Дорноговь аймгийн удирдлагуудтай хийсэн уулзалт

Хавсралт 13. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт 2019



ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН
ГАЗАР



ДОРНОГОВЬ
АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



МУИС
ЭДИЙН
ЗАСГИЙН



ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН
ЦОГЦ
ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛА

“ХӨТӨЛБӨР”

2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр
Говьсүмбэр аймгийн Боржигин чуулга

10:00-10:30		БҮРТГЭЛ	
НЭЭЛТИЙН АЖИЛЛАГАА			
Зөвлөгөөний хөтлөгч: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн)			
10:30-10:45	НЭЭЛТ: Б.БАЯРСАЙХАН (Үндэсний хөгжлийн газрын дарга, Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн дарга) Г.БАТСУУРЬ (Говьсүмбэр аймгийн Засаг дарга)		
10:45-10:50	Нэгдсэн зураг авах арга хэмжээ		
10:50-11:15	Илтгэл	“Монгол Улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн асуудал” Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга)	
11:15-11:40	Илтгэл	“Монгол Улсын хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төсөл” Б.ГҮНБОЛД (БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга)	
11:40-12:05	Илтгэл	“ЖАЙКА-гийн Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл ба аймгуудын хөгжлийн асуудал” Т.ХАШИМОТО (ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч)	
12:05-12:20		ЦАЙНЫ ЗАВСАРЛАГАА	
12:20-12:45	Илтгэл	“Орон нутгийн хөгжлийн бодлого” Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн)	

12:45-13:25	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХСАЙХАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Панелист: Г.БАТСУУРЬ (Говьсүмбэр аймгийн Засаг дарга) Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга) Б.ГҮНБОЛД (БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга) Т.ХАШИМОТО (ЖАЙКА-гийн Төслийн багийн ахлагч) Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Б.ОТГОНЧИМЭГ (Говьсүмбэр аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)
13:25-14:25	ҮДИЙН ЗАВСАРЛАГАА	
14:25-14:50	Илтгэл	“Говийн бүс нутгийн ландшафтийн үнэлгээ” Б.НЯМДАВАА (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх, МУИС-ийн Газарзүйн тэнхимийн ахлах багш, Ph.D)
14:50-15:15	Илтгэл	“Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын төлөвлөлт” Б.БАТБОЛД ((МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх, ШУТИС-ийн Уул уурхайн салбарын багш, Ph.D)
15:15-15:40	Илтгэл	“Зам тээврийн салбарын хөгжил, байршлын төлөвлөлт” И.БАЗАРРАГЧАА (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх, ШУТИС-ын МТС-ийн Тээврийн салбарын эрхлэгч, Ph.D)
15:40-15:55	ЦАЙНЫ ЗАВСАРЛАГАА	
15:55-16:20	Илтгэл	“Эрчим хүчний хөгжил, байршлын төлөвлөлт” Ц.ЖАРГАЛСАЙХАН (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судлаач)
16:20-17:00	Хэлэлцүүлэг	Модератор: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн) Панелист: Т.БАТ-ЭРДЭНЭ (Говьсүмбэр аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга) Б.БАТБОЛД (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн

		Уул уурхайн И.БАЗАРРАГЧАА хүрээлэнгийн МТС-ийн Тээврийн Ц.ЖАРГАЛСАЙХАН хүрээлэнгийн Б.НЯМДАВАА хүрээлэнгийн Газарзүйн У.ЭРДЭНЭТУЯА асуудал	судалгааны зөвлөх, ШУТИС-ийн салбарын багш) (МУИС-ийн Эдийн засгийн судалгааны зөвлөх, ШУТИС-ын салбарын эрхлэгч, Ph.D) (МУИС-ийн Эдийн засгийн судлаач) (МУИС-ийн Эдийн засгийн судалгааны зөвлөх, МУИС-ийн тэнхимийн ахлах багш, Ph.D) (Говьсүмбэр аймгийн эрчим хүчний хариуцсан албан тушаалтан)
--	--	--	---

Хавсралт 14. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт



ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН
ГАЗАР



ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



МУИС
ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”

(ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ)

“ХӨТӨЛБӨР”

2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр
Дорноговь аймгийн Саран хөхөө театр

08:00-09:30		БҮРТГЭЛ
НЭЭЛТИЙН АЖИЛЛАГАА		
Зөвлөгөөний хөтөлгөч: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн)		
09:30-10:00	НЭЭЛТ: Б.БАЯРСАЙХАН бүсчилэн боловсруулахад үүрэг Г.ЭРДЭНЭЦЭЦЭГ Ч.ОЮУН-ЭРДЭНЭ нийгэмлэгийн ЭТИС КАВАМУРА ЁОЖИ	(Үндэсний хөгжлийн газрын дарга, Эдийн засгийг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх бүхий ажлын хэсгийн дарга) (Дорноговь аймгийн Засаг даргын орлогч) (Германы олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Засаглал хариуцсан ахлах зөвлөх) (ЖАЙКА-гийн Төслийн багийн дэд ахлагчийн орлогч)
10:00-10:05	Нэгдсэн зураг авах арга хэмжээ	
10:05-10:45	Илтгэл	“Монгол Улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн арга зүйн асуудал” Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга)
10:45-11:10	Илтгэл	“Төвийн бүсийн говийн дэд бүсийн орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршил” С.НАМЖИЛМАА (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх, Монгол Улсын Зөвлөх архитектор)
11:10-11:25	Илтгэл	“Тогтвортой хөгжлийн түншлэлийн зөвлөл” Ч.ОЮУН-ЭРДЭНЭ (Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөрийн Засаглал хариуцсан ахлах зөвлөх)

11:25-11:40	ЦАЙНЫ ЗАВСАРЛАГАА	
11:40-12:00	Илтгэл	“Төвийн бүсийн говийн дэд бүсийн хот байгуулалт, газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлт, хөгжил байршлын судалгаа” Д.ДОРЛИГЖАВ (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач)
12:00-12:30	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХСАЙХАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн) Панелист: Г.ЭРДЭНЭЦЭЦЭГ (Дорноговь аймгийн Засаг даргын орлогч) Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга) С.НАМЖИЛМАА (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх, Монгол Улсын Зөвлөх архитектор) Ч.ОЮУН-ЭРДЭНЭ (Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөрийн Засаглал хариуцсан ахлах зөвлөх) КАВАМУРА ЁОЖИ (ЖАЙКА-гийн Төслийн багийн дэд ахлагчийн орлогч) Х.ӨЛЗИЙСҮРЭН (Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн дарга)
12:30-13:30	ҮДИЙН ЗООГ	
13:30-13:50	Илтгэл	“Орон нутгийн индекс, хөнгөн үйлдвэрийн хөгжил, байршлын төлөвлөлт” Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн)
13:50-14:10	Илтгэл	“Төвийн бүсийн говийн дэд бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил байршлын судалгаа” Д.ДАЛАЙЦЭЦЭГ (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач)
14:10-14:30	Илтгэл	“Төвийн бүсийн говийн дэд бүсийн аялал жуулчлалын хөгжил байршлын судалгаа” Б.ИНДРАА (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх)

14:30-15:00	Хэлэлцүүлэг	Модератор: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн) Панелист: Б.ИНДРАА (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх) Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн) С.ОДБАЯР (Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг дарга) Д.ДАЛАЙЦЭЦЭГ (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач) Д.СҮРЭН (Дорноговь аймгийн БОАЖГ-ын дарга) Ж.НАРАНБОЛД (Дорноговь аймгийн ХХААГ-ын дарга)
15:00-15:15	ЦАЙНЫ ЗАВСАРЛАГАА	
15:15-15:35	Илтгэл	“Бүс нутаг төлөвлөлтөд харгалзах ландшафтын үнэлгээ” Төвийн бүсийн говийн дэд бүсийн жишээн дээр Э.АЛТАНБОЛД (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач)
15:35-16:00	Илтгэл	“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дахь зүүн бүсийн дэд бүтэц” Н.ТОГТОХ (Мал тариалангийн эрсдэл судалгааны төвийн тэргүүн, доктор, профессор)
16:00-16:20	Илтгэл	“Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрчим хүчний хөгжил, байршлын судалгаа” Ц.ЖАРГАЛСАЙХАН (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач)
16:20-16:40	Илтгэл	“Бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулах ажлын удирдамж Д.ЭНХТУЯА (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн)
16:40-17:15	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн) Панелист: Г.ЭРДЭНЭЦЭЦЭГ (Дорноговь аймгийн Засаг даргын орлогч) Э.АЛТАНБОЛД (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач) Ц.ЖАРГАЛСАЙХАН (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач) Ч.ТҮВШИНТӨР (Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

		М.ДЭЛГЭРНАСАН (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн гэрээт судлаач) Ц.ОЮУНСАЙХАН (Дорноговь аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга)
17:15-17:30	ХААЛТ	Б.БАЯРСАЙХАН (Үндэсний хөгжлийн газрын дарга)

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Хавсралт 15. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт



ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



МУИС
ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”

“ХӨТӨЛБӨР”

2019 оны 2 дугаар сарын 28-ны өдөр
Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар

08:30-09:00		БҮРТГЭЛ
НЭЭЛТИЙН АЖИЛЛАГАА		
Зөвлөгөөний хөтөлгөч: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн)		
09:00-09:20	НЭЭЛТ:	Б.БАЯРСАЙХАН (Үндэсний хөгжлийн газрын дарга, Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн дарга) Н.НАРАНБААТАР (Өмнөговь аймгийн Засаг дарга) КАОРИ ИШИКАВА (НҮБ-ын ХАС-гийн менежер)
09:20-09:40	Илтгэл	“Монгол Улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн арга зүйн асуудал” Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга)
09:40-10:00	Илтгэл	“Өмнөговь-2018 суурь судалгааны зарим үр дүн” А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга)
10:00-10:20	Илтгэл	“Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлын явц, үр дүн” Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор)
10:20-10:50	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Панелист: Н.НАРАНБААТАР (Өмнөговь аймгийн Засаг дарга) Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга) А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга) Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор)

		Д.ГОТОВ (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх) Б.БАТБОЛД (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
10:50-11:05	ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА	
11:05-11:45	Илтгэл	“Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршил”, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл” С.НАМЖИЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх, Монгол Улсын Зөвлөх архитектор)
11:45-12:05	Илтгэл	Өмнөговь аймгийн хүн амын нутагшил суурьшлын өөрчлөлт А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга)
12:05-12:35	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХСАЙХАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Панелист: А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга) О.БАТТОГТОХ (Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг дарга) Ц.САНЖАА (Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Засаг дарга) Ю.ЭНХТУЯА (Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга) С.НАМЖИЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх, Монгол Улсын Зөвлөх архитектор) Ш.БАЙГАЛМАА “Оюутолгой” ХХК-ны Орон нутгийн харилцааны ерөнхий менежер
12:35-13:35	ҮДИЙН ЗООГ	
13:35-13:55	Илтгэл	Өмнөговь аймгийн эдийн засгийн өнөөгийн байдал А.ДЭМБЭРЭЛ (ҮСХ-ны Үндэсний тооцоо, судалгаа шинжилгээний газрын дарга)
13:55-14:15	Илтгэл	“Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын төлөвлөлт” Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор)
14:15-14:35	Илтгэл	“Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын төлөвлөлт” Б.БАТБОЛД (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
14:35-15:05	Хэлэлцүүлэг	Модератор: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн) Панелист:

		Х.БАТБОЛД (Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн асуудал) С.МӨНХБАЯР хариуцсан Засаг даргын орлогч) (Өмнөговь аймгийн уул уурхай, байгаль орчин, дэд бүтэц хариуцсан Засаг даргын орлогч) А.ДЭМБЭРЭЛ (ҮСХ-ны Үндэсний тооцоо, судалгаа шинжилгээний газрын дарга) Д.БАЯРСАЙХАН (ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын асуудалд хариуцсан мэргэжилтэн) Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор) Б.БАТБОЛД (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
15:05-15:20	ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА	
15:20-15:40	Илтгэл	Өмнөговь аймгийн Байгаль орчны өнөөгийн байдал Ц.ӨНӨРЦЭЦЭГ, Ж.ПҮРЭВЛЭЛГЭР (ҮСХ-ны Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа төсөл)
15:40-16:00	Илтгэл	“Зам тээврийн салбарын хөгжил, байршлын төлөвлөлт” Д.ГОТОВ (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
16:00-16:20	Илтгэл	“Эрчим хүчний хөгжил, байршлын төлөвлөлт” Ц.ЖАРГАЛСАЙХАН (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
16:20-16:50	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Панелист: С.МӨНХБАЯР (Өмнөговь аймгийн уул уурхай, байгаль орчин, дэд бүтэц хариуцсан Засаг даргын орлогч) Т.ЖАРГАЛСАЙХАН ӨБЦТС ТӨХК-ийн захирал Ц.ӨНӨРЦЭЦЭГ (ҮСХ-ны Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа төсөл) Д.ГОТОВ (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх) Ц.ЖАРГАЛСАЙХАН (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх) Ж.СҮХ-ЭРДЭНЭ (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
16:50-17:00	ХААЛТ	Б.БАЯРСАЙХАН (Үндэсний хөгжлийн газрын дарга)

Хавсралт 16. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. Зөвлөлдөх уулзалт



ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



МУИС
ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”

“ХӨТӨЛБӨР”

2019 оны 2 дугаар сарын 26-ны өдөр
Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар

08:30-09:00		БҮРТГЭЛ
НЭЭЛТИЙН АЖИЛЛАГАА		
Зөвлөгөөний хөтлөгч: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн)		
09:00-09:20	НЭЭЛТ:	Б.БАЯРСАЙХАН (Үндэсний хөгжлийн газрын дарга, Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн дарга) Н.НАРАНБААТАР (Өмнөговь аймгийн Засаг дарга) КАОРИ ИШИКАВА (НҮБ-ын ХАС-гийн менежер)
09:20-09:40	Илтгэл	“Монгол Улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн арга зүйн асуудал” Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга)
09:40-10:00	Илтгэл	“Өмнөговь-2018 суурь судалгааны зарим үр дүн” А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга)
10:00-10:20	Илтгэл	“Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлын явц, үр дүн” Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор)
10:20-10:50	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Панелист: Н.НАРАНБААТАР (Өмнөговь аймгийн Засаг дарга) Д.ЭРДЭНЭБАЯР (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга) А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга) Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор) Д.ГОТОВ (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх) Б.БАТБОЛД (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
10:50-11:05		ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА

11:05-11:45	Илтгэл	“Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршил”, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл” С.НАМЖИЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх, Монгол Улсын Зөвлөх архитектор)
11:45-12:05	Илтгэл	Өмнөговь аймгийн хүн амын нутагшил суурьшлын өөрчлөлт А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга)
12:05-12:35	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХСАЙХАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Панелист: А.АМАРБАЛ (ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга) О.БАТТОГТОХ (Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг дарга) Ц.САНЖАА (Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Засаг дарга) Ю.ЭНХТУЯА (Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга) С.НАМЖИЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх, Монгол Улсын Зөвлөх архитектор) Ш.БАЙГАЛМАА (“Оюутолгой” ХХК-ны Орон нутгийн харилцааны ерөнхий менежер)
12:35-13:35	ҮДИЙН ЗООГ	
13:35-13:55	Илтгэл	Өмнөговь аймгийн эдийн засгийн өнөөгийн байдал А.ДЭМБЭРЭЛ (ҮСХ-ны Үндэсний тооцоо, судалгаа шинжилгээний газрын дарга)
13:55-14:15	Илтгэл	“Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын төлөвлөлт” Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор)
14:15-14:35	Илтгэл	“Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын төлөвлөлт” Б.БАТБОЛД (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
14:35-15:05	Хэлэлцүүлэг	Модератор: Х.ЭРДЭНЭБУЛГАН (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн) Панелист: Х.БАТБОЛД (Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч) С.МӨНХБАЯР (Өмнөговь аймгийн уул уурхай, байгаль орчин, дэд бүтэц хариуцсан Засаг даргын орлогч)

		А.ДЭМБЭРЭЛ (ҮСХ-ны Үндэсний тооцоо, судалгаа шинжилгээний газрын дарга) Д.БАЯРСАЙХАН (ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын асуудалд хариуцсан мэргэжилтэн) Х.ЦЭВЭЛМАА (МУИС-ийн ЭЗХ-гийн захирал, доктор, профессор) Б.БАТБОЛД (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
15:05-15:20	ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА	
15:20-15:40	Илтгэл	Өмнөговь аймгийн Байгаль орчны өнөөгийн байдал Ц.ӨНӨРЦЭЦЭГ, Ж.ПҮРЭВДЭЛГЭР (ҮСХ-ны Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа төсөл)
15:40-16:00	Илтгэл	“Зам тээврийн салбарын хөгжил, байршлын төлөвлөлт” Д.ГОТОВ (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
16:00-16:20	Илтгэл	“Эрчим хүчний хөгжил, байршлын төлөвлөлт” Ц.ЖАРГАЛСАЙХАН (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх)
16:20-16:50	Хэлэлцүүлэг	Модератор: Д.МӨНХЖАРГАЛ (ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Ахлах мэргэжилтэн) Панелист: С.МӨНХБАЯР (Өмнөговь аймгийн уул уурхай, байгаль орчин, дэд бүтэц хариуцсан Засаг даргын орлогч) Т.ЖАРГАЛСАЙХАН ӨБЦТС ТӨХК-ийн захирал Ц.ӨНӨРЦЭЦЭГ (ҮСХ-ны Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа төсөл) Д.ГОТОВ (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх) Ц.ЖАРГАЛСАЙХАН (МУИС-ийн ЭЗХ-гийн судалгааны зөвлөх) Ж.СҮХ-ЭРДЭНЭ (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Хавсралт 17. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг. ҮХГ



Зураг 1. Судалгааны багийн ахлагч, МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн захирал



Зураг 2. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны хэлэлцүүлэг



Зураг 5. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны судлаач И.Базаррагчаа



208



Зураг 3. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх Б.Батболд



Зураг 4. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх Б.Индраа



Зураг 5. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх С.Намжилмаа



Зураг 6. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөх Б.Нямдаваа







**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
44103 Дорноговь аймаг, Сайншалант сум, 3 дугаар баг,
Утас/факс: (705) 2-25-13
И-мэйл: dorноговь_аймг_засаг дарга.сум

2019.07.04 № 1/259
танай _____ -ны № _____ -т

**ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА**

Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн бодлогод
Дорноговь аймгаас тусгах бодлогын болон хөрөнгө
оруулалтын саналыг сум тус бүрээр гаргаж, сумдын
ИТХ-ын тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргын
зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, дүнг нэгтгэн
хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.


Т.ЭНХТҮВШИН

44 615 1350
D: 2019/2 AN TOOT

Ч.Ф.М.С.М.П.

Тайлбар: Албан тоотыг оныг андууран бичсэн.


**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРТЫН ТАМГЫН ГАЗАР**
46063 Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар багс
Нутгийн удирдлагын ордон, 204 тоот
Утас: (976)70532848, Факс: (976)70532111,
И-мэйл: info@omn.gov.mn, Бэл сайт: www.omn.gov.mn

2020.08.25 № 5-2049
ТӨНГӨЙ -НЫ № -Г

**МУИС-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Х.ЦЭВЭЛМАА ТАНАА**

Үндэсний хөгжлийн газар, Оюу толгой ХХК-ийн дэмжлэгтэйгээр "Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлал"-ыг боловсруулж, эцэслэн гаргах хүрээнд хийгдсэн судалгааны эцсийн тайлантай танилцлаа.

Дээрх бодлогын баримт бичгийг боловсруулж, эцэслэн гаргах ажлын хүрээнд хийгдсэн судалгааны тайланд нэмэлт санал байхгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТГИЙН
ДАРГА  Ж.СҮХ-ЭРДЭНЭ

468200856

Хавсралт 21. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санал. ОТ ХХК



No 1639/15

2020 оны 08 сарын 25 өдөр

МУИС-ИЙН ХАРЬЯА ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ Х.ЦЭВЭЛМАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Юуны өмнө Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал 2030 судалгааны ажлыг гүйцэтгэсэн танай байгууллагын судлаачид болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тус үзэл баримтлалын судалгааг бүс нутгийн орон зайн төлөвлөлтийн арга зүйд нийцүүлэн судалснаар хөгжлийн асуудлыг олон талаас нь авч үзэх, тухайн бүсийн орон зай, газар зүйн онцлог, хэмжээс, хөдөлгөөн, шар хүрээ, бүтцийг нэгдсэн байдлаар үнэлэх боломжийг бүрдүүлсэн байна. Ингэснээр говийн болон дэд бүсийн төлөвлөлт, түүнд авч хэрэгжүүлэх бодлогын хувилбар болон санхүүжилтийн уялдааг хангах юм.

Говийн дэд бүсийн санал болгож буй үзэл баримтлалыг үндэслэн тус бүс нутгийн урт болон дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг говь нутгийн байгалийн нөөцийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан үйлдвэрлэл, тэр дундаа уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхэд анхаарахын зэрэгцээ иж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын техник технологийн мэдлэг ур чадварыг бүс нутагтаа бэхжүүлэхээр заажээ.

Мөн тус үзэл баримтлалд заасан Говийн бүсийн хүний хөгжил, ялангуяа амьдралын чанар, иргэний амьдрах тав тухтай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын тэргүүлэх чиглэлийг тогтоох нь тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чухал ач холбогдолтойг цохон тэмдэглэхэд таатай байна.

Цаашид Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд дараах асуудлыг авч үзэх талаар санал болгож байна. Үүнд:

- **Засаглалын механизмыг сайжруулах:** боловсруулсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн уялдааг хангах зохицуулалтын механизмыг бүсийн түвшинд Ажлыг хэсэг байхаар санал болгож буй нь тогтвортой бус бүтэц юм. Тиймээс Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан төв болон орон нутаг дахь нэгжүүдийн чадавхийг бэхжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна;
- **Санхүүжилтийн загварыг боловсронгуй болгох:** тус үзэл баримтлалын хэрэгжилтийг санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан "Бүсийн хөгжлийн сан"-ийн хэлбэрээр шийдвэрлэх нь шинэлэг боловч тухайн бүтцийн засаглалын нд тод байдлыг хангаагүй тохиолдолд нөөцийг оновчтой хуримтлуулах болон зарцуулах оновчтой механизм болж чадахгүйг бусад орны туршлага харуулж байна. Оюу толгой ХХК-ийн санаачлан Өмнөговь аймагтай хамтран байгуулсан "Говийн Оюу сан"-ийн туршлагын талаар хуваалцаж, энэ чиглэлээр манай компаниас хамтран ажиллах боломжтой юм;

Оюу Толгой ХХК
Улаанбаатар-14240
Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө-15
"Morris Damas"
Утас: (976) 11 331880
Факс: (976) 11 331890
E-mail: online@ot.mn
Web: www.ot.mn

Oyu Tolgoi LLC
Morris Tower
Chinggis Avenue 15
Sukhbaatar District
Ulaanbaatar 14240, Mongolia
Tel: (976) 11 331880
Fax: (976) 11 331890
E-mail: online@ot.mn
Web: www.ot.mn

- **Бодлогын төсөл хөтөлбөрийн эрэмбийг оновчтой тогтоох:** байгалийн нөөцийг түшиглэсэн аливаа үйлдвэрлэл (мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, уул уурхай, гэх мэт) нөөц ашигласны төлбөр төлөх эрхзүйн орчныг эн тэргүүнд бүрдүүлэх нь чухал юм. Ингэхдээ тус үзэл баримтлалд санал болгож буй Бүсийн хөгжлийн санд 30 хувийг төвлөрүүлэн зарцуулах чиглэлийг хэт олон салбар, чиглэлд зарцуулах тухай тогтоохоосоо илүүтэйгээр хөгжлийн тухайн үеийн онцлогт нийцэн, бүсийн дорвитой, нийтлэг асуудалд чиглүүлэхээр зааж өгөх;
- **Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах:** үзэл баримтлалын хэрэгжилтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог сайн хангаж, тэдгээрээс хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэхийн зэрэгцээ инноваци, технологийн шинэчлэл, төсөл хэрэгжүүлэх болон бизнес эрхлэх мэдлэг, арга барилыг нэвтрүүлэх тал дээр хамтран ажиллах зэрэг зүйлсийг санал болгож байна.

Бидний зүгээс дээрх саналын талаар тодруулах болон бусад чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцоход таатай байх болно.

Хүндэтгэсэн,

СТРАТЕГИЙН ТӨСЛҮҮД ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ш.БАЙГАЛМАА



Хувийг: Монгол Улсын Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан

Хавсралт 22. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санал. УХГ



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Х.ЦЭВЭЛМАА ТАНАА

2020.08.26 № 09/1249
талбай _____ нд № _____

Бодлогын баримт бичгийн төсөлд санал хүргүүлэх тухай

"Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал 2030"-ын төсөлд санал авах тухай албан бичиг, тайлангийн төсөлтэй танилцаад зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. "Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.5.6-д "Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр" гэж заасны дагуу бодлогын баримт бичгийн нэрийг хуульд нийцүүлэн өөрчлөх;

2. "Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль"-ийн 6.5-д "Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шапгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна," гэж заасны дагуу бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагааг дараах байдлаар томъёолох шаардлагатай байна.

- Бодлогын баримт бичгийн төсөлд зорилго тодорхойлогдоогүй бөгөөд Бодлогын зорилго нь бодлого хэрэгжиж дуусахад хүрсэн байх үр дүнг илэрхийлсэн байдлаар томъёолох. Жишээлбэл: "Говийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон, хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн бүс нутаг болгон хөгжүүлнэ." гэх мэт;

- Бодлогын зорилтуудыг "3.1.1 Байгаль ба эдийн засгийн тогтвортой харилцан уялдаа", "3.1.2 Эдийн засаг ба нийгмийн хүртээмжтэй харилцан үйлчлэл", "3.1.3 нийгэм ба хүрээлэн буй орчны тэнцвэртэй, тогтвортой шүтэлцээ" хүрээнд авч үзсэн нь ойлгомжгүй хэт ерөнхий;

3. Бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан "тодорхой", "хэмжиж болохуйц", "хүрч болохуйц", "хэрэгжихүйц бодитой", бодлогын зорилго, зорилтыг "хэрэгжүүлэх хугацааг" тодорхойлсон байх;

4. Бодлогын зорилтуудыг Засаглал, Эдийн засаг, Нийгэм, Байгаль орчин гэсэн үндсэн салбаруудын хүрээнд томъёолох;

5. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 7 дугаар бүлгийн 31-д заасны дагуу хавсралт мэдээллийг бүрэн боловсруулах;

Computer/Disc(D)/Alban bichig\root A-4 2020/

Дээрх засваруудыг оруулсаны дараа тайлангийн төслийг 2020 оны 8 дугаар сарын 31-ний дотор ирүүлнэ үү.

Хавсралт хуудас.

ДАРГА

Б. БАЯРСАЙХАН

Computer/Disco(D)/Alban bichig/foot A-4 2020/

Хавсралт 23. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн санал. Эрдэнэс Оюу Толгой ХХК

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот-14240, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, чингисийн ергөн чөлөө-15, Моннис цамхаг
14-р давхар, 16 тоот Утас/ Факс: (976) 7007 8085
<http://www.EOT.mn>

2020. 09. 01 № 01/146
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Х.ЦЭВЭЛМАА ТАНАА

"Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал 2030" судалгааны эцсийн тайлан, түүнд тусгагдсан "Говийн бүсийн хөгжлийн үзэл баримтлал"-ын төсөлтэй танилцлаа.

"Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн зэс-алтны ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Оюу Толгой" ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийг эзэмших эрхийг хэрэгжүүлэх, төслөөс Монголын талын хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой төрийн өмчит компани юм.

Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу Толгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж, Ажлын хэсгийн холбогдох асуудлыг 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэн 92 дугаар тогтоолыг баталсан. "Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах асуудал"-аар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан ба уг тогтоолын 6 дугаарт "Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 57 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах" гэсэн байна.

Үүнтэй холбоотой тус компанийн зүгээс УИХ-ын Ажлын хэсгийн санал, зөвлөмжид бүс нутгийн хөгжлийн асуудлаар туссан чиглэлийг түүвэрлэн, уялдаа холбоог хангах үүднээс хавсралтаар хүргүүлж байна.

Иймд УИХ-ын Ажлын хэсгийн санал, дүгнэлтэд багтсан асуудлуудыг судлан, "Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал" судалгааны эцсийн тайланг бичиг баримтыг эцэслэхэд уялдааг ханган ажиллах саналтай байгааг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: Оюу Толгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, зөвлөмжийн түүвэр: 3... хуудас.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.ТҮМЭНЦОГТ

**ОЮУ ТОЛГОЙ ОРДЫГ АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ ШАЛГАЖ, САНАЛ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН
ХЭСГИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ТҮҮВЭР**

**"Д. БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЭЦ, УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗРЫН
ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

1.Бүс нутгийн хөгжлийн талаар

1.Хөрөнгө оруулалтын гэрээний 4.1-д Засгийн газар "Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл" байгуулж үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэхээр тусгасан ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1. Өмнийн говийн бүсийг хөгжүүлэх байгууллагын статус, эрх үүрэг, ажиллах эрх зүйн орчныг тодорхой болгон, Зөвлөлийг яаралтай шинэчлэн зохион байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх чиглэлийг УИХ-аас Засгийн газарт чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
2. Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийг орон тооны гишүүдтэй, ажлын албатайгаар шинэчлэн зохион байгуулж, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, хариуцлагатай ажиллуулах шаардлагатай. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Үндэсний хөгжлийн газар, Барилга, хот байгуулалтын яамны төлөөллийг оролцуулах;
3. Засгийн газрын 2010 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Өмнийн говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г дүгнэх. Уг төлөвлөгөөний 3.3.1.1-д тусгагдсан зорилтын хүрээнд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас /хуучнаар/ боловсруулсан "Говийн бүсийн Тавантолгой, Оюу Толгой, Цагаан суваргын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги төсөл, хот байгуулалтын төлөвлөгөө төсөл"-ийг одоогийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж тодотгон батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;
4. Тус бүсийг эдийн засгийн дэд бүс болгон хөгжүүлэх нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцэх бөгөөд хэрэгжилтийг хангах боломж илүү бүрдэнэ. Хэрэв Өмнийн говийн бүсийн хөгжлийг бие даалган авч үзэх бол "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг шинэчлэн боловсруулж 2020 онд УИХ-аар батлуулахаар төлөвлөсөн ажлын хүрээнд цогцоор нь авч үзэж, нэг мөр шийдвэрлэх шаардлагатай болно;
5. "Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл"-ийн үйл ажиллагаа доголдсонтой холбоотойгоор "Оюу Толгой" ХХК-аас "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-г /ГОХДС/ байгуулан жил бүр 5 сая ам.доллар зарцуулж байна. Энэ сангийн үйл ажиллагааг Засгийн газрын бодлого, орон нутгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулах нь зүйтэй байна.
6. Орон нутгийн удирдлагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ болон Харилцан ойлголцлын санамж бичигт тусгагдсан асуудлуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, Оюу Толгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээний зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх;

7. ГОХДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг бүс нутгийн хөгжлийн баримт бичигт үндэслэн олон нийтийн саналд тулгуурлан төлөвлөж хэрэгжүүлэх, цахим хуудсанд байршуулсан үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад мэдээллүүдийг олон нийтэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй болгох, зарцуулалтын дүнг хянах;
8. Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийг байнгын ажиллагаатай, үйл ажиллагааг үр дүнтэй болгох шаардлагатай байна. Бүс нутгийн хөгжлийн асуудлыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллах үүрэгтэй учраас уг байгууллагад Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийн ажлыг хариуцуулах саналтай байна. Ингэхийн тулд холбогдох хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна. Үндэсний хөгжлийн асуудал улс орны хөгжлийн тулгуур гэдгийг хүлээн зөвшөөрч, тус байгууллагыг Ерөнхий сайдын хариуцах ажлын хүрээнд хамааруулж, ач холбогдол, эрх мэдлийг үлэмж нэмэгдүүлэх шаардлагатай байна. Өнөөгийн нөхцөлд Үндэсний хөгжлийн газар Засгийн газрын агентлаг учраас яамдтай харилцах болон салбар дундын зохицуулалт хийх ямар ч эрх мэдэл, бололцоогүй байна. Иймд Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Үндэсний хөгжлийн газрын эрх зүйн байдлыг сайжруулж, эрх мэдлийг өргөтгөх нь зүйтэй. Шадар сайдад үндэсний хөгжлийн асуудлыг дангаар хариуцуулж болно. Богино хугацаанд хөгжилд хүрсэн Азийн бар БНСУ, Малайз, Сингапур улсуудын түүхээс үзвэл Ерөнхий сайд, эсвэл Шадар сайд үндэсний хөгжлийн бодлогыг хариуцаж ажилладаг туршлагыг харгалзаж үзэх.

2. Стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн орд газрыг түшиглэн хөгжиж буй хот сууринд хүн амын шилжилт хөдөлгөөн, суурьшил дагасан нийгмийн бусад асуудлыг "Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл"-өөр шийдвэрлэгдэх асуудлууд тулгамдаж байна.

1. Хот төлөвлөлтийн хувьд тухайлсан аймэг, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан бол хэсэгчилсэн төлөвлөгөөг мөн батлуулж хот төлөвлөлтийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх;
2. Оюу Толгойн гүний уурхай ашиглах, цахилгаан станц барих, шинээр хот байгуулах зэрэгт усны нэмэгдэл шинэ эх үүсвэр зайлшгүй шаардлагатай байгааг судлах;
3. Шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулах асуудлаар "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа"-нд тулгуурлан "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-д нийцүүлэн, Барилга, хот байгуулалтын яамнаас боловсруулж байгаа "Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-д үндэслэн холбогдох шийдвэрийг баталж хэрэгжүүлэх;
4. Хязгаарлагдмал усны нөөцтэй говийн аймгуудад хот байгуулах, түүнтэй холбогдон гарах дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын асуудлыг зөв, оновчтой шийдэх боломжит хувилбарыг "Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл"-ийн хүрээнд боловсруулах. Энэ хүрээнд усны нөөцийн асуудалд онцгой анхаарах шаардлагатай бөгөөд гадаргын усны нөөцийг ашиглахаар төлөвлөсөн судалгаа, төслүүдийн хэрэгжилтийн эрсдэлийг бодитойгоор дахин үнэлэх;
5. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Орон нутгийн удирдлагууд "Оюу Толгой" ХХК-тай "Хамтын ажиллагааны гэрээ" байгуулсан боловч уг "Хамтын ажиллагааны гэрээ" гэрээний 6 дугаар зүйлд "...Талууд Ханбогд сумын хот төлөвлөлтөд хувь нэмэр оруулах буюу хот төлөвлөлтийг хийх үүрэг хүлээхгүй." гэж заасан нь Хөрөнгө оруулалтын гэрээний 4.4.3 дахь заалтыг үгүйсгэсэн шинжтэй байх тул дээрх гэрээний зөрчлийг арилгах арга хэмжээ авах;
6. Өмнөговь аймгийн Цогтцэций, Гурвантэс, Ханбогд сумдын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах

асуудлыг хөрөнгө оруулагч талтай хамтарч шуурхай зохион байгуулах, улмаар батлуулж хэрэгжилтийг хангах;

7. Монгол Улсын "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн судалгаа, үнэлгээний ажлыг Өмнөговь аймгаас эхлүүлэх.

3.ХөОГ-ний 4.8, 4.10 дахь заалтуудад заасан Оюу Толгой төслийн шууд болон шууд бус нөлөөлөлд өртсөн иргэдийн асуудлыг анхаарах, тэдэнд нөхөн төлбөр олгох тухай асуудлыг нэг мөр шийдвэрлэх.

1. Хөрөнгө оруулалтын гэрээний 4.8, 4.10-т заасан "Оюу Толгой" ХХК-ийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин болон бусад чиглэлээр боловсруулсан судалгааны баримт бичгийн хүрээнд Оюу Толгой төслийн шууд болон шууд бус нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд олгосон нөхөн төлбөрийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллагуудын оролцоог хангасан бүрэлдэхүүнтэй иж бүрэн хяналт шинжилгээг хийлгэн дүгнэж, цаашдын чиглэлээ тодорхой болгох;
2. Хөрөнгө оруулагч орон нутгийн иргэдийг сургах, ажлын байраар хангах асуудлыг зөвхөн уурхайд ажиллах зорилготойгоор шийдвэрлэх бус, цаашид орон нутгийн иргэдийн амьдралын баталгааг хангах чиглэлээр бодлогын түвшинд авч үзэж хэрэгжүүлэх;
3. Нийгэм, эдийн засгийн суурь судалгаа, нөлөөллийн үнэлгээ, эрсдэлийн шинжилгээ, орон нутгийн харилцааны удирдлагын систем, уурхай хаах төлөвлөгөөг боловсруулах ажлыг олон улсын жишигт (талууд тус жишгийг тохиролцон батлах) нийцүүлэн боловсруулж, олон нийтэд танилцуулан санал аасны үндсэн дээр баталж, хэрэгжүүлэх."